


**ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ
ХОХИРОГЧ ТӨВТЭЙ АРГАЧЛАЛЫГ ХЭРЭГЛЭХТЭЙ
ХОЛБООТОЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖ
БОЛОН СУРГАЛТЫН ГАРЫН АВЛАГЫГ ХАРЬЦУУЛАХ,
АЛБАН ХААГЧДЫН ЧАДАВХЫГ ҮНЭЛЭХ
СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

2017





ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН ЯАМ



The Asia Foundation



Энэхүү судалгааны тайланг Америкийн Нэгдсэн Улсын Төрийн Департаментын санхүүгийн дэмжлэгтэйгээр бэлтгэсэн болно. Энд дурдагдсан үзэл бодол, үр дүн, мэдээлэл, дүгнэлт нь зөвхөн зохиогчийнх бөгөөд Америкийн Нэгдсэн Улсын Төрийн Департаментын үзэл бодлыг илэрхийлээгүй болохыг анхаарна уу.

СУДАЛГААНЫ БАГ

Судлаач:

Г.Ганбаясгах (Хүйсийн тэгш эрхийн төв)
Т.Цогзолмаа (Хүйсийн тэгш эрхийн төв)
Г.Амаржаргал
Н.Манлайбаатар
Б.Эрдэнэбилэг

Судалгааны багийн гишүүд:

Ц.Амаржаргал
Д.Байгалмаа
Г.Баярмаа
Г.Ганцэцэг
Г.Ганбилэг
Г.Гансүх
Б.Ихтамир
Б.Мөнхзул
Б.Оюундарь
П.Тунгалагтамир
Б.Халиунаа
Б.Цэрэнханд
Ц.Шийтэрчулуун
П.Энхчимэг

Техник редактор:

Паулин Твийди (Азийн сан)
Г.Гантулга (Азийн сан)
С.Мөнхчулуун (Азийн сан)

АГУУЛГА

СУДАЛГААНЫ БАГ	3
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	4
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	5
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	8
ЕРӨНХИЙ ТОЙМ	9
Судалгааны зорилго, ач холбогдол	9
Үр дүнгийн хураангуй	10
БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ	17
1.1. Судалгааны зорилго	18
1.2. Судалгааны зорилтууд	18
1.3. Судалгааны түүвэр	18
БҮЛЭГ 2. СУДАЛГААНЫ ҮЙЛ ЯВЦЫН ТАНИЛЦУУЛГА	21
2.1. Судалгааны асуулга	22
2.2. Туршилтын судалгаа	22
2.3. Сургалт	22
2.4. Мэдээлэл цуглуулалт, боловсруулалт	22
2.5. Судалгааны давуу болон сул талууд	23
2.6. Мэдээлэл цуглуулах явцад гарсан хүндрэл бэрхшээл, даван туулсан байдал, сургамж	23
БҮЛЭГ 3. БОДЛОГЫН СУДАЛГАА 1: ХҮН, ЯЛАНГУЯА ЭМЭГТЭЙЧҮҮД, ХҮҮХЭД ХУДАЛДААЛАХААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТАСЛАН ЗОГСООХ, ШИЙТГЭХ ТУХАЙ ПРОТОКОЛ БОЛОН МОНГОЛ УЛСЫН ЗАРИМ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХАРЬЦУУЛАЛТ	25
3.1. Судалгааны үндэслэл	26
3.2. Судалгааг гүйцэтгэсэн тухай суурь мэдээлэл	27
3.3. Палермогийн протоколын хүн худалдаалах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн шинж Монгол Улсын Эрүүгийн хуульд хуульчлагдсан талаар	28
3.4. Палермогийн протоколын хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах хэм хэмжээ Монгол Улсын хууль тогтоомжид хуульчлагдсан талаар	30
3.5. Палермогийн протоколын хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэм хэмжээ Монгол Улсын хууль тогтоомжид хуульчлагдсан талаар	32
3.6. Дүгнэлт	34
3.7. Санал, зөвлөмж	36

БҮЛЭГ 4. БОДЛОГЫН СУДАЛГАА 2: ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ЧИГЛЭЛЭЭР ГАРГАСАН СУРГАЛТЫН ГАРЫН АВЛАГА, СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН ХАРЬЦУУЛАЛТ	37
4.1. Судалгааны хэрэгцээ, шаардлага	38
4.2. Судалгааны зорилго, зорилт	38
4.3. Судалгааны арга зүй	39
4.4. Судалгааны үр дүн	39
4.5. Дүгнэлт, санал	42
БҮЛЭГ 5. ШҮҮГЧ, ПРОКУРОР, ЦАГДАА, ХИЛ ХАМГААЛАХ БОЛОН ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН АЛБА ХААГЧДЫН ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ХОХИРОГЧ ТӨВТЭЙ АРГАЧЛАЛЫГ ХЭРЭГЛЭХ ЧАДАВХЫГ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН	44
5.1. Цагдаагийн байгууллагын алба хаагчдаас авсан санал асуулгын дүн	46
5.2. Прокурорын байгууллагын алба хаагчдаас авсан санал асуулгын дүн	56
5.3. Шүүх эрх мэдлийн байгууллагын алба хаагчдаас авсан санал асуулгын дүн	65
5.4. Хил хамгаалах ерөнхий газрын хилийн шалган нэвтрүүлэх албаны алба хаагчдаас авсан санал асуулгын дүн	74
5.5. Гадаадын иргэн, харьяатын газрын алба хаагчдаас авсан санал асуулгын дүн	82
5.6. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдоос авсан санал асуулгын дүн	89
ДҮГНЭЛТ	96
ЗӨВЛӨМЖ	100
ХАВСРАЛТ	101
Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол болон Монгол Улсын зарим хууль тогтоомжийн харьцуулалтын хавсралт	101
Хүн худалдаалах гэмт хэргийн талаарх сургалтын гарын авлага, бүтээлүүдийн харьцуулалтын хавсралт	112

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АС	Азийн сан
ГИХГ	Гадаадын иргэн, харьяатын газар
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
ОӨУБЕГ	Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар
ОУБ	Олон улсын байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХСИС	Хууль сахиулахын их сургууль
ХТЭТ	Хүйсийн тэгш эрх төв
ХХГХ	Хүн худалдаалах гэмт хэрэг
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
ХШНА	Хилийн шалган нэвтрүүлэх алба
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ЭХ	Эрүүгийн хууль
ЭХХШТХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

- Зураг 1.1 Судалгаанд оролцогчдын насны бүлэг, хүйсээр
- Зураг 1.2 Цагдаагийн байгууллагад ажилласан хугацаа
- Зураг 1.3 Таны бодлоор Монгол Улсад ХХГХ–ийн аль хэлбэр илүү давамгайлж байгаа вэ?
- Зураг 1.4 ХХГХ–тэй холбоотой хэргийг мөрдөн шалгаж оролцсон байдал
- Зураг 1.5 Хохирогч байх магадлалтай тохиолдол илэрвэл хаана хандах вэ?
- Зураг 1.6 Цагдаагийн байгууллагад ХХГХ–тэй холбоотой ихэвчлэн бүртгэгддэг хэргүүд
- Зураг 1.7 ХХГХ–ийг мөрдөн шалгах ажиллагаа явуулахад тохиолддог хүндрэл
- Зураг 1.8 Төрөөс явуулж буй сургалтын чанар, үр дүн сайн эсэх
- Зураг 1.9 Сургалтыг ямар аргачлалаар хүргэвэл илүү үр дүнтэй вэ?
- Зураг 1.10 ХХГХ–ийн талаарх ном, гарын авлага, нэг сэдэвт бүтээлийн чанар, хүртээмж
- Зураг 1.11 ХХГХ–тэй тэмцэх чиглэлийн ямар сургалтад хамрагдахыг хүсэж буй байдал
- Зураг 1.12 ХХГХ–ийн хохирогчид үйлчилгээ, туслалцаа үзүүлсэн байдал
- Зураг 1.13 Хохирогчоос мэдүүлэг авах тусгай өрөө байдаг уу?
ХХГХ–ийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, ялангуяа шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр өгөх санал
- Зураг 1.14
- Зураг 2.1 Судалгаанд оролцогчдын насны бүлэг, хүйсээр
- Зураг 2.2 Прокуророор ажилласан хугацаа
- Зураг 2.3 Таны бодлоор Монгол Улсад ХХГХ–ийн аль хэлбэр илүү давамгайлж байгаа вэ?
- Зураг 2.4 ХХГХ–ийг хүлээн авч хянах, шүүх хуралдаанд улсын яллагчаар оролцож байсан байдал
- Зураг 2.5 Прокурорын байгууллагад ХХГХ–тэй холбоотой ихэвчлэн бүртгэгдэн хяналт тавьж буй хэргүүд
- Зураг 2.6 ХХГХ–ийг шүүхээр хянан шийдвэрлэхэд тулгардаг хүндрэл бэрхшээл
- Зураг 2.7 Төрийн явуулж буй сургалтын чанар, үр дүн сайн байсан эсэх
- Зураг 2.8 Сургалтыг ямар аргачлалаар хүргэвэл илүү үр дүнтэй вэ?
- Зураг 2.9 ХХГХ–ийн ном, гарын авлага, нэг сэдэвт бүтээлийн чанар, хүртээмж
- Зураг 2.10 ХХГХ–тэй тэмцэх чиглэлийн ямар сургалтад хамрагдахыг хүсэж буй байдал
- Зураг 2.11 Хамтын ажиллагааг сайжруулах санал
- Зураг 2.12 ХХГХ–ийг амжилттай шалгаж чадахгүй байгаа шалтгаан
- Зураг 2.13 Шинэчилсэн Эрүүгийн хуулийг хэрэглэхэд тулгарч буй хүндрэл бэрхшээл байгаа эсэх
ХХГХ–ийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, ялангуяа шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр өгөх санал
- Зураг 2.14
- Зураг 3.1 Судалгаанд оролцогчдын насны бүлэг, хүйсээр
- Зураг 3.2 Шүүгчээр ажилласан хугацаа
- Зураг 3.3 Таны бодлоор Монгол Улсад ХХГХ–ийн аль хэлбэр илүү давамгайлж байгаа вэ?
- Зураг 3.4 Шүүхээр хянан шийдвэрлэгдэж байгаа ХХГХ–ийн төрөл, хэлбэрүүд
- Зураг 3.5 ХХГХ–ийг шүүхээр хянан шийдвэрлэхэд тулгардаг хүндрэл, бэрхшээл
- Зураг 3.6 Төрийн явуулж буй сургалтын чанар, үр дүн сайн байсан эсэх

- Зураг 3.7 Төрийн бус болон Олон улсын байгууллагаас зохион байгуулсан сургалтын чанар, үр дүн сайн байсан эсэх
- Зураг 3.8 ХХГХ–ийн талаарх ном, гарын авлага, нэг сэдэвт бүтээлийн чанар, хүртээмж
- Зураг 3.9 ХХГХ–тэй тэмцэх чиглэлийн ямар сургалтад хамрагдахыг хүсэж буй байдал
- Зураг 3.10 Хамтын ажиллагааг сайжруулах санал
- Зураг 4.1 Судалгаанд оролцогчдын насны бүлэг, хүйсээр
- Зураг 4.2 Хилийн шалган нэвтрүүлэх албанд ажилласан хугацаа
- Зураг 4.3 Таны бодлоор Монгол Улсад ХХГХ–ийн аль хэлбэр илүү давамгайлж байгаа вэ?
- Зураг 4.4 ХХГХ–ийн сэжигтэй тохиолдол гарвал авах арга хэмжээний талаарх оролцогчдын санал / хувиар/
- Зураг 4.5 Эмэгтэйчүүдийг хүүхэд тээлгэх зорилгоор худалдаалдаг талаар сонсож байсан уу?
- Зураг 4.6 Хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах байгууллагуудын хамтын ажиллагааны түвшин ямар байна вэ?
- Зураг 4.7 Төрийн явуулж буй сургалтын чанар, үр дүн сайн байсан эсэх
- Зураг 4.8 Сургалтыг ямар аргачлалаар хүргэвэл илүү үр дүнтэй вэ?
- Зураг 4.9 ХХГХ–ийн талаарх ном, гарын авлага, нэг сэдэвт бүтээлийн чанар, хүртээмж
- Зураг 4.10 ХХГХ–тэй тэмцэх чиглэлийн ямар сургалтад хамрагдахыг хүсэж буй байдал
- Зураг 5.1 Судалгаанд оролцогчдын насны бүлэг, хүйсээр
- Зураг 5.2 Гадаадын иргэн, харьяатын газарт ажилласан хугацаа
- Зураг 5.3 Таны бодлоор Монгол Улсад ХХГХ–ийн аль хэлбэр илүү давамгайлж байгаа вэ?
- Зураг 5.4 Төрийн явуулж буй сургалтын чанар, үр дүн сайн байсан эсэх
- Зураг 5.5 Сургалтыг ямар аргачлалаар хүргэвэл илүү үр дүнтэй вэ?
- Зураг 5.6 ХХГХ–ийн талаарх ном, гарын авлага, нэг сэдэвт бүтээлийн чанар, хүртээмж
- Зураг 5.7 ХХГХ–тэй тэмцэх чиглэлийн ямар сургалтад хамрагдахыг хүсэж буй байдал
- Зураг 6.1 Судалгаанд оролцогчдын нас
- Зураг 6.2 ХХГХ–ийн хэв шинжүүдтэй тулгарч байсан эсэх
- Зураг 6.3 Аль улсад худалдаалагдсан бэ?
- Зураг 6.4 ХХГХ–ийн хохирогчийн нөхцөл байдлаасаа зугтаж, аврагдсан байдал
- Зураг 6.5 Хуулийн байгууллагад хандаж гомдол гаргасан байдал
- Зураг 6.6 Хуулийн байгууллагаас хохирогчийн аюулгүй эрсдэлийн түвшнийг тогтоосон эсэх
- Зураг 6.7 ТББ–аас хохирогчийн аюулгүй байдлыг хангахаар авсан арга хэмжээ
- Зураг 6.8 ХХГХ–ийн хохирогчид учирсан хамгийн их хохирол
- Зураг 6.9 Хохирогчдын зүгээс хууль, төрийн байгууллагад өгөх санал, хүсэлт

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1	ХХГХ үйлдэгдэхэд нөлөөлж буй хүчин зүйлс
Хүснэгт 1.2	Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн зарчмын хэрэгжилт
Хүснэгт 1.3	Ямар хугацаатай сургалтад хамрагдсан бэ?
Хүснэгт 2.1	ХХГХ үйлдэгдэхэд нөлөөлж буй хүчин зүйлс
Хүснэгт 2.2	Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн зарчмуудын хэрэгжилт
Хүснэгт 2.3	Ямар хугацаатай сургалтад хамрагдсан бэ?
Хүснэгт 3.1	ХХГХ үйлдэгдэхэд нөлөөлж буй хүчин зүйлс
Хүснэгт 3.2	Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн зарчмуудын хэрэгжилт
Хүснэгт 3.3	Ямар хугацаатай сургалтад хамрагдсан бэ?
Хүснэгт 4.1	ХХГХ үйлдэгдэхэд нөлөөлж буй хүчин зүйлс
Хүснэгт 4.2	ХХГХ–ийг илрүүлэх, шалгах ажиллагаанд тулгардаг хүндрэл бэрхшээл
Хүснэгт 4.3	Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн зарчмуудын хэрэгжилт
Хүснэгт 5.1	ХХГХ үйлдэгдэхэд нөлөөлж буй хүчин зүйлс
Хүснэгт 5.2	ХХГХ–ийг илрүүлэх, шалгах ажиллагаанд тулгардаг хүндрэл бэрхшээл
Хүснэгт 5.3	Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн зарчмуудын хэрэгжилт
Хүснэгт 6.1	ХХГХ–т өртөхөд нөлөөлж буй хүчин зүйлс
Хүснэгт 6.2.	Хохирогч хуулийн байгууллагад гомдол гаргахад тухайн байгууллагын ажилтнуудын харьцаа, хандлага хэр байсан талаар

ЕРӨНХИЙ ТОЙМ

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ

Цагдаагийн байгууллагын тоо мэдээнээс¹ харахад сүүлийн жилүүдэд илрүүлж, шалгаж байгаа хүн худалдаалах гэмт хэрэг (ХХГХ)-ийн тоо жил тутам буурсан үзүүлэлттэй байгаа бөгөөд 2014 онд найм, 2015 онд зургаа, 2016 онд гурван хэргийг мөрдөн шалгажээ. Харин шүүхээр шийдвэрлэгдсэн ХХГХ-ийн шийдвэрлэлт багасаж 2014–2016 онуудад Эрүүгийн хууль (ЭХ)-ийн 113-р зүйл² ангиар эрүүгийн дөрвөн хэрэгт найман хүн ял шийтгүүлжээ³. Эдгээр тоо мэдээлэлд дүгнэлт хийж үзвэл Монгол Улсад хүн худалдаалах эрүүгийн хэрэг буурч, гаралт багасаж байгаа дүр зураг харагдаж байна. Гэвч ХХГХ-ийн хохирогчдод шууд туслалцаа үзүүлэн ажилладаг Хүйсийн тэгш эрхийн төв (ХТЭТ)-ийн тоон мэдээллээс 2014–2016⁴ онуудад 129 хохирогч хандсан байна.

2008–2012 онд ХХГХ-тэй тэмцэх чиглэлд олон донорууд⁵ анхаарал хандуулж, урьдчилан сэргийлэх, сургалт, сурталчилгааг хэрэгжүүлсэн бол 2013 оноос ХХГХ-тэй тэмцэх үйл ажиллагаа нь хоёр донорын⁶ санхүүжилтээр хязгаарлагдмал хүрээнд, зорилтод бүлгийн хэдхэн хүнийг хамруулсан сургалтыг төрийн бус байгууллага (ТББ) болон олон улсын байгууллага (ОУБ)-ууд зохион байгуулсан хэдий ч хангалттай хүрээг хамарч чадаагүй юм.

Ингээд 2017 онд Азийн сан (АС), Хууль зүй, дотоод хэргийн яам (ХЗДХЯ), Хууль сахиулахын их сургууль (ХСИС)-тай хамтран **“Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа: Албан хаагчдыг чадавхжуулах нь”** төслийг хэрэгжүүлж эхэлсэн ба төсөл нь доорх хоёр зорилтыг тавьсан байна. Үүнд:

- 1) Хохирогч төвтэй стратеги хэрэгжүүлэх, хууль сахиулах байгууллагын ажилтнууд, прокурор, шүүгчдийн хамтын ажиллагааг сайжруулах;

¹ ЦЕГ-ын Нэгтгэн, боловсруулах газрын статистикийн хэлтэс, 2014–2016 он

² Хуучин ЭХ-ийн 113-р зүйл, Хүн худалдаалах

³ Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн судалгаа мэдээллийн хүрээлэн, 04/90 албан тоотын хавсралт, 2017 он

⁴ ХТЭТ-ийн статистик мэдээлэл

⁵ Швейцарын хөгжлийн агентлаг нь 3 жилийн хугацаатай 2 000 000 швейцар франкны санхүүжилттэй “Монгол Улс дахь ХХГХ-тэй тэмцэх” төслийг хэрэгжүүлж байсан.

⁶ Европын холбооны дэмжлэгтэйгээр Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын туслалцаатайгаар ХХГХ-ийн хохирогчдод шууд туслалцаа үзүүлэх төслийг ХТЭТ хэрэгжүүлсэн. Нийт санхүүжилт нь 49 644 евро. 2016–2017 он

- 2) Хил хамгаалах ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын газар (ГИХГ)-ын алба хаагч нарын ХХГХ-ийн хохирогчдыг илрүүлэх, хариу арга хэмжээ авах чадавхыг сайжруулах юм.

Монгол Улсын Засгийн газраас ХХГХ-ийн илрүүлэлтийг нэмэгдүүлэх, хэргийг амжилттайгаар хянан шийдвэрлэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор мөрдөгч, прокуроруудын нөөцийг нэмэгдүүлэх үүднээс эрүүгийн эрх зүйн шинэчлэлийг хийж байгаа билээ. Энэхүү шинэчлэлд “Хүн худалдаалахтай тэмцэх тухай” хууль (2012), “Гэрч, хохирогчийг хамгаалах тухай” хууль (2014) болон Шинэчилсэн Эрүүгийн хууль (2017), Шинэчилсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (ЭХХШТХ) (2017) зэрэг багтаж байна.

Энэтөсөл нь Америкийн нэгдсэн улсын Төрийн департаментаас 2015 онд гаргасан ХХГХ-ийн тухай тайлангийн тэргүүлэх чиглэлийн нэг болох төрийн байгууллагуудын хүрээнд хохирогч төвтэй мөрдөн шалгах ажиллагаа, прокурорын шатны хянан шалгах ажиллагааг институцлэх асуудлыг хангах бөгөөд ХХГХ-ийн хөдөлмөрийн болон бэлгийн мөлжлөгийн асуудлуудыг шийдвэрлэхээр тусгагдсан. Түүнчлэн төсөл хэрэгжүүлж эхлэхийн өмнө хууль сахиулах байгууллагын алба хаагчид, прокурор, шүүгч, хил хамгаалах, гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн байгууллагын алба хаагчдын ХХГХ-ийн талаарх ойлголт мэдлэг, хохирогч төвтэй үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдлыг судлахыг зорьсон. Энэ судалгаагаар ХХГХ-тэй тэмцэхээр гаргаж буй хууль тогтоомж, бодлого шийдвэрүүд нь олон улсын баримт бичиг, нэгдэн орсон гэрээний үндсэн зорилго, зорилтод нийцэж буй эсэх талаар мэдээлэлтэй болох, энэ чиглэлээр гарсан гарын авлага, сургалтын материалуудад ямар нийтлэг болон ялгаатай шинжүүд агуулагдаж байгаа, хууль сахиулах, хууль хяналтын болон шүүх эрх мэдлийн байгууллагуудын алба хаагчдад зориулж ямар төрлийн сургалтын материал боловсруулж, ямар арга барилаар сургалт зохион байгуулах нь үр дүнтэй гэдгийг олж мэдэхийг зорьсон юм. Үүнээс гадна цаашид энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр зөвлөмж, саналыг энэ судалгаанд тусгасан.

1. НҮБ–ын Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол болон Монгол Улсын зарим хууль тогтоомжийн харьцуулалт, бодлогын судалгаа

- 2008 онд Палермогийн протоколыг соёрхон баталж ХХГХ–ээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хохирогчдыг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр ажиллаж буй төрийн бус байгууллагын хүчин чармайлт, олон улсын дэмжлэгтэйгээр олон судалгаа хийгдэж Монгол Улсын хууль тогтоомжийн хүн худалдаалахтай тэмцэх хууль тогтоомжийн чадавх эрс сайжирч олон улсын жишигт нийцжээ.
- Эрүүгийн хууль тогтоомжийн шинэчлэлийн хүрээнд хүн худалдаалах, мансууруулах, сэтгэгдэд нөлөөлөх эм, бэлдмэлийн хууль бус эргэлт, мөнгө угаах зэрэг улс дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд шинээр батлагдсан хуулиудын тодорхой хугацааны хэрэгжилтийн явцад уялдаа холбоог хангах, коллиз, хийдэл, алдааг холбогдох судалгааг үндэслэн Хууль тогтоомжийн тухай хуулийн⁷ дагуу боловсронгуй болгох шаардлага бий болжээ.
- ХХГХ–тэй тэмцэх хууль тогтоомжийн мөн чанар нь нэгэнт үйлдэгдсэн ХХГХ–ийг нотлоход бус урьдчилан сэргийлэхэд хууль зүйн учир холбогдол нь оршиж байгаа бөгөөд тэдгээрийн хэрэгжилт нь нийгэм, эдийн засгийн байдалтай холбоотой боловч төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, алба хаагчдын хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хангах хамгаалах хандлага, мэдлэг, мэргэшлийн ур чадвараас ихээхэн шалтгаалдаг байна.
- Монгол Улсын Засгийн газраас баталсан хүн худалдаалахтай тэмцэх болон бусад үндэсний хөтөлбөр, төрөөс баримтлах бодлогын баримт бичгүүдийн уялдаа холбоо болон төсөв, санхүүгийн хүндрэлтэй байдлаас шалтгаалан зохих үр дүнгээ үзүүлэхгүй байгаа нь цаашид Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн⁸ хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх талтай байна.

2. ХХГХ–тэй тэмцэх чиглэлээр гаргасан сургалтын гарын авлага, судалгааны тайлангийн харьцуулалт, бодлогын судалгаа

- ХХГХ–тэй тэмцэх ном, гарын авлага, сургалтын материалын олдоц боломжийн байна. Хэдийгээр ном, гарын авлага байгаа нь сайшаалтай ч тэдний

⁷ Төрийн мэдээлэл 2015 он №25 Хууль тогтоомжийн тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Энэ хуулийн зорилго нь хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр /цаашид “хууль тогтоомж” гэх/-ийг санаачлах, боловсруулах ажиллагааны үндэслэл, чанарыг сайжруулах, ... оршино.” гэж заасан.

⁸ Төрийн мэдээлэл эмхэтгэл 2015 он №47

дотоод агуулга зарим бүтээлүүдэд давхцах байдал ажиглагдлаа. Энэ нь тухайн бүтээлийн чанар чансааг илтгэх үзүүлэлт болох магадлалтай. Цөөн тооны, хязгаарлагдмал бүтээл байгаагийн гол шалтгаан нь ХХГХ–ийн мөн чанарыг ерөнхийлөн судалж байгаад оршино.

- ХХГХ–ийн түүхийг илүү дэлгэрэнгүй авч үзэх шаардлагатай байна. Бие даасан сурах бичиг гаргах шаардлагатай гэж бид үзэж байна. Өөрөөр хэлбэл ХХГХ–ийн түүхийг бичсэнээр хойч үеийнхэндээ уг гэмт хэргийн хор хөнөөл, аюул, заналхийллийг ойлгуулах онцгой ач холбогдолтой. Түүхэн үзэгдлийнхээ хувьд ямар хэлбэр, төрлөөр улам бүр баяжиж байгааг зурагт тайлбар толь гаргах замаар нийтэд мэдээлэх нь энэ гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх механизмыг улам бүр боловсронгуй болгоно.
- Дотоодын бүтээлд ХХГХ–т шинжилгээ хийхтэй холбоотой зүйл дурдагдаагүй байна. ХХГХ үйлдэгдсэн тохиолдолд илрүүлж бэхжүүлсэн мөр, эд мөрийн баримтад шинжилгээ хийх арга зүйн талаар тусгаж өгөх нь мөрдөх ажиллагаанд чухал нөлөөтэй. Хэрвээ шинжилгээ зүйн асуудал орхигдвол бид асуудалд иж бүрэн хандахгүй байгааг илтгэх хэрэг болно. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, ХСИС–ийн Шинжлэн магадлахуйн тэнхимтэй хамтран энэ агуулгыг судлах нь илүү оновчтой гэж үзсэн.
- ХХГХ–тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогч төвтэй мөрдөн шалгах ажиллагаа болон хууль сахиулах байгууллагуудын /Цагдаа, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, Хил хамгаалах алба, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, ГИХГ, Хууль зүйн туслалцааны төв, ХСИС/ ажлын уялдаа холбоог сайжруулах, тусгайлан зориулсан гарын авлага боловсруулах нь зүйтэй.
- Шинээр батлагдсан Эрүүгийн болон ЭХХШТХ–ийн агуулгаар бид ХХГХ–ийн талаар шинэлэг тодорхойлолт гаргах болсон байна. ХХГХ–ийг эрүүгийн эрх зүйн үүднээс тайлбарлах, хохирогч төвтэй мөрдөн шалгах ажиллагааг оновчтой, зөв зохион байгуулах, ингэхдээ ил болон нууц мөрдөн шалгах ажиллагааг оновчтой хослуулан явуулах, прокурор, шүүх, хилийн шалган нэвтрүүлэх алба (ХШНА), ГИХГ–ын алба хаагчдад энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд шаардлагатай мэдээлэл өгөхүйц иж бүрэн сургалтын гарын авлагыг боловсруулах зайлшгүй шаардлагатай байна.

3. Шүүгч, прокурор, цагдаа, хил хамгаалах болон гадаадын иргэн, харьяатын газрын алба хаагчдын хүн худалдаалах

гэмт хэрэгтэй тэмцэх хохирогч төвтэй аргачлалыг хэрэглэх чадавхыг үнэлэх судалгаа

1) Цагдаагийн байгууллага (Судалгаанд нийт 200 цагдаагийн алба хаагчид оролцсон):

- Судалгаанд оролцогчдын 70% (140) нь ХХГХ-ийг ЭХ-ийн тодорхойлолтын дагуу ойлгоно гэж хариулсан бөгөөд 5% (10) нь мэдэхгүй, үлдсэн хувь болох 25% (50) нь хариулаагүй байна.
- Судалгаанд хамрагдсан алба хаагчдын 16% (32) нь энэ төрлийн гэмт хэргийг шалгахад оролцож байсан ба тэдний 40.6% (13) нь нэг удаа л мөрдөн шалгахад оролцсон байна.
- ХХГХ-тэй холбоотой хэргийг Улсын мөрдөн байцаах газрын дэргэдэх Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх тасгийн 6 албан хаагч тус судалгаанд хамрагдсан бөгөөд бүгдээрээ ХХГХ-ийн 3 буюу түүнээс олон удаа шалгаж байсан бол 65.6% нь буюу 3 мөрдөгч тутмын 2 нь 1–2 удаа тус төрлийн хэргийг мөрдөн шалгахад оролцжээ.
- ХХГХ-ийг шалгахдаа эрсдэлтэй гэж үзсэн хохирогчтой ажиллахдаа хэрэглэдэг тусгай асуумж, арга техник, журам байдаг гэж 11.5% (23) нь хариулсан. Харин 88.5% (177) нь ийм журам, стандарт байхгүй гэж хариулсан нь анхаарал татсан асуудлын нэг юм.
- Цагдаагийн байгууллагад ихэвчлэн бүртгэгдэж байгаа хүн худалдаалахтай холбоотой гомдол мэдээллүүдээс бэлгийн мөлжлөг гэж хамгийн өндөр буюу 75.5% (151), албадан хөдөлмөр эрхэлсэн талаар гомдол хүлээн авдаг гэж 32% (64) нь хариулсан байна.
- ХХГХ бусад зохион байгуулалттай гэмт хэргүүдтэй хамт үйлдэгдэж байна гэж судалгаанд оролцогчдын 50% (100) нь үзсэний 62% (124) нь хар тамхи, 64% (128) нь цахим гэмт хэрэгтэй, 3% (6) нь зэвсгийн наймаатай, харин “бусад” гэж хариулсан 1% (2) оролцогчид залилан, мөнгө угаах зэрэг гэмт хэргүүдтэй хамт үйлдэгдэж байна гэж үзсэн.
- Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн зарчмуудын хэрэгжилтийг үнэлэхэд нийт оролцогчдын тал хувь нь 48% (96) нь тэдгээр зарчмуудын хэрэгжилт “хангалтгүй”, “туйлын хангалтгүй” гэж үзжээ.
- ХХГХ-ийг шалгаж байсан гэж хариулсан 32 цагдаагийн ажилтнуудын 53% (17) нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад хохирогч, гэрч аюулгүй байдлаа хамгаалуулах хүсэлт гаргаж байсан бөгөөд ТББ-ын болон гэр бүлийн хүчирхийллийн хамгаалах байруудад байрлуулах,

болзошгүй эрсдэлээс нь урьдчилан сэргийлэх үйл ажиллагаануудыг авч хэрэгжүүлсэн байна.

- Судалгаанд хамрагдагсдын 75.5% (151) нь ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр төрийн зүгээс явуулж буй сургалтад огт хамрагдаагүй бөгөөд хамрагдсан 49 алба хаагчдын 57% (28) нь мэргэшүүлэх сургалтын үр дүн сайн байсан гэж үзжээ. Мөн ХХГХ-ийн чиглэлээр ТББ, ОУБ-аас зохион байгуулдаг сургалтад судалгаанд хамрагдагсдын 83.5% (167) нь хамрагдаж чадаагүй байна.
- Цаашид сургалтыг бодит кейсүүд дээр ажиллах байдлаар зохион байгуулбал илүү үр дүнтэй гэж 68% (136) нь хариулсан бол 88% (176) нь багш лекц уншдаг уламжлалт аргыг халахыг санал болгосон.
- ХХГХ-ийг шалгаж байсан нийт 32 алба хаагчаас хэрэг шалгах явцад хохирогчийн зүгээс эрүүл мэнд, хууль эрх зүй, сэтгэлзүйн үйлчилгээ авах хүсэлтийг 31%-д (10) гаргаж байсан бол 28% (9) нь хохирогч хүсэлт гаргаагүй ч тэдний хэрэгцээнд тохирсон үйлчилгээг үзүүлсэн байна. Тухайлбал: Тусгай уулзалтын өрөөнд зөвлөгөө өгөх, сэтгэлзүйн зөвлөгөө тусламж, сэтгэл зүйчтэй уулзуулах, эрүүл мэнд, хууль зүй, сэтгэлзүйн тусалцаа үзүүлэх зэрэг үйлчилгээг үзүүлж байжээ.
- Судалгаанд хамрагдсан Цагдаагийн газар, хэлтсүүдэд хохирогчоос мэдүүлэг авах тусгай өрөө байгаа эсэх талаар тодруулахад 52% (104) нь байгаа гэсэн боловч тэдний 47% (49) нь л тогтмол ашигладаг гэж хариулсан нь өрөөний ашиглалт хангалтгүй байгааг харуулж байна. Ашигладаггүй шалтгааныг тодруулахад шалтгааныг нь сайн мэдэхгүй байна, үүнийг хариуцдаг эрх бүхий хүн биш гэсэн хариултаа өгсөн. ХХГХ-ийн хохирогч, гэрчийн мэдээллийн аюулгүй байдлыг хангахад мэдүүлэг авах тусгай өрөө нь чухал ач холбогдолтой учраас энэхүү өрөөний ашиглалтыг сайжруулах шаардлагатай байна.
- ХХГХ-ийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, ялангуяа шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр 22% (44) нь саналаа илэрхийлсний 81.8% (36) нь сургалт зохион байгуулах, 91% (40) нь манай улсын иргэд холбогдсон, хохирсон бодит хэргийн кейс танилцуулж түүн дээр хамтран ажиллуулах, харилцан туршлага солилцох, иргэдэд мэдээлэл өгөх зэргийг цагдаагийн алба хаагчид онцолжээ.

2) Шүүх эрх мэдлийн байгууллага (Судалгаанд нийт 39 шүүгч оролцсон)

- ХХГХ-ийн талаарх ойлголт мэдлэгийг тандахад шүүгчдийн 41% (16) нь хүний эрхийг ноцтой зөрчсөн гэмт хэрэг гэжээ. Харин 25.6% (10) нь ХХГХ гэдэгт хүчээр биеийг нь үнэлүүлэх, мөлжих зорилгоор хуурч мэхлэх, хүнийг дотоод гадаадад худалдаалах, шинэ төрлийн гэмт хэрэг, бэлгийн болон хөдөлмөрийн мөлжлөг, эд эрхтний наймаа гэж хариулсан бол судалгаанд оролцсон шүүгчдийн 33.4% (13) нь энэ төрлийн гэмт хэргийг мэдэхгүй эсвэл хариулахыг хүсээгүй байна.
- Монгол Улсад ХХГХ-ийн ямар хэлбэр, төрлүүд давамгайлж байна вэ гэхэд 76.9% (30) нь биеийг нь хүчээр үнэлүүлэх, 69.2% (27) бэлгийн мөлжлөг байна гэж үзсэн байна. Бусад нь хөдөлмөр мөлжлөг, хуурамч гэрлэлт, эд эрхтний наймаа, гэрийн үйлчлэгч, тээгч эх гэсэн хариултаудыг мөн сонгосон байсан бөгөөд 5% (2) нь мэдэхгүй гэж хариулжээ.
- ХХГХ-тэй холбоотой хэргийг шийдвэрлэж байсан эсэхийг тодруулахад дийлэнх олонх буюу 79.5% (31) нь үгүй гэж хариулжээ.
- Шүүгч нараас шүүх хуралдааны үеэр ХХГХ-ийн хохирогчоос асуулт асуухад тусгай стандарт, журам байдаг уу гэхэд 84.6% (33) нь үгүй, 10.2% (4) нь тийм, 5.1% (2) нь мэдэхгүй гэжээ. Тийм гэж хариулсан шүүгчдээс ямар стандарт, журам байдаг талаар тодруулахад бүхий л төрлийн гэмт хэргийн хохирогчидтой ажиллахдаа ашигладаг “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам”, “ЭХХШТХ”, “насанд хүрээгүй хохирогчоос тусгайлан мэдүүлэг авах журам”-ыг хэрэглэдэг гэжээ. Шүүх хуралдааны явцад хохирогчийн аюулгүй байдал, хувь хүний нууцлалыг хэрхэн хамгаалж ажилладаг талаар асуухад 59% (23) нь мэдэхгүй, үлдсэн 41% (16) нь хуульд заагдсаны дагуу явагдаж байгаа, гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн дагуу арга хэмжээ авах, гэрч, хохирогчоос мэдүүлэг авах, хохирогчийн аюулгүй байдлыг хангах, шүүхэд ийм эрх олгогдоогүй, цагдаагийн байгууллагаас тусгайлан хамгаалалт гаргадаг, шүүхийн цагдаагаар хамгаалуулдаг, хохирогчийг шүүгдэгчээс тусгаарлаж хуралдаан явуулдаг, шүүх хуралдааныг хаалттай явуулдаг, хохирогчийг хамгаалах шийдвэр гаргадаг, хохирогчийн аюулгүй байдал нийтлэг хэрэг дээр бүрэн хангагддаггүй зэргээр хариулжээ.
- ХХГХ бусад зохион байгуулалттай гэмт хэргүүдтэй хамт үйлдэгдэж байна гэж судалгаанд оролцогчдын 43.5% (17) нь үзсэний 33.3% (6) нь цахим гэмт хэрэг, 28.2% (5) нь хар тамхи, 10.3% (2) нь залилан мэхлэх хэргүүдтэй хамт үйлдэгдэж байна гэж үзсэн. Харин 43.5% (17) нь мэдэхгүй гэж хариулжээ.
- Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн зарчмуудын хэрэгжилтийг үнэлэхэд нийт оролцогчдын 46.3% (17) нь “хангалтгүй” гэж үнэлсэн байна.
- Шүүхийн шатанд ХХГХ-ийн хохирогч, гэрч аюулгүй байдлаа хамгаалуулах хүсэлт, гомдол гаргаж байсан эсэхийг тодруулахад тийм гэж 1, үгүй гэж 97.3% (38) нь хариулжээ. Тийм гэж хариулсан шүүгч ямар төрлийн хүсэлтийг шийдвэрлэснийг тодруулахад “орон нутгаас ирсэн хохирогчийг Улаанбаатар хотод оршин суух газаргүй байхад хамгаалах байранд байрлуулах” арга хэмжээ авч байсан байна.
- Судалгаанд оролцогчдоос ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр төрийн байгууллагаас зохион байгуулж байгаа мэргэшүүлэх сургалтын чанар, үр дүнгийн талаар тодруулахад нийт 39 шүүгчийн 31 нь энэ чиглэлийн ямар ч сургалтад хамрагдаагүй гэж хариулжээ. Цаашид сургалтыг “бодит кейсүүд дээр ажиллах” (35 шүүгч буюу 89.7%), “багаар ажиллах” (15 шүүгч буюу 38.5%), “оролцоонд суурилсан” (14 шүүгч буюу 35.9%), “багш лекц унших” (5 шүүгч буюу 12.8%) арга, аргачлалаар зохион байгуулбал илүү үр дүнтэй гэж үзэж байлаа.
- Шүүгчдээс ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр нэн чухал, чухал гэж ХХГХ-ийн хохирогч, гэрчийг хамгаалах, харилцах, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаа урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах, таслан зогсоох, нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх ажиллагаа, ХХГХ-тэй тэмцэх байгууллагуудын хамтын ажиллагаа гэсэн чиглэлээр мэдээлэл авах гэж үзэж, эдгээр чиглэлээр сургалтад хамрагдах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн.
- Шүүх эрх мэдлийн байгууллагад ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр тусгай мэргэшсэн шүүгч бэлтгэх хэрэгтэй гэж судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 76.9% (30) нь үзэж байгаа нь энэ төрлийн гэмт хэргийг хянан шийдвэрлэдэг эрүүгийн шүүгч нарыг мэргэшүүлэн сургах зайлшгүй хэрэгцээ, шаардлага байгааг харуулж байна.
- ХХГХ-тэй тэмцэхэд шүүх эрх мэдэл, хууль сахиулах, төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагын хамтын ажиллагааг судалгаанд оролцогчдын 30.8% (12) нь хангалтгүй, 25.6% (10) нь хангалттай, 41% (16) нь мэдэхгүй гэж хариулжээ. Төрийн, төрийн бус болон ОУБ, хууль хяналт, сахиулах байгууллагын хамтын ажиллагааг сайжруулахын тулд “нэгдсэн ойлголттой”, “хамтын ажиллагааны уялдаа холбоог бий болгон ажиллах”,

“улс орны сайн туршлагыг судлах” гэсэн саналыг гаргажээ.

3) Прокурорын байгууллага (Судалгаанд нийт 51 прокурор оролцсон)

- Прокурор нарын 41.6% (21) нь ХХГХ-ийг ЭХ-ийн 13.1 дэх заалтад зааснаар ойлгоно гэж тайлбарласан байна. 9.8% (5) нь ХХГХ-ийг хүний эрхийн эсрэг гэмт хэрэг, 7.8% (4) нь хохирогчийг мөлжих зорилгоор эрх чөлөөг нь хязгаарлах, 29% (15) нь бэлгийн, хөдөлмөрийн мөлжлөг, эд эрхтний наймаа, хүчээр биеийг нь үнэлүүлэх, хүний эмзэг байдлыг ашигладаг гэмт хэрэг зэрэг олон төрлийн хариулт өгсөн бол 11.8% (6) нь мэдэхгүй гэж хариулсан байна.
- Нийт судалгаанд хариулагчдын 84.3% (43) нь биеийг нь хүчээр үнэлүүлэх, 76.5% (39) нь бэлгийн мөлжлөг, 47.1% (24) нь албадан хөдөлмөр эрхлүүлэх, 35.3% (18) нь хуурамч гэрлэлтийн хэлбэрүүд Монгол улсад давамгайлж байна гэсэн бол 5.9% (3) нь тээгч эхийн асуудлыг ХХГХ-ийн төрөл, хэлбэр гэж үзсэн байна.
- Судалгаанд оролцогчдоос ХХГХ-ийн гомдол мэдээллийг хүлээн авч, хянах, шүүх хуралдаанд улсын яллагчаар оролцож байсан уу гэхэд 15.7% (8) нь тийм гэсэн бол 84.3% (43) нь үгүй гэжээ.
- Прокурор нараас эрүүгийн хэрэгт хяналт тавих, шүүх хуралдаанд улсын яллагчаар оролцож байхдаа хохирогчтой ажиллахдаа хэрэглэдэг тусгай арга, техник, журам, асуумж байдаг гэж 5 хүн буюу 9.9% нь хариулсан ба дэлгэрэнгүй лавлахад “хууль, прокурорын аргачилсан заавар байдаг”, “хохирогчтой уулзах, түүний сэтгэл зүйн байдалд тохируулан харилцаж мэдээлэл авдаг” гэсэн байна.
- Хохирогчтой ажиллах тусгай журам заавар байдаггүй гэж 84.3% (43) нь үзсэн нь цаашид хууль хэрэгжүүлэгч байгууллагад хохирогчтой ажиллах заавар, стандарт, журмыг боловсруулах, алба хаагчдыг энэ чиглэлээр мэргэшүүлэх, үйл ажиллагаанд хэрэгжүүлэх хэрэгцээтэй байгааг харуулж байна.
- ХХГХ-ийг бусад зохион байгуулалттай гэмт хэргүүдтэй хамт үйлдэгдэж байна гэж судалгаанд оролцогчдын 45.1% (23) үзсэний 35.3% (18) нь хар тамхи, 23.5% (12) нь цахим гэмт хэрэг, 11.8% (6) нь биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэгтэй гэж үзсэн бол 35.3% (18) нь мэдэхгүй, 19.6% (10) нь үгүй гэж хариулжээ.
- Судалгаанд хариулагч нараас 2012 онд батлагдсан “Хүн худалдаалахтай тэмцэх” тухай хуулийн зарчмуудын хэрэгжилтэд 50%-с дээш хувь (26+) нь “Хангалтгүй” гэсэн үнэлгээг өгсөн байна.
- Прокурорыг хяналт тавих явцад ХХГХ-ийн хохирогч, гэрчийн аюулгүй байдлыг хамгаалах чиглэлээр нэг л удаа хүсэлт, гомдол гаргаж байсан ба прокурор чиг үүргийн дагуу хохирогчийг хамгаалах аюулгүй газар байрлуулж байсан байна.
- Судалгаанд хамрагдагсдын 52.9% (27) нь ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр төрийн байгууллагаас зохион байгуулж буй сургалтад хамрагдаж байгаагүй ба сургалтад хамрагдсан 24 прокурор нараас 33.3% (8) нь л сургалтын үр дүн сайн байсан гэж хариулсан байна. Мөн ХХГХ-ийн чиглэлээр төрийн бус болон ОУБ-аас зохион байгуулсан сургалтад 88.2% (45) нь хамрагдаж байгаагүй байна. Хууль сахиулах байгууллагын алба хаагчдад зориулсан сургалтыг бодит кейс дээр ажиллах, оролцоонд суурилсан, багаар ажиллах аргачлалаар зохион байгуулах нь үр дүнтэй гэж 86.3% (44) хариулсан бол багш лекц унших аргачлалыг 7.8% (4) санал болгосон байна.
- Прокурорын байгууллагад ХХГХ-ийн чиглэлээр тусгайлсан сургалт байдаг гэж 45.1% (23) нь хариулсан байхад 5.9% (3) нь энэ чиглэлийн сургалт байдаг эсэхийг мэдэхгүй гэж хариулсан байна.
- Нийт судалгаанд оролцогчдын тал орчим хувь нь ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр илүү нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх ажиллагаа, урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах, таслан зогсоох, хохирогч, гэрчээс мэдүүлэг авах ажиллагаа, байгууллагуудын хамтын ажиллагаа зэрэг асуудлаар илүү сургалт авах хүсэлтэйгээ илэрхийлсэн байна.
- Прокурорын байгууллагад ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр мэргэшсэн албан тушаалтан бэлтгэх шаардлагатай гэж 92.2% (47) нь хариулснаас үзэхэд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд тусгай прокурор, илүү мэргэшсэн түвшинд ажиллах хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.
- ХХГХ-ийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах үе шатанд Прокурорын хяналтыг хэрэгжүүлэхэд хохирогчийн зүгээс эрүүл мэнд, хууль зүй, сэтгэл зүйн үйлчилгээ авах хүсэлтийг 3.9% (2)-д гаргаж байсан бол 94.1% (48) нь ийм хүсэлт хүлээж авч байгаагүй гэжээ. Хүсэлт гаргаж байсан хохирогчдод “сэтгэл зүйн үйлчилгээнд хамруулах” туслалцаа үзүүлэх арга хэмжээ авч байсан байна.
- Прокурорын байгууллагын алба хаагчдаас ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр шүүх эрх мэдэл, хууль

сахиулах, төрийн, төрийн бус болон олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааны өнөөгийн байдлыг тодруулахад 58.8% (30) нь хангалтгүй, 33.3% (17) нь мэдэхгүй гэж хариулжээ.

- Прокурор нарын хувьд учирч буй бэрхшээлд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа олон үе шаттай болсон, прокурорын ажлын ачаалал ихэссэн, ХХГХ-ийн зүйл анги нь 2002 оны зохицуулалтаас дордсон, биеэ үнэлэх, зохион байгуулах явцад ашиг олж, хүнийг мөлжсөн бол хэрхэн шийдвэрлэх нь тодорхой бус, гэмт хэрэгт тооцохгүй, зөрчил гэж үзэх болсон зэрэг хүндрэлүүд байгааг онцлон илэрхийлж байлаа.
- Судалгаанд оролцогчдоос ХХГХ-ийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ялангуяа шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж 52.9% (27) нь үзсэн ба тухайлбал нэгдсэн ойлголт өгөх, практик дадлага олгох нэгдсэн стандарт бүхий сургалтуудыг тодорхой үе шаттай зохион байгуулах, гадаад улс орны туршлагыг судлах, албан хаагчдыг мэргэшүүлэх чиглэлээр ажиллах шаардлагатай байна гэсэн чухал саналууд гарсан байна.

4) Гадаадын иргэн, харьяатын газар (Судалгаанд нийт 18 алба хаагч оролцсон)

- ГИХГ-ын алба хаагчдын 44.4% (8) нь ХХГХ нь бэлгийн болон албадан хөдөлмөрийн мөлжлөг, хүний эд эрхтнийг авах явдал гэсэн ойлголттой байна. 27.8% (5) нь ХХГХ-ийг хүнийг мөлжих зорилгоор хууран мэхлэх, хохирогчийг хорих, хүний эрхийн эсрэг гэмт хэрэг, зохион байгуулалттай гэмт хэрэг, хүчээр хүний биеийг үнэлүүлэх гэсэн ойлголттой байсан бол 27.8% (5) нь мэдэхгүй, хариулахыг хүсээгүй (3 хүн) байна.
- ГИХГ-ын алба хаагчдаас 1 л хүн ХХГХ-ийн хэргийн шинжтэй үйлдэл гарч байсан ба хохирогчдод зөвлөгөө, мэдээлэл өгсөн гэж хариулжээ.
- Судалгаанд оролцогчдын 44.4% (8) нь улсын байцаагч хяналт, шалгалтын явцад ХХГХ-ийн талаар мэдээлэл авч, нотлох баримт цуглуулах боломжтой гэж хариулсан бол 38.9% (7) нь боломжгүй гэж хариулсан байна. Судалгаанд оролцогчдын 11.1% (2) нь нотлох баримтыг ямар аргаар хэрхэн яаж цуглуулахыг “мэдэхгүй” гэж хариулжээ. Хуулиар хүлээсэн үүргийн дагуу холбогдох албан хаагчид нь баримт бичиг шалгах аас өөрөөр нягтлан шалгах үйл ажиллагаа явуулах эрхгүй гэдгээ тайлбарласан байна.
- Гадаадын иргэн ХХГХ-т өртсөн тухай мэдээллийг

авч байгаагүй гэж судалгаанд оролцогчдын 77.8% (14) хариулсан байна. Энэ тухай мэдээллийг оролцогчдын 16.7% (3) нь авч байсан бөгөөд БНХАУ, Тайланд улсын иргэд байсан гэжээ. Гадаадын иргэн Монгол Улсад ХХГХ-т өртөх эрсдэл байна гэж эдгээр алба хаагчид үзсэн бөгөөд гол шалтгаан нь ажлын хөлсийг олгохгүй, цалин хөлсний зөрчил байдаг гэсэн байна.

- Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхэд үрчлүүлэх нь ОУБ-аар дамжуулан хуулийн дагуу үйлдэгддэг, суурь өвчтэй хүүхдийг үрчилж аваад сайхан өсгөж байгаа тохиолдол байгаа, ГААГ-ийн конвенцийн дагуу хууль хэрэгждэг, эрсдэлтэй нөхцөл байдал нотлогдоогүй, ГИХГ үрчлэгдсэн хүүхдүүдэд маш сайн хяналт тавьдаг зэрэг тодорхой учир шалтгааныг үндэслэн ХХГХ-ийн эрсдэл үүсэхгүй гэж судалгаанд оролцсон алба хаагчдын 77.8% (14) үзэж байна.
- Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай болон Гэр бүлийн тухай хуульд зааснаар гадаадын иргэнд үрчлэгдэж байгаа Монгол Улсын харьяат хүүхдийн асуудлыг шийдвэрлэхэд ГИХГ болон Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар (ОӨУБЕГ)-ын эрх үүрэг, хариуцлага тодорхой байдаг гэж оролцогчдын 55.6% (10), тодорхойгүй гэж 16.7% (3) хариулсан бөгөөд 27.8% (5) нь мэдэхгүй гэсэн байна.
- Судалгаанд оролцогчдын 22.2% (4) нь хохирогчтой харьцахдаа баримтлах тусгай тогтсон стандарт арга техник, журам, асуумж байхгүй, 66.7% (12) нь мэдэхгүй гэж хариулсан байгаа тул холбогдох стандарт арга техник, журам, асуумжийг боловсруулах, сайжруулах, гарын авлага болгон алба хаагч бүрд хүртээмжтэй тараах, хохирогчийг таньж илрүүлэх, холбогдох арга хэмжээ авах сургалтыг зохион байгуулах хэрэгцээ байна.
- ХХГХ-ийг илрүүлэх, шалгахад ТББ-тай хамтран ажилладаг гэж оролцогчдын 33.4% (6) хариулжээ. Энэхүү хамтын ажиллагааг мэдээлэл солилцох, уулзалт зохион байгуулах, буцах зардал, торгуулийн мөнгөнд туслуулах, ТББ-ыг шалгах зэрэг арга хэмжээгээр хэрэгжүүлдэг байна.
- Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн зарчмуудын хэрэгжилтийг “хангалтгүй” гэж алба хаагчдын 33.4% (6) үнэлсэн байгаа нь анхаарал татахуйц мэдээлэл болж байна.
- Алба хаагчдын 55.6% (10) нь ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр төрийн зүгээс явуулж буй мэргэшүүлэх ямар ч сургалтад хамрагдаж байгаагүй гэжээ. Судалгаанд оролцсон алба хаагчид цаашид

сургалтыг “бодит кейсүүд дээр ажиллах” хэлбэрт илүү ач холбогдол өгсөн оролцогчдын 77.8% (14) нь санал болгосон байна. Мөн “багаар ажиллах” хэлбэрийг оролцогчдын 55.5% (10) нь дэмжиж байгаагаар илэрхийлсэн байна. Сургалтын интерактив арга 27.8% (5)-ийн дэмжлэг авчээ. Судалгаанд оролцсон алба хаагчид “гадагшаа танилцах аялал хийх”, “бусад орны туршлагаас суралцах” саналаа “бусад” гэсэн хэлбэрт илэрхийлсэн байна.

- ГИХГ-аас судалгаанд оролцсон алба хаагчдын 55.6% (10) нь ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр төрийн бус болон ОУБ-аас зохион байгуулсан сургалтад хамрагдаж, 44.4% (8) нь энэ төрлийн сургалтад өмнө огт хамрагдаж байгаагүй байна.
- ГИХГ-т ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр мэргэшсэн албан тушаалтан бэлтгэх шаардлагатай гэж судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 88.9% (16) үзэж байна. Судалгаанд оролцогчдын 83.3% (15) нь ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр зохион байгуулалтын дараах арга хэмжээ авах ёстой гэж үзэж байгаагаар илэрхийлжээ.

5) Хил хамгаалах ерөнхий газрын Хилийн шалган нэвтрүүлэх алба (Судалгаанд нийт 53 алба хаагч оролцсон)

- ХШНА-аас судалгаанд оролцсон алба хаагчид хүний эрх, эрх чөлөөнд халдах (18.9%-10), хөдөлмөрийг мөлжих (13.2%-7), ноцтой гэмт хэрэг (13.2%-7), бэлгийн мөлжлөг (11.3%-6), хүчээр биеийг нь үнэлүүлэх (7.5%-4), хүний эд эрхтнийг зарах (7.5%-4) зэргийг ХХГХ гэж үзэж байна. ХХГХ-ийн аль хэлбэрүүд Монгол Улсад давамгайлж байна вэ гэсэн асуултад биеийг нь хүчээр үнэлүүлэх, бэлгийн мөлжлөгт байлгах, албадан хөдөлмөр эрхлүүлэх хэлбэрүүд давамгайлж байна гэж судалгаанд оролцогчдын дийлэнх нь үзжээ. Оролцогчдын 17% (9) нь ХХГХ-ийн ямар хэлбэрүүд Монгол Улсад давамгайлах болсныг “мэдэхгүй” гэсэн байна.
- Хувь хүний зан байдал, төлөвшил 3.8% (2), нийт иргэдийн дунд мэдээлэл дутмаг 5.7% (3) байгаа нь ХХГХ-т өртөхөд нөлөөлж байна гэж мэргэжлийн байгууллагын алба хаагчид үзэж байгаа нь ХХГХ-ийн талаарх ойлголт, мэдлэгийг олон нийтэд таниулахад төслийн зүгээс хувь нэмэр оруулах хэрэгцээ байж болох юм. ХХГХ гарахад ямар хүчин зүйлс нөлөөлж байгааг “мэдэхгүй” гэдгээ оролцогчдын 11.3% (6) илэрхийлсэн байна.
- ХХГХ-ийн шинжийг илрүүлсэн тохиолдолд нотлох баримт цуглуулахдаа оролцогчдын 43.4% (23) нь гэрч, хохирогчийн мэдүүлэг авна, 30.2% (16) нь бичиг баримтад үзлэг хийнэ, 22.6% (11) нь

баримтжуулалт хийнэ гэсэн байна. Тагнуулын байгууллага журмын дагуу ажилладаг гэж 3.8% (2) нь хариулсан байна. ХХГХ-ийн шинжийг илрүүлсэн тохиолдолд юуг нотлох баримт гэж үзэх тухайд саналаа илэрхийлсэн оролцогчдын 43.4% (23) нь иргэний бичиг баримтыг, 20.8% (11) нь фото зураг, 20.8% (11) нь дүрс бичлэгийг ХХГХ-ийн нотлох баримт гэж үзнэ гэжээ

- ХШНА-ны судалгаанд оролцсон алба хаагчдын 54% (29) нь эмэгтэйчүүдийг хүүхэд тээлгэх зорилгоор худалдаалдаг талаар сонсож байгаагүй байна. Хүүхэд тээлгэх зорилго нь сайн дурын үндсэн дээр харилцан тохиролцсон байвал танин мэдэх, таслан зогсооход хүндрэлтэй, эх, хүүхэд хоёрын амь насанд эрсдэлтэй, жирэмсэн эсэхийг нь мэдэх боломжгүй, тээгч эх гэдгийг нотлоход хүндрэлтэй зэрэг олон хүндрэл бэрхшээл байдгийг алба хаагчид дурдсан байна. Хүүхэд тээлгэх зорилготой ХХГХ-ийг илрүүлэхэд учирч болох хүндрэл бэрхшээлийг “мэдэхгүй” гэж судалгаанд оролцогчдын тал хувь нь хариулсан байна.
- Эрсдэлтэй гэж үзсэн ХХГХ-ийн хохирогчийг илрүүлэх тусгай арга техник, журам ашигладаг гэж судалгаанд оролцогчдын 13.2% (7), ашигладаггүй гэж 77.4% (41) нь хариулсан байна.
- Судалгаанд оролцогчдын 34.9% (18.5) нь ХХГХ-тэй тэмцэх хуулийн зарчмуудын хэрэгжилт болон хохирогчийг хамгаалах хүний эрхэд суурилсан хэм хэмжээ, стандартын хэрэгжилт ямар түвшинд байгааг “мэдэхгүй” гэж хариулжээ. Олон улсын хамтын ажиллагаа, иргэний нийгмийн оролцоонд түшиглэх зарчмуудын хэрэгжилтийг хамгийн олон буюу оролцогчдын 47.1% (25), олон улсын стандарт, гэрээ, конвенцийн хэрэгжилтийг оролцогчдын 37.7% (20) нь “мэдэхгүй” гэсэн байна
- ХШНА-аас судалгаанд оролцсон алба хаагчдын 67.9% (36) нь ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр төрийн зүгээс явуулж буй мэргэшүүлэх ямар ч сургалтад хамрагдаж байгаагүй гэжээ. Алба хаагчдын 56.6% (30) нь ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр төрийн бус болон ОУБ-аас зохион байгуулсан сургалтад хамрагдаагүй байна.
- ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр ХШНА-ны алба хаагчдад зориулсан тусгайлсан сургалт явуулсан гэж судалгаанд оролцогчдын дөнгөж 18.9% (10) хариулсан бөгөөд 69.8% (37) нь ийм сургалт явуулдаггүй гэж хариулсан байгаа нь “ХХГХ-ийн хохирогч төвтэй мөрдөн байцаалт, прокурорын хяналтыг сайжруулах нь” төслийн үйл ажиллагааны хүрээнд зохих анхаарал хандуулах хэрэгтэй байна

- Судалгаанд оролцогчдын олонх буюу 90.6% (48) нь ХХГХ-ийн талаарх ерөнхий ойлголт өгөх сургалт мэдээлэл хэрэгтэй гэж үзэж байна.
- Судалгаанд оролцогчдын санал болгож байгаа сургалтын чанар, үр дүнг сайжруулах, ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр зохион байгуулалтын зарим арга хэмжээ авах тухай саналуудад анхаарч сургалт, мэдээллийн хөтөлбөрөө боловсруулах нь төслийн хэрэгжилтэд хувь нэмрээ оруулах болно.

6) Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид (Судалгаанд нийт 20 хүн оролцсон)

- Судалгаанд оролцогчдын 45% (9) нь эх орон дотроо, 55% (11) нь хилийн чанадад ХХГХ-ийн хохирогч болж байсан байна. Тэдний 20% (4) нь насанд хүрээгүй байхдаа улс дотроо бэлгийн мөлжлөгийн хохирогч болж байжээ. Хохирогчид өөрийн эх орон дотроо болон хилийн чанадад байгаагаасаа үл хамаарч цалин хөлсгүй ажиллаж, ар гэр, ойр дотных нь хүнтэй холбоо бариулахгүй, бэлгийн, бие махбодын хүчирхийлэлд байлгаж, анх амлаж байснаас өөр ажлыг хүчээр хийлгэсэн байна.
- Хохирогчдын 90% (18) нь тухайн газарт очиж, хүчээр биеэ үнэлэх нөхцөл, байдалд орсныхоо дараа л ХХГХ-ийн хохирогч болсноо мэдсэн байгаа нь хохирогчид мэдээлэл муутай, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа хангалтгүй байгаатай холбоотой гэж үзэж болохоор байна.
- ХХГХ-т өртөж буй хамгийн гол шалтгааныг дурдахдаа бусад бүлгүүдээс ялгаатай хариулт өгсөн нь анхаарал татсан юм. Гэр бүлийн таагүй орчин буюу эцэг эхийн таарамжгүй байдал, хойд эцэг, эх, гэр бүл салалт, гэр оронгүй амьдарч байгаа, гэр бүлийн хүчирхийлэл зэрэг нөхцөлүүдийг оролцогчдын 85% (17) нь дурдсан байгаагаас харвал ажилгүйдэл, ядуурлаас гадна гэр бүл рүү чиглэсэн үйл ажиллагаа дутмаг байгаатай холбоотой байна. Ажилгүйдэл (45%-9), ядуурал (40%-8) ХХГХ-т өртөх хоёр дахь болон гурав дахь хүчин зүйлс болсон байна. Гэр бүлийн таагүй байдлаас зугтаасан охид, эмэгтэйчүүд энэ гэмт хэрэгт өртөх эрсдэл өндөр байгааг энэхүү судалгааны дүн харуулж байна.
- Хохирогчид ХХГХ-ийн нөхцөл байдлаас аврагдах, зугтаж гарах нийтлэг арга зам, төгс жишээ байдаггүй гэдгийг 20 хохирогч тус бүр 14 өөр аргаар аврагдаж, зугтсанаас харж болно. Тэд боломжтой хугацааг байнга хүлээж, тооцож, судалж байдаг бөгөөд үүнд зөвхөн хохирогчийн тооцоолол, төлөвлөгөөнөөс гадна бусад хүчин

зүйлүүд нөлөөлж биеллээ олдог гэж үзэж болно.

- Хохирогчдын 5 хүн тутмын 4 нь хуулийн аль нэг шатны байгууллагад гомдол гаргаж, эдгээр гомдлын 4 хэрэг тутмын 3-т шүүхээс гэмт буруутай этгээдүүдэд ял шийтгэл оногдуулсан байна. Энэ тооноос харвал ямар нэг байдлаар шүүхийн шат хүртлээ явсан хэрэг шийдвэрлэгдэх боломжтой гэж үзэж болохоор байна. Гэвч судалгаанд оролцохыг зөвшөөрсөн хохирогчдын дийлэнх нь хуулийн байгууллагаар асуудлаа шийдвэрлүүлж чадсан хохирогчид байсан тул үр дүн ингэж гарсан байх магадлалтай. Харин хуулийн байгууллагад хандаад хэрэг нь хэрэгсэхгүй болсон, асуудлаа шийдүүлж чадаагүй хохирогчид үл итгэх байдлаар хандаж, 31 хүнээс 11 хүн судалгаанд оролцохыг зөвшөөрөөгүй нь хуулийн байгууллагад хандах итгэл нь алдагдсантай холбоотой гэж үзэж байна.
- Хохирогчдын үзэж байгаагаар хуулийн байгууллагын ажилтнуудын харьцаа, хандлага эерэг байсан боловч, зарим ажилтан албан хаагчдын зүгээс олон таагүй харьцаа гаргаж байсан тухай өгүүлсэн байна. Ихэнхдээ тэднийг өөрсдийг нь буруутгах, хэргийг сунжруулах, олон дахин явуулахаас гадна гаднын өөр хүмүүсийн дэргэд байцаалт авдаг нь тэдэнд сөрөг сэтгэгдэл төрүүлж байсан байна.
- Судалгаанд хамрагдсан хоёр хүн л аюулгүйн зэргийн байдлаа тогтоолгож хамгаалалт авч байсан гэж хариулсан нь нэг талаар хохирогчид энэ талаар хүсэлт гаргаж мэдэхгүй байгаатай, нөгөө талаар ихэвчлэн ТББ-ын хамгаалалтад орсон тул өөр нэмэлт хамгаалалт шаардлагагүй байсантай холбоотой гэж үзэж байна.
- Хохирогчдын 10 хүний 9 (80%) нь ТББ-аас дөрвөөс дээш төрлийн туслалцаа авсан нь ТББ-ын үзүүлж буй үйлчилгээ цогц байгааг харуулж байна. Бүх хохирогчид эдийн засаг, сэтгэл санаа, эрүүл мэндийн хохирол бий болсноос гадна нэр төрөө алдаж, гэр бүлийн гишүүдийн зүгээс харьцах харьцаа нь өөрчлөгдөж, зарим ах дүүстэйгээ холбоогоо тасалсан байна.
- Хохирогчдын хохирол барагдуулалт хангалтгүй, зарим тохиолдолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар гаргуулахаар шийдвэрлэдэг боловч амжилттай шийдвэрлүүлсэн тохиолдол байхгүй байгаа нь хүндрэл учруулдаг. Хохирогчид энэ гэмт хэргийн хохирлыг барагдуулж өгөх, хэт удаан хуулийн байгууллагаар явдаг процессыг халж өгөхийг хууль, хяналтын болон төрийн байгууллагуудаас хүсэж байна.

БҮЛЭГ 1.

**СУДАЛГААНЫ
АРГА ЗҮЙ**

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

1.1. Судалгааны зорилго

- Монгол Улсын ХХГХ–тэй холбоотой өнөөгийн хууль тогтоомж, бодлогуудыг нягтлан судлах, тэдгээрийн Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцтэй хэрхэн нийцэж байгаа байдлыг судлах;
- Монгол Улсад ХХГХ–тэй тэмцэх чиглэлээр явагдаж байгаа сургалтын материал, гарын авлага, хөтөлбөрүүдийг судлах;
- Хууль сахиулах алба хаагчид, прокурор, шүүгч, хил хамгаалах болон ГИХГ–ын алба хаагчдын дунд ХХГХ, хохирогч төвтэй аргачлалын талаарх ойлголт, мэдлэг, чадвар, чадавхыг үнэлэх;
- ХХГХ–ийн хохирогчдод үзүүлж буй үйлчилгээний хүртээмж, хамрагдах боломж, чанар, хууль эрх зүйн үйлчилгээ авахад хохирогчид тулгарч буй саад, хууль эрх зүйн үйлчилгээ үзүүлдэг төрийн байгууллагуудын хандлага, хохирогчдын аюулгүй байдал, эрүүл мэнд, сэтгэл зүйн байдалд хэрхэн анхаарч буй хандлагыг судлах;
- Дээрх судалгаануудад дүгнэлт гаргах, санал асуулгад оролцогчдын ойлголт, мэдлэг, чадварын ялгаа, сул болон давуу талуудыг хамруулан судалгааны үр дүнг нарийн тодорхойлсон тайлан боловсруулах.
- Тус судалгааны тайланд судалгааны явцад илэрсэн хохирогч төвтэй аргачлалын талаарх мэдлэг, ойлголтын зөрүүтэй байдлыг арилгах, хууль тогтоомж, бодлогуудын талаарх ойлголт, хэрэглээг сайжруулах тусгайлсан санал зөвлөмж боловсруулах.

1.2. Судалгааны зорилтууд

Тус судалгаа нь үндсэн 3 зорилгын хүрээнд дараах зорилтуудыг тавьж ажилласан.

1. Монгол Улсын ХХГХ–тэй холбоотой өнөөгийн хууль тогтоомж, бодлогуудыг нягтлан судлах, тэдгээрийг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцтэй хэрхэн нийцэж байгаа байдлыг судлах; Үүнд
 - 1.1 Палермогийн протоколын ХХГХ–ийн эрүүгийн эрх зүйн шинж Монгол Улсын ЭХ–д хуульчлагдсан талаар,
 - 1.2 Палермогийн протоколын ХХГХ–ийн хохирогчийг хамгаалах хэм хэмжээ Монгол Улсын хууль тогтоомжид хуульчлагдсан талаар,
 - 1.3 Палермогийн протоколын ХХГХ–ээс урьдчилан

сэргийлэх хэм хэмжээ Монгол Улсын хууль тогтоомжид хуульчлагдсан талаар.

2. Монгол Улсад ХХГХ–тэй тэмцэх чиглэлээр явагдаж байгаа сургалтын материал, гарын авлага, хөтөлбөрүүдийг судлах; Үүнд:
 - 2.1 Монгол Улсад ХХГХ–ийн талаар хэвлэгдсэн ном бүтээлүүдийг цуглуулж тухайн номын давуу талыг нь товч тэмдэглэж авах, түүндээ дүгнэлт хийх,
 - 2.2 Нэгэнт хэвлэгдсэн ном, гарын авлагууд нь өөр хоорондоо агуулгын давхцал байгаа эсэх, агуулга зөрүүтэй бол ямар байдлаар ялгарч байгааг матрицаар харуулах,
 - 2.3 Хамгийн бага давхцалтай байгаа бүлгийг олж илрүүлэх, цаашид шинээр цогц сургалтын материал боловсруулах нөхцөл боломжийг бүрдүүлэх.
3. Хууль сахиулах алба хаагчид, прокурор, шүүгч, хил хамгаалах болон ГИХГ–ын алба хаагчдын дунд хохирогч төвтэй аргачлалыг хэрэглэх чадавхыг үнэлэх судалгаа:
 - 3.1 Улаанбаатар хот болон сонгогдсон 4 орон нутгаас ойролцоогоор 300 хууль сахиулах алба хаагч, прокурор, шүүгч, хил хамгаалах болон ГИХГ–ын алба хаагчдаас анкетын аргаар асуулга авах замаар мэдээлэл цуглуулах,
 - 3.2 Асуулгад оролцох алба хаагчдыг удирдах, гүйцэтгэх болон дунд шатны төлөөллүүдээс оролцуулан сонгох,
 - 3.3 ХХГХ–ийн хохирогчдоос асуулга авах замаар мэдээлэл цуглуулна.
 - 3.4 Судалгааны үр дүнд суурилсан нэгтгэсэн дүгнэлтийг гарган улмаар зөвлөмжийг боловсруулах гэсэн зорилтыг тавин ажилласан.

1.3. Судалгааны түүвэр

Судалгаанд магадлалт бус, зорилтот түүвэрлэлтийн арга зүйг ашиглалаа. Судалгаанд Улаанбаатар хот, Дорноговь аймгийн Замын–Үүд сум⁹, Өмнөговь аймаг, Гашуун сухайт боомт¹⁰, Дорнод аймаг, Хавиргын боомт¹¹, Сэлэнгэ аймаг, Алтанбулагийн боомт¹²–ыг хамруулсан.

⁹ Улаанбаатар хотоос Замын–Үүд сум явахад нэг талдаа 750 км–ийн зайтай

¹⁰ Улаанбаатар хотоос Өмнөговь аймаг, Гашуун сухайтын боомт явахад нэг талдаа 895 км–ийн зайтай

¹¹ Улаанбаатар хотоос Дорнод аймаг, Хавиргын боомт явахад нэг талдаа 792 км–ийн зайтай

¹² Улаанбаатар хотоос Сэлэнгэ аймаг, Алтанбулагийн боомт явахад нэг талдаа 341 км–ийн зайтай.

Хүснэгт: Судалгаанд хамрагдсан алба хаагчдын тоо байршил, албан байгууллагаар

Байгууллагын нэр	Цагдаагийн байгууллага	Шүүх	Прокурор	ХХЕГ-ын ХШНА	ГИХГ	Хохирогч	ДҮН
1 Улаанбаатар хот	160 (16 газар)	29	39	16	10	-	254
2 Орон нутаг	40 (4 хэлтэс, газар)	10	12	37	8	-	107
3 ХХГХ-ийн хохирогч	-	-	-	-	-	20	20
Нийт	200	39	51	53	18	20	381

БҮЛЭГ 2.

СУДАЛГААНЫ ҮЙЛ ЯВЦЫН ТАНИЛЦУУЛГА

СУДАЛГААНЫ ҮЙЛ ЯВЦЫН ТАНИЛЦУУЛГА

2.1. Судалгааны асуулга

Зургаан төрлийн асуулгыг боловсруулахдаа дараах материалуудыг ашигласан бөгөөд судалгааны асуумж, удирдамжийг туршилтын судалгааны явцад тухай бүрд нь засаж сайжруулсан болно.

1. “Бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэргийн талаарх ойлголт, мэдлэг, хандлага” судалгаа, 2002 он, УБ хот, Дэлхийн Зөн, ХТЭТ
2. “Үйлчилгээний газрыг түшиглэсэн охид, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт ба биеэ үнэлэгчдийн асуудал” судалгаа, 2005–2006 он, УБ хот, Олон улсын хөдөлмөрийн байгууллага, ХТЭТ
3. “Монгол Улс дахь хүн худалдах гэмт хэрэг: Эрсдэл, эмзэг байдал, хор уршиг” судалгаа, 2006 он, АС, ХТЭТ
4. “Биеэ үнэлэгч болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхэд” судалгаа, 2010 он, Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Үндэсний статистикийн хороо, ХТЭТ
5. “ХХГХ–ийн хохирогчдын аюулгүй байдал, өртөх эрсдэл, хохирол” судалгаа, 2015 он, Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага, ХТЭТ
6. “Тодорхой төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны өртөг, зардал: ХХГХ–ийн жишээн дээр” бодлогын судалгаа, 2016 он, Нээлттэй нийгэм хүрээлэн, ХТЭТ

Судалгааны асуулгыг боловсруулахдаа мэргэшсэн цагдаагийн албан хаагч, судлаач багш нараас зөвлөгөө авч засан сайжруулалт хийхийн зэрэгцээ АС–ийн төсөл хариуцсан ажилтнууд, зөвлөхийн зөвлөгөө, саналыг авч эцсийн боловсруулалт хийгдсэн.

Асуулгын бүтэц нь ХХГХ–ийн ойлголт, мэдлэг, хандлага, төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагын зүгээс явуулсан сургалтын агуулга, чанар, үр дүнг үнэлэх, хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд үнэлгээ өгөх, хууль сахиулах байгууллагын алба хаагчид, прокурор, шүүгч, хил хамгаалах, ГИХГ–ын алба хаагчдын хамтын ажиллагаа, цаашид анхаарах асуудал, саналыг авах гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.

2.2. Туршилтын судалгаа

Цагдаагийн байгууллага, шүүх эрх мэдлийн байгууллага, прокурорын байгууллага, ХХЕГ–ын ХШНА, ГИХГ–ын алба хаагчдаас авах асуулгуудыг турших судалгааг 2017 оны 08–р сарын 11–14–ний хооронд Улаанбаатар хотод зохион

байгуулсан. Туршилтын судалгаанд нийт 4 багийн 8 судлаач оролцож, 14 холбогдох албан хаагчдыг бэлтгэсэн асуумжийн дагуу ярилцлагад хамруулсан. Багууд туршилтын судалгааны тайланг дэлгэрэнгүйгээр бичиж өгсөн бөгөөд нийт 30 орчим санал гарсныг нэгтгэн 6 төрлийн асуулгыг засан сайжруулсан. Судалгааны асуулгатай холбоотой гарсан эргэлзээтэй асуудлуудыг нэг бүрчлэн тодруулах, асуулгаа дахин сайжруулахад АС–ийн мэргэжилтэн, зөвлөхүүдийн саналыг мөн адил нэгтгэн тусгаж, эцэслэн боловсруулалт хийгдэж дууссан.

2.3. Сургалт

Судалгааны ажлыг чанартай сайн гүйцэтгэх, нэгдсэн ойлголттой болох, анхаарах асуудал, шаардлага хангасан мэдээлэл цуглуулах үүднээс судалгааны багийн гишүүдийг сургалтад хамруулсан. Сургалтаар судалгааны үндсэн зорилго, түүвэрлэлтийн төрөл, хэлбэр, түүврийн хэмжээ, судалгааны үе шатны ажлууд болон ярилцлага хийх, эрсдэлт бүлгийн асуулгад хэрэглэгдэж байгаа нэр томьёо, ойлголтуудыг тайлбарлан, асуулгын хуудсыг хэрхэн нөхөх тухай дэлгэрэнгүй зааварчилгааг өгч, нийгмийн судалгаа авахад баримтлах ёс зүйн гарын авлага боловсруулж сургалтад ашигласан. Сургалт “Holiday Inn” зочид буудлын сургалтын танхимд 2017 оны 08–р сарын 15–ны өдөр явагдсан.

2.4. Мэдээлэл цуглуулалт, боловсруулалт

Судалгааны багт ХТЭТ–ийн судлаачид болон иргэний нийгмийн байгууллага (ИНБ)–ын мэргэшсэн нийгмийн ажилтнууд ахлан жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх, хохирогчдод үйлчилгээ үзүүлдэг “Хөөрхөн зүрхнүүдийн аян”, “Өсвөр үеийнхний хөгжлийн төв”, “Цөлийн Сарнай”, Дорнод аймгийн “Эрүүл–Боломж” зэрэг мэргэшсэн төрийн бус байгууллагуудын нийгмийн ажилтан нар, мөн ХСИС–ын судлаач багш нарыг ажиллуулсан. Судалгааны багийн ахлагч нарын удирдлага дор багууд судалгаанд хамрагдагч нэг бүртэй уулзаж, ярилцлага авах замаар мэдээллээ цуглуулсан.

Судалгааны асуулгыг шалгаж, хүлээн авч, мэдээллийг кодлон, компьютерт шивж, мэдээллийн баазыг үүсгэсэн. Зургаан бүлэг тус бүрийн анкетын асуулга тус бүрд мэдээллийн бааз үүсгэн SSPS 22.0 судалгааны багц программын тусламжтайгаар боловсруулалтыг хийх ажлыг Монгол Улсын Их Сургуулийн Хүн Амын Сургалт Судалгааны Төвийн дэмжлэгтэйгээр гүйцэтгэв.

2.5. Судалгааны давуу болон сул талууд

Судалгаанд хамтран оролцсон төрийн болон ТББ-ууд энэхүү судалгааг цаг үеэ олсон, нийгмийн эрэлт хэрэгцээтэй судалгаа гэдгийг онцолж байлаа.

Давуу тал:

- Судалгаанд мэргэшсэн ажилтнуудыг оролцуулж хамтран ажилласан нь мэдээллийг бодитой, үнэн зөв цуглуулах нөхцөлийг бүрдүүлсэн.
- Судлаачдад судалгаа авахад баримтлах ёс зүйн сургалт явуулж судлаач тус бүртэй ёс зүйн гэрээ байгуулсан нь судалгааны явцад гарч болох хүндрэл бэрхшээлийг даван туулахад ихээхэн хувь нэмрээ оруулсан.
- Багаар ажиллах арга туршлагаа гүнзгийрүүлж, хамтаар асуудлыг шийдэж байсан нь судалгааны үр дүнд эергээр нөлөөлсөн.
- Судалгаа авахад хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын удирдах ажилтнууд албан хаагчдаа идэвхтэй оролцуулах тал дээр дэмжлэг үзүүлж байсан нь судалгааны ажлыг хугацаандаа дуусгахад эергээр нөлөөлсөн.

Сул тал:

- Судалгаанд оролцсон 5 байгууллагын төлөөллүүд нийтлэгээр зарим асуултад хариулахаас татгалзаж байсан нь “мэргэжлийн болгоомжлол” байх магадлалтай гэж судалгааны багийнхан үзэж байна.
- Судалгаанд оролцогчдын дийлэнх хувь нь энэ чиглэлийн сургалтад хамрагдаагүй, мэдээлэлгүй, энэ төрлийн хэргийг шалгаж, шийдвэрлэж байгаагүй нь нарийвчилсан мэдээллийг авахад хүндрэлтэй байлаа.
- Хохирогчдын хаягаар очих, эсвэл уулзалт товлоод очиход ирэхгүй байх, ярилцлага өгөхөөс татгалзах асуудал цөөнгүй тохиолдож байсан.

2.6. Мэдээлэл цуглуулах явцад гарсан хүндрэл бэрхшээл, даван туулсан байдал, сургамж

- Зарим төрийн албан хаагч нар уулзалтын цагийг товлосон ч хугацаандаа уулзахгүй ажил хүндрүүлэх, би хариуцахгүй, өөр хүнээс асуу г.м-ээр олон удаа явуулах зэргээр хүндрэл учруулж байсан. Тиймээс тухайн судалгаанд хамрагдах байгууллагуудын удирдлагуудад хандсан албан хүсэлтийн дагуу судалгаанд хамрагдах хүнийг томилуулж ажилласан.
- Хохирогчдын талаарх мэдээллийн нэгдсэн сан байдаггүй, одоо шалгагдаж байгаа хэргүүд цөөн тул өмнө нь хохирогч болж байсан хүмүүсийг олж тогтоох, холбоо барих асуудал хүндрэлтэй байсан. Тиймээс мэргэшсэн ТББ-уудад энэ асуудлаар туслалцаа хүсэж хандаж байсан хүмүүсийн бүртгэлүүдээс шүүх, хууль хяналтын байгууллагын ажилтнуудын туслалцааг авах зэргээр ажилласан. Хамгийн гол нь хохирогчийн нууцыг алдагдуулахгүй байх гэсэн үндсэн зарчмаа баримталж ажилласан.
- Мэдээлэл цуглуулах явцад бичиг баримт шаардах, хэн гэдгийг тодруулах шаардлага тавигдах зэрэг асуудал гарахаас болгоомжилж бүх судлаачдад “Түр үнэмлэх” олгосон.
- Олон байгууллагын ажилтнууд оролцсон учир цагийг зохицуулах асуудал хүндрэлтэй байсан. Тиймээс зарим байгууллагад судалгааны мэдээлэл цуглуулах хугацаанд ажиллах боломжоор хангаж өгөх тухай албан хүсэлт явуулж зохицуулсан.

БҮЛЭГ 3.

БОДЛОГЫН СУДАЛГАА 1: ХҮН,
ЯЛАНГУЯА ЭМЭГТЭЙЧҮҮД,
ХҮҮХЭД ХУДАЛДААЛАХААС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,
ТАСЛАН ЗОГСООХ, ШИЙТГЭХ
ТУХАЙ ПРОТОКОЛ БОЛОН
МОНГОЛ УЛСЫН ЗАРИМ
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН
ХАРЬЦУУЛАЛТ

БОДЛОГЫН СУДАЛГАА 1: ХҮН, ЯЛАНГУЯА ЭМЭГТЭЙЧҮҮД, ХҮҮХЭД ХУДАЛДААЛАХААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТАСЛАН ЗОГСООХ, ШИЙТГЭХ ТУХАЙ ПРОТОКОЛ БОЛОН МОНГОЛ УЛСЫН ЗАРИМ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХАРЬЦУУЛАЛТ

3.1. Судалгааны үндэслэл

Мэдээллийн зуунд терроризм үйлдэх, хүн худалдаалах, мөнгө угаах, мансууруулах, сэтгэгээд нөлөөлөх бодис, галт зэвсгийн хууль бус эргэлттэй тэмцэх талаар Монгол Улс дэлхийн хамтын нийгэмлэгийн гишүүн улс болохын хувьд олон улс, үндэстний хэмжээнд хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах чиглэлээр улс орнуудтай хамтын ажиллагааг улам бүр идэвхжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Хүний эрхийн түгээмэл тунхаглал¹³-ын 1 дүгээр зүйл “Хүн бүр төрөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна...”, 3 дугаар зүйл “Хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй”, 4 дүгээр зүйл “Хэнийг ч боолчлох буюу бусдын эрхшээлд байлгах ёсгүй. Аливаа төрлийн боолчлол болон боолын худалдааг хориглоно” гэж тус тус тунхагласан билээ.

Мөн Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын хэлэлцээрийн¹⁴ 8 дугаар зүйлд “хэнийг ч бусдын эрхшээлд байлгах болон боол болгох, түүнчлэн албадан хөдөлмөрлүүлж буюу заавал ажилд тулгаж болохгүй” агуулга тусгалаа олсон.

Энэ ч утгаар Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлд “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасан.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2000 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн A/RES/54/263 дугаар тогтоолоор “Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцэд оруулах нэмэлт протокол”¹⁵-ыг баталж, 2002 оны 01 дүгээр сарын 18-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилжээ.

2012 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр Монгол Улсын Их Хурлаас Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль¹⁶-ийг баталж, өнөөг хүртэл хүчин төгөлдөр мөрдөж байна.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл

¹³ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 217/A/III/ тогтоолоор 1946 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталсан. Legalinfo.mn. Монгол Улсын олон улсын гэрээ

¹⁴ Legalinfo.mn. Монгол Улсын олон улсын гэрээ

¹⁵ Legalinfo.mn. Монгол Улсын олон улсын гэрээ

¹⁶ Төрийн мэдээлэл эмхэтгэл 2012 он №7 /Хуулийг батлахдаа хуулийн нэрийг бичихээ орхигдуулсан/

баримтлал¹⁷-ын 3.4.4.2-т “хүүхэд, эмэгтэйчүүд, иргэдийг хүн худалдах гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоохтой холбогдсон эрх зүйн орчныг боловсронгуй болгож энэ чиглэлд бэхжүүлнэ” гэж заасан.

НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2000 оны 11 сарын 15-ны 55/22 тоот тогтоолоор Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг нэгдсэн үндэстний байгууллагын конвенцийн нэмэлт болох хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох шийтгэх тухай протокол /цаашид Палермогийн протокол гэх/-ыг баталж, Монгол Улсын хууль тогтоох дээд байгууллага 2008 оны 05 дугаар сарын 16-ны өдөр нэгдэн орсныг соёрхон баталж хуульчилсан.¹⁸

Дараах гэмт хэргүүд үндэстэн дамнасан шинж чанартай, зохион байгуулалттай гэмт бүлэглэл үйлдсэн бол Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц үйлчлэх хэмжээ, хязгаарыг тодорхойлжээ. Үүнд:

1. Конвенцийн 6, 8, 23-р зүйлд тодорхойлсон гэмт хэргүүд
2. Конвенцийн 2-р зүйлийн нэр томъёонд тусгагдсан дөрвөөс доошгүй жилийн хугацаагаар хорих буюу онц хүнд ял оногдуулах гэмт хэргүүд
3. Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протоколын 5 дугаар зүйлийн дагуу тодорхойлогдсон гэмт хэргүүд¹⁹-ийг конвенцийн дагуу тодорхойлсон гэмт хэргүүдийн нэгэн адил авч үзнэ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж зааснаар Улсын дээд шүүхээс Монгол Улсын олон улсын гэрээг эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхэд дараах

¹⁷ Улсын Их Хурлын 2010 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн 48 тоот тогтоолоор батлагдсан.

¹⁸ “Төрийн мэдээлэл” Монгол Улсын Их Хурлын албан мэдээллийн эмхэтгэл №17 /734/ “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг нэгдсэн үндэстний байгууллагын конвенцийн нэмэлт болох хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол” 910-923 дахь тал

¹⁹ “Төрийн мэдээлэл” Монгол Улсын Их Хурлын албан мэдээллийн эмхэтгэл №17 /734/ 912 хуудас “Палермогийн протокол”-ийн 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг

тохиолдолд шууд хэрэглэхээр тайлбарлажээ. Үүнд:

- Эрүүгийн хэргийг шийдвэрлэх шүүхийн ажиллагаанд эрүүгийн процессын эрх зүйн дотоодын хуулиар тогтоосон журмаас өөр журмыг олон улсын гэрээ тогтоосон бол;
- Шүүхийн хэлэлцүүлгийн зүйл болох харилцаа (тэдгээрийн дотор гадаадын этгээдийн оролцоотой) зөвхөн олон улсын гэрээгээр зохицуулагдаж байгаа бол;

Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцэд зааснаар ХХГХ нь дараах тохиолдолд үндэстэн дамнасан шинж чанартай байна. Үүнд:

1. Зохион байгуулалттай гэмт хэрэг нэгээс илүү улсад үйлдэгдсэн,
2. Нэг улсад үйлдэгдсэн, гэхдээ гэмт хэрэг үйлдэх үе шатны бэлтгэх, завдалт, төлөвлөх, удирдах буюу хяналтын үндсэн хэсэг нь өөр улсад гүйцэтгэсэн,

3. Нэг улсад үйлдэгдсэн, гэхдээ нэгээс илүү улсад гэмт хэргийн үйл ажиллагаа явуулдаг зохион байгуулалттай гэмт бүлэглэл оролцсон,
4. Нэг улсад үйлдэгдсэн, гэхдээ бодит үр дагавар нь нөгөө улсад илэрсэн.

Энэхүү шинжүүд нь олон улсын гэрээ, конвенц, хоёр буюу түүнээс дээш улсын хамтын ажиллагаа болон үндэсний хууль тогтоомжийн зохицуулалт, шүүх эрх мэдлийн болон мөрдөн шалгах, хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааны үр дүнгээс хамаарч ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох болон нотлох ажиллагааны үр дүн, цаашилбал хэргийн шийдвэрлэлтэд нөлөөлдөг тул Палермогийн протоколыг Монгол Улсын зарим хуулиудтай харьцуулан судлах нь чухал ач холбогдолтой байна.

3.2. Судалгааг гүйцэтгэсэн тухай суурь мэдээлэл

1	Судалгааны ажлын зохион байгуулалт	Зөвлөх үйлчилгээний гэрээ, түүний хавсралтад тусгагдсан судалгааны ажлын удирдамж, зорилтот үр дүн, төлөвлөгөө
2	Судалгааны чиглэл	Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцийн нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол болон Монгол Улсын зарим хууль тогтоомжийн харьцуулалт
3	Судалгааны ажлын зорилго	Палермогийн протоколын агуулгад ХХГХ-тэй тэмцэх /урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, нотлох/-д хамаарах Монгол Улсын хууль тогтоомж нийцэж буйг судлахад энэ судалгааны ажлын зорилго оршино.
4	Судалгааны ажлын зорилт	Судалгааны ажлын зорилтын хүрээнд Палермогийн протоколыг дараах чиглэлээр харьцуулан судлан үнэлэлт, дүгнэлт өгнө. Үүнд: <ul style="list-style-type: none"> ▪ ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх Монгол Улсын хууль, тогтоомж; ▪ ХХГХ-ийн эрүүгийн эрх зүйн шинжийг тодорхойлсон ЭХ; ▪ Энэхүү гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, нотлох хэм хэмжээг агуулсан ЭХХШТХ; ▪ ХХГХ-ийн хохирогч хамгааллын Монгол Улсын хууль тогтоомж; ▪ ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр, төлөвлөгөө.
5	Гүйцэтгэсэн хугацаа	2017.07.21 – 2017.08.21
6	Судалгааг гүйцэтгэсэн үндсэн чиглэл	<ol style="list-style-type: none"> 1. Монгол Улсын олон улсын гэрээний хууль зүйн учир холбогдлыг тодорхойлох 2. Палермогийн протоколын агуулга, мөн чанарыг Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжийг батлах, тэдгээрт нэмэлт өөрчлөлт оруулах замаар тусгасан эсэх 3. Монгол Улс ХХГХ-тэй тэмцэх эрх зүйн орчноо боловсронгуй болгох, Палермогийн протоколоор хүлээсэн үүргийн биелэлт 4. ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр УИХ, Засгийн газраас баталсан үндсэн чиглэл, төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, хөтөлбөрийн агуулга мөн чанарт дүн шинжилгээ хийх 5. Хууль тогтоомж, хөтөлбөрийн уялдаа холбоо

7	Практик ач холбогдол	Судалгааны ажлын практик ач холбогдол нь Палермогийн протокол болон ХХГХ–тэй тэмцэх Монгол Улсын хууль тогтоомж дээдлэх, хэрэгжилтийг хангах талаар шүүх эрх мэдэл, мөрдөн шалгах, хууль сахиулах байгууллагын албан тушаалтан, алба хаагчдад зориулсан санал боловсруулах, судалгааны ажлыг цаашид хэрхэн үргэлжлүүлэн хийх ажлын чиглэлийг тодорхойлсон байх явдал юм.
8	Судалгааны ажлын арга зүй, аргачлал	<ul style="list-style-type: none"> – Цагдаагийн Ерөнхий газар (ЦЕГ)–ын Эрүүгийн цагдаагийн албаны Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн ХХГХ–тэй тэмцэх тасгийн алба хаагчид, эрдэм шинжилгээ, судалгаа, сургалтын болон төрийн бус байгууллагын ХХГХ–тэй тэмцэх чиглэлээр судалгаа хийж байсан туршлагатай судлаачид²⁰–тай социологийн ярилцлага хийж хууль тогтоомжийн өнөөгийн байдал, хэрэгжилтийн тулгамдсан асуудлыг тодорхойлох; – Улс дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр тэр дундаа ХХГХ–ийн эрүүгийн хэргийн шинж, шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх, хамтын ажиллагаа, нотлох ажиллагаа, улмаар гэрч хохирогчийн хамгаалал сэдвээр бичигдсэн эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл, гарын авлага, нэг сэдэвт бүтээлийг судлах; – Монгол Улсын хууль тогтоомжийн цахим сан болон Төрийн мэдээлэлд нийтлэгдсэн хууль тогтоомжийг Палермогийн протоколтой харьцуулан дүн шинжилгээ хийх; – Судалгаанд ашиглагдах бусад баримт бичиг, олон улсын гэрээ, бусад эх сурвалжийг судалж, судалгааны үр өгөөжийг дээшлүүлэхэд ашиглав.

9	Судлагдсан хууль тогтоомжийн зарим тоон мэдээлэл²¹			
	Олон улсын гэрээ	Монгол улсын хууль	Хөтөлбөр	Стандарт
	4	27	5	1

Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протоколд Монгол Улсын үндэсний хууль тогтоомж хэрхэн нийцэж байгаа талаар судлан үзвэл:

3.3. Палермогийн протоколын ХХГХ–ийн эрүүгийн эрх зүйн шинж Монгол Улсын Эрүүгийн хуульд хуульчлагдсан талаар²²

1.1. 2002 оны ЭХ–д 113 дугаар зүйлд ХХГХ тусгагдаж Монгол Улсын Дээд Шүүх 2008 оны 3 дугаар сард 12 дугаар тогтоол гарган “ЭХ–ийн 113 дугаар зүйлийг тайлбарлах тухай” албан ёсны тайлбар гаргаснаас гадна Улсын Их Хурлаас 2008 онд ЭХ–ийн 113 дугаар зүйлд нэмэлт өөрчлөлт оруулсан нь Палермогийн протоколд нийцүүлэх чухал алхмууд байсан.

²⁰ Төрийн тусгай алба хаагч, судлаачдын хүсэлтээр нэр, албан тушаалыг дурдах шаардлагагүй гэж үзсэнээс гадна тэдгээрийн санаа нь эрдэм шинжилгээний бүтээлд нэгэнт тусгагдсан тул давхардуулан оруулах шаардлагагүй гэж үзэв. Тухайлбал, Дотоод хэргийн их сургууль “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд тулгамдаж буй асуудал” улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, 2012, УБ.

²¹ Хавсралт №1–ээс үзнэ үү.

²² Хавсралт №2–оос харьцуулалтыг үзнэ үү.

1.2. ХХГХ–ийг 2015 оны ЭХ²³–д Арван гуравдугаар бүлэг /хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг/–т системчилж Палермогийн протоколын 3 дугаар зүйлд заасан агуулгаар **13.1 дүгээр зүйлд гэмт хэрэгт тооцохоор хуульчилж 2017 оны 07 дугаар сарын 01–ний өдрөөс мөрдөгдөж байна.**

1.3. Палермогийн протоколын 3 дугаар зүйлд заасан тайлбарууд буюу хүүхдийг худалдаалах гэмт хэргийн хохирогчоор тогтоох болон хохирогч зөвшөөрсөн эсэх нь ХХГХ–ийн зүйлчлэлд үл нөлөөлөх агуулгууд нь ЭХ–ийн **13.1 дүгээр зүйлийн тайлбарт бүрэн утгаар тусгагдсан байна.**

Харин ЭХ–ийн 12.3 дугаар зүйлд “Хохирогчид хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан зорчих эрхийг хязгаарлахгүйгээр бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулсан бол бэлгийн мөлжлөг гэмт хэрэгт тооцох”–оор хуульчилсан.

²³ ЭХ–д тус хуулийн 13.1 дугаар зүйл буюу Хүн худалдаалах гэмт хэргээс ангид хүн худалдаалахтай холбоотой нарийвчилсан зохицуулалт тусгагдаагүй бөгөөд ЭХ–ийн шинэчлэлийн ахиц, дэвшлийг харьцуулан судлах нь судалгааны зорилгод тусгагдаагүй болно.

Энэ нь ХХГХ-ээс зорчих эрхийг хязгаарлахгүй шинжээр ялгагдаж байгаа боловч Палермогийн протоколын 3 дугаар зүйлийн хохирогч бэлгийн мөлжлөгт өртөж байгаагаар зөвшөөрсөн түүнчлэн Монгол Улсын ЭХ-ийн 13.1-д заасан ХХГХ-ийн тайлбарт дурдсан хохирогч зөвшөөрсөн эсэх нь гэмт хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй байх агуулгатай зөрчилдөж байгаагаас гадна ХХГХ-ийг бэлгийн мөлжлөг гэмт хэргээр зүйлчлэн шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлснээр ХХГХ-ийн статистик бодитой гарахгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

Мөн бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийг хохирогчийн биеийг үнэлүүлж ашиг олох зорилгоор насанд хүрээгүй, бага насны хүүхдийг албадан оруулж үйлдсэн тохиолдолд зүйлчлэлийг хүндрүүлэн ял оногдуулахаар заасан нь Палермогийн протоколын 3 дугаар зүйл болон ЭХ-ийн 13.1-д заасан ХХГХ-ийн тайлбартай зөрчилдсэн байна.

Түүнчлэн 2015 оны ЭХ-ийн 13.11 дүгээр зүйлд бусдад хүч

хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, илт хохиролтой болзол, нөхцөл тулгаж, эсхүл хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдлыг далимдуулан эрхшээлдээ оруулж цалин хөлсгүй хөдөлмөр эрхлүүлсэн бол албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан байна.

Энэхүү албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэрэг нь Палермогийн протоколын 3 дугаар зүйлд заасан хөдөлмөрийн мөлжлөгийн зорилгыг агуулж байгаа төдийгүй зарим ХХГХ-ийг албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэргээр зүйлчлэн шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлэх эрсдэлтэй байна.

- 2012 оны ЭХ-ийн 113 дугаар зүйлд тусгагдсан байсан ХХГХ үйлдсэн хүнд хүлээлгэж байсан эрүүгийн хариуцлагыг 2015 оны ЭХ-аар дараах байдлаар өөрчилж, чангатгасан нь шударга ёс тогтоох, энэхүү төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх агуулгатай байна. Үүнд:

2002 оны Эрүүгийн хууль		2015 оны Эрүүгийн хууль	
<i>Зүйл, хэсэг</i>	<i>Оногдуулах ял</i>	<i>Зүйл хэсэг</i>	<i>Оногдуулах ял</i>
113.1 хүндэвтэр гэмт хэрэг	3–5 жил хорих	13.1 хүнд гэмт хэрэг	2–8 жил хорих
113.2 хүнд гэмт хэрэг	5–10 жил хорих	13.2 хүнд гэмт хэрэг	5–12 жил хорих
113.3 онц хүнд гэмт хэрэг	10–15 жил хорих	13.3 хүнд гэмт хэрэг	12–20 жил хорих

2015 оны ЭХ-аар гэмт хэргийг хөнгөн, хүнд гэж ангилж, давтан гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд тухайн хэрэг нэг бүрд ял оногдуулахаар харин байнга тогтвортой үйлдсэн болон хүндрүүлж зүйлчлэхээр хуульчилсан байна.

- 2002 оны ЭХ-ийн гэмт хэрэгт хамтран оролцох хэлбэрийг бүлэглэх, урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл гэж тогтоож байсныг 2015 оны ЭХ-аар бүлэглэх, зохион байгуулалттай гэмт бүлэг гэсэн хэлбэрт тусгаж зохион байгуулалттай гэмт бүлэг ХХГХ үйлдсэн тохиолдолд хүндрүүлж зүйлчлэн ял оногдуулахаар тусгажээ.
- Монгол Улсын ЭХ-д Палермогийн протоколын 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан ХХГХ-ийг үйлдэхийг завдах, хамтран оролцох болон зохион байгуулах буюу удирдах үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор хуульчлагдсан төдийгүй ХХГХ-ийг үйлдэхээр бэлтгэсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр тусгагджээ.
- Түүнчлэн ХХГХ-ийг зохион байгуулалттай бүлэг үйлдсэн тохиолдолд зохион байгуулалттай гэмт бүлэг байгуулсан, удирдсан хүнийг зохион

байгуулалттай гэмт бүлэг байгуулсан, удирдсан үйлдэлд нь ба зохион байгуулалттай гэмт бүлгийн бусад гишүүний үйлдсэн гэмт хэргийн гүйцэтгэгчид тооцож ял оногдуулахаас гадна тус бүлгийн гишүүнийг зохион байгуулалттай гэмт бүлэгт элссэн үйлдэлд ба өөрийнх нь үйлдсэн гэмт хэрэгт ял оногдуулахаар хуульчлагдсан нь Палермогийн протоколын агуулгад нийцэж байна.

- ЭХХШТХ-ийн 6.1 дүгээр зүйлд зааснаар цагдаагийн байгууллага ХХГХ-г хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулахаар хуульчилснаас гадна Тагнуулын байгууллага өөрсдийн илрүүлсэн ЭХ-ийн тусгай ангийн 13.1 дүгээр зүйл /Хүн худалдаалах/ гэмт хэргийг мөрдөхөөр хоёрдмол харьяалалтайгаар тусгасан нь 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн уламжлалыг хадгалж, энэхүү гэмт хэрэгтэй тэмцэх цар хүрээ, урьдчилан сэргийлэх Палермогийн протоколын агуулгатай нийцэж байна.
- Конвенцэд тодорхойлогдсон зохион байгуулалттай гэмт бүлэглэл гэсэн нэр томъёо нь Монгол Улсын ЭХ-д зохион байгуулалттай бүлэг гэж тодорхойлогдсон байна.

Энэхүү Конвенцийн дагуу хүлээн зөвшөөрөгдсөн нэг эсхүл хэд хэдэн хүнд гэмт хэрэг буюу гэмт хэрэг үйлдэх зорилгоор тохиролцон, шууд буюу шууд бус хэлбэрээр санхүүгийн эсхүл бусад материаллаг ашиг олохоор тодорхой хугацаанд байгуулагдсан, гурав буюу түүнээс дээш этгээдтэй бүлгийг **зохион байгуулалттай гэмт бүлэглэл** гэнэ.

3.8 дугаар зүйл. Зохион байгуулалттай гэмт бүлэг

1. Гэмт хэрэг байнга үйлдэж ашиг олох зорилгоор урьдчилан нэгдсэн гурав, түүнээс олон хүний тогтвортой нэгдлийг зохион байгуулалттай гэмт бүлэг гэнэ.

- 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуульд хөнгөн гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, бусад ангиллын гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулж байсныг ЭХХШТХ-аар гэмт хэрэг, түүнийг үйлдсэн хүнийг олж тогтоох мөрдөн шалгах ажиллагааг хэрэг бүртгэлт, яллагдагчаар татагдвал зохих хүн тогтоогдсон хэрэгт мөрдөн байцаалт явуулахаар тогтоосон нь олон улсын жишиг хандлагад нийцжээ.
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж эхэлснээр буюу гэмт хэргийн тухай гомдол, мэдээллийг хүлээн авч хэрэг бүртгэлтийн хэрэг нээснээр хуульд заасан мөрдөгчийн бие даасан болон прокурорын зөвшөөрөлтэй мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх зүйн зохицуулалт бий болсон нь гэрч, хохирогчийг олон удаа дуудан чирэгдүүлэх хүний эрх, эрх чөлөөг хамгаалах олон улсын стандартад нийцсэн зохицуулалт байна.
- ХХГХ нь ихэвчлэн үндэстэн дамнасан шинжтэй буюу зохион байгуулалттайгаар үйлдэгддэгээс шалтгаалан мөрдөн шалгах нууц ажиллагааны төрлүүд ЭХХШТХ-д анх удаа хуульчлагдан түүний үр дүнг нотлох баримтын хэмжээнд үнэлэх боломж бүрджээ.

Харин мөрдөн шалгах нууц ажиллагааг хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн тохиолдолд явуулах үндэслэлтэй тул мөрдөн шалгах байгууллага, мөрдөгчийн ХХГХ-ийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор явуулсан Гүйцэтгэх ажлын тухай хууль²⁴-ийн дагуу цуглуулсан баримт, мэдээлэл цаашид нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэхээргүй байгаа нь сөрөг үр дагавартай байна.

- ХХГХ үйлдсэн зохион байгуулалттай гэмт бүлгийн гишүүн гэмт хэргээ илчлэн ирсэн, зохион байгуулалттай гэмт бүлгийн үйлдсэн гэмт хэргийг илрүүлэхэд туслалцаа үзүүлэх, мэдээлэл өгөх, эрх бүхий байгууллагатай хамтран ажиллахаа илэрхийлсэн тохиолдолд “хамтран ажиллах гэрч”-ээр тогтоох журам ЭХХШТХ-д тусгагдаж харин ялаас чөлөөлөх, хөнгөрүүлэх үндэслэлийг ЭХ-д хуульчилжээ.

- ЭХХШТХ-д ХХГХ-ийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурорын хяналт, шүүхээр хянан шийдвэрлэхтэй холбоотой тухайлсан зохицуулалт буюу хэсэг, бүлэг, зүйл, заалт тусгагдаагүй байна.

Иймд эрүүгийн материаллаг, процессын хуулиудын уламжлал, шинэчлэлийг харьцуулан ахиц, дэвшлийг тодорхойлох нь гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлогын үр дүнд мониторинг хийх явдал төдийгүй тодорхой цаг хугацааны хэрэгжилтийн дараа судлах шаардлагыг нөхцөлдүүлж байна.

Дүгнэхэд ЭХ-д ХХГХ-ийг Палермогийн протоколын агуулгаар, ЭХХШТХ-д Гэрч хохирогчийг хамгаалах институтийг тус тус хуульчилснаас гадна Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх конвенцэд заасан нотлох ажиллагаанууд эрүүгийн процессын хуульд хуульчлагдаж хүн худалдаалахтай тэмцэх Монгол Улсын хууль тогтоомжийн чадавх сайжирч олон улсын жишигт нийцсэн байна.

3.4. Палермогийн протоколын ХХГХ-ийн хохирогчийг хамгаалах хэм хэмжээ Монгол Улсын хууль тогтоомжид хуульчлагдсан талаар²⁵

- Палермогийн протоколын 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Энэхүү протоколын 1 дүгээр зүйлд заасныг хэрэгжүүлэхдээ оролцогч улс бүр хүмүүнлэг ба нигүүлсэх хүчин зүйлийг зохих ёсоор харгалзан авч үзнэ агуулгын хүрээнд Палермогийн протоколд нэгдэн орсныг соёрхон батлах тухай Монгол Улсын хууль баталжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж заасан.

- ХХГХ-ийн гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, тэднийг мэдээллээр хангах, дэмжлэг, туслалцаа үзүүлэх эрх зүйн үндсийг тогтоосон Гэрч хохирогчийг хамгаалах тухай

²⁴ Төрийн мэдээлэл эмхэтгэл 1998 №3

²⁵ Хавсралт №3-аас харьцуулалтыг үзнэ үү.

Монгол Улсын хууль 2013 оны 07 дугаар сарын 05-ны өдөр батлагдан мөрдөгдсөн.

Энэхүү хуульд хохирогчийн нууцлалыг хамгаалах зарчим тусгагдаж улмаар хамгаалалтад буй гэрч, хохирогчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газар, өмчлөлд нь байгаа үл хөдлөх хөрөнгө, харилцах утасны дугаар болон тээврийн хэрэгслийн улсын дугаар зэрэг мэдээллийн нууцлалыг хангах арга хэмжээ авахаар хуульчлагдсан нь эхний нааштай алхам болжээ.

- Палермогийн протоколын 6 дугаар зүйлд заасан ХХГХ-ийн хохирогчдын хувийн амьдралыг ба тэдгээрийг бие хүний хувьд тухайлбал, хүн худалдаалахтай холбогдох тухайн хэргийн шүүн таслах ажиллагааг нууц байлгах зорилгоор 2017 оны ЭХХШТХ-д “Гэрч хохирогчийг хамгаалах бүлэг” анх удаа системчлэгдэн хуульчлагджээ.
- Түүнчлэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн хохирогчийн эрхийг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлэх, ялангуяа хохирлыг барагдуулах чиглэлээр энэхүү хуульд тодорхой заалтууд шинээр тусгагдсан нь НҮБ-аас гаргасан “Эрүүгийн процессын загвар хууль”-д нийцэж Палермогийн протоколын агуулгад нийцжээ.
- ЭХХШТХ болон Гэрч хохирогчийг хамгаалах хуульд хохирогчийн аюулгүй байдлыг хангахын тулд гэмт хэргийн холбогдогчид урьдчилан хариуцлагыг сануулах, түүний талаар тодорхой үйлдлийг хязгаарлах, хохирогчийг биечилсэн хамгаалалтад авах, мэдээллийн нууцлалыг хангах, нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, холбооны хэрэгслээр хангах, аюулгүй газарт түр байрлуулах, нүүлгэн шилжүүлэх, баримт бичгийг солих, гадаад төрхийг өөрчлөх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхээр хуульчлагдсан.
- Мөн хохирогчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрээс бусад биеийн байцаалтыг мөрдөн шалгах ажиллагааны тэмдэглэлд тусгахгүйгээр тусад нь бичиж битүүмжлэн хавтаст хэрэгт хавсаргах нь хавтаст хэргийн материалтай танилцах үед хохирогчийн гэрийн болон ажлын хаяг, утасны дугаарыг мэдсэнээр яллагдагч болон бусад хүний зүгээс дарамтлах, айлган сүрдүүлэх, нөлөө үзүүлэхийг оролдох зэрэг явдал гаргахаас сэргийлэх шинэлэг зохицуулалт болсон байна.
- Палермогийн протоколын 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн /а/-д заасан хохирогчийг мэдээллээр хангах агуулга ЭХХШТХ-ийн 8.3 дугаар зүйлд анх удаа хуульчлагдсан нь яллагдагчийн зүгээс

хохирогчид учирч болох аюул, заналхийллээс хохирогч өөрийгөө хамгаалах эсхүл хамгаалалтад орох эрхийг хангах хууль зүйн учир холбогдолтой байна.

- Палермогийн протоколын 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн /б/-д заасан хохирогчийн санал бодол, болгоомжлолыг нь илэрхийлэх, хэлэлцүүлэх боломжийг бүрдүүлэх талаар туслалцаа үзүүлэх арга хэмжээнүүдийг ЭХХШТХ-ийн 8.2 дэх зүйлд санал, хүсэлт, гомдол гаргах хэлбэрээр тусгасан байна.
- Палермогийн протоколын 6 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн /б/ дэх заалтын “ХХГХ-ийн хохирогчдоод ойлгогдох хэлээр, ялангуяа хуулиар тогтоосон эрхийн талаар зөвлөгөө ба мэдээлэл өгөх” агуулга нь Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйл /хохирогчид үзүүлэх халамж, үйлчилгээ/-ийн 12.1.4 дэх заалт, ЭХХШТХ-ийн 8.2 дүгээр зүйлийн 1.1 дэх заалтад хуульчлагдсан байна.
- Мөн протоколын /с/ дэх заалтын “эмнэлгийн, сэтгэл зүйн ба материаллаг туслалцаа үзүүлэх” агуулга нь Гэрч хохирогчийг хамгаалах тухай 18 дугаар зүйл /хамгаалалтад байгаа гэрч хохирогчид үзүүлэх туслалцаа/-д, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйл /хохирогчид үзүүлэх халамж, үйлчилгээ/-ийн 12.1.1, 12.1.2 дахь заалтуудад хуульчлагдсан байна.
- Палермогийн протоколын 6 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн Засгийн газрын бус байгууллагууд, бусад холбогдох байгууллагууд болон иргэний нийгмийн бусад хэсэгтэй хамтран хэрэгжүүлэх агуулгыг тусгасан нь шүүх эрх мэдлийн болон мөрдөн шалгах, хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг тусгасан заалт бөгөөд 6 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн /а/ дэх заалтын “зохих орон байраар хангах” агуулгатай нийцүүлэн Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 9 дүгээр зүйлд ХХГХ-ийн хохирогчийн нэр төр, алдар хүндийг хамгаалах, аюулгүй байдлыг нь хангах зорилгоор хамгаалах байр ажиллуулахыг зааж Засгийн газрын шийдвэрээр хамгаалах байрны үйл ажиллагааг ТББ-д хариуцуулж болохоор зохицуулжээ.
- Палермогийн протоколын 6 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн /д/ дэх заалтын “хөдөлмөрлөх, боловсрол эзэмших болон суралцах бололцоогоор хангах” агуулга нь Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйл /хохирогчид үзүүлэх

- халамж, үйлчилгээ/-ийн 12.1.3 дахь хэсэгт тусгагджээ.
- Палермогийн протоколын 6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “оролцогч улс бүр энэхүү зүйлийн заалтуудыг хэрэгжүүлэхдээ хүн худалдаалах хэргийн хохирогчдын нас, хүйс ба тусгай хэрэгцээг, тухайлбал хүүхдийн тусгай хэрэгцээг, үүнд зохих орон байр, боловсрол болон асран халамжийн асуудлыг харгалзан үзнэ” гэснийг агуулгын хүрээнд ЭХХШТХ-д ХХГХ-ийн хохирогч хүүхдэд холбогдуулсан нарийвчилсан зохицуулалт байхгүй боловч Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 13 дугаар зүйлд хохирогч хүүхдийг хамгаалах талаар тусгасан байна.
 - Палермогийн протоколын 6 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “Оролцогч улс бүр ХХГХ-ийн хохирогчид нутаг дэвсгэрт нь байх хугацаанд тэдний биеийн аюулгүй байдлыг хангахыг эрмэлзэнэ” гэсэн агуулгын хүрээнд эсхүл эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээний дагуу ЭХХШТХ болон Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан журмаар тэдгээрийн аюулгүй байдлыг хамгаалах боломжтой байна.
 - Палермогийн протоколын 6 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “Оролцогч улс бүр дотоодын хууль зүйн тогтолцооны хүрээнд хүн худалдаалах хэргийн хохирогчид учирсан хохиролдоо нөхөн төлбөр авах боломж олгож байх арга хэмжээг харгалзсан нөхцөлийг хангана” агуулгын хүрээнд Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйл /Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох/-д гэмт хэргийн хохирогчид Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 213 дугаар зүйлд заасан журмын дагуу нөхөн төлбөр олгоно гэж заажээ.
 - Палермогийн протоколын 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Оролцогч улс бүр энэхүү протоколын 6 дугаар зүйлийн дагуу арга хэмжээ авахын зэрэгцээ хүн худалдаалах хэргийн хохирогчид, зохих тохиолдолд, түүний нутаг дэвсгэрт нь түр буюу байнга байх бололцоо олгох талаар хууль тогтоох буюу бусад зохих арга хэмжээ авах асуудлыг авч үзнэ” агуулгын хүрээнд Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 11 дүгээр зүйл /Гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг хамгаалах/-д ХХГХ-ийн хохирогч гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг албадан гаргахыг хориглох үндэслэл, тэдгээрийн Монгол Улсад оршин суух зөвшөөрлийг олгох, сунгах харилцааг зохицуулжээ.

- Палермогийн протоколын 8 дугаар зүйлийн хүн худалдаалах хэргийн хохирогчдыг нутагт нь буцаах талаар Монгол Улсын хуульд тухайлсан зүйл, хэсэг, заалт тусгагдаагүй боловч холбогдох хууль, нэгдэн орсон улсын гэрээгээр зохицуулж байна.

Эцэст нь Палермогийн протоколын агуулгаар ХХГХ-ийн хохирогчийн эрх зүйн байдал, түүний хамгаалал нь ЭХХШТХ, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуульд тусгагдан олон улсын жишигт нийцсэн ч хуулиуд тунхаг бус амьдралд хэрэгжих баталгаа механизм үгүйлэгдэж, төрийн дэмжлэгийг шаардсаар байгаа нь энэхүү чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ, судлаачдын эрдэм шинжилгээний илтгэл, нийтлэлээс дүгнэгдэж байна.

3.5. Палермогийн протоколын ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх хэм хэмжээ Монгол Улсын хууль тогтоомжид хуульчлагдсан талаар²⁶

- Палермогийн протоколын 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Оролцогч улсууд дараах асуудлаар бүрэн цогц бодлого, хөтөлбөрүүд болон бусад арга хэмжээг тодорхойлох” агуулгын хүрээнд ХХГХ-тэй тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтад Засгийн газар нь хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр батлахаар тусгагдсан.

Энэ хуулийн заалтыг хэрэгжүүлэх үүднээс 2005 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн Засгийн газрын 234 дугаар тогтоолоор “Хүн худалдах ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг батлан 2006–2014 он хүртэл хэрэгжүүлжээ.

Улсын Их Хурлын 2016 оны 121 дүгээр тогтоолоор баталсан “Засгийн газрын 2016–2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 5.4.4-т мөнгө угаах, хүний наймаа, хар тамхи болон цахим гэмт хэрэг зэрэг шинэ төрлийн гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлэхээр, Засгийн газрын 2016 оны 204 дүгээр тогтоолоор баталсан “НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016–2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө”-нд хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр үндэсний хөтөлбөр боловсруулж, батлан хэрэгжүүлэхээр тус тус заасан байна.

2017 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн Засгийн газрын 148 дугаар тогтоолоор 2017–2021 он хүртэл “Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг баталж хэрэгжүүлэн ажиллаж байна.

2002 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн Засгийн газрын 274 дугаар тогтоолоор “Жендерийн тэгш байдлыг хангах

²⁶ Хавсралт №-4-өөс харьцуулалтыг үзнэ үү.

үндэсний хөтөлбөр”-ийг 2003–2015 он хүртэл хэрэгжүүлжээ.

2012 оны 07 дугаар сарын 25–ны өдрийн Засгийн газрын 252 дугаар тогтоолоор “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөр”-ийг 2012–2016 он хүртэл хэрэгжүүлжээ.

2015 оны 08 дугаар сарын 24–ний өдрийн Засгийн газрын 346 дугаар тогтоолоор 2016–2024 он хүртэл “Гэрч хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр” хэрэгжүүлж байна.

- Зөрчлийн тухай хууль²⁷-ийн 2.3 дугаар зүйлд 4 дэх хэсэгт “Төрийн албан хаагчийн хуулиар хүлээсэн албаны чиг үүргээ хэрэгжүүлсэн үйлдэл, эс үйлдэхүй нь энэ хуульд заасан зөрчлийн шинжтэй бол түүнд холбогдох хууль тогтоомжид заасан сахилгын шийтгэл хүлээлгэнэ” гэж заасан нь хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлээгүй иргэн, хуулийн этгээд, албан тушаалтанд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол холбогдох хууль тогтоомжид заасан сахилгын шийтгэл хүлээлгэнэ.
- Палермогийн протоколын 9 дүгээр зүйлийн 2 дэх хэсгийн “Оролцогч улсууд хүн худалдаалах хэргээс урьдчилан сэргийлэх ба түүнтэй тэмцэх зорилгоор судалгаа олон нийтийн хэвлэл мэдээллийн компани ажил явуулах, түүнчлэн нийгэм, эдийн засгийн холбогдох санаачилгуудыг хэрэгжүүлэх зэрэг арга хэмжээ авахыг эрмэлзэнэ” агуулгын хүрээнд хүн худалдаалах хэргээс урьдчилан сэргийлэх ба түүнтэй тэмцэх зорилгоор нийгэм, эдийн засгийн холбогдох санаачилгуудыг хэрэгжүүлэх зэрэг арга хэмжээ авах хүрээнд Монгол Улсын Улсын Их хурал болон Засгийн газраас олон талт арга хэмжээ авч байна.

Тухайлбал, 2017 оны 05 дугаар сарын 18–ны өдөр Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль²⁸ батлагдан 2018 оны 01 дүгээр сарын 01–ний өдрөөс мөрдөгдөх бөгөөд тус хуулийн 12 дугаар зүйлд залуучуудын аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж, 17 зүйлд УИХ хурлаас залуучуудын хөгжлийн төрийн бодлогыг тодорхойлох, 18 дугаар зүйлд Засгийн газраас залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр, төлөвлөгөөг батлахаар тусгагдсан нь Палермогийн протоколын агуулгад нийцжээ.

- Палермогийн протоколын 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Энэхүү зүйлийн дагуу тодорхойлсон бодлого, хөтөлбөрүүд болон бусад арга хэмжээ нь зохих нөхцөлд засгийн газрын бус байгууллагууд, бусад холбогдох байгууллага болон иргэний

нийгмийн бусад хэсэгтэй хамтран ажиллах асуудлыг хамарна” агуулгын хүрээнд батлагдсан гарсан хууль тогтоомж бүрд төрийн байгууллага, ТББ, ИНБ, олон нийт, иргэдтэй хамтран ажиллах талаар тусгасан байна.

Тухайлбал, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэгт Залуучуудын хөгжлийн үндэсний болон салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийн байгууллага, залуучуудын ИНБ, залуучуудын төлөөллийг оролцуулахаас гадна 22.4.2 дахь заалтад залуучуудын хөгжлийг дэмжих, эрх ашгийг хамгаалах асуудлыг шийдвэрлэхэд залуучууд, залуучуудын ИНБ, аж ахуйн нэгж, байгууллагыг оролцуулах, гаргасан санаачилгыг дэмжих агуулга тусгагджээ.

- Палермогийн протоколын 9 дүгээр зүйлийн 4 дахь хэсгийн “Оролцогч улсууд хүмүүсийг, ялангуяа эмэгтэйчүүд болон хүүхдүүдийг хүн худалдаалах хэрэгт өртөмтгий болгож буй ядуурал, буурай хөгжил, тэгш бололцоогүй байх зэрэг хүчин зүйлийн нөлөөг бууруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг, тухайлбал, хоёр буюу олон талаар хамтран ажиллах замаар хэрэгжүүлэх буюу боловсронгуй болгох болно” агуулгын хүрээнд дараах хууль тогтоомжуудыг дурдаж болно. Үүнд:
 - Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль²⁹-ийн 1 дүгээр зүйлд “Энэ хуулийн зорилт нь улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд жендерийн эрх тэгш байдлыг хангах нөхцөл бүрдүүлэх эрх зүйн үндсийг тодорхойлж, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж тодорхойлсон.
 - Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай тухай хууль³⁰-ийн 1 дүгээр зүйлд “Энэ хуулийн зорилт нь хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлж, түүний төрөл, хэлбэр, хамрах хүрээ, санхүүжилт, хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын тогтолцоотой холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж тодорхойлжээ.
 - Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль³¹-ийн 1 дүгээр зүйлд “Энэ хуулийн зорилт нь гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, хохирогч, түүний гэр бүлийн бусад гишүүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, үйл

²⁷ Төрийн мэдээлэл эмхэтгэл 2017 он №24

²⁸ Төрийн мэдээлэл эмхэтгэл 2017 он №29

²⁹ Төрийн мэдээлэл эмхэтгэл 2011 он №8

³⁰ Төрийн мэдээлэл эмхэтгэл 2011 он №40

³¹ Төрийн мэдээлэл эмхэтгэл 2017 он №5

- ажиллагааны эрх зүйн үндсийг тогтооход оршино” гэж заасан.
- Палермогийн протоколын 9 дүгээр зүйлийн 5 дэх хэсгийн “Оролцогч улсууд хүн худалдаалахад хүргэж буй, хүн, ялангуяа эмэгтэйчүүд болон хүүхдүүдийг бүх хэлбэрээр мөлжих явдлыг бий болгодог эрэлт хэрэгцээний эсрэг чиглэсэн хууль тогтоох буюу боловсрол, нийгэм, соёлын гэсэн бусад арга хэмжээнүүдийг, тухайлбал, хоёр буюу олон талаар хамтран ажиллах замаар авах буюу боловсронгуй болгох болно” агуулгын хүрээнд дараах хууль тогтоомжуудыг дурдаж болно. Үүнд:
 - Зар сурталчилгааны тухай хууль³²-ийн 6 дугаар зүйлийн 6.5.дахь хэсэгт Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчих үйлдэл, үйл ажиллагаанд хүргэж болох эсхүл хүчирхийлэл, садар самуунд уруу татах, түүнчлэн хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд гэм хор учруулах үйлдэл, үйл ажиллагаанд хүргэж болох зар сурталчилгааг хориглосон байна.
 - Садар самуунтай тэмцэх тухай хууль³³-ийн 1 дүгээр зүйлд “Энэ хуулийн зорилт нь садар самууныг сурталчлах, биеэ үнэлж явалдахтай тэмцэх болон эротик сурталчилгаа, үйлчилгээг журамлахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж тодорхойлжээ.
 - Донорын тухай хууль³⁴-ийн 1 дүгээр зүйл “Энэ хуулийн зорилт нь бусдын эрүүл мэндийг сайжруулах, амь насыг аврахын тулд хүмүүнлэг сэтгэлээр сайн дураараа цус, эд эрхтнээ үнэ төлбөргүй өгөх, амьд болон амьгүй донорын эд, эрхтнийг шилжүүлэн суулгах зорилгоор авах, цус, цусан бүтээгдэхүүн, эд эрхтнийг эмчилгээний зориулалтаар хэрэглэхээр авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, хэрэглэх, экспортлох, импортлох, донорын үйлсийг сурталчлах, түүнд иргэдийг татан оролцуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж тодорхойлжээ.
 - Харьяатын тухай хууль³⁵-ийн 1 дүгээр зүйлд “Энэ хуулийн зорилт нь иргэний харьяалал хийгээд Монгол Улсын харьяат болох, иргэний харьяаллыг сэргээн тогтоох, харьяатаас гарахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж тодорхойлжээ.

- Палермогийн протоколын 3 дугаар бүлгийн 10 дугаар зүйлд тусгагдсан мэдээлэл солилцоо болон сургалтын талаар авах арга хэмжээнүүд нь Монгол Улсын Засгийн газрын хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдсан байна.

Түүнчлэн хилийн хяналтын зөвлөмжүүдийн хүрээнд Монгол Улсын хилийн халдашгүй, дархан байдлыг хангах зорилгоор хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээг хэрэгжүүлэх, хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, улсын хил хамгаалах байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, бүрэн эрх, улсын хил хамгаалалтад иргэн, байгууллагын оролцоог тодорхойлж, хилийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон бусад харилцааг зохицуулах Хилийн тухай хууль³⁶-ийг 2016 онд шинэчлэн баталжээ.

Мөн иргэний баримт бичгүүд нь хууль ёсны бөгөөд хүчинтэй байх, улмаар түүний баталгаа болон хяналтын талаар улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоотой холбогдсон харилцааг зохицуулах Улсын бүртгэлийн ерөнхий хууль³⁷-ийг 2009 онд шинэчлэн баталж мөрдөж байна.

- Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 252 дугаар тогтоолоор 2012–2016 он хүртэл 5 жилийн хугацаанд “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөр”-ийг баталж, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 6 дугаар зүйлд ХХГХ–тэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 120,0 сая төгрөгийн төсөв тусгажээ.³⁸

Дүгнэхэд хууль, хөтөлбөр, төлөвлөгөө батлагдан төр, байгууллага, албан тушаалтан, иргэдэд эрх олгож үүрэг хүлээлгэснээр ХХГХ–тэй тэмцэж байгаа асуудал бус бөгөөд Монгол иргэний хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэн ядуурал, ажилгүйдэлтэй тэмцэн шат шатны удирдах албан тушаалтан, алба хаагчдын хариуцлагын тогтолцоог шинэчлэх, гэмт хэргийг шударгаар, шуурхай шийдвэрлэхдээ улс орнуудтай хамтран ажиллах, хохирогчоо буруутгах бус хамгаалах сэтгэл, зүтгэл, итгэлийг бий болгох төрийн бодлогын манлайлал үгүйлэгдсээр байна.³⁹

3.6. Дүгнэлт

Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протоколд Монгол Улсын үндэсний хууль тогтоомж нийцэж буй эсэхийг судлахад дараах нөхцөл байдал дүгнэгдэж байна. Үүнд:

1. 2008 онд Палермогийн протоколыг соёрхон баталж ХХГХ–ээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох,

³² Төрийн мэдээлэл эмхэтгэл 2002 он №23

³³ Төрийн мэдээлэл эмхэтгэл 1998 он №3

³⁴ Төрийн мэдээлэл эмхэтгэл 2000 он №6

³⁵ Төрийн мэдээлэл эмхэтгэл 1995 он №10, 11

³⁶ Төрийн мэдээлэл эмхэтгэл 2017 он №6

³⁷ Төрийн мэдээлэл эмхэтгэл 2009 он №26

³⁸ Хавсралт №5–аас дэлгэрэнгүйг үзнэ үү.

³⁹ Хүйсийн тэгш эрхийн төвийн тэргүүн Г.Ганбаясгах “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд иргэний нийгмийн байгууллагын оролцоо” илтгэлээс он?

хохиогчдыг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр ажиллаж буй төрийн бус байгууллагын хүчин чармайлт, олон улсын дэмжлэгтэйгээр олон судалгаа хийгдэж Монгол Улсын хууль тогтоомжийн хүн худалдаалах явдалтай тэмцэх хууль тогтоомжийн чадавх эрс сайжирч олон улсын жишигт нийцжээ.

Тухайлбал, Монгол Улсад ЭХ тогтоомжийн шинэчлэлийн явцад Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцийн агуулгыг ЭХ, ЭХХШТХ, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хууль, Прокурорын тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль зэрэг олон хуулиудад олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэн нийцүүлсэн байна.⁴⁰

Засгийн газрын 148 дугаар тогтоолоор батлагдан 2017–2021 он хүртэл хэрэгжих “Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр”-т “..хуулийн хэрэгжилтийг хангах, гэмт хэргийн хохирогчийг хамгаалах цогц үйлчилгээг бий болгох, цаашид энэ төрлийн гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, таслан зогсоох чиглэлээр төрийн байгууллага, ТББ, ОУБ-ын хамтын ажиллагааг өргөжүүлэх” зорилго тавьсан нь хүн худалдаалахтай тэмцэх хууль эрх зүйн орчин Монгол Улсад бүрдсэн гэж дүгнэсэнтэй утга нэг байна.

2. Түүнчлэн ЭХ тогтоомжийн шинэчлэлийн хүрээнд хүн худалдаалах, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэлийн хууль бус эргэлт, мөнгө угаах зэрэг улс дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд шинээр батлагдсан хуулиудын тодорхой хугацааны хэрэгжилтийн явцад уялдаа холбоог хангах, коллиз, хийдэл, алдааг холбогдох судалгааг үндэслэн Хууль тогтоомжийн тухай хууль⁴¹-ийн дагуу боловсронгуй болгох шаардлага бий болно.

Тухайлбал, ЭХ дахь хүн худалдаалах, бэлгийн мөлжлөг гэмт хэргүүдийн зүйлчлэлийг Палермогийн протоколтой нийцүүлэх болон гүйцэтгэх ажлын шугамаар олж авсан баримт, мэдээллийг нотлох баримтын хэмжээнд үнэлэх эрх зүйн зохицуулалтыг ЭХХШТХ–д тусгах, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хуулийг ЭХ тогтоомжийн шинэчлэлтэй холбогдуулан шинэчлэн найруулан батлах хэрэгцээ шаардлага нэгэнт бий болжээ.

А. ХХГХ нь ихэвчлэн зохион байгуулалттай үйлдэгддэгээс түүнтэй тэмцэх цогц үндэсний механизм, улс хоорондын хамтын ажиллагаа, мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэх,

⁴⁰ “Аливаа хууль тогтоомжийг батлагдмагц иргэд, олон нийтэд таниулах, сурталчлах, хэрэгжүүлэгчдийн хандлага, чадавхыг дээшлүүлэх зэрэг наад захын арга хэмжээ авсны дараа буюу тодорхой цаг хугацааны дараа мөрддөг. 2002 оны ЭХ тогтоомжийг баталж 9 сарын дараа хэрэгжүүлж байсан бол Эрүүгийн хуулийг 2017 оны 05 сарын 11, ЭХХШТ хуулийг 2017 оны 05 дугаар сарын 18–нд баталж сар гаруй хугацааны дараа мөрдүүлжээ.

⁴¹ Төрийн мэдээлэл 2015 он №? Хууль тогтоомжийн тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Энэ хуулийн зорилго нь хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр /цаашид “хууль тогтоомж” гэх/-ийг санаачлах, боловсруулах ажиллагааны үндэслэл, чанарыг сайжруулах, оршино.” гэж заасан.

тогтвор суурьшилтай ажиллуулах явдал чухал байдаг билээ.

Хүн худалдаалахтай холбоотой хууль тогтоомж, нэгдсэн бодлого, стратеги, хөтөлбөрүүдийн хэрэгжилт тэр дундаа шүүх эрх мэдлийн болон мөрдөн шалгах, хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааны хандлага, сэтгэлгээнд дорвитой өөрчлөлт ороогүйгээс хүн, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүд хохирсоор байгаа талаар судлаачид, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагуудын тайланд дурдагдсаар байна.

Энэ нь хүн худалдаалахтай холбоотой хууль, тогтоомж, Засгийн газраас батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх нэгдсэн бодлого, тэдгээрийг хэрэгжүүлэх механизм, менежмент үгүйлэгдэж, хүн худалдаалахтай тэмцэж буй үйл ажиллагааны үр дүн гагцхүү цагдаа болон төрийн бус байгууллагын үйл ажиллагааны тайланг нэгтгэх төдийхнөөр мониторинг явуулж, төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, бодлого чиглэл, хандлага шинэчлэгддэггүй байна.

Б. ХХГХ–тэй тэмцэх хууль тогтоомжийн мөн чанар нь нэгэнт үйлдэгдсэн ХХГХ–ийг нотлоход бус урьдчилан сэргийлэхэд хууль зүйн учир холбогдол нь оршиж байгаа бөгөөд тэдгээрийн хэрэгжилт нь нийгэм, эдийн засгийн байдалтай холбоотой боловч төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, алба хаагчдын хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хангах хамгаалах хандлага, мэдлэг, мэргэшлийн ур чадвараас ихээхэн шалтгаалдаг билээ.

Жишээлбэл, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хохирогчийг “буруутгасаар” ирсэн нь шүүх эрх мэдлийн болон мөрдөн шалгах, хууль сахиулах байгууллагад үл итгэх хандлагыг хохирогчдод бий болгодгийг төрийн бус байгууллагууд шүүмжилсээр байна.

ХХГХ–тэй тэмцэх ажлын үр дүн нь батлагдсан хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээ тогтоосон актын агуулга, мөн чанараас гадна түүнийг хэрэгжүүлэх тогтолцоо, иргэн, албан тушаалтны үйл ажиллагаа, сэтгэлгээний хандлагаас ихээхэн шалтгаалах нь дамжиггүй.

Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаа нь зохион байгуулалттай гэмт хэргийн олон улсын хандлагаас хоцорч байгаа нь хүний эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх бус нөгөөтэйгүүр нэгэнт зөрчигдсэн эрхийг нь сэргээн эдлүүлэх үүргийн хэрэгжилт хангалтгүй байгааг судлаачид дурдаж байна.

В. Монгол Улсын Засгийн газраас баталсан хүн худалдаалахтай тэмцэх болон бусад үндэсний хөтөлбөр, төрөөс баримтлах бодлогын баримт бичгүүдийн уялдаа холбоо болон төсөв, санхүүгийн хүндрэлтэй байдлаас шалтгаалан зохих үр дүнгээ үзүүлэхгүй байгаа нь цаашид

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль⁴²-ийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.

Хэдийгээр Монгол Улсын улс төр, нийгэм, эдийн засгийн онцлогоор Засгийн газар хязгаарлагдмал нөөцтэй ч санхүүжилтгүй хөтөлбөр, төлөвлөгөө батлах төдийхнөөр ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажилд оролцож буй нь мөрдөн шалгах болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна.

3.7. Санал, зөвлөмж

Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протоколд Монгол Улсын үндэсний хууль тогтоомжийг харьцуулан дүгнэсний эцэст дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

- **“Гэмт хэрэгтэй тэмцэх” үндсэн чиглэлийн бодлогын баримт бичгийг хууль тогтоох байгууллагаас батлан гаргах;** Энэ нь Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуульд заасны дагуу урт хугацаанд хэрэгжсэнээр Монгол Улсын гэмт хэрэгтэй тэмцэх хуулиудын хөгжлийн үе шат, хандлагыг тодорхойлж, уялдаа холбоо, залгамж чанар хадгалагдаж, улмаар шүүх эрх мэдлийн болон мөрдөн шалгах, хууль сахиулах байгууллагуудын тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.
- Засгийн газрын 148 дугаар тогтоолоор батлагдсан “Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангахад онцгой анхаарч эрчимжүүлэх. Үүнд:
 - ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдэх ажлын хүрээнд шүүх эрх мэдлийн болон мөрдөн шалгах, хууль сахиулах байгууллагуудын удирдлага, алба хаагчдын чадавхыг сайжруулах;
 - 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөгдсөн Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуулиудаас гадна хүн худалдаалахтай холбоотой хууль тогтоомжийн шинэчлэлийн хандлагыг шүүх эрх мэдлийн болон мөрдөн шалгах, хууль сахиулах алба хаагч, иргэдэд сурталчлах нийгмийн хэрэгцээ шаардлага нэгэнт бий болсон байна.

- Хохирогч төвтэй хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, түүнд тавих прокурорын хянан шалгах ажиллагааны механизмыг бүрдүүлэх журам, стандартыг баталж мөрдүүлэх;
- ХХГХ-ийн хохирогчид учирсан “сэтгэл санааны” хохирлыг тогтоох жишиг аргачлалтай болох;
- ХХГХ-тэй тэмцэх зорилгоор эрүүгийн хэргийн талаар харилцан туслалцаа үзүүлэх гэрээг Монгол Улсын иргэд олноор зорчдог улс орнуудтай байгуулах талаар санаачилга гарган ажиллах;
- Хүн худалдаалахтай тэмцэх хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд шаардлагатай дүрэм, журам, стандартуудад хэрэгжилтийн үр нөлөөний судалгаа хийх замаар шинэчлэн баталж мөрдүүлэх;
- ЭХ-ийн **12.3 дугаар зүйлд** заасан “Бэлгийн мөлжлөг” гэмт хэргийг ЭХ-д өөрчлөлт оруулах замаар хасах;
- ЭХ-ийн **12.3 дугаар зүйлд** заасан “Бэлгийн мөлжлөг” гэмт хэргийг ЭХ-д Улсын дээд шүүхийн тайлбар гаргуулах;
- ЭХ-ийн **13.13 дугаар зүйлд** заасан албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэргийг ХХГХ-ээс ялган зүйлчлэх талаар Улсын дээд шүүхийн тайлбар гаргуулах;
- ЭХХШТХ-д гүйцэтгэх ажлын шугамаар олж авсан баримтат мэдээллийг нотлох баримтаар тооцох агуулгыг хуульчлах.

Гэмт хэрэг үлдэгдсэний дараа явуулах мөрдөн шалгах нууц ажиллагааны баримт л нотлох баримт болох бус ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх хүрээнд мөрдөгчийн Гүйцэтгэх ажлын тухай хуульд заасан үндэслэл, журмаар явуулсан арга хэмжээний баримтат мэдээллийг нотлох баримтаар үнэлэх шаардлагатай байна.

⁴² Төрийн мэдээлэл эмхэтгэл 2015 он №47

БҮЛЭГ 4.

БОДЛОГЫН СУДАЛГАА 2:
ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ
ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ЧИГЛЭЛЭЭР
ГАРГАСАН СУРГАЛТЫН
ГАРЫН АВЛАГА, СУДАЛГААНЫ
ТАЙЛАНГИЙН ХАРЬЦУУЛАЛТ

БОДЛОГЫН СУДАЛГАА 2: ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ЧИГЛЭЛЭЭР ГАРГАСАН СУРГАЛТЫН ГАРЫН АВЛАГА, СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН ХАРЬЦУУЛАЛТ

4.1. Судалгааны хэрэгцээ шаардлага

ХХГХ-ийн шинж, мөн чанарыг түүхэн нөхцөл байдлын хувьд хэрхэн хувьсан өөрчлөгдөж ирсэн, үндэсний хууль тогтоомж болон олон улсын гэрээнд хэрхэн тусгасан, түүнчлэн энэ гэмт хэргийн гаралт, шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам, нэгэнт үйлдэгдсэн тохиолдолд түүнийг мөрдөх арга зүй, ил болон далд аргаар илрүүлэх, гэрч, хохирогчтой харилцах асуудал, нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх, ижил төсөөтэй гэмт хэргээс ялган зүйлчлэх зэрэг агуулгаар гаргасан ном бүтээлүүдийг цуглуулж, түүнд дүн шинжилгээ хийх зайлшгүй шаардлага үүсэн бий болжээ.

Нэгэнт ХХГХ-ийн гаралт цаашид өсөх хандлагатай байгаа нь уг гэмт хэрэгтэй тэмцэх боловсон хүчин, хүний нөөцийг цогц чадамжтай бэлтгэх, цаашид энэ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хэрхэн тэмцэх талаар системтэй арга хэмжээ авах үүднээс бидэнд байгаа ном, гарын авлагуудыг харьцуулан агуулгаар нь хянан магадлав. ХХГХ нь нийгмийн дунд харилцан адилгүй ойлголттой, хууль хэрэгжүүлэгчдийн хувьд мөн нэгдмэл ойлголтгүй байгаа байдал одоо ч байсаар байна. Энэ утгаараа судалгааны бүтээл, ном, гарын авлага, эмхэтгэлүүдийг системтэй дүгнэж, цаашид онцгой ач холбогдолтой бүтээл хэвлүүлэх шаардлагатай. Тийм ч учраас бидний хувьд гарсан ном гарын авлагуудад дүгнэлт хийх цаг хугацаа болсон байна. Бид нэгэнт дүгнэлт хийж байгаа нь цаашид ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр шинэлэг цогц сургалтын материал боловсруулах шаардлагыг үүгээр бататгаж байгаа билээ.

ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр гарсан бүтээлүүд нь агуулгаараа зарим тохиолдолд давхцах, адил байх нь олонтоо тохиолдож байгаа нь цаашид энэ гэмт хэргийн онцлог, агуулга, мөн чанарын талаар бүтээл гаргахдаа анхаарч үзэх шаардлага байгааг бид ажигласан болно.

Дунд болон их дээд сургуульд суралцаж байгаа оюутан, сурагчдад энэ гэмт хэргийн хор аюулыг таниулахдаа ном бүтээл, гарын авлагаар дамжуулан танилцуулах шаардлага байгаа. Энэ нь олон хүнд уг гэмт хэргийг таниулах боломж төдий зүйл бус харин ч нийгмийг соён гэгээрүүлэх алхам болох тул ХХГХ-ийн талаар гарсан бүтээлүүдийг нэг бүрчлэн уншин танилцаж агуулгын тэмдэглэгээг хийсэн болно.

Онолын хувьд ХХГХ-ийн талаар нэгдсэн ойлголт авах үндэс

нь ном, гарын авлага болно. Цаашид нэгдсэн ойлголттой байх нь ХХГХ-тэй зөв алхмаар, зөв арга зүйтэй тэмцэх нөхцөл бүрдэнэ. Нэгдсэн ойлголттой болох гол нөхцөл нь ном, гарын авлагуудад дүн шинжилгээ хийх явдал мөн гэж үзсэн болно. Хэдийгээр онолын хувьд ач холбогдол өгч байгаа хэдий ч энэ нь практик үр дагавартай байна. Тухайлбал: хууль сахиулах байгууллага ХХГХ-тэй тэмцэх, түүнийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх явцад нэгдсэн ойлголттой бол хууль тогтоомжийг нэг мөр ойлгож хэрэглэхэд дөхөмтэй болно.

ХХГХ-тэй тэмцэх чиглэлийн ном, гарын авлагад харьцуулалт хийснээр сургалт, эрдэм шинжилгээний хувьд зохих үр дагаврыг бий болгоно. Өөрөөр хэлбэл ХХГХ-ийн талаар эрдэмтэн судлаачид судалгаа хийх, бага, дунд болон их, дээд боловсролын сургалтын тогтолцоонд энэ чиглэлээр тодорхой хичээл орох, эрх зүйн болон хууль сахиулах чиглэлийн сургалтад гүнзгийрүүлэн авч үзэх зэрэг өргөн хүрээний зэрэг үр дагаврууд байна гэж ойлгож байна.

ХХГХ-ийн хохирогч, гэрчтэй харилцахад гарах хүндрэлтэй тал байгааг судалгааны бүтээлүүдэд нэлээд авч үзсэн байна. Гэвч тэдний аюулгүй байдал үнэн хэрэгтээ зөрчигдөх нөхцөл байгааг тэмдэглэж буй нь анхаарал татна. Өөрөөр хэлбэл гарсан бүтээлүүдэд хохирогч, гэрчийн аюулгүй байдлыг хангах механизм бүрдээгүй байгаа явдлыг бид цаашид засах, сайжруулах алхам хийх нөхцөл байгааг авч үзжээ. Тийм ч учраас бидний өмнө уг судалгаа нь хэд хэдэн шийдвэрлэх асуудлыг тавьж байгаа нь зүйтэй болжээ.

4.2. Судалгааны зорилго, зорилт

ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр гарсан судалгааны бүтээлүүдийг цуглуулж тэдгээрт дүн шинжилгээ хийснээр цаашид энэ чиглэлээр бичигдэх ном, гарын авлага ямар агуулгатай байж болох, дутуу орхигдуулсан зүйлсийг улам баяжуулан судлах, одоо байгаа зарим ойлголтын зөрүүг нэгтгэж өгөх, энэ гэмт хэрэгтэй тэмцэх шинэлэг арга барилыг нэвтрүүлэхэд ном бүтээлийн ач холбогдол ямар чухал болохыг нээж өгөхөд оршино.

Бид дээрх зорилгод хүрэхийн тулд дараах зорилтыг дэвшүүлсэн. Үүнд:

- Монгол Улсад ХХГХ-ийн талаар хэвлэгдсэн ном бүтээлүүдийг цуглуулж тухайн номын давуу талыг нь товч тэмдэглэж авах, түүндээ дүгнэлт хийх,

- Нэгэнт хэвлэгдсэн ном, гарын авлагууд нь өөр хоорондоо агуулгын давхцал байгаа эсэх, агуулга зөрүүтэй бол ямар байдлаар ялгарч байгааг матрицаар харуулах,
- Хамгийн бага давхцалтай байгаа бүлгийг олж илрүүлэх, цаашид шинээр цогц сургалтын материал боловсруулах нөхцөл боломжийг бүрдүүлэх зэрэг болно.

4.3. Судалгааны арга зүй

Бид судалгааг хийхдээ шинжлэх ухааны арга, арга зүйн хүрээнд тухайлбал анализын, синтезийн арга, харьцуулалтын арга, түүвэрлэлтийн арга, харьцуулалтын арга, матриц боловсруулах аргуудыг өргөнөөр ашиглалаа.

4.4. Судалгааны үр дүн

1. Бид нийт 46 асуулга тавьж матриц /№1, №2/ хийсэн. Судалгаанд хамрагдсан 12 гарын авлага, номд бүтээлүүдэд ХХГХ-ийн ойлголт ямар нэг хэмжээгээр дурдагдсан байна. Төдий л зөрүүгүй байдлаар бичиж ирсэн нь нийт бүтээлүүдэд байгаа агуулгаар бататгагдана. Нийт 16 ном, судалгааны ажил, тайлан⁴³ байгаа боловч практик хэрэглээнд хүндрэлтэй нөхцөл байдал байсаар байгаа. Энэ нь бүтээлийн хүртээмж, сургалт, сурталчилгаа бага байгааг илтгэнэ. ХХГХ-ийн ойлголтыг сонгон авсан 12 бүтээлээс АС, ХТЭТ-ийн хамтын бүтээл, “ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх нь, сургагч багшийн гарын авлага”, Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам⁴⁴, НҮБ-ын Хүүхдийн сан, ХТЭТ, Цагдаагийн академи⁴⁵, Хилийн цэргийн дээд сургуулийн хамтын бүтээл, “Хүн худалдаалах гэмт хэрэг” /багшийн болон суралцагсдын гарын авлага/, Хүйсийн тэгш эрхийн төв, “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх” /Цагдаа, ХШНА-ны ажилтнуудад зориулсан/, Хүйсийн тэгш эрхийн төв, Хүний аюулгүй байдлын судалгааны төвийн хамтын бүтээл, “Монгол Улс дахь ХХГХ-ийн зураглал”, С.Гантулга, “Хүн худалдаалах гэмт хэрэг”, С.Ю.Журавлев нарын хамтын бүтээл, “Хүн худалдаалах гэмт хэрэг мөрдөх ажиллагааны арга зүй, тактик” /орчуулгын бүтээл/, Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага, “ХХГХ-ийн хохирогчдод үзүүлэх шууд тусламжийн гарын авлага” зэрэг бүтээлүүдэд агуулсан байна. Гэхдээ энэ нь тухайн ном, гарын авлагын зориулалтаас шалтгаалсан байсныг тэмдэглэх нь зүйтэй.
2. Түүхэнд ХХГХ хэрхэн үйлдэгдэж ирсэн талаар бүтээлүүдэд маш товч хэлбэрээр авч үзсэн байна. Тухайлбал, АС, ХТЭТ-ийн хамтын бүтээл, “ХХГХ-

ээс урьдчилан сэргийлэх нь”, сургагч багшийн гарын авлага, Хүйсийн тэгш эрх төв, Хүний аюулгүй байдлын судалгааны төвийн хамтын бүтээл, “Монгол Улс дахь ХХГХ-ийн зураглал”, Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам, НҮБ-ын Хүүхдийн сан, ХТЭТ, Цагдаагийн академи, Хилийн цэргийн дээд сургуулийн хамтын бүтээл, “Хүн худалдаалах гэмт хэрэг” /багшийн болон суралцагсдын гарын авлага/, ХТЭТ, “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх гарын авлага” /Цагдаа, ХШНА-ны ажилтнуудад зориулсан/, С.Гантулга, “Хүн худалдаалах гэмт хэрэг”, С.Ю.Журавлев нарын хамтын бүтээл, “Хүн худалдаалах гэмт хэрэг мөрдөх ажиллагааны арга зүй, тактик” /орчуулгын бүтээл/ зэрэг бүтээлүүдэд ХХГХ-ийн түүхэн тоймыг авч үзсэн байна. Ингэхдээ маш товч хэлбэрээр судалсан байгаа нь түүхэн талаасаа судалгааг зарим талаар орхигдуулсан гэж үзэх үндэслэлтэй байна. Цаашид ХХГХ түүхэнд хэрхэн тэмдэглэгдэн үлдсэн талаар нарийн судлах шаардлагатай. Энэ нь уг гэмт хэрэгтэй тэмцэх арга замыг боловсронгуй болгоход онцгой учир холбогдолтой. Гадаад орнуудад уг гэмт хэрэг үйлдэгдэж ирсэн, Монгол Улсад хэрхэн үйлдэгдэж ирсэн зэргээр өвөрмөц онцлог байдлаар нь судлах нь зүйтэй гэж үзэж байна.

3. Олон улсын гэрээ конвенцүүдийн талаар АС, ХТЭТ-ийн хамтын бүтээл, “ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх нь, сургагч багшийн гарын авлага”, Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам, НҮБ-ын Хүүхдийн сан, ХТЭТ, Цагдаагийн академи, Хилийн цэргийн дээд сургуулийн хамтын бүтээл, “Хүн худалдаалах гэмт хэрэг” /багшийн болон суралцагсдын гарын авлага/, ХТЭТ, “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх гарын авлага” /Цагдаа, ХШНА-ны ажилтнуудад зориулсан/, ХТЭТ, Хүний аюулгүй байдлын судалгааны төвийн хамтын бүтээл, “Монгол Улс дахь ХХГХ-ийн зураглал”, С.Ю.Журавлев нарын хамтын бүтээл, “Хүн худалдаалах гэмт хэрэг мөрдөх ажиллагааны арга зүй, тактик” /орчуулгын бүтээл/ бүтээлүүдэд түгээмэл оруулж өгөхийг зорьсон байгаа нь ажиглагдаж байна. Гэхдээ бүрэн эхээрээ бус тодорхой бүтээлд цухас авч үзсэн нь тухайн бүтээлийн зориулалтаас шалтгаалсан байна. Олон улсын гэрээ, конвенцийн агуулга, учир холбогдлыг түлхүү тайлбарлан таниулах нь чухал гэж үзэж байна.
4. Мөрдөн шалгах ажиллагааг хохирогч төвтэй явуулах талаар нийт бүтээлүүдэд товч агуулгаар тусгасан бол Хууль зүйн яам, АС, “Хүн худалдаалах

⁴³ Хавсралтад дурдсан бүтээлүүд

⁴⁴ Хуучин нэрээр

⁴⁵ Хуучин нэрээр

- гэмт хэрэгтэй тэмцэхэд мөрдөгчийн ур чадварыг дээшлүүлэх модуль сургалтын гарын авлага”, ХТЭТ, Хүний аюулгүй байдлын судалгааны төвийн хамтын бүтээл, “Монгол Улс дахь ХХГХ-ийн зураглал”, С.Ю.Журавлев нарын хамтын бүтээл, “Хүн худалдаалах гэмт хэрэг мөрдөх ажиллагааны арга зүй, тактик” /орчуулгын бүтээл/, Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага, “ХХГХ-ийн хохирогчдод үзүүлэх шууд тусламж” зэрэг гарын авлагуудад хохирогч төвтэй мөрдөн шалгах ажиллагаа явуулах талаар тусгасан нь мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий байгууллага, албан тушаалтанд төдий л хүртээмжгүй байна гэж үзэх үндэслэлтэй байна. Цаашид хохирогч төвтэй мөрдөн шалгах ажиллагааны талаар тусгай сургалт зохион байгуулах, мөрдөгчдийн хандлагад нөлөөлөхүйц ном гарын авлага гаргах нь зүйд нийцнэ гэж үзлээ.
5. Цагдаагийн байгууллагад зориулсан нэг сэдэвт бүтээл, гарын авлага хэдийгээр гараагүй байгаа ч Хууль зүйн яам, АС, “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхэд мөрдөн байцаагчдын ур чадварыг дээшлүүлэх модуль сургалтын гарын авлага”, ХТЭТ, “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх гарын авлага” /Цагдаа, ХШНА-ны ажилтнуудад зориулав/, С.Ю.Журавлев нарын хамтын бүтээл, “Хүн худалдаалах гэмт хэрэг мөрдөх ажиллагааны арга зүй, тактик” /орчуулгын бүтээл/, Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага, “ХХГХ-ийн хохирогчдод үзүүлэх шууд тусламж”-ийн гарын авлага, Хүний эрх Хөгжил Төв, “ХХГХ-ийн асуудлаар ажилладаг хуулийн байгууллагын ажилтнуудад зориулсан гарын авлага”-д цагдаагийн алба хаагчид болон мөрдөгчид зориулсан дэд бүлэг, хэсэг байна. Цаашид зөвхөн цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагчдад зориулсан нэг сэдэвт бүтээл, гарын авлага боловсруулах нь тэдний үйл ажиллагааг цэгцлэх, нэгдсэн ойлголттой болох нөхцөлийг бүрдүүлэх үндэс болно гэж үзэж байна.
 6. ХШНА, ГИХГ-ын эрх бүхий алба хаагчдад зориулсан гарын авлага хомс байна. Тухайлбал Хууль зүйн яам, АС, “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхэд мөрдөн байцаагчдын ур чадварыг дээшлүүлэх модуль сургалтын гарын авлага”, ХТЭТ, “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх гарын авлага” /Цагдаа, ХШНА-ны ажилтнуудад зориулав/-д тодорхой тусгасан. Цаашид эдгээр албанд зориулсан гарын авлага, сургалтын материал бэлтгэж, сургалт зохион байгуулах шаардлагатай байна.
 7. ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр боловсруулсан сургалтын материал, судалгааны ажлууд хэдийгээр тооны хувьд олон байгаа ч нийт судалгааны ажлуудад ХХГХ нь бусад зохион байгуулалттай гэмт хэрэгтэй холбогдож байгааг авч үзээгүй байна. Гэтэл ХХГХ нь бусад зохион байгуулалттай гэмт хэрэг /мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлт, зэвсгийн наймаа, мөнгө угаах, терроризм үйлдэх/-тэй уялдаатай байж болох талтайг авч үзээгүй байгааг бид цаашид гарах гарын авлага, судалгаандаа оруулж өгөх шаардлагатай гэж үзэж байна.
- Хууль зүйн яам, АС, “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхэд мөрдөн байцаагчдын ур чадварыг дээшлүүлэх модуль сургалтын гарын авлага”, АС, Хууль зүйн үндэсний хүрээлэн. “Хүн худалдаалах гэмт хэрэг”, шүүгч, прокурорт зориулсан гарын авлагуудад ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр прокурор, шүүгч, шүүхийн байгууллага хэрхэн ажиллах талаар тусгасан. Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд тэдэнд ХХГХ-ийг хянан хэлэлцэх, шүүн таслах талаар шинэ ном, гарын авлага боловсруулан сургалт, сурталчилгаа явуулах нь уг гэмт хэргийг шийдвэрлэх практикийг зөв тогтоох үндэс болно.
 - Дотоодын хууль тогтоомжуудыг маш товч агуулгаар нь буюу зүйл, заалтаар нь тусгаж өгсөн бүтээл байгаа нь ажиглагдсан. Гэхдээ тодорхой хууль тогтоомжуудыг зайлшгүй оруулж өгөх ёстой байсан ч огт авч үзээгүй байгаа нь анхаарал татаж байна. Тухайлбал: Хүүхдийн эрхийн тухай хууль⁴⁶, Хүүхэд хамгааллын тухай хууль⁴⁷, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль⁴⁸, Гэр бүлийн тухай хууль⁴⁹, Үндэсний хөтөлбөрүүдийг төдий л тусгаж авч үзээгүй байна. Цаашид эдгээр хууль тогтоомжуудыг нарийн судлан авч үзэх шаардлагатай. Учир нь эдгээр хууль тогтоомжийн боловсронгуй бус байдалтай холбоотойгоор хууль бус үрчлэлт, захиалгат гэрлэлт, хүүхдийн хөдөлмөрийн мөлжлөг үйлдэгдэх нэгэн шалтгаан нөхцөл болно гэж судлаачдын хувьд дүгнэж байна. Иймд бид хууль тогтоомжийн уялдаа холбоог сайтар нарийвчлан харьцуулан судлах нь зүйтэй.
 - ХХГХ-тэй тэмцэх сайн туршлага төдий л тохиолдохгүй байгаа нь анхаарал татаж байна. Цагдаагийн байгууллагын зүгээс ХХГХ-ийг мөрдөх, нотлох

⁴⁶ <http://legalinfo.mn/law/details/11709?lawid=11709>

⁴⁷ <http://legalinfo.mn/law/details/11710?lawid=11710>

⁴⁸ <http://legalinfo.mn/law/details/546?lawid=546>

⁴⁹ <http://legalinfo.mn/law/details/226?lawid=226>

ажиллагааны талаар тодорхой алхмуудыг хийсэн байна. Энэ нь өнөөгийн байдлаар туршлага гэхээсээ илүүтэйгээр практик тогтох шатандаа явж байна. Цаашид гадаад улс орнуудын сайн туршлагаас хуваалцах хэрэгцээ зүй ёсоор тавигдана. Бидний судалгааны хүрээнд авсан ном, гарын авлагуудад сайн туршлага бага байгаа нь энэ чиглэлээр судалгааг өргөтгөх шаардлагатайг илтгэн харуулж байна гэж үзлээ.

- ХХГХ-ийн эрүүгийн эрх зүйн шинжийг нийт бүтээлүүдийн үндсэндээ тал хувьд нь авч үзсэн байна. Цаашид шинээр боловсруулах ХХГХ-тэй тэмцэх цогц сургалтын гарын авлагыг нэн яаралтай боловсруулах, нийтийн хүртээл болгох хэрэгцээ шаардлага байна. Учир нь ЭХ-ийн шинэчилсэн найруулга 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Гэвч одоо байгаа бүтээлүүд нь хуучин ЭХ-ийн агуулгад тулгуурлан бичигдсэн байна.
- ХХГХ-ийн криминологи шинжийн талаар АС, ХТЭТ-ийн хамтын бүтээл, “ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх нь, сургагч багшийн гарын авлага”, Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам, НҮБ-ын Хүүхдийн сан, ХТЭТ, Цагдаагийн академи, Хилийн цэргийн дээд сургуулийн хамтын бүтээл, “Хүн худалдаалах гэмт хэрэг” /сургагч багшийн болон суралцагсдын гарын авлага/, ХТЭТ, Хүний аюулгүй байдлын судалгааны төвийн хамтын бүтээл, “Монгол Улс дахь ХХГХ-ийн зураглал”, С.Гантулга, “Хүн худалдаалах гэмт хэрэг”, АС, Хууль зүйн үндэсний хүрээлэн, “Хүн худалдаалах гэмт хэрэг”, “Шүүгч, прокурорт зориулсан гарын авлага” зэрэг бүтээлд авч үзсэн. ХХГХ-ийн криминологи шинжийг дахин авч үзэх, илүү дэлгэрэнгүйгээр тодорхойлох хэрэгцээтэй гэдэг нь ажиглагдсан. Учир нь ХХГХ-ийн бүтэц, хөдөлгөөн өөрчлөгдөж илүү боловсронгуй болж байгаа нь анхаарал татлаа. Цаашид шинээр авч үзэх хэрэгтэй байна.
- Зүйлчлэлийн хувьд нийт бүтээлүүдийн тал хувьд нь авч үзжээ. Эрүүгийн хэрэг үүсгэх, шалгах явцад зүйлчлэл өөрчлөгдөх тохиолдол байгаа нь төсөөтэй гэмт хэргээс ялгахад хүндрэлтэй байсантай холбоотой гэж үзнэ. Өөрөөр хэлбэл гадаад, дотоодод ажилд зуучлах замаар бусдын биеийг үнэлүүлэхийг зохион байгуулах явдал нь хүндрэлтэй байсан. Одоо бид шинээр батлагдсан ЭХ-д /13.1 дүгээр зүйл/ байгаа энэ гэмт хэргийн талаар харьцуулан судлах шаардлагатай байгааг тэмдэглэж байна.
- ХХГХ-ийн хэлбэрүүдийн талаар нэлээд судалсан байгаа нь ном, гарын авлагаас харагдаж байна. Гэхдээ тухайн ном, гарын авлагын зориулалтаас шалтгаалж

авч үзээгүй байгаа байдал байсан болно. Уг агуулга нийтлэг байдлаараа боломжийн хэмжээнд судлагдсан байна.

- ХХГХ-ийн шалтгаан нөхцөлийн талаар АС, ХТЭТ-ийн хамтын бүтээл, “ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх нь, сургагч багшийн гарын авлага”, Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам, НҮБ-ын Хүүхдийн сан, ХТЭТ, Цагдаагийн академи, Хилийн цэргийн дээд сургуулийн хамтын бүтээл, “Хүн худалдаалах гэмт хэрэг” /сургагч багшийн болон суралцагсдын гарын авлага/, ХТЭТ, “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх гарын авлага” /Цагдаа, ХШНА-ны ажилтнуудад зориулав/, ХТЭТ, Хүний аюулгүй байдлын судалгааны төвийн хамтын бүтээл, “Монгол Улс дахь ХХГХ-ийн зураглал”, Хүүхдийн төлөө газар, ХТЭТ-ийн хамтын бүтээл, “Хүүхэд худалдаалах гэмт хэрэг” /нийгмийн ажилтнуудад зориулсан гарын авлага, С.Гантулга, “Хүн худалдаалах гэмт хэрэг” зэрэг бүтээлүүдэд боломжийн хэмжээнд авч үзсэн байна. Шалтгаан нөхцөлийг судлахдаа уламжлалт криминологийн арга, арга зүйгээр авч үзсэн нь төдий л анхаарал татахгүй байна. Бид уг гэмт хэргийн шалтгааныг тодорхойлохын тулд шинэ үеийн криминологийн арга, арга зүйд үндэслэн авч үзэх хэрэгцээ шаардлага байгааг анхаарах цаг болжээ. Цаашид бүтээл гаргахдаа энэ талаар анхаарах, зайлшгүй өөр байдлаар бичих нь зүйтэй. Хэрвээ тийнхүү авч үзэхгүй бол бид энэ гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэж чадахгүй гэдэг нь ойлгомжтой болно.
- ХХГХ-ийн хохирогчид тусламж үзүүлэх, дэмжлэг үзүүлэх, хамгаалах чиглэлээр Австралийн хөгжлийн агентлаг, ХТЭТ-ийн хамтын бүтээл, “Бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэргийн хохирогчид туслалцаа үзүүлэх” гарын авлага, “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх гарын авлага” /Цагдаа, ХШНА-ны ажилтнуудад зориулав/, ХТЭТ, Хүний аюулгүй байдлын судалгааны төвийн хамтын бүтээл, “Монгол Улс дахь ХХГХ-ийн зураглал”, Хүүхдийн төлөө газар, ХТЭТ-ийн хамтын бүтээл, “Хүүхэд худалдаалах гэмт хэрэг” /нийгмийн ажилтнуудад зориулсан гарын авлага/, Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага, “ХХГХ-ийн хохирогчдод үзүүлэх шууд тусламж” гарын авлага зэрэг бүтээлд тусгасан. ХХГХ-ийн улмаас хохирсон хохирогч нь сэтгэл зүйн хувьд маш түвэгтэй нөхцөлд байсны улмаас хүнд итгэхгүй болох, амьдрах хүсэлгүй болох зэргээр хүнд нөхцөлд байдаг тул тэдэнд дэмжлэг үзүүлэх, сэргээх, сэтгэл зүйн хувьд анхаарал хандуулах, хамгаалах шаардлага зүй ёсоор тавигдана. Хууль сахиулах байгууллагын ажилтны зүгээс ХХГХ-ийн хохирогчид сэтгэл зүйн дэмжлэг, туслалцааг үзүүлэх мэдлэг, чадвартай байхыг шаардах болжээ.

Цаашид хохирогч хамгаалах, тэдэнтэй харилцах чиглэлээр тактикийн шинжтэй зүйлсийг нарийн судлах шаардлагатай.

- ХХГХ-ийг нотлох ажиллагаа, нотлох баримт түүний эх сурвалжуудыг тогтоох талаар онолын шинжтэй зүйлс тусгасан, мэдүүлэг авахдаа асууж болох асуултын хүрээ хязгаарыг гаргаж өгснийг харахад боломжийн тусгагдсан байна. Гэхдээ энэ гэмт хэргийн онцлог байдлаас хамаарч маш олон төрлийн нотлох баримтууд үлдэх боломжтой тул цаашид нотлох баримтын эх сурвалжийн хувьд нарийн судлах шаардлага байна. Уг гэмт хэргийг ил мөрдөн шалгах ажиллагаагаар нотлохоосоо илүүтэй нууц мөрдөн шалгах ажиллагааг хослуулснаар нотлох боломжтой тул энэ чиглэлийн зүйлсийг тусгаж өгөх шаардлагатай байна.
- ХХГХ-ийн криминалистик шинжийг огт авч үзээгүй байна. Тийм ч учраас ХХГХ-ийн криминалистик шинжийг маш нарийн тодорхойлж өгөх шаардлага үүсэн бий болж байна. Хэрвээ энэ гэмт хэргийн криминалистик шинжийг тодорхойлж өгөхгүй бол мөрдөх арга зүй боловсронгуй болж чадахгүй. Бидний үзэж байгаагаар мөрдөх арга зүйг илүү түвшинд гарахыг хүсвэл гарцаагүй криминалистик шинжийг тодорхойлж өгөх ёстой гэж үзсэн болно.
- ХХГХ-тэй тэмцэхэд хамтын ажиллагаа сайнгүй байна. Хамтын ажиллагааны хэмжээ хязгаар нь эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ бүхий улсуудаар хэмжигдэнэ. Энэ нөхцөл байдал нь бидний өмнө хүндрэлтэй байдлыг бий болгодог. Нийт бүтээлүүдэд энэхүү агуулга боломжийн хэмжээнд бичигдсэн байна. Боловсронгуй болгоход чиглэсэн асуудлыг судлаачид авч үзэх шаардлага байна.
- Хүн худалдаалах болон хүний цус, эд эрхтэн хууль бусаар авах гэмт хэрэгтэй эрүүгийн тагнуулын ажлаар тэмцэх талаар доктор хамгаалсан эрдэмтэн, судлаачид /хууль зүйн доктор /Ph.D/ Р.Баярмагнай, хууль зүйн доктор /Ph.D/ С.Гантулга байгаа нь зүй ёсоор энэ гэмт хэрэгтэй тэмцэх шинжлэх ухаанч замыг чиглүүлэх нөхцөл бүрдэж байгааг илтгэнэ.

4.5. Дүгнэлт, санал

- ХХГХ-ийн түүхийг илүү дэлгэрэнгүй авч үзэх шаардлагатайг бид дурдсан. Бие даасан ном гаргах шаардлагатай гэж бид үзэж байна. Өөрөөр хэлбэл ХХГХ-ийн түүхийг бичсэнээр хойч үеийнхэндээ уг гэмт хэргийн хор хөнөөл, аюул, заналхийллийг ойлгуулах онцгой ач холбогдолтой. Түүхэн үзэгдлийнхээ хувьд ямар хэлбэр, төрлөөр улам бүр баяжиж байгааг зурагт тайлбар толь гаргах замаар нийтэд мэдээлэх нь энэ гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх механизмыг улам бүр боловсронгуй болгоно.
- Зарим ном, гарын авлага ХХГХ-ийн талаар иж бүрэн авч үзэх гэж оролдсон оролдлоготой байгаа нь сайшаалтай. Гэвч иж бүрэн авч үзэх гэсэн зорилт тавих тусам агуулга багасах, ерөнхийлөх байдал уруу шилжсэн байна. Энэ нь бидний бүтээлд нийтлэг ажиглагдаж байна. Гэтэл ХХГХ мөрдөх арга зүй, тактик гэсэн орчуулгын бүтээл нь нэлээд чамбай байна. Ямар хэргийг мөрдөж байна вэ гэдгээсээ шалтгаалж өмнөө тавьсан зорилгодоо хүрэхэд шаардлагатай арга, арга зүйг нарийн зааж өгсөн байна. Дотоодын бүтээлүүдэд уг номоос шингээж болох талтай байна.
- Дотоодын бүтээлд ХХГХ-т шинжилгээ хийхтэй холбоотой зүйл дурдагдаагүй байна. ХХГХ үйлдэгдсэн тохиолдолд илрүүлж бэхжүүлсэн мөр, эд мөрийн баримтад шинжилгээ хийх арга зүйн талаар тусгаж өгөх нь мөрдөх ажиллагаанд чухал нөлөөтэй. Хэрвээ шинжилгээ зүйн асуудал орхигдвол бид асуудалд иж бүрэн хандахгүй байгааг илтгэх хэрэг болно. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, ХСИС-ийн Шинжлэн магадлахуйн тэнхимтэй хамтран энэ агуулгыг судлах нь илүү оновчтой гэж үзсэн.
- ХХГХ-ийн хохирогч хамгаалах асуудлаар нэлээд зүйлс бичсэн бүтээл байна. Хохирогч хууль сахиулах байгууллагад хандахгүй байгаа байдал чухам ямар шалтгаантайг бид анхаарах ёстой. Яагаад хандахгүй байгааг хүний эрхийн байгууллагын судлаач нар тогтоосон байгааг бид үйл ажиллагаандаа авч хэрэгжүүлэх шаардлагатай.
- ХХГХ үйлдэгдсэн газар үзлэг, нэгжлэг хийх гэх зэргээр мөрдөн шалгах ажиллагаа явуулах тактикийн талаар цаашид авч үзэх шаардлагатай болжээ. Бидний судалгаанд авсан бүтээлүүдэд тактик зүйн асуудал харьцангуй бага байгааг бид урагшлуулж, хөгжүүлэх ёстой болно.
- ХХГХ-тэй тэмцэхэд хууль сахиулах байгууллага ямар чухал болохыг бид заавал авч үзэж байх нь зүй ёсны хэрэг. Гэтэл хамтын ажиллагааг хэлбэр төдий судлах явдал судалгааны ном, гарын авлагуудад ажиглагдлаа.

Цаашид ХХГХ-тэй тэмцэхэд хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа, тактик гэсэн чиглэлийг нарийн судлах, дараа дараагийн бүтээлд түлхүү оруулж өгөх шаардлагатай.

- ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогч төвтэй мөрдөн шалгах ажиллагаа болон хууль сахиулах байгууллагуудын /Цагдаа, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, Хил хамгаалах алба, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, ГИХГ, Хууль зүйн туслалцааны төв, ХСИС/ ажлын уялдаа холбоог сайжруулах, тусгайлан зориулсан гарын авлага боловсруулах нь зүйтэй.
- ХХГХ-ийг эрүүгийн тагнуулын ажлаар илрүүлэх нь түгээмэл бөгөөд бид Эрүүгийн цагдаагийн албаны холбогдох нэгжид эрдэмтэн, судлаачдаа ажиллуулах,

мэдээлэл, туршлагаа солилцох шаардлагатай. Энэ нь цаашид ХХГХ-ийн илрүүлэлтэд эерэг нөлөөтэй гэж үзэж байгаа юм. Мөн эрүүгийн цагдаагийн албаны эрх бүхий алба хаагчид зориулсан гарын авлага боловсруулах нь зүйтэй гэж үзэж байна.

- Шинээр батлагдсан Эрүүгийн болон ЭХХШТХ-ийн агуулгаар бид ХХГХ-ийн талаар шинэлэг тодорхойлолт гаргах болсон байна. ХХГХ-ийг эрүүгийн эрх зүйн үүднээс тайлбарлах, хохирогч төвтэй мөрдөн шалгах ажиллагааг оновчтой, зөв зохион байгуулах, ингэхдээ ил болон нууц мөрдөн шалгах ажиллагааг оновчтой хослуулан явуулах, прокурор, шүүх, ХШНА, ГИХГ-ын алба хаагчдад энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд шаардлагатай мэдээлэл өгөхүйц иж бүрэн сургалтын гарын авлагыг боловсруулах зайлшгүй шаардлагатай байна.

БҮЛЭГ 5.

ШҮҮГЧ, ПРОКУРОР, ЦАГДАА, ХИЛ
ХАМГААЛАХ БОЛОН ГАДААДЫН
ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН АЛБА
ХААГЧДЫН ХҮН ХУДАЛДААЛАХ
ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ
ХОХИРОГЧ ТӨВТЭЙ АРГАЧЛАЛЫГ
ХЭРЭГЛЭХ ЧАДАВХЫГ ҮНЭЛЭХ
СУДАЛГААНЫ ТАЙЛАН

1. Цагдаагийн байгууллага
2. Прокурорын байгууллага
3. Шүүх эрх мэдлийн байгууллага
4. Хил хамгаалах ерөнхий газрын Хилийн шалган нэвтрүүлэх алба
5. Гадаадын иргэн, харьяатын газар
6. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч


5.1. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧДААС АВСАН САНАЛ АСУУЛГЫН ДҮН

ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ БАЙДАЛ

Улаанбаатар хотын 8 дүүргийн 16 газар болон Өмнөговь, Дорнод, Сэлэнгэ, Дорноговь аймгийн Замын-Үүд сумын цагдаагийн газар, хэлтсүүдийн цагдаа, мөрдөгч, эрүүгийн мөрдөгч, удирдлагуудыг санамсаргүйгээр сонгон 200

хүнийг санал асуулгад оролцууллаа. Хүйсийн хувьд 86.5% (173) нь эрэгтэй, 13.5% (27) нь эмэгтэй, байршлаар 20% (40) нь орон нутгаас, 80% (160) нь Улаанбаатар хотоос оролцсон бол ажлын туршлагын хувьд цагдаагийн байгууллагад 1–27 жил ажилласан байлаа. (Зураг 1.1)


Зураг 1.1. Судалгаанд оролцогчдын насны бүлэг, хүйсээр



Судалгаанд оролцогчдыг албан тушаалын бүтцээр харвал 39.5% (79) нь мөрдөгч, 15% (30) нь удирдах ажилтнууд, 25% (50) нь цагдаа, 20.5% (41) нь эрүүгийн мөрдөгчид байсан. Нийт судалгаанд оролцогчдын 50% (100) нь цагдаагийн байгууллагад 6–аас дээш жил ажилласан боловч 70% (140) нь одоогийн албан тушаал дээрээ томилогдоод 1–5 жил болж байна. (Зураг 1.2)

Энэ тооноос харахад цагдаагийн байгууллагын ажилтнуудын дийлэнх нь тухайн ажиллаж буй албан тушаалаараа мэргэшиж, тогтвор суурьшилтай ажиллаж чадахгүй байгаа дүр зураг харагдаж байна.

Зураг 1.2. Цагдаагийн байгууллагад ажилласан хугацаа




ХХГХ-ИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТ, МЭДЛЭГ

ХХГХ-ийн талаарх ойлголтын талаар тодруулахад санал асуулгад оролцогчдын 70% (140) нь бүрэн болон бүрэн бус байдлаар ЭХ-ийн тодорхойлолтын дагуу ХХГХ-ийг томъёолж хариулж байсан бол 5% (10) нь огт мэдэхгүй, 25% (50) нь хариулахаас татгалзсан. ХХГХ-ийг тодорхойлохдоо ЭХ-ийн заалтаас гадна хүний эрх чөлөөнд халдаж буй гэмт хэрэг, өрийн дарамтад оруулах, бие биеэ барьцаалах, цалин

хөлсийг өгөхгүй байх ноцтой гэмт хэргийг хэлнэ гэж үзсэн. Нийт судалгаанд оролцогчдын 78% (156) нь буюу 5 хүн тутмын 4 нь хүний биеийг хүчээр үнэлүүлэх, 59% (118) нь бэлгийн мөлжлөг, 35% (70) нь албадан хөдөлмөр эрхлүүлэх асуудлыг Монгол улсад давамгайлж байна гэж үзсэн бол 26% (52) нь тээгч эхийн болон эд эрхтний наймааг онцгойлон авч үзсэн байна. (Зураг 1.3)

Зураг 1.3. Таны бодлоор Монгол Улсад ХХГХ-ийн аль хэлбэр илүү давамгайлж байгаа вэ?



* Олон сонголттой хариулт учир 100% барихгүй

ХХГХ үйлдэгдэхэд дийлэнхдээ нийгмийн хүчин зүйлс болох ажилгүйдэл, ядуурал, нийгмийн тогтворгүй байдал, хувь хүнээс нөлөөлөх хүчин зүйлсэд ар гэрийн хараа хяналт сул, мөнгөний ашиг сонирхол ихтэй, хууль эрх зүйн мэдлэг мэдээлэл дутмаг байдлууд энэ гэмт хэрэгт нөлөөлж байна гэж хариулжээ. Хүснэгт 1.1-д үзүүлсэн хариултуудаас

харахад энэ гэмт хэргийн гаралтад нийгмийн хүчин зүйлс нь хувь хүний хүчин зүйлсээс 2 дахин их нөлөөлж байгааг харуулжээ. Эдгээр хүчин зүйлс нь ХХГХ-т өртөх эрсдэлийг нэмэгдүүлж, хохирогчийг улам эмзэг болоход нөлөөлж байна гэж дүгнэж болохоор байна.


Хүснэгт 1.1. Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлж буй хүчин зүйлс

Нийгмийн хүчин зүйлс	Хувь	Хувь хүний хүчин зүйлс	Хувь
Ядуурал	44.5%	Ар гэрийн хараа, хяналт сул	14%
Ажилгүйдэл	30.5%	Мэдлэг, мэдээлэл дутмаг	21.5%
Нийгмийн тогтворгүй байдал	23%	Мөнгөний ашиг сонирхол	19.5%
Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа хангалтгүй	19%	Хувь хүний зан байдал, төлөвшил	7.5%
Цахим ертөнц	4%	Мансуурах бодист донтох	1%
Архидалт	6%	Гадаад явах хүсэл, сонирхол	11%
Эдийн засгийн хүндрэл	28%	Өрийн сүлжээ, өрийн дарамт	7%

Судалгаанд хамрагдсан цагдаагийн албан хаагчдын 16% (32) нь энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгахад 1–ээс дээш удаа оролцож үзсэн байна. ХХГХ–тэй холбоотой хэргийг Улсын мөрдөн байцаах газрын дэргэдэх Зохион

байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх тасгийн албан хаагчид 3 буюу түүнээс дээш шалгасан бол 65.5% (131) нь буюу 3 мөрдөгч тутмын 2 нь 1–2 удаа мөрдөн шалгахад оролцжээ. (Зураг 1.4)

Зураг 1.4. ХХГХ–тэй холбоотой хэргийг мөрдөн шалгаж оролцсон байдал




Мөрдөн шалгасан хэргүүдийн 68.7% нь биеийг нь хүчээр үнэлүүлэх, 53.1% нь бэлгийн мөлжлөгийн хэргүүд байжээ. ХХГХ–ийг шалгахдаа эрсдэлтэй гэж үзсэн хохирогчтой ажиллахдаа хэрэглэдэг тусгай асуумж, арга техник, журам байдаг гэж 11.5% (23) нь хариулсан. Тухайн баримт бичгийг нэрлэхийг хүсэхэд тухайлсан журам, дүрэм, стандартыг нэрлэсэн хүн байхгүй байсан бөгөөд 5 хүн ЦЕГ–ын журам, 8 хүн мөрдөн шалгах ажиллагааны журмын дагуу, 7 хүн ярилцаж тайвшруулан нөхцөл байдлыг үнэлэх гэсэн бол 2 хүн тусгай өрөөнд сэтгэл зүйг сэтгэл зүйчээр бэлтгүүлэх журамтай гэж хариулжээ. Харин 88.5% (177) нь ийм журам,

стандарт байхгүй гэж хариулсан нь анхаарал татсан асуудлын нэг юм. Хэдийгээр хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа боловч онцгой гэмт хэргийн хохирогчтой ажиллах арга зүй, стандартыг боловсруулж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх хэрэгцээтэй байгааг харуулж байна.

ХХГХ–ийн хохирогч байх магадлалтай тохиолдол илэрсэн үед 53% (106) нь хуулийн байгууллагад, түүн дотроо прокурорын байгууллагад болон тагнуулын байгууллагад мэдэгдэнэ гэсэн хувь өндөр байна. (Зураг 1.5)

Зураг 1.5. Хохирогч байх магадлалтай тохиолдол илэрвэл хаана хандах вэ?




Мөн 19% (38) нь төрийн байгууллагад буюу харьяалах нийслэл, аймаг, дүүрэг, сумын гэр бүл хөгжлийн газруудад мэдэгдэнэ гэсэн бол 9% (18) нь ТББ-д, 25% (5) нь ар гэрт нь мэдэгдэнэ гэжээ. Харин 2 хүн тэр даруйд гомдол мэдээлэлд бүртгэж шалгана гэсэн байна.

Цагдаагийн байгууллагад ихэвчлэн бүртгэгдэж байгаа хүн худалдаалахтай холбоотой гомдол мэдээллүүдээс бэлгийн мөлжлөг гэж хамгийн өндөр буюу 75.5% (151) хариулсан байна. Мөн албадан хөдөлмөр эрхэлсэн талаар гомдол

хүлээн авдаг гэж 32% (64) нь хариулсан. Хэдийгээр шүүхээр хилийн чанадад болон эх орон дотроо бэлгийн мөлжлөгт өртсөн хэргүүд л шийдвэрлэгдсэн боловч цагдаагийн байгууллагад гэрийн үйлчлэгч, хуурамч гэрлэлтээс хохирсон мэдээллүүд цөөн боловч бүртгэгддэг гэжээ. Одоогийн байдлаар ХХГХ-ийн бэлгийн мөлжлөгөөс бусад төрлийг ЭХ-ийн 113-р зүйлийн дагуу шийдвэрлэсэн тохиолдол бүртгэгдээгүй байна.

Зураг 1.6. Цагдаагийн байгууллагад ХХГХ-тэй холбоотой ихэвчлэн бүртгэгддэг хэргүүд



* Олон сонголттой хариулт учир 100% барихгүй.

ХХГХ бусад зохион байгуулалттай гэмт хэргүүдтэй хамт үйлдэгдэж байна гэж судалгаанд оролцогчдын 50% (100) нь үзсэний 62% (62) нь хар тамхи, 64% (64) нь цахим гэмт хэрэгтэй, 3% (3) нь зэвсгийн наймаатай, харин “бусад” гэж хариулсан 1% (1) оролцогчид залилан, мөнгө угаах зэрэг гэмт хэргүүдтэй хамт үйлдэгдэж байна гэж үзсэн. Харин 13.5% (27) нь ХХГХ бусад зохион байгуулалттай гэмт хэргүүдтэй хамт үйлдэгддэггүй гэжээ.

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн зарчмуудын хэрэгжилт болон хохирогчийг хамгаалах хүний эрхэнд суурилсан хэм хэмжээ, стандартын хэрэгжилтийг

үнэлүүлэхэд дотоодын хууль тогтоомжийн хэрэгжилт хангалттай гэж 24.5% (49) нь үзсэн бол 4.5% (9) нь маш сайн хангалттай хэрэгжилттэй, харин 57% (114) нь хангалтгүй, туйлын хангалтгүй гэж үзсэн. Доорх 8 үзүүлэлтийн хүрээнд маш хангалттай, хангалттай гэж үзсэн үзүүлэлтийн хамгийн өндөр хувийг хувийн нууцыг хамгаалах асуудал гэж оролцогчдын 44% (88) нь хариулжээ. Нийт үзүүлэлтүүдээр авч үзэхэд ойролцоогоор нийт оролцогчдын тал хувь нь болох 48% (96) нь доорх зарчмуудын хэрэгжилт хангалтгүй, туйлын хангалтгүй гэж үзжээ.

Хүснэгт 1.2. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн зарчмуудын хэрэгжилт

д/д	ЗАРЧМУУД	Хангалттай сайн	Хангалттай	Хангалтгүй	Туйлын хангалтгүй	Мэдэхгүй	Хариулаагүй
		(4)	(3)	(2)	(1)	(0)	
1	Дотоодын хууль тогтоомжийн хэрэгжилт	9 (4.5%)	49 (24.5%)	100 (50%)	14 (7%)	16 (8%)	12 (6%)
2	Олон улсын стандарт, гэрээ, конвенцийн хэрэгжилт	10 (5%)	54 (27%)	81 (40.5%)	10 (5%)	31 (15.5%)	13 (6.5%)
3	Хохирогчийн нэр төрийг хүндэтгэх	6 (3%)	70 (35%)	76 (38%)	19 (9.5%)	18 (9%)	11 (5.5%)
4	Хохирогчдыг хүйс, бэлгийн чиг хандлага, иргэншил, үндэс угсаагаар нь ялгаварлан гадуурхахгүй байх	6 (3%)	72 (36%)	73 (36.5%)	14 (7%)	23 (11.5%)	12 (6%)
5	Хохирогчийг үл буруутгах	6 (3%)	56 (28%)	82 (41%)	14 (7%)	30 (15%)	11 (5.5%)
6	Хохирогчийн аюулгүй байдлыг хангах	8 (4%)	51 (25.5%)	87 (43.5%)	17 (8.5%)	21 (10.5%)	16 (8.5%)
7	Хувийн нууцыг нь хамгаалах	21 (10.5%)	67 (33.5%)	63 (31.5%)	21 (10.5%)	17 (8.5%)	11 (5.5%)
8	Олон улсын хамтын ажиллагаа, иргэний нийгмийн оролцоонд түшиглэх	5 (2.5%)	45 (22.5%)	87 (43.5%)	13 (6.5%)	37 (18.5%)	13 (6.5%)

Цагдаагийн ажилтнуудад ХХГХ дээр мөрдөн шалгах ажиллагаа явуулахад тулгардаг хүндрэл, бэрхшээлийг тодруулахад 72% (144) нь энэ төрлийн хэрэг шалгаж, мөрдөж байгаагүй учир мэдэхгүй, хариулахаас татгалзсан. Хариулт өгсөн 56 оролцогчдын 28.6% (16) нь хууль эрхзүйн орчин дутмаг, 12.5% (7) нь нотлох баримт дутмаг, бүрддэггүй байдал гэж хариулсан бол 41% (23) нь хохирогчоос өөрөөс нь

хамаарах шалтгаанууд буюу хохирогчид дуудсан хугацаанд ирдэггүй, олддоггүй, хохирогч мэдүүлгээсээ буцдаг, гэмт хэрэг үүсгүүлэхээс татгалздаг зэргээс гадна хохирогч, гэрчийн аюулгүй байдлыг хангах механизм бүрдээгүй байдал нь хүндрэл, бэрхшээл учруулдаг гэж хариулсан. (Зураг 1.7)

Зураг 1.7. ХХГХ-ийг мөрдөн шалгах ажиллагаа явуулахад тохиолддог хүндрэл



Судалгаанд хамрагдсан цагдаагийн ажилтнуудын 8.5% (17) албан хаагчид хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад хохирогч, гэрч аюулгүй байдлаа хамгаалуулах хүсэлт гаргаж байсан бөгөөд ТББ-ын болон гэр бүлийн хүчирхийллийн хамгаалах байруудад байрлуулах, болзошгүй эрсдэлээс

нь урьдчилан сэргийлэх үйл ажиллагаануудыг авч хэрэгжүүлжээ. Энэ байдлаас харахад хохирогч, гэрч өөрийгөө хамгаалуулах хүсэлт гаргахаа мэддэггүй, гэрч хохирогчийг хамгаалах хуулийн сурталчилгаа хангалтгүй байгаатай холбоотой гэж үзэж болохоор байна.


ХХГХ-ТЭЙ ТЭМЦЭХ ЧИГЛЭЛЭЭР ЯВУУЛЖ БУЙ СУРГАЛТЫН ЧАНАР, ҮР ДҮН

Төрийн байгууллагаас зохион байгуулсан сургалт

Судалгаанд хамрагдагсдын 75.5% (151) нь ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр төрийн зүгээс явуулж буй сургалтад огт хамрагдаагүй бөгөөд төрийн зүгээс явуулсан сургалтад хамрагдаж байсан хүмүүсээс 57% (28) нь л мэргэшүүлэх сургалтын үр дүн сайн гэж үзсэн. Хангалтгүй гэж үзсэн

21 (43%) оролцогч сургалтын цаг бага байсан, агуулга тохиромжгүй байсан гэдгээс гадна хамрагдах боломжгүй, зөвхөн энэ чиглэлээр ажиллаж буй чиглэлийн 1–2 хүн л хамрагддаг, сургалт нь тогтмол бус явагддаг гэж хариулсан. (Зураг 1.8)

Зураг 1.8. Төрөөс явуулж буй сургалтын чанар, үр дүн сайн байсан эсэх



Судалгааны үр дүнгээс харахад төрийн зүгээс зохион байгуулж буй сургалтад хамрагдаж буй хувь маш бага бөгөөд судалгаанд санамсаргүй түүврээр авсан 200 хүний 4 хүн тутмын 3 нь сургалтад хамрагдаагүй байлаа. Сургалтад

хамрагдсан 49 хүний 55% (27) нь 1–3 цагийн сургалтад хамрагдсан бол 4 (8%) хүн 3–аас дээш удаа 1–3 өдрийн сургалтуудад хамрагдаж байжээ.


Хүснэгт 1.3. Ямар хугацаатай сургалтад хамрагдсан бэ?

Сургалтын хугацаа	Тоо	Нийт хариулагчдын хувь	Сургалтад оролцсон бүлэгт хамаарагдах хувь
Энэ чиглэлийн ямар ч сургалтад хамрагдаагүй	151	75.5	0
1–3 цаг	27	13.5	55.1
Хагас өдөр	4	2.0	8.2
Бүтэн өдөр	7	3.5	14.3
2 өдөр	1	.5	2.0
3 өдөр	6	3.0	12.2
4 ба түүнээс дээш өдөр	4	2.0	8.1
Бүгд дүн	200	100.0	100.0

Сургалтад хамрагдсан албан хаагчдын 69.3% (34) нь сургалтын хугацаа хангалттай байсан гэсэн бол хангалтгүй гэж үзсэн оролцогчдын 30.7% (15) нь хугацаа бага, нэг хичээлийг гүнзгийрүүлж үзэх цаг байхгүй, хэт олон багш ганц ганц цагаар мэдээлэл өгдөг зэргээс гадна ажлаас бүрэн чөлөөлж өгдөггүй гэж 2 (4%) оролцогч хариулсан. Сургалтад оролцсон албан хаагчдын 63.3% (31) нь сургалтын агуулга тодорхой, хэрэгцээтэй байсан, ялангуяа ХХГХ-ийн үйлдэгддэг шинж байдал, арга хэлбэр (35.5%), хохирогчийн

сэтгэлзүйн хямралд анхаарч ажиллах, хохирогчтой ажиллах заавар (25.8%), ХХГХ үйлдэгдэх процесс, хяналт тавих ажиллагаа, олон улсын эрхзүйн гэрээ конвенцүүдийн талаар болон бодит кейс дээр мэдээлэл өгсөн сургалтууд хэрэгцээтэй байсан гэж үзсэн. Хэдийгээр их хувийг эзлээгүй ч сургагч багш ур чадвар муутай, мэргэшээгүй, сургалтын хугацаа богино байсан, монгол орны онцлогт тохироогүй, гадаадын мэдээллүүд ихтэй зэрэг дутагдалтай гэж үзсэн 14 (28.6%) оролцогч байсан.

Зураг 1.9. Сургалтыг ямар аргачлалаар хүргэвэл илүү үр дүнтэй вэ?



*Олон сонголттой хариулт тул дүн 100%-д барихгүй

Сургалтыг бодит кейсүүд дээр ажиллах байдлаар зохион байгуулбал илүү үр дүнтэй гэж 68% (136) нь хариулсан бол 88% (176) нь багш лекц уншдаг уламжлалт аргыг халахыг санал болгосон. (Зураг 1.9)

Төрийн бус болон Олон улсын байгууллагаас явуулсан сургалт


ХХГХ-ийн чиглэлээр ТББ, ОУБ-аас зохион байгуулдаг сургалтад судалгаанд хамрагдагсдын 83.5% (167) нь хамрагдаж чадаагүй байна. Дээрх тоо мэдээнээс ТББ, ОУБ-ын сургалт хязгаарлагдмал нөөцийн хүрээнд хийгдэж байгаагаас цөөн тооны хүнтэй, бага хүрээг хамарч байгаа нь харагдаж байна. Сургалтад хамрагдсан 33 албан хаагчдын 54.5% (18) нь сургалтын үр дүн, чанар сайн, ялангуяа хуулийн зүйлчлэл, ялгаа, ХХГХ-ийн хэрхэн таньж мэдэх, олон улсын туршлага зэрэг сэдвүүд нь хэрэгцээтэй байсан

бол 45.5% (15) нь сайн биш цаг нь хүрэлцээгүй, орчуулагч нь өөрөө ойлголт муутай, орчуулгын материалтай, манай улсын нөхцөлд нийцээгүй кейсүүдийг ярьсан зэрэг шалтгаануудыг дурдсан. Тэдний 57.6% (19) нь 1-3 өдрийн сургалтад, 42.4% (14) нь 3-4 өдрийн сургалтад хамрагдсан ба 4 хүний 3 нь сургалтын хугацаа хангалттай гэж үзсэн.

Энэ чиглэлээр боловсруулагдсан ном, гарын авлага, нэг сэдэвт бүтээлийн чанар, хүртээмжийг 29.5% (59) нь ойлгомжтой, 31% (62) хүндрэлтэй, монголын нөхцөл байдалд нийцээгүй, амьдрал дээр хэрэглэж ашиглах боломжгүй гэж үзжээ.

Харин цагдаагийн байгууллагад ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр алба хаагчдад зориулсан тусгайлан сургалт байдаг гэж 33% (66), 7.5% (15) нь энэ талаар мэдээлэлгүй гэж хариулсан байна.

Зураг 1.10. ХХГХ-ийн талаарх ном, гарын авлага, нэг сэдэвт бүтээлийн чанар, хүртээмж



Цагдаагийн албан хаагчдын ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр талаас илүү хувь нь ХХГХ-ийн нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх ажиллагаа, энэ гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах, таслан зогсоох ажиллагаа, байгууллагуудын хамтын ажиллагааны талаарх мэдээлэл

авах сургалтад хамрагдах хүсэлтэй байгаагаа илүүтэй илэрхийлжээ. Дунджаар нийт судалгаанд оролцогчдын 82% (164) нь дээрх сургалтын чиглэлүүдийг чухал, нэн чухал хэрэгцээтэй гэж үзсэн. (Зураг 1.11)

Зураг 1.11. ХХГХ-тэй тэмцэх чиглэлийн ямар сургалтанд хамрагдахыг хүсч буй байдал




Санал асуулгад оролцогчид цагдаагийн байгууллагад ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр мэргэшсэн албан тушаалтан бэлтгэх шаардлагатай гэж 91.5% (183) нь хариулснаас харахад энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх, мөрдөн шалгахад мэргэшсэн албан хаагчдын оролцоо чухал үр дүнтэй нь харагдаж байна. Судалгааны үр дүнгээс харахад 10 хүн тутмын 9 нь энэ гэмт хэргийн талаар цогц мэдлэгтэй болохыг хүсэж буй байдал нь сургалтын гарын авлага тэдний хүлээлтийг хангахуйц байх хэрэгцээ шаардлагыг бий болсныг харуулж байна. Дээрх мэдлэгүүдийг цогцоор, тодорхой үечлэлтэй эзэмшүүлснээр ХХГХ-тэй тэмцэх үйл

ажиллагаанд хохирогч, гэрчээ хамгаалсан, хэргийг нотлох, бэхжүүлэх, ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд чухал алхам болж чадна гэж үзэж байна.

ХХГХ шалгагдах явцад хохирогчийн зүгээс эрүүл мэнд, хууль зүй, сэтгэлзүйн үйлчилгээ авах хүсэлтийг 5%-д (10) гаргаж байсан бол 4.5% (9) нь хохирогч хүсэлт гаргаагүй ч тэдний хэрэгцээнд тохирсон үйлчилгээг үзүүлсэн байна. Тухайлбал: тусгай уулзалтын өрөөнд зөвлөгөө өгөх, сэтгэлзүйн зөвлөгөө тусламж, сэтгэл зүйчтэй уулзуулах, эрүүл мэнд, хууль зүй, сэтгэлзүйн тусалцаа үзүүлэх зэрэг үйлчилгээг үзүүлж байжээ. (Зураг 1.12)


Зураг 1.12. ХХГХ-ийн хохирогчид үйлчилгээ, тусалцаа үзүүлсэн байдал



Судалгаанд хамрагдсан Цагдаагийн газар, хэлтсүүдэд хохирогчоос мэдүүлэг авах тусгай өрөө байгаа эсэх талаар тодруулахад тал хувь нь (100) байгаа гэсэн боловч тэдний 48% (48) нь л тогтмол ашигладаг гэж хариулсан нь өрөөний ашиглалт хангалтгүй байгааг харуулж байна. Ашигладаггүй шалтгааныг тодруулахад шалтгааныг нь

сайн мэдэхгүй байна, үүнийг хариуцдаг эрх бүхий хүн биш гэсэн хариултуудыг өгсөн. ХХГХ-ийн хохирогч, гэрчийн мэдээллийн аюулгүй байдлыг хангахад мэдүүлэг авах тусгай өрөө нь чухал ач холбогдолтой учраас энэхүү өрөөний ашиглалтыг сайжруулах шаардлагатай байна. (Зураг 1.13)

Зураг 1.13. Хохирогчоос мэдүүлэг авах тусгай өрөө байдаг уу?



Мөн анхаарал татсан асуудлын нэгт ХХГХ-тэй тэмцэхэд шүүх эрх мэдэл, хууль сахиулах, төрийн болон ТББ-ын хамтын ажиллагааг 4 хүний 1 (25%) нь хангалттай гэж үнэлсэн явдал юм. Хамтын ажиллагааг сайжруулахын тулд мэдээлэл солилцох, ажлын уялдаа холбоогоо сайжруулах, хамтарсан багаар ажиллах, орон нутгуудад нэг адил түвшинд мэдээлэл түгээх шаардлагатай гэж үзсэн байна.

Судалгаанд оролцсон албан хаагчдын 42% (84) нь ХХГХ-ийг зарим тохиолдолд амжилттай мөрдөн байцааж, хянан шийдвэрлэж чадахгүй байгаа үндсэн шалтгаануудын талаар өөрийн саналыг илэрхийлсэн ба мэргэшсэн албан хаагчдын хүрэлцээгүй байдал, хохирогчид мэдүүлгээсээ буцдаг, гэрч, хохирогчид үзүүлэх бодит тусламж байдаггүй, практик тогтоогүй, нотлох баримт олоход хэцүү, хүндрэл үүсдэгээс гадна гадаад улсад үйлдэгддэг, зохион байгуулалттай үйлдэгдэж, байнга хувьсан өөрчлөгдөж байдаг нь үндсэн шалтгаануудын нэг гэж үзжээ.

ХХГХ-ийг хянах болон хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулахад шинэчлэн батлагдсан ЭХ⁵⁰, ЭХХШТХ-ийг хэрэглэхэд ямар нэгэн бэрхшээл тулгарч буй эсэхийг тодруулахад 12% (24) учирсан, үлдсэн хэсэг нь үгүй, энэ төрлийн хэрэг дээр ажиллаагүй, мэдэхгүй гэж хариулсан нь хууль хэрэгжиж эхлээд маш бага хугацаа өнгөрч байсантай холбоотой. Бэрхшээл учирч буй мөрдөгчдийн хувьд сэжигтэнд таслан шийдвэрлэх арга хэмжээ авах боломжгүй, ажлын ачааллыг нэмэгдүүлсэн, шинэ хуулийн сурталчилгаа хангалтгүй, хэрэг шалгах хуулийн хугацаа бага, энэ хугацаанд нотлох баримтыг бэхжүүлэх боломж хязгаарлагдмал, хүн худалдаалах (ЭХ-ийн 13.1), бэлгийн мөлжлөгийг (ЭХ-ийн 12.3) төсөөтэй байдлаар ялгаж зүйлчлэхэд хүндрэлтэй болсон, албадан хөдөлмөрийг (ЭХ-ийн 13.13) ХХГХ-т оруулах эсэх нь эргэлзээтэй зэрэг нөхцөл байдлуудыг дурджээ.

⁵⁰ 2017 оны 7 сарын 01-ээс ЭХ (шинэчилсэн найруулга), ЭХХШТХ (шинэчилсэн найруулга) хэрэгжиж эхэлсэн.

Зураг 1.14. ХХГХ–ийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, ялангуяа шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр өгөх санал



ХХГХ–ийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, ялангуяа шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр 22% (44) нь саналаа илэрхийлсний 81.8% (36) нь

сургалт зохион байгуулах, 91% (40) нь манай улсын иргэд холбогдсон, хохирсон бодит хэргийн кейс танилцуулж түүн дээр хамтран ажиллуулах, харилцан туршлага солилцох, иргэдэд мэдээлэл өгөх зэргийг онцоллоо.


5.2. ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧДААС АВСАН САНАЛ АСУУЛГЫН ДҮН

ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ БАЙДАЛ

Судалгаанд нийт 51 прокурор хамрагдсанаас 76.5% (39) Улаанбаатар хотын 8 дүүрэг, 23.5% (12) нь Замын-Үүд сум, Дорнод аймаг, Өмнөговь аймаг, Сэлэнгэ аймгийн прокурор


нар оролцлоо. Хүйсийн хувьд 56.9% (29) нь эрэгтэй, 43.1% (22) нь эмэгтэй бол ажлын туршлагын хувьд 1–25 болон түүнээс дээш жил ажилласан албан хаагчид хамрагдсан байна. (Зураг 2.1)

Зураг 2.1. Судалгаанд оролцогчдын насны бүлэг, хүйсээр



Судалгаанд оролцогчдын ажилласан жилийг харахад 43.1% (22) нь 1–5 жил ажилласан алба хаагчид байсан байна. (Зураг 2.2)

Зураг 2.2 Прокуророор ажилласан хугацаа



ХХГХ-ИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТ, МЭДЭЭЛЭЛ


Судалгаанд оролцогчдоос “Та ХХГХ-ийн талаар ойлголтоо хэлнэ үү” гэхэд 21.6% (11) нь ЭХ-ийн 13.1⁵¹ дэх заагдсан ойлголтыг хэлнэ гэсэн бол 11.8% (6) нь мэдэхгүй гэж хариулсан байлаа. Түүнчлэн хүчээр биеийг үнэлүүлэх, бэлгийн мөлжлөг, хөдөлмөр мөлжлөг, эд эрхтэн авах, хүний

хүсэл, эмзэг байдлыг ашиглан ашиг олох, хүний эрх, эрх чөлөөнд халдаж буй гэмт хэрэг, дотоод болон гадаадад худалдах, зохион байгуулалттай бүлэг үйлдэл, хүнийг мөлжих зорилгоор хууль бус аргаар эрхшээлдээ оруулах гэмт хэргийг хэлнэ гэжээ.

Нийт судалгаанд хариулагчдын 84.3% (43) нь биеийг нь хүчээр үнэлүүлэх, 76.5% (39) нь бэлгийн мөлжлөг, 47.1% (24) нь албадан хөдөлмөр эрхлүүлэх, 35.3% (18) нь хуурамч гэрлэлтийн хэлбэрүүд манай улсад давамгайлж байна гэж үзсэн бол 5.9% (3) нь тээгч эхийн асуудлыг ХХГХ-ийн нэг төрөл, хэлбэр мөн гэж үзсэн байна. (Зураг 2.3)

⁵¹ www.legalinfo.mn шинэчлэн батлагдсан 2017 оны ЭХ-ийн 13-р зүйлд Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн; тээвэрлэсэн; орогнуулсан; дамжуулсан; хүлээн авсныг ойлгон гэж хуульчилсан байна.

Зураг 2.3. Таны бодлоор Монгол Улсад ХХГХ–ийн аль хэлбэр илүү давамгайлж байгаа вэ?



* Олон сонголттой хариулт учир 100% барихгүй.

ХХГХ–ийн гаралт, үйлдэгдэхэд нөлөөлж буй хүчин зүйлийг судалгаанд оролцогчид ядуурал, эдийн засгийн байдал, ар гэрийн хараа хяналт сул, мэдлэг мэдээлэл дутмаг байдлаас болж байна гэж дүгнэжээ.


Хүснэгт 2.1. ХХГХ үйлдэгдэхэд нөлөөлж буй хүчин зүйлс

Нийгмийн хүчин зүйл	Хувь	Хувийн хүчин зүйл	Хувь
Ядуурал	72.5% (37)	Мэдлэг мэдээлэл дутмаг	25.5% (13)
Нийгмийн байдал	23.5% (12)	Ар гэрийн хараа хяналт сул, анхаарал халамж сул	19.6% (10)
Эдийн засгийн нөхцөл байдал	7.7% (4)	Боловсрол	1.9% (1)
Цахим орчин дахь хэрэглээ	1.9% (1)	Хууль эрх зүйн мэдлэг, мэдээлэл дутмаг	7.7% (4)
Мөнгөний ашиг сонирхол	5.9% (3)		
Ажилгүйдэл	31.4% (16)		
Хариулаагүй	1.9% (1)		

* Олон сонголттой хариулт учир 100% барихгүй.

Судалгаанд оролцогчдоос ХХГХ–ийн гомдол мэдээллийг оролцож байсан гэж 15.7% (8) нь хариулсан бол 84.3% (43) хүлээн авч, хянах, шүүх хуралдаанд улсын яллагчаар нь үгүй гэж хариулжээ.

Зураг 2.4. Хүн худалдаалах гэмт хэргийг хүлээн авч хянах, шүүх хуралдаанд улсын яллагчаар оролцож байсан байдал



Зураг 2.4-с үзэхэд 1 удаа энэ төрлийн гэмт хэргийн хянах, шүүх хуралдаанд улсын яллагчаар оролцож байсан гэж 4 (50%) прокурор, 2-3 удаа гэж 3 (37.5%) прокурор, олон удаа гэж 1 (12.5%) прокурор хариулсан бол эдгээр прокурорууд 100% бэлгийн мөлжлөгтэй холбоотой хэрэгт хяналт тавьж ажилласан байна.

Эрүүгийн хэрэгт хяналт тавих, шүүх хуралдаанд улсын яллагчаар оролцож байхдаа хохирогчтой ажиллахдаа хэрэглэдэг тусгай арга, техник, журам, асуумж байдаг гэж 5 (9.9%) хүн хариулжээ. Хэрэв **“Тийм бол”** ямар арга, тактик, асуумж хэрэглэдгийг тодруулахад нэг прокурор *“хууль, прокурорын аргачилсан заавар байдаг”*, нэг прокурор *“хохирогчтой уулзах, түүний сэтгэл зүйн байдалд тохируулан харилцаж мэдээлэл авдаг”*, үлдсэн 3 прокурор *“тийм”* гэсэн хариултыг сонгосон хэдий ч хэрэглэдэг журмын нэрийг нэрлээгүй байна.


Хохирогчтой ажиллах тусгай журам заавар байдаггүй гэж 84.3% (43) хүн нь үзсэн нь цаашид хууль хэрэгжүүлэгч байгууллагад хохирогчтой ажиллах заавар, стандарт, журмыг боловсруулах, алба хаагчдыг энэ чиглэлээр

мэргэшүүлэх, үйл ажиллагаанд хэрэгжүүлэх хэрэгцээтэй байгааг харуулж байна.

ХХГХ-ийн хохирогч болох магадлалтай тохиолдол илэрсэн үед 72.5% (37) нь цагдаагийн байгууллагад, 11.8% (6) нь тагнуулын байгууллагад мэдэгдэнэ гэжээ. Мөн 23.5% (12) нь төрийн байгууллагад ялангуяа Гэр бүл, хүүхэд залуучуудын газар, түүний харьяа газар, хэлтэст хандан гэсэн хариултыг өгөхөд 17.6% (9) ар гэрийнхэнтэй нь холбогдох, 3.9% (2) нь ТББ-д мэдэгдэнэ гэж хариулжээ.

Прокурорын байгууллагад бүртгэгдэн, хяналт тавьж ажилласан байсан ХХГХ-ийн 76.5% бэлгийн мөлжлөг байсан гэж хариулсан байна. Түүнчлэн 29.4% нь албадан хөдөлмөр эрхэлсэн, 23.5% нь хүүхэд албадан хөдөлмөр эрхлүүлсэн, 15.7% нь хуурамч гэрлэлтээс хохирсон, 3.9% нь гэрийн үйлчлэгч, 3.9% нь эд эрхтний наймаа, 3.9% нь хүүхэд үрчлэлтэй эрүүгийн хэргүүдэд хяналт тавьж ажилласан гэжээ. Эндээс үзэхэд ХХГХ-ийн хэлбэр, төрлүүдийг бэлгийн мөлжлөгөөр хязгаарлахгүй өөр шинэ хэлбэрүүд бүртгэгдэн шалгагдаж байгаа нь ажиглагдлаа.

Зураг 2.5. Прокурорын байгууллагад ХХГХ-тэй холбоотой ихэвчлэн бүртгэгдэн хяналт тавьж буй хэргүүд



ХХГХ-ийг бусад зохион байгуулалттай гэмт хэргүүдтэй хамт үйлдэгдэж байна гэж судалгаанд оролцогчдын 45.1% (23) үзсэний 34.8% (8) нь хар тамхи, 21.7% (5) нь цахим гэмт хэрэг, 13% (3) нь биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэгтэй хамт үйлдэгдэж байгаа гэж үзсэн бол 35.3% (18) нь мэдэхгүй, 19.6% (10) нь үгүй гэж хариулжээ.

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Судалгаанд хариулагч нараас 2012 онд батлагдсан “Хүн худалдаалахтай тэмцэх” тухай хуулийн зарчмуудын хэрэгжилтэд тавиас дээш хувь нь **“Хангалтгүй”** гэсэн үнэлгээг өгсөн байна.

Хүснэгт 2.2 Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн зарчмуудын хэрэгжилт


д/д	ЗАРЧМУУД	Хангалттай сайн (4)	Хангалттай (3)	Хангалтгүй (2)	Туйлын хангалтгүй (1)	Мэдэхгүй (88)	Хариулаагүй (99)
1	Дотоодын хууль тогтоомжийн хэрэгжилт	1 (2.0%)	14 (27.5%)	30 (58.8%)	2 (3.9%)	3 (5.9%)	1 (2.0%)
2	Олон улсын стандарт, гэрээ, конвенцийн хэрэгжилт	3 (5.9%)	9 (17.6%)	27 (52.9%)	4 (7.8%)	7 (13.7%)	1 (2.0%)

3	Хохирогчийн нэр төрийг хүндэтгэх	2 (3.9%)	11 (21.6%)	27 (52.9%)	4 (7.8%)	6 (11.8%)	1 (2.0%)
4	Хохирогчдыг хүйс, бэлгийн чиг хандлага, иргэншил, үндэс угсаагаар нь ялгаварлан гадуурхахгүй байх	5 (9.8%)	15 (29.4%)	23 (45.1%)	2 (3.9%)	5 (9.8%)	1 (2.0%)
5	Хохирогчийг үл буруутгах	3 (5.9%)	10 (19.6%)	26 (51.0%)	1 (2.0%)	10 (19.6%)	1 (2.0%)
6	Хохирогчийн аюулгүй байдлыг хангах	2 (3.9%)	6 (11.8%)	33 (64.7%)	2 (3.9%)	7 (13.7%)	1 (2.0%)
7	Хувийн нууцыг нь хамгаалах	2 (3.9%)	10 (19.6%)	31 (60.8%)	2 (3.9%)	5 (9.8%)	1 (2.0%)
8	Олон улсын хамтын ажиллагаа, иргэний нийгмийн оролцоонд түшиглэх	2 (3.9%)	6 (11.8%)	26 (51.0%)	6 (11.8%)	10 (19.6%)	1 (2.0%)

Хуулийн зарчмын хэрэгжилт “хангалттай” гэж үзсэн үзүүлэлтээс хамгийн өндөр буюу 29.4% (15) нь хохирогчдыг хүйсээр нь, иргэншил, үндэс угсаагаар нь ялгаварлан гадуурхахгүй байх гэж хариулжээ. Нийт судалгаанд оролцогчдын дунджаар 54.65% (27.9) нь Хүснэгт 2.2.-т тусгагдсан үзүүлэлтийн хэрэгжилтэд “хангалтгүй” гэсэн үнэлгээг өгчээ. Эндээс үзэхэд “Хүн худалдаалахтай тэмцэх” тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байгааг харуулахын зэрэгцээ энэхүү хуулийг сайжруулах шаардлагатай байгааг давхар харуулж байна.

Судалгаанд оролцогчдоос ХХГХ-ийг шүүхээр хянан шийдвэрлэхэд тулгарч буй бэрхшээлийг тодруулахад 76.6% (39) нь бэрхшээл тулгардаг гэсэн бол 17.6% (9) нь мэдэхгүй, 5.9% (3) нь хариулаагүй байна. Тийм гэсэн хариултаас хууль эрх зүйн орчин хангалтгүй, нотлох баримтыг бэхжүүлэх, үнэлэх байдал муу, хохирогчид нөлөөнд автаж мэдүүлгээсээ буцдаг, гадаад улсад үйлдэгддэг учир нотлох баримт цуглуулах боломж хомс, эрх зүйн туслалцааны хүрээнд мөрдөн шалгах ажиллагаа явуулахад хүндрэлтэй байдаг, хохирогч гэмт хэрэг үүсгэхээс татгалздаг, практик хомс зэрэг хүндрэл, бэрхшээл гардаг гэж хариулжээ.

Зураг 2.6. ХХГХ-ийг шүүхээр хянан шийдвэрлэхэд тулгардаг хүндрэл бэрхшээл




Прокурорыг хяналт тавих явцад ХХГХ-ийн хохирогч, гэрчийн аюулгүй байдлыг хамгаалах чиглэлээр нэг л удаа хүсэлт, гомдол ирж байсан ба прокурор чиг үүргийн дагуу хохирогчийг хамгаалах аюулгүй газар байрлуулж байсан байна. Эндээс үзэхэд гэрч, хохирогчийг хамгаалах, тэдний аюулгүй байдлыг хангах чиглэлээр хууль тогтоомжийн сурталчилгаа хангалтгүй, мэдлэг мэдээлэлгүй байгаа нь ажиглагдлаа.

ХХГХ-ТЭЙ ТЭМЦЭХ ЧИГЛЭЛЭЭР ЗОХИОН БАЙГУУЛЖ БҮЙ СУРГАЛТЫН ХҮРТЭЭМЖ, ЧАНАР, ҮР НӨЛӨӨГ ТАНДАХ

Төрийн байгууллагаас зохион байгуулсан сургалт

Судалгаанд хамрагдагсдын 52.9% (27) нь ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр төрийн байгууллагаас зохион байгуулж байсан сургалтад хамрагдаж байгаагүй ба сургалтад хамрагдагсдаас 45.8% (11) нь сургалтын үр дүн сайн байсан гэж хариулсан байна. (Зураг 2.7)

Зураг 2.7. Төрийн явуулж буй сургалтын чанар, үр дүн сайн байсан эсэх



Төрийн байгууллагаас зохион байгуулж байгаа сургалтад прокурор нараас 21.6% (11) хамрагдаж байжээ. Харин судалгаанд хариулагчдын дийлэнх хувь буюу 74.5% (38) нь энэ чиглэлийн сургалтад хамрагдаагүй байгаа нь анхаарал хандуулах асуудал юм. Цаашид прокурор нарт зориулсан ХХГХ-ийн нэгдсэн ойлголт өгөх, мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулах хэрэгцээ, шаардлага бий байгааг харуулж байна. Сургалтад хамрагдсан оролцогчдын хувьд сургалтын

үр дүнг хангалтгүй гэж 6 оролцогч хариулахдаа “бодит хэргийн жишээн дээр хэлж тайлбарлах нь дутмаг”, “хэт онолын”, “Монгол Улсад үйлдэгдсэн гэмт хэргийн жишээ сургалтад байдаггүй”, “хэт сунжруу” зэрэг шалтгаануудыг дурджээ. Сургалтад хамрагдсан 11 хүнээс 1–3 цагийн болон 2–4 өдрийн сургалтад хамгийн их прокурор хамрагдсан байна. Нэг прокурор ахисан түвшний сургалтад хамрагдаж байсан гэжээ.

Хүснэгт 2.3. Ямар хугацаатай сургалтад хамрагдсан бэ?


Сургалтын үргэлжлэх хугацаа	Тоо	Нийт хариулагчдын хувь
Энэ чиглэлийн сургалтад хамрагдаагүй	38	74.5%
1–3 цаг	4	7.8%
Хагас өдөр	3	5.9%
2–4 өдөр	4	7.8%
Сургагч багшийн сургалт /3–5өдөр/	1	2.0%
Ахисан түвшний сургалт (Гадаадад 21 хоногийн сургалтад хамрагдсан)	1	2.0%
Бүгд	51	100%

Сургалтад хамрагдсан прокуроруудын 81.8% (9) нь сургалтын хугацаа хангалттай байсан гэсэн бол хангалтгүй гэсэн оролцогчдын хувьд тодорхой үе шаттай нарийвчилсан мэдээлэл өгдөггүй, онол практик хосолсон биш, цаг нь маш бага байсан гэж үзэж байлаа. Мөн сургалтын агуулга тодорхой байсан эсэхийг тодруулахад 63.6% (7) нь сайн байсан, ялангуяа хэргийг хянан шалгах зүйлчлэл, хохирогчийг шүүх хуралд бэлтгэх зэрэгт анхаарах хандуулах хэрэгтэй юм байна гэдгийг ойлгосон гэж саналаа хэлжээ. Түүнчлэн сургалтуудад дутагдалтай талууд байсан уу гэхэд “сэдэв давтагддаг”, “бодит хэргийн жишээн дээр хэлж

тайлбарлах нь дутмаг”, “хэт онолын байсан”, “Монгол Улсад үйлдэгдсэн гэмт хэргийн жишээн дээр сургалт явагддаггүй” гэж 45.5% (5) нь үзжээ.

Хууль хяналтын болон хууль сахиулах байгууллагын албан хаагчдад зориулсан сургалтыг бодит кейс дээр ажиллах, оролцоонд суурилсан, багаар ажиллах аргачлалаар зохион байгуулах нь үр дүнтэй гэж 86.3% (44) хариулсан бол багш лекц унших аргачлалыг 7.8% (4) санал болгосон байна. (Зураг 2.8)

Зураг 2.8. Сургалтыг ямар аргачлалаар хүргэвэл илүү үр дүнтэй вэ?




Төрийн бус болон Олон улсын байгууллагаас явуулсан сургалт

Санал асуулгад оролцогчдын 88.2% (45) нь ХХГХ-ийн чиглэлээр төрийн бус болон ОУБ-аас зохион байгуулдаг сургалтад хамрагдаж байгаагүй байна. Сургалтад хамрагдсан гэж 5 (9.8%) оролцогч хариулсан ба сургалтын үр дүн, чанар, хүртээмжийг 100% сайн байсан, түүнчлэн дутагдалтай талыг тодруулахад нэг хариулагч нь Монголд

шийдвэрлэсэн хэргийн бодит жишээн дээр ажилласан бол илүү үр дүнтэй байх байсан гэжээ. Сургалтад хамрагдсан хариулагчдын 2 нь олон өдрийн сургалтад болон нэг өдрийн сургалтад, 1 нь хагас өдрийн сургалтад хамрагдсан ба бүгд сургалтын хугацааг хангалттай байсан хариулжээ.

Энэ чиглэлээр боловсруулан гаргасан ном, гарын авлага, нэг сэдэвт бүтээлийн чанар, хүртээмжийг 21.6% (11) ойлгомжтой, 35.3% (18) нь мэдэхгүй гэж үзжээ. (Зураг 2.9)

Зураг 2.9. ХХГХ-ийн ном, гарын авлага, нэг сэдэвт бүтээлийн чанар, хүртээмж



Прокурорын байгууллагад ХХГХ-ийн чиглэлээр тусгайлсан сургалт байдаг гэж 45.1% (23) нь хариулсан байхад 5.9%

(3) нь энэ чиглэлийн сургалт байдаг эсэхийг мэдэхгүй гэж хариулсан байна.

Зураг 2.10. ХХГХ–тэй тэмцэх чиглэлийн ямар сургалтанд хамрагдахыг хүсч буй байдал



Судалгаанд хамрагдсан прокурор нараас ХХГХ–тэй тэмцэх чиглэлээр нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх ажиллагаа, урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах, таслан зогсоох, хохирогч, гэрчээс мэдүүлэг авах ажиллагаа, байгууллагуудын хамтын ажиллагаа зэрэг асуудлаар илүү сургалт авах хүсэлтэйгээ илэрхийлсэн байна. Нийт судалгаанд оролцогчдын дунджаар 42 (82.4%) нь **Зураг 2.10–т** тусгагдсан сургалтын чиглэлүүдээс нэн чухал, чухал гэж үзжээ.


Прокурорын байгууллагад ХХГХ–тэй тэмцэх чиглэлээр мэргэшсэн албан тушаалтан бэлтгэх шаардлагатай гэж 92.2% (47) нь хариулснаас үзэхэд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд тусгай прокурор, илүү мэргэшсэн түвшинд ажиллах хэрэгцээ шаардлага бий байгааг харуулж байна.

ХХГХ–ийн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах үе шатанд Прокурорын хяналтыг хэрэгжүүлэхэд хохирогчийн зүгээс

эрүүл мэнд, хууль зүй, сэтгэл зүйн үйлчилгээ авах хүсэлтийг 3.9% (2) нь хүлээж авч байсан бол 94.1% (48) тийм хүсэлт хүлээж авч байгаагүй гэжээ. Хүсэлт гаргаж байсан хохирогчдод **“сэтгэл зүйн үйлчилгээнд хамруулах”** туслалцаа үзүүлэх арга хэмжээ авч байсан байна.

ХХГХ нь үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэг учир илүү олон улсын түвшинд, бүс нутгийн түвшинд, улс дотроо хууль хяналтын болон хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа маш чухал байдаг. Тийм учир Прокурорын байгууллагын алба хаагчдаас ХХГХ–тэй тэмцэх чиглэлээр шүүх эрх мэдэл, хууль сахиулах, төрийн, төрийн бус болон олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааны өнөөгийн байдлыг тодруулахад 58.8% (30) нь хангалтгүй, 33.3% (17) нь мэдэхгүй гэж хариулжээ. Байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулахын тулд **Зураг 2.11.–т** тусгагдсан саналуудыг дэвшүүлсэн.


Зураг 2.11. Хамтын ажиллагааг сайжруулах санал



Судалгаанд оролцогчдын ХХГХ-ийг амжилттай шалгаж, хянан шийдвэрлэж чадахгүй байгаа шалтгааныг дийлэнх хувийг хууль эрх зүйн орчин оновчгүй, алба хаагчид

нь мэргэшээгүй, нотлох баримт олоход хэцүү, хамтын ажиллагаа муу байгаатай холбоотой гэж үзсэн. (Зураг 2.12)


Зураг 2.12. ХХГХ-ийг амжилттай шалгаж чадахгүй байгаа шалтгаан



Хүн худалдаалахтай холбоотой гэмт хэрэгт Прокурорын хяналтыг хэрэгжүүлэхэд шинэчлэн батлагдсан ЭХ, ЭХХШТХ-ийг хэрэглэхэд ямар нэгэн бэрхшээл тулгарч байгаа эсэхийг тодруулахад 8% (4) нь бэрхшээл тулгарсан гэжээ. Энэ нь

дээрх хууль тогтоомж 2017 оны 07-р сарын 01-ээс эхлэн хэрэгжиж эхэлсэн бөгөөд шинэчилсэн хуулийн хэрэглээний үр нөлөөг судлахад цаг хугацааны хувьд үнэлэлт дүгнэлт өгөхөд эрт байсан байх талтай юм. (Зураг 2.13)


Зураг 2.13. Шинэчилсэн Эрүүгийн хуулийг хэрэглэхэд тулгарч буй хүндрэл бэрхшээл байгаа эсэх



Прокуроруудын хувьд учирч буй бэрхшээлд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа олон үе шаттай болсон, прокурорын ажлын ачаалал ихэссэн, ХХГХ–ийн зүйл анги нь 2002 оны зохицуулалтаас дордсон, биеэ үнэлэх, зохион байгуулах

явцад ашиг олж, хүнийг мөлжсөн бол хэрхэн шийдвэрлэх нь тодорхой бус, гэмт хэрэгт тооцохгүй, зөрчил гэж үзэх болсон зэрэг хүндрэлүүдийг онцлон илэрхийлж байлаа.

Зураг 2.14. ХХГХ–тэй тэмцэх чиглэлээр шүүх эрх мэдэл, хууль хяналт болон сахиулах байгууллагын албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах санал



Судалгаанд оролцогчдоос ХХГХ–ийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ялангуяа шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж 52.9% (27) нь хариулсан ба тухайлбал нэгдсэн ойлголт өгөх, практик

дадлага олгох нэгдсэн стандарт бүхий сургалтуудыг тодорхой үе шаттай зохион байгуулах, гадаад улс орны туршлагыг судлах, албан хаагчдыг мэргэшүүлэх чиглэлээр ажиллах шаардлагатай байна гэсэн чухал саналуудыг илэрхийлсэн. (Зураг 2.14)

5.3. ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧДААС АВСАН САНАЛ АСУУЛГЫН ДҮН


ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ БАЙДАЛ

Хууль сахиулах байгууллагын алба хаагчид, прокурор, шүүгч, хил хамгаалах болон ГИХГ-ын алба хаагчдаас “ХХГХ-ийн хохирогч төвтэй мөрдөн шалгах ажиллагаа, прокурорын хяналтыг сайжруулах нь” төслийн хүрээнд “Хууль хяналт болон хууль сахиулах байгууллагын алба хаагчдын хохирогч төвтэй аргачлалыг хэрэглэх чадавхыг үнэлэх” судалгаанд нийт 39 эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэдэг шүүгчдээс 74.3% (29) Улаанбаатар хотоос, 25.7% (10) нь сонгогдсон орон нутаг⁵² болох Замын-Үүд сум, Дорнод аймаг, Өмнөговь


аймаг, Сэлэнгэ аймгийн шүүгчид хамрагдсан ба үүнээс 28 (71.8%) шүүгч нь анхан шатны шүүхээс, 9 (23.1%) шүүгч нь давж заалдах шатны шүүхээс, 2 (5.1%) шүүгч нь хяналтын шатны шүүхийн шүүгчид байлаа.

Зураг 3.1-с харахад Эрүүгийн хэргийн шүүгчдийн дийлэнх буюу 53.8% (21) нь эрэгтэй шүүгч үлдсэн 46.2%-ийг (18) нь эмэгтэй шүүгчид эзэлж байлаа.

Зураг 3.1. Судалгаанд оролцогчдын насны бүлэг, хүйсээр



Зураг 3.2. Шүүгчээр ажилласан хугацаа



Зураг 3.2-с харахад 41% (16) нь 1-5 жил шүүгчээр ажиллаж байгаа шүүгчид хамрагдсан байна. Эндээс үзэхэд томилогдоод удаагүй байгаа шүүгчдийн хувьд ХХГХ-ийн

талаарх ойлголт мэдлэггүй байх эрсдэлийг бий болгох байдал ажиглагдаж байлаа.

⁵² Хүн худалдаалах гэмт хэрэг гаралт ихтэй, хилийн бүс орчмын гурван аймаг (Дорнод аймаг, Хавирга боомт, Өмнөговь аймаг, Гашуун Сухайтын боомт, Сэлэнгэ аймаг, Алтанбулаг боомт), нэг сум (Дорноговь аймгийн Замын үүд сумын боомт)-ыг сонгон судалгаанд хамруулсан.


ХХГХ-ИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТ, МЭДЭЭЛЭЛ

Судалгаанд оролцогчдоос ХХГХ-ийн ойлголтыг тандан мэдэх нь судалгааны багийн хувьд чухал байсан. Учир нь мэргэжлийн бүлгүүдийн хүрээнд ялангуяа хууль хяналт болон хууль сахиулах байгууллагын алба хаагчдын ойлголт мэдлэг, мэдээлэл ямар түвшинд байгаа, нэгдмэл нэгдсэн ойлголттой эсэхийг тодруулахыг зорьсон. Судалгаанд оролцогчдоос “Та ХХГХ-ийн талаарх өөрийн ойлголтыг хэлнэ үү” гэхэд 41% (16) нь ноцтой гэмт хэрэг гэсэн бол 33.4% (13) нь хэлж мэдэхгүй эсвэл хариулаагүй ба үлдсэн

хувь болох 25.6% (10) нь хүний эрх, эрх чөлөөнд халдаж буй гэмт хэрэг, хүчээр хүний биеийг үнэлүүлэх, хүнийг дотоод болон гадаадад худалдах, бэлгийн мөлжлөг, хөдөлмөрийн мөлжлөг, эд эрхтнийг нь авах, шинэ төрлийн гэмт хэрэг, хүний хүсэл зоригийг хууль бус аргаар хууран мэхэлж арилжааны арга болгох зэргээр илэрхийлснээс харахад нэгдсэн ойлголт байхгүй байгаа нь харагдаж байна.

Түүнчлэн Монгол Улсад ХХГХ-ийн ямар хэлбэр, төрлүүд давамгайлж байна вэ гэхэд 76.9% (30) нь биеийг нь хүчээр үнэлүүлэх, 69.2% (27) бэлгийн мөлжлөг гэж хариулжээ.

Зураг 3.3. Таны бодлоор Монгол улсад ХХГХ-ийн аль хэлбэр илүү давамгайлж байгаа вэ?



*Олон сонголттой асуулт учир 100% барихгүй болно.

Шүүгчид энэ төрлийн гэмт хэргийг гаргахад нөлөөлж буй хүчин зүйлийг ядуурал, эдийн засгийн хямрал, нийгмийн эмх замбараагүй байдал гэж хариулжээ.

Хүснэгт 3.1. ХХГХ үйлдэгдэхэд нөлөөлж буй хүчин зүйлс

Нийгмийн хүчин зүйл	Хувь	Хувийн хүчин зүйл	Хувь
Ядуурал	41%	Мэдлэг мэдээлэл дутмаг	2.6%
Нийгмийн байдал	5.1%	Ар гэрийн хараа хяналт сул, анхаарал халамж сул	2.6%
Эдийн засгийн нөхцөл байдал	7.7%	Боловсрол	2.6%
Интернет сошиал сайтууд	2.6%	Хууль эрх зүйн мэдлэг, мэдээлэл дутмаг	7.7%
Хэвлэл мэдээллээр замбараагүй мэдээлэл гаргадаг	2.6%		
Тусгай чиг үүргийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо сул, чиг үүрэг тодорхойгүй	5.1%		
Хариулаагүй			12.8%
Мэдэхгүй			5.2%

*Олон сонголттой асуулт учир 100% барихгүй болно.

Судалгаанд оролцогчдын 64.1% (25) нь нийгмийн хүчин зүйлийн нөлөөгөөр ХХГХ үйлдэгдэж байна гэж үзсэн. Ялангуяа ядуурал, эдийн засгийн нөхцөл байдал нь энэ төрлийн гэмт хэргийн гаралтыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ хувь хүний хүчин зүйл мөн адил нөлөөлж байна гэж дүгнэсэн байна. Хувь хүний хүчин зүйл гэдэгт боловсрол, хууль эрх зүйн мэдлэг мэдээлэл дутмаг, ар гэрийн хараа хяналт, анхаарал халамж сул зэрэг нь ХХГХ–т өртөх хүчин зүйл болж байна гэжээ. Түүнчлэн тусгай чиг үүргийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо сул, чиг үүрэг тодорхойгүй гэсэн нь хариултыг өгсөн байгаа нь анхаарал хандуулах асуудал юм. (Зураг 3.1)

ХХГХ–тэй холбоотой хэргийг шийдвэрлэж байсан эсэхийг тодруулахад дийлэнх олонх буюу 79.5% (31) нь үгүй, 20.5% (8) нь тийм гэж хариулжээ. Засгийн газрын 2017 оны 148–р тогтоол⁵³–ын нийтлэг үндэслэлд дурдсанаар “Сүүлийн 5 жилийн байдлаар авч үзвэл (2010–2016 он) цагдаагийн байгууллагад ХХГХ–ийн 54 гэмт хэрэг бүртгэгдэн шалгагдсанаас хүн худалдаалах 8 хэрэгт 15 хүнд шүүхээс ял шийтгэл оногдуулжээ” гэсэн байна. ХХГХ–ийн статистик тоо мэдээллийн хувьд шүүх, цагдаагийн байгууллага хоёрын тоо зөрүүтэй байгаа нь харагдаж байна. Мөн шүүхээр яагаад ХХГХ хянан шийдвэрлэгдэхгүй байгааг илүү судлах шаардлагатай нь ажиглагдсан. 2017 оны шинэчилсэн ЭХ–аар шийдвэрлэгдсэн эрүүгийн хэрэг одоогоор байхгүй байна. Тиймээс тусгай чиг үүргийн байгууллагуудын алба хаагчдыг мэргэшүүлэх, нэгдсэн ойлголт өгөх сургалт зохион байгуулах хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.


АС–ийн хэрэгжүүлж буй энэхүү төсөл нь хохирогч төвтэй мөрдөн байцаах үйл ажиллагааг сайжруулах, хяналтыг боловсронгуй болгоход чиглэсэн. Иймд шүүгч нараас шүүх хуралдааны үеэр хохирогчоос асуулт асуухад тусгай

стандарт, журам байдаг уу гэхэд 33 (84.6%) хүн үгүй, 4 (10.3%) хүн тийм, 2 (5.1%) хүн мэдэхгүй гэсэн байна. Хэрвээ хохирогчоос асуудаг тусгай стандарт, журам байдаг бол нэрлэнэ үү гэхэд “**хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам**”, “**ЭХХШТХ**”, “**насанд хүрээгүй хохирогчийг тусгайлан мэдүүлэг авах журам**” гэсэн хариулт өгчээ.

Харин шүүх хуралдааны явцад хохирогчийн аюулгүй байдал, хувь хүний нууцлалыг хэрхэн хамгаалж ажилладаг талаар асуухад 59% (23) нь мэдэхгүй, үлдсэн 41% (16) нь хуульд заагдсаны дагуу явагдаж байгаа, гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн дагуу арга хэмжээ авах, гэрч, хохирогчоос мэдүүлэг авах, хохирогчийн аюулгүй байдлыг хангах, шүүхэд ийм эрх олгогдоогүй, цагдаагийн байгууллагаас тусгайлан хамгаалалт гаргадаг, шүүхийн цагдаагаар хамгаалуулдаг, хохирогчийг шүүгдэгчээс тусгаарлаж хуралдаан явуулдаг, шүүх хуралдааныг хаалттай явуулдаг, хохирогчийг хамгаалах шийдвэр гаргадаг, хохирогчийн аюулгүй байдал нийтлэг хэрэг дээр бүрэн хангагддаггүй зэргээр хариулжээ. Эндээс үзэхэд шүүх эрх мэдлийн байгууллагын хүрээнд ч гэсэн хохирогчийг аюулгүй байдал, хувь хүний нууцлалыг хэрхэн хамгаалан ажиллах талаар нэгдсэн ойлголт өгөх тусгайлан сургалт зохион байгуулах шаардлагатай байгааг харуулж байлаа.

ХХГХ бусад зохион байгуулалттай гэмт хэргүүдтэй хамт үйлдэгдэж байна гэж судалгаанд оролцогчдын 43.5% (17) нь үзсэний 35.3% (6) нь цахим гэмт хэрэг, 29.4% (5) нь хар тамхи, 11.8% (2) нь залилан мэхлэх хэргүүдтэй хамт үйлдэгдэж байна гэж үзсэн. Харин 43.5% (17) нь мэдэхгүй гэж хариулжээ. Тэгэхээр шүүгчдэд үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн талаарх үндсэн ойлголт өгөх сургалтад хамруулах, тэдэнд мэдлэг мэдээлэл өгөх хэрэгцээ үүссэн байгааг харуулж байна.

Зураг 3.4. Шүүхээр хянан шийдвэрлэгдэж байгаа ХХГХ–ийн төрөл, хэлбэрүүд



⁵³ www.legalinfo.mn Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр

* Олон сонголттой хариулт учир 100% барихгүй болно.

Судалгаанд оролцогчдоос “Таны мэдэж байгаагаар Зураг 3.4-т тусгагдсан ХХГХ-ийн аль тохиолдол нь ихэвчлэн шүүхээр хянан шийдвэрлэгдэж байгаа вэ?” гэхэд 82% (32) нь “бэлгийн мөлжлөг”, 30.8% (12) “хүүхэд албадан хөдөлмөр эрхэлсэн”, 20.5% (8) нь “албадан хөдөлмөр эрхэлсэн”, 17.9% (7) нь “хуурамч гэрлэлтээс хохирсон”, 12.8% (5) нь “эд эрхтний наймааны хохирогч”, 10.2% (4) нь “хүүхэд үрчлэлтэй холбоотой”, 2.6% (1) нь “тээгч эхтэй холбоотой” гэсэн тохиолдлуудыг нэрлэсэн байна. Эндээс үзэхэд ХХГХ-ийн бэлгийн мөлжлөг, албадан хөдөлмөр эрхэлсэн гэсэн төрлөөс илүү олон хэлбэр шүүхээр хянан шийдвэрлэгдсэн гэдгийг судалгаанд хамрагдсан оролцогчдын хариултаас харж болохоор байна. Гэсэн хэдий ч өнөөг хүртэл шүүхээс гаргаж буй статистик мэдээлэлд дээрх төрөл, хэлбэрүүд тухайлбал эд эрхтний наймаа, хуурамч гэрлэлт, тээгч эх, хүүхдийн албадан хөдөлмөр зэрэг төрөл, хэлбэр мэдээлэгддэгүүд анхаарал хандуулан гүнзгийрүүлэн судлах хэрэгтэй гэж үзэж байна.

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

2012 онд батлагдсан Монгол Улсын Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн зарчмуудын хэрэгжилт, хүний эрхэд суурилсан хэм хэмжээ, хохирогчийг хамгаалах, стандарт, журмын хэрэгжилтийг үнэлүүлэхэд дотоодын хууль тогтоомжийн хэрэгжилт хангалттай гэж 28.2% (11) нь үзсэн бол 5.1% (2) нь маш сайн хангалттай, харин 41% (16) нь хангалтгүй, 10.3% (4) мэдэхгүй гэж үзсэн. Хүснэгт 3.2-т тусгагдсан найман үзүүлэлтийн хүрээнд хангалттай сайн, хангалттай гэж үзсэн үзүүлэлтийн хамгийн өндөр нь олон улсын хамтын ажиллагаа, иргэний нийгмийн оролцоонд түшиглэх, хохирогчийн аюулгүй байдлыг хангах гэж дунджаар оролцогчдын 31.6% (12.3) нь хариулжээ. Нийт үзүүлэлтүүдээр авч үзэхэд дунджаар нийт оролцогчдын бараг тал хувь нь болох 42.95% (16.75) нь хуулийн зарчмын хэрэгжилт хангалтгүй гэж үзсэн байна. Мэдэхгүй гэж хариулсан эсвэл хариулаагүй үлдээсэн шүүгчид дунджаар 16.7%-ийг (6.5) эзэлж байлаа.

Хүснэгт 3.2. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн зарчмуудын хэрэгжилт


№	Зарчим	Хангалттай сайн	Хангалттай	Хангалтгүй	Туйлын хангалтгүй	Мэдэхгүй	Хариулаагүй
		(4)	(3)	(2)	(1)	(88)	(99)
1	Дотоод хууль тогтоомжийн хэрэгжилт	2 (5.1%)	11 (28.2%)	16 (41%)	5 (12.8%)	4 (10.3%)	1 (2.6%)
2	Олон улсын стандарт, гэрээ, конвенцийн хэрэгжилт	1 (2.6%)	12 (30.8%)	14 (35.9%)	4 (10.3%)	7 (17.9%)	1 (2.6%)
3	Хохирогчийн нэр төрийг хүндэтгэх		9 (23.1%)	22 (56.4%)	4 (10.3%)	3 (7.7%)	1 (2.6%)
4	Хохирогчдыг хүйс, бэлгийн чиг хандлага, иргэншил, үндэс угсаагаар нь ялгаварлан гадуурхахгүй байх	1 (2.6%)	11 (28.2%)	18 (46.2%)	3 (7.7%)	5 (12.8%)	1 (2.6%)
5	Хохирогчийг үл буруутгах		11 (28.2%)	17 (43.6%)	3 (7.7%)	7 (17.9%)	1 (2.6%)
6	Хохирогчийн аюулгүй байдлыг хангах		13 (33.3%)	17 (43.6%)	4 (10.3%)	4 (10.3%)	1 (2.6%)
7	Хувийн нууцыг нь хамгаалах		11 (28.2%)	19 (48.7%)	6 (15.4%)	2 (5.1%)	1 (2.6%)
8	Олон улсын хамтын ажиллагаа, иргэний нийгмийн оролцоонд түшиглэх		12 (30.8%)	11 (28.2%)	3 (7.7%)	12 (30.8%)	1 (2.6%)

* Олон сонголттой хариулт учир 100% барихгүй.

Шүүхээр хүн худалдаалахтай холбоотой эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхэд тулгардаг хүндрэл бэрхшээлийг тодруулахад 48.7% (19) нь энэ төрлийн эрүүгийн хэргийг шийдвэрлэж байгаагүй, 5.1% (2) нь мэдэхгүй, 5.1% (2) нь хариулаагүй байна. Харин тийм гэж хариулснаас 12.8% (5) нь одоогоор бэрхшээл ажиглагдаагүй, 7.7% (3) нь хохирогчийн хувийн байдлаас шалтгаалан бодит үнэнийг

тогтооход эргэлзээ төрдөг, 5.1% (2) нь шүүхээр хангалттай нотлох баримт бүрдсэн хэрэг орж ирдэггүй, үлдсэн хувь нь шүүгдэгч болон хохирогчид оргон зайлдаг, нотлох баримт төдийлөн хангалттай цуглардаггүй, үнэлэлт дүгнэлт өгөхөд бэрхшээлтэй, хэргийг дутуу шалгадаг зэрэг хүндрэлүүд гардаг гэж хариултыг өгчээ. (Зураг 3.5)

Зураг 3.5. ХХГХ–ийг шүүхээр хянан шийдвэрлэхэд тулгардаг хүндрэл, бэрхшээл



Шүүхийн шатанд ХХГХ–ийн хохирогч, гэрч аюулгүй байдлаа хамгаалуулах хүсэлт, гомдол гаргаж байсан эсэхийг тодруулахад тийм гэж 1, үгүй гэж 38 шүүгч хариулжээ. Тийм гэж хариулсан шүүгч ямар төрлийн хүсэлтийг шийдвэрлэснийг тодруулахад **“Орон нутгаас ирсэн ХХГХ–ийн хохирогчийг Улаанбаатар хотод оршин суух газаргүй байхад хамгаалах байранд байрлуулах”** арга хэмжээ авч байсан байна. Эндээс үзэхэд гэрчийг хамгаалах, хохирогчдод туслалцаа үзүүлэх хууль тогтоомжийн хэрэглээ шүүх хуралдаанд оролцогчдын хувьд сул байна гэж дүгнэгдэж байна.

Өнөөгийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж буй⁵⁴ хууль тогтоомжууд ХХГХ–ийн хохирогчийн эрхийг бүрэн хамгаалж чадахгүй байна гэж 19 (48.7%) хүн, мэдэхгүй гэж 3 (7.7%) хүн, хариулахаас татгалзсан 2 (5.1%) хүн байлаа. Хохирогчийг хамгаалж чадахгүй байгаа бол ямар өөрчлөлт, нэмэлт оруулах шаардлагатайг тодруулахад 15 (38.5%) хүн **“хохирогчийн аюулгүй байдлыг хангах”, “эрх зүйн орчныг сайжруулах, өөрчлөх”, “эрх зүйн орчин байгаа ч хэрэгжилт муу”, “гэр оронгүй хүмүүс, хүүхдүүдийг хамгаалах хамгаалалт муу байгаа учраас хохирогч болж байна”** гэсэн саналыг гаргажээ.

⁵⁴ Одоогоор www.legalinfo.mn сайтаас үзэхэд 639 хууль тогтоомж мөрдөгдөж байна.


ХХГХ-ТЭЙ ТЭМЦЭХ ЧИГЛЭЛЭЭР ЗОХИОН БАЙГУУЛЖ БУЙ СУРГАЛТЫН ХҮРТЭЭМЖ, ЧАНАР, ҮР НӨЛӨӨГ ТАНДАХ

Төрийн байгууллагаас зохион байгуулсан сургалт

Судалгаанд оролцогчдоос ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр төрийн байгууллагаас зохион байгуулж байгаа мэргэшүүлэх

сургалтын чанар, үр дүн сайн байсан талаар тодруулахад нийт 39 шүүгчийн 31 (79.5%) нь энэ чиглэлийн ямар ч сургалтад хамрагдаагүй, харин хамрагдсан 8 (20.5%) хүнээс 5 (62.5%) шүүгч тийм, 3 (37.5%) шүүгч үгүй гэж хариулсан байна.

Зураг 3.6. Төрийн явуулж буй сургалтын чанар, үр дүн сайн байсан эсэх



Зураг 3.6-с харахад ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр сургалтад хамрагдаж байгаагүй гэж 79.5% (31) нь хариулсан нь төрийн байгууллагын зүгээс алба хаагчдыг мэргэшүүлэх, мэдлэг, мэдээлэл олгох сургалт зохион байгуулдаггүй нь ажиглагдаж байна. Тэгвэл сургалтад хамрагдаж байсан 8 (20.5%) шүүгчээс сургалтын агуулга, хүртээмжийг тодруулахад **“сургалт үр дүнтэй байгаагүй”, “олон улсын**

туршлагыг ярихдаа Монгол Улсын эрх зүйн орчинтой ойролцоо, хөрсөнд буусан байдлаар явуулах шаардлагатай” гэсэн саналыг гаргасан. Судалгаанд оролцогчдын сургалтад хамрагдсан хугацааны хувьд харилцан адилгүй байсан ба хагас өдрийн сургалтад 2 хүн нэг удаа, 1 кредит цагийн сургалтад 2 хүн нэг удаа, 1–6 цагийн сургалтад нэг удаа хамрагдсан ба давтан суусан хүн байхгүй байлаа.

Хүснэгт 3.3. Ямар хугацаатай сургалтад хамрагдсан бэ?

Сургалтын үргэлжлэх хугацаа	Тоо	Нийт хариулагчдын хувь
Энэ чиглэлийн сургалтад хамрагдаагүй	31	79.5%
1–6 цаг	1	2.6%
Хагас өдөр	2	5.1%
1 кредит	2	5.1%
Бусад	3	7.7%
Бүгд	39	100%

Сургалтад хамрагдсан алба хаагчдын 87.5% (7) нь сургалтын агуулга хэрэгцээтэй байсан бөгөөд сургалтаас ерөнхий ойлголт авсан, харьцангуй шинэ ойлголт байсан гэсэн бол үлдсэн 12.5% (1) нь олон жилийн өмнө буюу 2008 онд хамрагдаж байсан болохоор агуулгыг тодорхой санахгүй байна гэж хариулсан. Мөн түүнчлэн сургалтын дутагдалтай талыг нэрлэнэ үү гэхэд **“гаднын багш өөрийн орны туршлагыг их ярьдаг”, “энэ нь зөв боловч Монгол Улсын хууль**

тогтоомж, ХХГХ-ийн хууль, ёс уламжлалтай зөрдөг”, “зарим тохиолдолд сургагч багш нар нь мэргэшээгүй байсан” зэрэг нь учир дутагдалтай байсан гэжээ.


Цаашид сургалтыг **“бодит кейсүүд дээр ажиллах”** (35 шүүгч буюу 89.7%), **“багаар ажиллах”** (15 шүүгч буюу 38.5%), **“оролцоонд суурилсан”** (14 шүүгч буюу 35.9%), **“багш лекц унших”** (5 шүүгч буюу 12.8%) арга, аргачлалаар зохион байгуулбал илүү үр дүнтэй гэж үзэж байлаа.

Төрийн бус болон олон улсын байгууллагаас явуулсан сургалт

Судалгаанд хамрагдсан нийт 39 хүний 32 (82%) нь энэ

чиглэлийн ямар ч сургалтад хамрагдаагүй гэж хариулсан. Хамрагдсан 7 хүнээс 3 (42.9%) нь сургалтын чанар, үр дүн сайн байсан, 4 (57.1%) нь сайн байгаагүй гэж хариулжээ.

Зураг 3.7. Төрийн бус болон Олон улсын байгууллагаас зохион байгуулсан сургалтын чанар, үр дүн сайн байсан эсэх



Төрийн бус болон ОУБ-аас зохион байгуулагдаж буй сургалтад шүүгч нар бүрэн хамрагдаж чадахгүй байгаа нь харагдаж байна. Энэ нь шүүгч нарын ажлын ачаалалтай нь холбоотой байх магадлалтай юм. Бид судалгааны ажлаа хийх явцад шүүгч нараас судалгаа авахын тулд нэг судлаач хамгийн багадаа 2 өдөр очиж байсан. Иймээс шүүгч нарыг ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр мэргэшүүлэн сургах сургалтад хэрхэн зөв оновчтой зохион байгуулах талаар Шүүхийн Ерөнхий Зөвлөл, Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнтэй хамтран ажиллах замаар эрүүгийн шүүгчдийг бүрэн хамруулах хэрэгтэй юм. Түүнчлэн шүүгчид 1–3 кредит цагийн сургалтад хамрагдсан ба сургалтын үр дүнг **“манай орны бодит байдалтай тохирохгүй байсан”, “үйл ажиллагаа явцуу учир төдийлөн хамрагддаггүй”, “зарим нэг ОУБ-аас зохион байгуулж буй сургалтууд үр дүн муутай байдаг”** гэж байсан ба сургалтын агуулгын талаар тодруулахад **“Монголын нөхцөл байдалд нийцээгүй”** гэсэн дүгнэлтийг хэлжээ.

Шүүгчдэд зориулсан ХХГХ-тэй тэмцэх, шүүх байгууллагын оролцоог тогтвортой, тасралтгүй явуулах, цогц мэдлэг, мэдээлэл өгөх сургалтыг тэдний бодит хэрэгцээнд суурилсан, Монгол Улсын нөхцөл байдалд тохирсон, гадаад орны туршлагыг ярихдаа эрх зүйн орчны хувьд ижил төстэй орны жишээг дурдах, шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх явцад анхаарах асуудлыг түлхүү тусгасан байдлаар оруулах нь зүйтэй гэсэн саналыг асуулга авч явахад дэвшүүлэн гаргаж байсан.

Судалгаанд оролцогчдоос ХХГХ-ийн асуудлаар гаргасан ном, гарын авлага, нэг сэдэвт бүтээлийн чанар, хүртээмжийн талаар тодруулахад 33.3% (13) нь гарын авлага, нэг сэдэвт бүтээлийг хэрэглэхэд ойлгомжтой байсан, 25.7% (10) нь амьдрал дээр хэрэглэх боломжгүй, Монголын ХХГХ-ийн нөхцөл байдалд нийцээгүй, ойлгоход хүндрэлтэй гэж хариулсан байна. (Зураг 3.8)

Зураг 3.8. ХХГХ-ийн талаарх ном, гарын авлага, нэг сэдэвт бүтээлийн чанар, хүртээмж



Шүүгчдээс ХХГХ-ийн хохирогч, гэрчийг хамгаалах, харилцах, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаа урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах, таслан зогсоох, нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх ажиллагаа, ХХГХ-тэй

тэмцэх байгууллагуудын хамтын ажиллагаа гэсэн чиглэлээр мэдээлэл авах, сургалтад хамрагдах асуудлыг тус гэмт хэрэгтэй тэмцэхэд чухал болон нэн чухал гэж үзсэн байна.

Зураг 3.9. ХХГХ-тэй тэмцэх чиглэлийн ямар сургалтанд хамрагдахыг хүсч буй байдал



Энэхүү судалгааны нэг онцлог нь судалгаанд оролцогчдоос сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлохын зэрэгцээ сургалтын агуулга, ямар төрлийн мэдээллийг ямар арга аргачлалаар авах хүсэлтэй байгааг гаргаж, тэдний хэрэгцээнд суурилсан үр дүнтэй сургалтыг зохион байгуулах, бодлогын түвшинд оновчтой сургалтын тогтолцоог бий болгож мэргэшсэн алба хаагч нарыг бэлтгэх нь хамгийн чухал юм.

Шүүх эрх мэдлийн байгууллагад ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр тусгай мэргэшсэн шүүгч бэлтгэх хэрэгтэй гэж судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 76.9% (30) нь үзэж байгаа нь энэ төрлийн гэмт хэргийг хянан шийдвэрлэдэг эрүүгийн шүүгч нарыг мэргэшүүлэн сургах нь зайлшгүй хэрэгцээ, шаардлагатай байгаа нь харагдаж байна. Энэхүү судалгааны үр дүнгээс харахад 39 шүүгчдээс төрийн байгууллагаас зохион байгуулж буй сургалтад 20.5% (8), төрийн бус болон олон улсын байгууллагын сургалтад 17.9% (7) нь хамрагдсан нь ХХГХ-тэй тэмцэхэд шүүгчдийн мэдлэг, боловсрол хангалтгүй байгаа нь харагдаж байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2016 оны үйл ажиллагааны тайлан⁵⁵-д анхан шатны шүүхэд 391 шүүгч, давж заалдах шатны шүүхэд 105 шүүгч ажиллаж байгаа бөгөөд үүнээс эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд 130 шүүгч, давж заалдах шатны шүүхэд 21 шүүгч ажиллаж байна.

Эрүүгийн⁵⁵ эрх зүйн шинэтгэлийн хүрээнд 2017 онд ЭХ⁵⁶, Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тухай хууль⁵⁷, Зөрчлийн тухай хууль⁵⁸, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль⁵⁹ батлагдан мөн оны 07-р сарын 01-ээс эхлэн

хэрэгжиж эхэлсэн. Үүнтэй холбогдуулан нийт судалгаанд оролцогчдоос ХХГХ-ийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид Монгол Улсын хилээр нэвтрэх хилийн хориогийг шүүхээр шийдвэрлэхэд хүндрэл бэрхшээлтэй байна гэж 7.7% (3), үгүй гэж 61.5% (24) нь хариулсан байхад 30.8% (12) нь мэдэхгүй буюу хариулаагүй байна. Ямар төрлийн хүндрэл тулгарч байгааг асуухад “ЭХ, Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулийг хэрэглэхэд ойлгомжгүй”, “шүүгч нараас тусгайлан санал авалгүйгээр өөрчилсөн” зэрэг нь хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй байна гэжээ.

Судалгаанд оролцогчдын 20.5% (8) нь хүн худалдаалах эрүүгийн хэргийг шийдвэрлэж байсан гэж хариулсан ба хэргийг хянан хэлэлцэх, шийдвэрлэх үед хохирогчдод ямар нэгэн эрүүл мэнд, хууль зүй, сэтгэл зүйн үйлчилгээ авах хүсэлт, гомдол гаргасан уу гэхэд “нэг л шүүгч тийм” гэсэн хариулт өгчээ. Тухайн шүүгч ямар төрлийн арга хэмжээ авсан талаар тодруулахад “**хохирогчид сэтгэл зүйчийн дүгнэлт гаргуулах арга хэмжээ**” авч байжээ. Эндээс үзэхэд хохирогчид хуулийн байгууллагаар хууль ёсны эрх ашгаа бүрэн хамгаалуулах, хуулиар хамгаалагдсан, олгогдсон эрхээ дутуу эдлэх хандлагууд байсаар байна. Мөн хууль хэрэгжүүлэгч нарт хүний эрхэд суурилсан хандлагыг бий болгох, хохирогчийн эдлэх боломжтой хууль ёсны эрхийг бүрэн эдлүүлэхэд чиглэгдсэн, мэдлэг нэмэгдүүлэх сургалт, сурталчилгааны ажил хэрэгцээтэй байгаа нь харагдаж байна.

ХХГХ-тэй тэмцэхэд шүүх эрх мэдэл, хууль сахиулах, төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагын хамтын ажиллагааг судалгаанд оролцогчдын 30.8% (12) нь хангалтгүй, 25.6% (10) нь хангалттай, 41% (16) нь мэдэхгүй гэж хариулжээ. Төрийн, төрийн бус болон ОУБ, хууль хяналт, сахиулах байгууллагын хамтын ажиллагааг сайжруулахын

⁵⁵ <http://www.judcouncil.mn/tailan2016.html>

⁵⁶ <http://www.legalinfo.mn/law/details/11634?lawid=11634>

⁵⁷ <http://www.legalinfo.mn/law/details/12694?lawid=12694>

⁵⁸ <http://www.legalinfo.mn/law/details/12695?lawid=12695>

⁵⁹ <http://www.legalinfo.mn/law/details/12696?lawid=12696>

тулд “**нэгдсэн ойлголттой**”, “**хамтын ажиллагааны уялдаа холбоог бий болгон ажиллах**” гэсэн саналыг гаргасан. Энэ нь шүүгч, прокурор, мөрдөгч, өмгөөлөгч нарт цогц нэгдсэн ойлголт өгөх сургалтад хамруулах, улмаар хамтын ажиллагааг бий болгох нь чухал байгааг харууллаа.

Шүүхээр эцэслэн шийдвэрлэгдэж буй хэрэг, цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн хэргийн тоо мэдээ байнгын зөрүүтэй байдаг талаар олон сургалт, семинар, бага хурал дээр яригддаг асуудал юм. Энэ нь олон төрлийн

хүчин зүйлтэй холбоотой байдаг гэж хууль хэрэгжүүлэгч байгууллагын төлөөллүүд тайлбарладаг. Иймээс бид шүүгч нараас ХХГХ–ийг яагаад амжилттай мөрдөн байцааж, хянан шийдвэрлэж чадахгүй байгаа шалтгааныг тодруулав. Зураг 3.10.–т ХХГХ–ийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилсан сэргийлэх ялангуяа шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр танд санал байгаа юу гэхэд 74.4% (29) нь үгүй, 23.1% (9) нь тийм гэж хариулжээ.

Зураг 3.10. Хамтын ажиллагааг сайжруулах санал



Шүүгчдийн хувьд ХХГХ–тэй тэмцэх чиглэлээр хамтын ажиллагааг сайжруулахын тулд “**эрх зүйн орчныг сайжруулах**”, “**алба хаагчдын мэргэжлийн ур чадварыг**

дээшлүүлэх, шаталсан сургалтыг зохион байгуулах”, “**ХХГХ–тэй тэмцэх чиглэлээр нэгдсэн ойлголттой болох**”, “**улс орны сайн туршлагыг судлах**” зэрэг саналыг гаргасан.

5.4. ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХИЛИЙН ШАЛГАН НЭВТРҮҮЛЭХ АЛБАНЫ АЛБА ХААГЧДААС АВСАН САНАЛ АСУУЛГЫН ДҮН


ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ БАЙДАЛ

Хууль сахиулах байгууллагын алба хаагчид, прокурор, шүүгч, хил хамгаалах болон ГИХГ-ын алба хаагчдын хохирогч төвтэй аргачлалыг хэрэглэх чадавхыг үнэлэх судалгаанд ХШНА-ны 53 алба хаагч оролцсон байна. ХШНА-ны үйл ажиллагааны онцлог, хил орчмын байршилтай холбоотойгоор орон нутагт

ажилладаг алба хаагчид судалгаанд оролцогчдын 69.8%-ийг (37) эзэлж байгаа юм.

Судалгаанд оролцогчдын нас, хүйсийн бүтцийг дараах зургаар харуулав. (Зураг 4.1)


Зураг 4.1. Судалгаанд оролцогчдын насны бүлэг, хүйсээр



ХШНА-аас судалгаанд оролцогчдын 54.7% (29) нь эрэгтэй, 45.3% (24) нь эмэгтэй алба хаагчид байлаа. Оролцогчдын 50.9% (27) нь 1-5 жил, 41.5% (22) нь 6-15 жил, 7.5% (4)

нь 16-20 жил ХШНА-нд ажиллаж байгаа алба хаагчид судалгаанд хамрагдсан байна. (Зураг 4.2)

Зураг 4.2. Хилийн шалган нэвтрүүлэх албанд ажилласан хугацаа



ХШНА-аас судалгаанд оролцогчдын 32.1% (17) нь удирдах, 62.3% (33) нь гүйцэтгэх албан тушаалын ажилтнууд байлаа.


ХХГХ-ИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТ, МЭДЛЭГ

Энэхүү судалгаанаас хүлээж буй гол үр дүнгийн нэг бол холбогдох алба хаагчдын ХХГХ талаарх мэдлэг, ойлголт ямар байгаад суурь үнэлгээ хийх явдал юм. ХШНА-аас судалгаанд оролцсон алба хаагчид хүний эрх, эрх чөлөөнд халдах 18.9% (10), хөдөлмөрийн мөлжлөг 13.2% (7), ноцтой

гэмт хэрэг 13.2% (7), бэлгийн мөлжлөг 11.3% (6), хүчээр биеийг нь үнэлүүлэх 7.5% (4), хүний эд эрхтнийг зарах 7.5% (4) нь ХХГХ гэж үзэж байна.

Судалгаанд оролцогчдын 16.9% (9) нь ХХГХ-ийн талаар “мэдэхгүй” гэж хариулжээ. ХХГХ-ийн талаарх өөрийн ойлголтыг тодорхойлсон асуултад хариулсан байдлаас үзвэл ХХГХ-ийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, холбогдох алба хаагчдад илүү мэдлэг, мэдээлэл өгөх хэрэгтэй байгаа нь харагдаж байна.

Зураг 4.3. Таны бодлоор Монгол Улсад ХХГХ-ийн аль хэлбэр илүү давамгайлж байгаа вэ?



* Олон сонголттой хариулт учир 100% барихгүй

Таны бодлоор, ХХГХ-ийн аль хэлбэрүүд Монгол Улсад давамгайлж байна вэ гэсэн асуултад биеийг нь хүчээр үнэлүүлэх 69.8% (37), бэлгийн мөлжлөгт байлгах 58.5% (35), албадан хөдөлмөр эрхлүүлэх 58.5% (35) хэлбэрүүд Монгол Улсад давамгайлж байна гэж судалгаанд оролцогчдын дийлэнх үзжээ. Мөн хуурамч гэрлэлт, эд эрхтнийг наймаалах, тээгч эх болгох хэлбэрүүд олшрох болсон гэж үзэж байгаагаа илэрхийлжээ. Оролцогчдын 3.8% (2) нь ХХГХ-ийн ямар хэлбэрүүд Монгол Улсад давамгайлах болсныг “мэдэхгүй” гэсэн байна. (Зураг 4.3)

Судалгаанд оролцогчдын 11.3% (6) нь хилийн шалган нэвтрүүлэх үүрэг гүйцэтгэх явцдаа ХХГХ-ийн шинжтэй үйлдлийг илрүүлж удирдлагадаа мэдэгдэх, цагдаагийн

болон тагнуулын байгууллагад шилжүүлэх, ар гэрт нь хүлээлгэж өгөх арга хэмжээ авч байжээ.

Монгол Улсад ХХГХ үйлдэгдэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар алба хаагчдын санаа бодлыг асууж судаллаа. Судалгаанд оролцогчдын 49% (26) нь ХХГХ үйлдэгдэхэд ядуурал хамгийн ихээр нөлөөлж байгаа гэж үзсэн байна. Түүнчлэн мөнгөний ашиг сонирхол, нийгмийн байдал, ажилгүйдэл, хууль эрх зүйн мэдлэг дутмаг байдал нөлөөлж байна гэжээ.

ХХГХ гарахад нөлөөлж буй хүчин зүйлсийн талаарх судалгаанд оролцогчдын саналыг дараах зурагт үзүүлээ.


Хүснэгт 4.1. Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлж буй хүчин зүйлс

Нийгмийн хүчин зүйлс	Хувь	Хувь хүний хүчин зүйлс	Хувь
Ядуурал	49%	Ар гэрийн хараа, хяналт сул	1.9%
Ажилгүйдэл	5.7%	Мэдлэг, мэдээлэл дутмаг	9.4%
Нийгмийн тогтворгүй байдал	5.7%	Мөнгөний ашиг сонирхол	13.2%
		Хувь хүний зан байдал, төлөвшил	3.8%
Мэдэхгүй			11.3%

Хувь хүний зан байдал, төлөвшил 3.8% (2), нийт иргэдийн дунд мэдээлэл дутмаг 9.4% (5) байгаа нь ХХГХ-т өртөхөд нөлөөлж байна гэж мэргэжлийн байгууллагын алба хаагчид үзэж байгаа нь ХХГХ-ийн талаарх ойлголт, мэдлэгийг олон нийтэд таниулахад төслийн зүгээс хувь нэмэр оруулах хэрэгцээ байж болох юм. ХХГХ гарахад ямар хүчин зүйлс нөлөөлж байгааг “мэдэхгүй” гэдгээ оролцогчдын 11.3% (6) илэрхийлсэн байна.

ЭХХШТХ-ийн 30.7 дугаар зүйлийн 2.6 дахь хэсэгт зааснаар хилийн зурваст үйлдэгдсэн аливаа гэмт хэрэгт хойшлуулшгүй тохиолдолд мөрдөн шалгах ажиллагаа явуулах үүрэгтэй. Хэрвээ хилийн шалган нэвтрүүлэх үүрэг гүйцэтгэж байх үедээ ХХГХ-ийн сэжигтэй тохиолдол гарвал ямар ажиллагаа явуулж илрүүлэх вэ гэсэн асуултад судалгаанд оролцсон алба хаагчдын хамгийн олон буюу 37.8% (20) нь “удирдлагадаа мэдэгдэнэ” гэж хариулсан байна.

Зураг 4.4. ХХГХ–ийн сэжигтэй тохиолдол гарвал авах арга хэмжээний талаарх оролцогчдын санал /хувиар/




Хилийн шалган нэвтрүүлэх үүрэг гүйцэтгэж байх үедээ ХХГХ–ийн сэжигтэй тохиолдол гарвал ямар ажиллагаа явуулж илрүүлэхээ оролцогчдын 1.9% (1) нь мэдэхгүй гэжээ. ХХГХ–ийн шинжийг илрүүлсэн тохиолдолд нотлох баримтыг хэрхэн яаж цуглуулах талаар өөрсдийнх нь бодлыг тодруулсан болно. Хариулт өгсөн оролцогчдын 43.4% (23) нь гэрч хохирогчийн мэдүүлэг авна, 30.2% (16) нь бичиг баримтад үзлэг хийнэ, 22.6% (12) нь баримтжуулалт хийнэ гэсэн байна. Тагнуулын байгууллага журмын дагуу ажилладаг гэж 3.8% (2) нь хариулсан байна. ХХГХ–ийн шинжийг илрүүлсэн тохиолдолд юуг нотлох баримт гэж үзэх тухайд саналаа илэрхийлсэн оролцогчдын 43.4% (23) нь иргэний бичиг баримтыг, 18.9% (10) нь фото зураг, 18.9% (10) нь дүрс бичлэгийг ХХГХ–ийн нотлох баримт гэж үзнэ гэжээ. Хохирогч өөрийн амаар болон бичгээр өгсөн баримт, аяллын зорилго, хил нэвтрэх шалтгааны тодорхойгүй байдал, хохирогчтой ганцаарчилсан уулзалт хийсэн мэдээлэл, биеэ авч яваа байдал, баримт бичгийн эзэн мөн гэдэг нотолгоо зэрэг нөхцөл байдлыг “бусад баримт бичиг”–т багтах нотлох баримт болно гэж алба хаагчдын 17% (9) нь үзэж байна.

Насанд хүрээгүй хүнийг хилээр шалган нэвтрүүлэхдээ ХЗДХ–ийн сайдын 2017 оны 03 сарын 03–ны А49 тоот тушаалаар

батлагдсан “Хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих” журмаар зохицуулдаг гэж судалгаанд оролцсон алба хаагчдын 86.8% (46) нь хариулсан байна. Оролцогчдын 7.5% (4) нь Монгол Улсын Иргэний хуулиар насанд хүрээгүй хүнийг хилээр шалган нэвтрүүлэх ажиллагааг зохицуулдаг гэжээ. Ямар хууль, журмаар зохицуулдгийг мэдэхгүй гэж 3.8% (2) нь хариулсан байна. Насанд хүрээгүй хүнийг хилийн чанадад үлдээгээд ирсэн тохиолдолд голлон “тодруулга” авах зохицуулалт хийдгийг судалгаанд оролцогчдын 56.6%–н (30) санал харуулж байна. Энэхүү зохицуулалтын хүрээнд нотолгоо үйлдээд цагдаагийн байгууллагад шилжүүлэх, ахлах дарга, удирдлагад мэдэгдэх мөн нотолгоо үйлдээд тагнуулын байгууллагад шилжүүлэх ажиллагаа багтдаг ажээ. Насанд хүрээгүй хүнийг хилийн чанадад үлдээгээд ирсэн тохиолдолд хаана ямар хүнд үлдээсэн тухай тайлбар, холбогдох хаяг, утасны дугаар, паспорт үнэмлэхийн хуулбар зэрэг нотлох баримт, үлдээсэн газрын талаарх мэдээлэл бүхий тодруулга авдаг байна.

ХШНА–ны судалгаанд оролцсон алба хаагчдын 54.7% (29) нь эмэгтэйчүүдийг хүүхэд тээлгэх зорилгоор худалдаалдаг талаар сонсож байгаагүй байна.

Зураг 4.5. Эмэгтэйчүүдийг хүүхэд тээлгэх зорилгоор худалдаалдаг талаар сонсож байсан уу?



Хүүхэд тээлгэх зорилгоор ХХГХ үйлдэгдэж байсан хэрэгтэй судалгаанд оролцогч нэг алба хаагч таарч байсан гэж хариулсан байгаа боловч тус хэргийг хэрхэн илрүүлсэн, ямар арга хэмжээ авсан тухайгаа тайлбарлаагүй байна. Хүүхэд тээлгэх зорилго нь сайн дурын үндсэн дээр харилцан тохиролцсон байвал танин мэдэх, таслан зогсоход хүндрэлтэй, эх, хүүхэд хоёрын амь насанд эрсдэлтэй, жирэмсэн эсэхийг нь мэдэх боломжгүй, тээгч эх гэдгийг нотлоход хүндрэлтэй зэрэг олон хүндрэл бэрхшээл байдгийг алба хаагчид дурдсан байна. Хүүхэд тээлгэх зорилготой ХХГХ-ийг илрүүлэхэд хувь хүн өөрөө нууцалж байвал илрэх боломжгүй гэж алба хаагчдын 22.6% (12), илрүүлэхэд хүнд гэж 13.2% (7), улсын хилээр нэвтэрч буй жирэмсэн эмэгтэй бүрийг сэжиглэх боломжгүй гэж 7.5% (4) нь үзэж байна. Хүүхэд тээлгэх зорилготой ХХГХ-ийг илрүүлэхэд учирч болох хүндрэл бэрхшээлийг “мэдэхгүй” гэж оролцогчдын 49.1% (26) нь хариулсан байна.


Эрсдэлтэй гэж үзсэн ХХГХ-ийн хохирогчийг илрүүлэх тусгай арга техник, журам ашигладаг гэж судалгаанд оролцогчдын 13.2% (7), ашигладаггүй гэж 77.4% (41) нь хариулсан байна. Эрсдэлтэй гэж үзсэн хохирогчийг илрүүлэхдээ хилийн боомтын дүрэм журмын дагуу гүнзгийрүүлсэн асуулт асуудаг гэжээ. ХХГХ-ийн хохирогчийг илрүүлсэн тохиолдолд оролцогчдын 90.6% (48) нь хууль, шүүхийн байгууллага, түүнээс цагдаа, тагнуулын байгууллагад хандаж арга хэмжээ

авна гэжээ. Төрийн байгууллагаас нийслэл, аймгийн гэр бүл хөгжлийн газарт юуны түрүүнд хандах юм байна. ТББ болон ар гэрийнхэнтэй нь холбогдож хүлээлгэж өгдөг гэж оролцогчдын 11.3% (6) нь хариулсан байна.

ХХГХ-ийг илрүүлэх, шалгахдаа бусад хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах байгууллагуудтай хамтран ажилладаг гэж судалгаанд оролцогчдын 62.3% (33) нь хариулсан. Хамтын ажиллагааны гол чиглэлүүд нь ХХГХ-ийн хохирогчийг илрүүлэх, шалгахдаа цагдаагийн болон тагнуулын байгууллагатай хамтран ажиллаж эдгээр байгууллагуудад хүлээлгэн өгдөг байна. Харилцан мэдээлэл солилцох замаар лавлагаа, тодруулга гаргадаг гэжээ. ХХГХ-ийг илрүүлэх, шалгахдаа бусад хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах байгууллагуудтай хамтран ажилладаггүй гэж хариулсан алба хаагчдын тухайд ХХГХ-тэй таарч байгаагүй, бид илрүүлэх үүрэгтэй ч шалгах эрхгүй учир хохирогч илэрсэн тохиолдолд ахлах даргадаа илтгэдэг, илэрсэн тухай мэдээлэл авч байгаагүй, мэдэхгүй гэсэн тайлбар хийсэн байна.

Хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах байгууллагууд ХХГХ-ийг илрүүлэх, шалгахдаа хамтран ажилладаг гэж үзэж байгаа алба хаагчдын энэхүү хамтын ажиллагааны одоогийн түвшнийг хэрхэн үнэлж байгааг Зураг 4.6-г үзүүлээ.

Зураг 4.6. Хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах байгууллагуудын хамтын ажиллагааны түвшин ямар байна вэ?



ХХГХ-ийг илрүүлэх, шалгахдаа ТББ-тай хамтран ажилладаг гэж оролцогчдын 15.1% (8) хариулжээ. ТББ-тай хамтран ажиллахдаа мэдээлэл солилцох, тараах материалаар хангах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа зохион байгуулах зэрэг арга хэмжээгээр хэрэгжүүлдэг байна. ХХГХ-ийг илрүүлэх,

шалгах ажиллагаа явуулахад хүндрэл, бэрхшээл учирдаггүй гэж асуулгад оролцогчдын 73.6% (39), учирдаг гэж 26.4% (14) нь хариулсан байна.

Судалгаанд оролцогчид дараах хүндрэл, бэрхшээлийг нэрлэж байна. Үүнд:

Хүснэгт 4.2. ХХГХ-ийг илрүүлэх, шалгах ажиллагаанд тулгардаг хүндрэл бэрхшээл

Хууль эрх зүйн орчны хүрээнд:	Хууль, эрх зүйн мэдлэгийг олгодоггүй Хууль, дүрэм хангалттай байдаггүй Хууль, тэдгээртэй нийцүүлж гаргасан журмыг сурталчилж олон хийтэд хүргэх нь дутагдалтай Байгууллага хоорондын харилцаа муу
Ажиллах орчин, нөхцөлийн тухай:	Цаг хугацаа бага Сургалт мэдээлэл ордоггүй Техник хэрэгсэл муу
Мэргэжлийн мэдлэг, ур чадварын тухайд:	Боловсон хүчний дадлага чадвар дутмаг, энэ талаар сургалт бага Мэдлэг, ур чадвар дутмаг ХХГХ-ийн талаарх ойлголт, мэдлэг дутмаг
Дотоодын хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах байгууллагуудын хамтын ажиллагааны тухайд:	Хамтын ажиллагаа муу
Гадаадын хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах байгууллагуудын хамтын ажиллагааны тухайд:	Хамын ажиллагаа байхгүй

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

ХХГХ-тэй тэмцэх хуулийн зарчмуудын хэрэгжилт болон хохирогчийг хамгаалах хүний эрхэд суурилсан хэм хэмжээ,

стандартын хэрэгжилтэд судалгаанд оролцогчдын өгсөн үнэлгээг дараах хүснэгтээр үзүүлээ.

Хүснэгт 4.3. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн зарчмуудын хэрэгжилт

Д/д	ЗАРЧМУУД	Хангалттай сайн	Хангалттай	Хангалтгүй	Туйлын хангалтгүй	Мэдэхгүй
		(4)	(3)	(2)	(1)	(88)
1	Дотоодын хууль тогтоомжийн хэрэгжилт	4 (7.5%)	13 (24.5%)	17 (32.1%)	1 (1.9%)	18 (34.0%)
2	Олон улсын стандарт, гэрээ, конвенцийн хэрэгжилт	2 (3.8%)	16 (30.2%)	14 (26.4%)	1 (1.9%)	20 (37.7%)
3	Хохирогчийн нэр төрийг хүндэтгэх	1 (1.9%)	14 (26.4%)	18 (34.0%)	3 (5.7%)	17 (32.1%)
4	Хохирогчдыг хүйс, бэлгийн чиг хандлага, иргэншил, үндэс угсаагаар нь ялгаварлан гадуурхахгүй байх	4 (7.5%)	11 (20.8%)	16 (30.2%)	5 (9.4%)	17 (32.1%)
5	Хохирогчийг үл буруутгах	1 (1.9%)	9 (17.0%)	18 (34.0%)	5 (9.4%)	20 (37.7%)

6	Хохирогчийн аюулгүй байдлыг хангах	3 (5.7%)	8 (15.1%)	18 (34.0%)	8 (15.1%)	16 (30.2%)
7	Хувийн нууцыг нь хамгаалах	3 (5.7%)	13 (24.5%)	15 (28.3%)	7 (13.2%)	15 (28.3%)
8	Олон улсын хамтын ажиллагаа, иргэний нийгмийн оролцоонд түшиглэх	2 (3.8%)	10 (18.9%)	13 (24.5%)	3 (5.7%)	25 (47.1%)

Судалгаанд оролцогчдын өгсөн үнэлгээний дүнгээс харахад дотоодын хууль тогтоомжийн хэрэгжилт хангалттай сайн гэж оролцогчдын 7.5% (4) үзэж байгаа нь энэ түвшний хамгийн өндөр үнэлгээ байна. Дотоодын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангалттай гэж оролцогчдын 24.5% (13), хангалтгүй гэж 32.1% (17) нь үзжээ. Хохирогчдын хүйс, бэлгийн чиг хандлага, иргэншил, үндэс угсаагаар ялгаварлан гадуурхахгүй байх зарчмын хэрэгжилтийг “хангалттай сайн” гэж судалгаанд оролцогчдын 7.5% (4) нь үзсэн бол 30.2% (16) нь хангалтгүй гэж үзсэн байна. Хохирогчийн нэр төрийг хүндэтгэх зарчмын хэрэгжилт хангалтгүй гэж оролцогчдын 34% (18), хохирогчийг үл буруутгах зарчмын хэрэгжилт хангалтгүй гэж 34% (18) нь үзэж байгаагаа илэрхийлжээ. Судалгаанд оролцогчид хохирогчийн аюулгүй байдлыг хангах (15.1% – 8), хувийн нууцыг нь хамгаалах 13.2% (7) зарчмуудын хэрэгжилт “туйлын хангалтгүй” гэсэн үнэлгээ өгсөн байгаа нь хамгийн өндөр түвшин байна. Оролцогчдын 34.9% (18.5) нь дунджаар ХХГХ–тэй тэмцэх хуулийн зарчмуудын хэрэгжилт болон хохирогчийг хамгаалах хүний эрхэд суурилсан хэм хэмжээ, стандартын хэрэгжилт ямар

түвшинд байгааг “мэдэхгүй” гэж хариулжээ. Олон улсын хамтын ажиллагаа, иргэний нийгмийн оролцоонд түшиглэх зарчмуудын хэрэгжилтийг хамгийн олон буюу оролцогчдын 47.1% (25), олон улсын стандарт, гэрээ, конвенцийн хэрэгжилтийг оролцогчдын 37.7% (20) нь “мэдэхгүй” гэсэн байна.


Алба хаагчдад хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, бусад эрх зүйн баримт бичгүүд, олон улсын стандарт, гэрээ, конвенцийн холбогдох материал, хэрэгжилтийн байдлын талаарх мэдээллийг хүртээмжтэй хүргэж бодит хэрэгцээ байгаа юм байна.

ХХГХ–ТЭЙ ТЭМЦЭХ ЧИГЛЭЛЭЭР ЯВУУЛЖ БУЙ СУРГАЛТЫН ЧАНАР, ҮР ДҮН

Төрийн байгууллагаас зохион байгуулсан сургалт

ХШНА–аас судалгаанд оролцсон алба хаагчдын 73.6% (39) нь ХХГХ–тэй тэмцэх чиглэлээр төрийн зүгээс явуулж буй мэргэшүүлэх ямар ч сургалтад хамрагдаж байгаагүй гэжээ.

Зураг 4.7. Төрөөс явуулж буй сургалтын чанар, үр дүн сайн байсан эсэх




Сургалтад оролцогчдын 14.3% (2) нь сургалтын чанарыг “сайн” гэж үнэлсэн байна. Сургалтын чанарыг сайн гэж үзэхгүй байгаа 85.7%–ийг (12) эзэлж буй алба хаагчид дараах шалтгааны улмаас сургалт үр дүнд хүрэхгүй байна гэж үзсэн байна. Үүнд:

1. Мэдээ, мэдээлэл хомс.
2. Үндсэн сургалтад хамрагдах ёстой хүмүүсийг хамруулдаггүй.
3. Бүх шатанд үр дүн тооцох арга хэмжээ авдаггүй, ач холбогдол өгдөггүй.

Төслийн хэрэгжилтийг сайжруулахад хувь нэмэр оруулах зорилгоор сургалтын чанар, үр дүнг хянах шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, явцын үнэлгээ хийж байх

шаардлагатай гэж судлаачид үзэж байна. Сургалтын 1–3 цаг, хагас өдрөөс 2 өдөр үргэлжлэх хугацаа хангалттай гэж 4 (28.6%) хүн л хариулсан байгаа бөгөөд хангалтгүй, хугацаа богино байсан гэж 3 (21.4%) хүн үзсэн байна. Сургалтын агуулга хэрэгцээтэй байсан гэж оролцогчдын 14.3 % (2) хариулсан. Гэмт хэргийн тухай ойлголтууд, олон улсын жишиг жишээтэй танилцах, гарах үр дүнг нэмэгдүүлэх арга зүйн агуулга нь илүү ойлгомжтой, тодорхой байжээ. Сургалтын зарим агуулга ойлгомжгүй, хугацаа нь богино байсан гэж сургалтын сул талыг тодорхойлсон байна. Сургалтыг ямар хэлбэрээр зохион байгуулбал илүү үр дүнтэй болно гэж үзэж байгаа талаар нь судалгаанд оролцогчдоос авсан санал асуулгын дүнг Зураг 4.8–т үзүүлээ.

Зураг 4.8. Сургалтыг ямар аргачлалаар хүргэвэл илүү үр дүнтэй вэ?



**Олон сонголттой хариулт тул дүн 100%–д барихгүй.*


Судалгаанд оролцсон алба хаагчид “бодит кейсүүд дээр ажиллах” хэлбэрийн сургалтад илүү ач холбогдол өгч байгаа нь сургалтыг үр дүнтэй болгох асуудалд оролцогчдын өгсөн 77.4%–н (41) санал харуулж байна. Мөн “багаар ажиллах” хэлбэрийг оролцогчдын 37.7% (20) нь дэмжиж байгаагаа илэрхийлсэн байна. Сургалтын интерактив арга 26.4%–н (14) санал авчээ.

Төрийн бус болон олон улсын байгууллагаас явуулсан сургалт

ХШНА–ны судалгаанд оролцсон алба хаагчдын 56.6% (30) нь ХХГХ–тэй тэмцэх чиглэлээр төрийн бус болон ОУБ–

аас зохион байгуулсан сургалтад хамрагдаагүй байна. Сургалтад хамрагдаагүй шалтгаанаа ийм төрлийн сургалтын талаар мэдээлэл аваагүй гэж хариулжээ. Сургалтад оролцогчдын 30.2% (16) нь сургалтын чанар сайн, 47.2% (25) нь сайн биш гэж үзжээ. Сургалтын хугацаа богино байсан гэж оролцогчид үзэж байна. Зарим сургалтын талаар дээш уламжлахад хэцүү, ойлгомжгүй сул тал байсан байна. Сургалтын агуулгын талаар ямар бодолтой байгаагаа хэн ч илэрхийлсэнгүй.

Зураг 4.9. ХХГХ–ийн талаарх ном, гарын авлага, нэг сэдэвт бүтээлийн чанар, хүртээмж



ХХГХ–ийн талаарх ном, гарын авлага, нэг сэдэвт бүтээлийн чанар, хүртээмжийг судалгаанд оролцогчдын гуравны нэг нь ойлгомжтой гэж үзжээ. ХХГХ–тэй тэмцэх чиглэлээр ХШНА–ны алба хаагчдад зориулсан тусгайлсан сургалт явуулсан гэж судалгаанд оролцогчдын дөнгөж 18.9% (10) хариулсан бөгөөд 69.8% (37) нь ийм сургалт явуулдаггүй гэж хариулсан байгаа нь “ХХГХ–ийн хохирогч төвтэй мөрдөн

шалгах ажиллагаа, прокурорын хяналтыг сайжруулах нь” төслийн үйл ажиллагааны хүрээнд зохих анхаарал хандуулах хэрэгтэй байна.

Зураг 4.10–т ХХГХ–тэй тэмцэх чиглэлийн аль сэдвийг ХШНА–ны алба хаагчид хамгийн чухал гэж үзэж байгаа талаарх мэдээллийг үзүүлээ.

Зураг 4.10. ХХГХ–тэй тэмцэх чиглэлийн ямар сургалтанд хамрагдахыг хүсч буй байдал



Судалгаанд оролцогчдын олонх буюу 90.6% (48) нь ХХГХ–ийн талаарх ерөнхий ойлголт өгөх сургалт мэдээлэл нэн чухал ба чухал гэж үзэж байна. ХХГХ–тэй тэмцэх үйл ажиллагаа болон ХХГХ–ийн нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх ажиллагааны талаар мэдлэг, мэдээлэл олж авах нь ХШНА–ны алба хаагчдын тухайд хамгийн чухал асуудал болж байна.

ХШНА–нд ХХГХ–тэй тэмцэх чиглэлээр мэргэшсэн албан тушаалтан бэлтгэх шаардлагатай гэж судалгаанд оролцогчдын 86.8% (46) үзэж байна. Судалгаанд оролцогчдын 60.4% (32) нь ХХГХ–тэй тэмцэх чиглэлээр зохион байгуулалтын дараах арга хэмжээ авах ёстой гэж үзэж байгаагаа илэрхийлжээ. Үүнд:

1. Сургалт зохион байгуулж, холбогдох бүх алба хаагчдыг хамруулах,
2. Мэргэшсэн алба хаагчид бий болгох,
3. Сургагч багш бэлтгэх,
4. Урьдчилан сэргийлэх ажиллагааг тогтмол хугацаанд явуулж байх,
5. Туршлага солилцох,
6. Хууль эрх зүйн дүрэм, журмыг сайжруулж, түүнийг дагаж мөрдөх гэсэн үзэл бодолтой байлаа.

Саналаа илэрхийлсэн оролцогчдын 58.5% (31) нь Хил хамгаалах байгууллагаас сургалт зохион байгуулах шаардлагатай гэж үзэж байна.


5.5. ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН АЛБА ХААГЧДААС АВСАН САНАЛ АСУУЛГЫН ДҮН

ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ БАЙДАЛ

Хууль сахиулах байгууллагын алба хаагчид, прокурор, шүүгч, хил хамгаалах болон цагаачлалын албаны алба хаагчдын хохирогч төвтэй аргачлалыг хэрэглэх чадавхыг үнэлэх судалгаанд ГИХГ-ын 15 эрэгтэй, 3 эмэгтэй, нийт 18

алба хаагч оролцсон байна. Судалгаанд оролцогчдын 80 гаруй хувь нь хяналтын улсын байцаагч нар байлаа. Зураг 5.1.-т судалгаанд оролцогчдын тоог насны бүлэг, хүйсээр үзүүлээ.


Зураг 5.1. Судалгаанд оролцогчдын тоо насны бүлэг, хүйсээр



Судалгаанд оролцогчдын 22.3% (4) нь нэгээс таван жил, 44.4% (8) нь зургаагаас арван жил, 33.3% (6) нь арван нэгээс арван зургаан жил тухайн байгууллагадаа ажилласан

туршлагатай байна. Мөн орон нутагт ажилладаг алба хаагчид 44.4%-ийг (8) эзэлж байгаа нь хот, хөдөөгийн алба хаагчдын оролцоог хангаж өглөө.

Зураг 5.2 ГИХГ-т ажилласан хугацаа




ХХГХ-ИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТ, МЭДЛЭГ

Энэхүү судалгаанаас хүлээж буй гол үр дүнгийн нэг бол холбогдох алба хаагчдын ХХГХ-ийн талаарх мэдлэг, ойлголт ямар байгааг олж мэдэх явдал юм. ГИХГ-аас судалгаанд оролцсон алба хаагчдын 44.4% (8) нь ХХГХ нь

бэлгийн болон албадан хөдөлмөрийн мөлжлөг, хүний эд эрхтнийг авах явдал гэсэн ойлголттой байна. Зураг 5.3-т ХХГХ-ийн Монгол Улсад давамгайлж байна гэж үзэж байгаа хэлбэрүүдийг судалгаанд оролцогчдын саналаар эрэмбэлэн харууллаа.

Зураг 5.3. Таны бодлоор Монгол Улсад ХХГХ–ийн аль хэлбэр илүү давамгайлж байгаа вэ?



* Олон сонголттой хариулт учир 100% барихгүй

ХХГХ–ийн хүний биеийг хүчээр үнэлүүлэх, бэлгийн мөлжлөгт байлгах, албадан хөдөлмөр эрхлүүлэх, хуурамч гэрлэлт, эд эрхтнийг наймаалах хэлбэрүүд Монгол Улсад давамгайлж байна гэж судалгаанд оролцогчдын дийлэнх үзжээ. Мөн худалдах, гэрийн үйлчлэгч, тээгч эх болгох хандлага энэ гэмт хэргийн давамгайлах хэлбэрт багтаж байна гэж тус бүр 3 хүн хариулсан байна.

Төрийн хяналт, шалгалт хийх явцад ХХГХ–ийн шинжтэй үйлдэл гарч байсан гэж ганцхан оролцогч хариулсан бөгөөд зөвлөгөө, мэдээлэл өгөх арга хэмжээ авсан байна. Хөдөлмөрийн гэрээнд заасан нөхцөл байдал нь ХХГХ–ийн шинжтэй гэж үзэх нотлох баримт болно гэж тухайн алба хаагч үзжээ.

ХХГХ гарахад эдийн засгийн хүчин зүйлс нөлөөлж байна гэж судалгаанд оролцогчдын 83.3% (15) нь үзсэн байна.

Хүснэгт 5.1. Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлж буй хүчин зүйлс

Нийгмийн хүчин зүйлс	Хувь	Хувь хүний хүчин зүйлс	Хувь
Эдийн засаг	83.3% (15)	Ар гэрийн хараа, хяналт сул	5.6% (1)
Хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаа сул	44.4% (8)	Мэдлэг, мэдээлэл дутмаг	16.7% (3)
Ажилгүйдэл	16.7% (3)	Гадаад явах хүсэл, сонирхол	5.6% (1)
Нийгмийн тогтворгүй байдал	27.8% (4)		
Цахим ертөнц	5.6% (1)		

Судалгаанд оролцогчдын 44.4% (8) нь хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаа сул байгаа нь ХХГХ гарахад нөлөөлж байна гэж үзсэн нь анхаарал татаж байгаа юм. Хууль хяналтын байгууллагын алба хаагчдын энэхүү саналыг ХХГХ–ийн талаарх холбогдох эрх зүйн баримт бичгийг дэлгэрэнгүй танилцуулах, ойлголт, мэдлэг, мэдээлэл олгох шаталсан сургалтууд зохион байгуулах хэрэгцээ гэж судлаачид харж байна. Мөн нийт иргэдийн дунд мэдээлэл

дутмаг байгаа нь ХХГХ гарахад нөлөөлж буй хүчин зүйл гэж судалгаанд оролцогчдын 16.7% (3) үзсэн байна.

ХХГХ гарахад нөлөөлж буй хүчин зүйлсийн талаарх судалгаанд оролцогчдын саналыг Хүснэгт 5.1–т үзүүлснээр ажилгүйдэл, ядуурал, нийгмийн байдал зэрэг нийгмийн шинжтэй хүчин зүйлс байна гэж тодорхойлсон байна. Түүнчлэн, “бусад” гэсэн бүлэгт ар гэрийн хараа хяналт сул,

интернет сошиал сайтууд, боловсролын байдал, мөнгөний ашиг сонирхол, засаглалын байдал зэрэг хүчин зүйлийг нэрлэж, эдгээр нь ХХГХ гарахад нөлөөлж буй хүчин зүйл мөн гэж үзжээ.

Холбогдохалбахаагчидхяналт,шалгалтынажлаахэрэгжүүлэх явцдаа ХХГХ–ийн шинжийг илрүүлэх боломжтой эсэх, юуг нотлох баримт гэж үзэх, нотлох баримтыг ямар арга барилаар хэрхэн яаж цуглуулж болох тухай мэдээллийг судалгаанд оролцогчдоос асууж судаллаа. Судалгаанд оролцогчдын 44.4% (8) нь хяналт, шалгалтын явцад ХХГХ–ийн талаар мэдээлэл авч, нотлох баримт цуглуулах боломжтой гэж хариулсан бол 38.9% (7) нь боломжгүй гэж хариулсан байна. Хууль, журмын дагуу цуглуулсан бичиг баримт, иргэний бичиг баримт, фото зураг, дуу, дүрс бичлэг зэрэг нь ХХГХ–ийн шинж байгааг нотлох баримт болно гэж алба хаагчид үзэж байна. Хөдөлмөрийн гэрээнд заасан нөхцөл, цалин хөлс олгосон, мөнгө авсан баримт, камерын бичлэг, холбогдох утасны дугаар руу залгах, тайлбар авах зэргээр нотлох баримт цуглуулах боломжтой гэж оролцогчид үзжээ. Мөн асуулга авах, уулзалт хийх, ашиг олох зорилготой хүний дүрээр гэмт хэрэгтнүүдтэй уулзах, видео бичлэг хийх, дуу хураагуур ашиглах зэргээр нотлох баримт цуглуулж болно гэсэн саналууд гарсан байна. Судалгаанд оролцогчдын 11.1% (2) нь нотлох баримтыг ямар аргаар хэрхэн яаж цуглуулахыг “мэдэхгүй” гэж хариулжээ. Хуулиар хүлээсэн үүргийн дагуу холбогдох алба хаагчид нь баримт бичиг шалгахгаас өөрөөр нягтлан шалгах үйл ажиллагаа явуулах эрхгүй гэдгээ тайлбарласан байна. Энэ байдлыг ХХГХ–ийн талаарх ойлголт, мэдлэг, мэдээллийг илүү хүртээмжтэй болгох ёстой гэж харж байна.

Гадаадын иргэн ХХГХ–т өртсөн тухай мэдээллийг авч байгаагүй гэж судалгаанд оролцогчдын 77.8% (14) хариулсан байна. Энэ тухай мэдээллийг оролцогчдын 16.7% (3) нь авч байсан бөгөөд БНХАУ, Тайланд улсын иргэд байсан гэжээ. Гадаадын иргэн Монгол Улсад ХХГХ–т өртөх эрсдэл байна гэж эдгээр алба хаагчид үзсэн бөгөөд гол шалтгаан нь ажлын хөлсийг олгохгүй, цалин хөлсний зөрчил байдаг гэжээ.

Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхэд үрчлүүлэх нь ОУБ–аар дамжуулан хуулийн дагуу үйлдэгддэг, суурь өвчтэй хүүхдийг үрчилж аваад сайхан өсгөж байгаа тохиолдол байгаа, ГААГ–ийн конвенцийн дагуу хууль хэрэглэдэг, эрсдэлтэй нөхцөл байдал нотлогдоогүй, ГИХГ үрчлэгдсэн хүүхдүүдэд маш сайн хяналт тавьдаг зэрэг тодорхой учир шалтгааныг үндэслэн ХХГХ–ийн эрсдэл үүсэхгүй гэж судалгаанд оролцсон алба хаагчдын 77.8% (14) үзэж байна. Харин манай орны нөхцөл байдлыг сайн тодорхойлох шаардлагатай тул эрсдэл байна гэж 11.1% (2) нь үзсэн байхад эрсдэл үүсэх эсэхийг мэдэхгүй гэж 11.1% (2) нь хариулжээ.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай болон Гэр бүлийн тухай хуульд зааснаар гадаадын иргэнд үрчлэгдэж байгаа Монгол Улсын харьяат хүүхдийн асуудлыг шийдвэрлэхэд ГИХГ болон ОӨУБЕГ–ын эрх үүрэг, хариуцлага тодорхой байдаг гэж оролцогчдын 55.6% (10), тодорхойгүй гэж 16.7% (3) хариулсан бөгөөд 27.8% (5) нь мэдэхгүй гэсэн байна. Холбогдох байгууллагууд журамдаа нарийн тусгаж өгсөн, гадаадын иргэнд хүүхэд үрчлүүлэх асуудлыг урьдчилан мэдэгдэж судалдаг, байгууллагууд өөрсдийн чиг үүргийн асуудлаа хариуцдаг тул хоёр байгууллагын эрх үүрэг, хариуцлага тодорхой гэж олонх нь үзэж байгаа бол ОӨУБЕГ–ын оролцоо, үүрэг байдаггүй гэж оролцогчдын 11.1% (2) хариулжээ. Хоёр өөр байгууллага асуудлыг хариуцаж байгаа нь хүүхэд үрчлэх замаар ХХГХ үйлдэгдэх эрсдэлийг нэмэгдүүлнэ гэж судалгаанд оролцогчдын 11.1% (2) үзэж байхад 16.7% (3) нь эрсдэл үүсэхгүй гэж үзсэн байна.

Эрсдэлтэй гэж үзсэн ХХГХ–ийн хохирогчийг илрүүлэх тусгай тогтсон стандарт арга техник, журам, асуумж байдаг гэж 11.1% (2) хариулсан бөгөөд санамж, гарын авлага тараадаг байсан гэжээ. Судалгаанд оролцогчдын 22.2% (4) нь тусгай тогтсон стандарт арга техник, журам, асуумж байхгүй, 66.7% (12) нь мэдэхгүй гэж хариулсан байгаа тул холбогдох стандарт арга техник, журам, асуумжийг боловсруулах, сайжруулах, гарын авлага болгон алба хаагч бүрд хүртээмжтэй тараах, хохирогчийг таньж илрүүлэх, холбогдох арга хэмжээ авах сургалтыг зохион байгуулах хэрэгцээ байна.

ХХГХ–ийн хохирогч байж болох магадлалтай тохиолдол илэрвэл цагдаагийн байгууллагад л ханддаг ажээ. Төрийн байгууллагаас “Гэр бүл, хүүхэд залуучуудын газар”–т, цөөн тохиолдолд ТББ болон ар гэрийнхэнтэй нь холбогддог байна.

ХХГХ–ийг илрүүлэн шалгахад бусад хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах тагнуул, цагдаагийн байгууллага, ХШНА, хилийн тагнуултай хамтран ажилладаг гэж судалгаанд оролцогчдын 66.7% (12) нь хариулсан. Дээрх байгууллагууд нь хяналт шалгалт хийх, сургалт семинар зохион байгуулах замаар хамтран ажилладаг бөгөөд хамтын ажиллагааны түвшнийг хангалттай гэж оролцогчдын 33.3% (6) нь тодорхойлжээ.

Түүнчлэн ХХГХ–ийг илрүүлэн шалгахад хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах байгууллагууд хэрхэн хамтран ажиллах тухай нэгдсэн мэдээллээр алба хаагчдыг хангах хэрэгтэй байгаа нь оролцогчдын 33.3% (6) нь хамтран ажилладаггүй гэж хариулсан байгаагаас харагдаж байна. Эдгээр оролцогчид гэмт хэргийг илрүүлэх чиг үүрэггүй учир хамтран ажиллах шаардлагагүй, ер нь хамтран ажиллаж байгаагүй гэсэн тайлбар хийжээ.

ХХГХ–ийг илрүүлэх, шалгахад ТББ–тай хамтран ажилласан гэж оролцогчдын 33.3% (6) хариулжээ. Энэхүү хамтын ажиллагааг мэдээлэл солилцох, уулзалт зохион байгуулах, буцах зардал, торгуулийн мөнгөнд туслуулах, ТББ–ыг

шалгах зэрэг арга хэмжээгээр хэрэгжүүлдэг байна. ХХГХ– бэрхшээл учирдаг гэж судалгаанд оролцогчдын 16.7% (2) ийг илрүүлэх, шалгах ажиллагаа явуулахад хүндрэл, нь хариулсан байна. Дараах хүндрэл, бэрхшээл гарч байна:

Хүснэгт 5.2. ХХГХ–ийг илрүүлэх, шалгах ажиллагаанд тулгардаг хүндрэл бэрхшээл

Хууль эрх зүйн орчны хүрээнд:	Хуульд нэмэлт өөрчлөлт орсон, Гэр бүлийн хүчирхийллийн тухай болон Зөрчлийн тухай хууль Хилийн тухай хуулиар тус байгууллага хяналт, шалгалтын дараалалд байхгүй.
Ажиллах орчин, нөхцөлийн тухай:	Техник хэрэгсэл, сошиал медиаг хянах боломжгүй Ажиллах орчин, техник хэрэгсэл шаардлагад нийцэхгүй Техник хэрэгсэл муу, ур чадвар дутмаг
Мэргэжлийн мэдлэг, ур чадварын тухайд:	Сургалт жилд 1–2 удаа явагддаг Мэдлэг, ур чадвар дутмаг
Дотоодын хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах байгууллагуудын хамтын ажиллагааны тухайд:	Хамтын ажиллагаа боломжийн тодорхой Бодит байдалд хамтын ажиллагаа дундаж
Гадаадын хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах байгууллагуудын хамтын ажиллагааны тухайд:	Цагдаа нарын хамтын ажиллагаа сайн Дарга нар л гадаад арга хэмжээнд явдаг. Холбогдох албан тушаалтныг хэрэгтэй сургалтад явуулдаггүй.

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

ХХГХ–тэй тэмцэх хуулийн зарчмуудын хэрэгжилт болон стандартын хэрэгжилтэд судалгаанд оролцогчдын өгсөн хохирогчийг хамгаалах хүний эрхэд суурилсан хэм хэмжээ, үнэлгээг дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 5.3. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн зарчмуудын хэрэгжилт

д/д	ЗАРЧМУУД	Хангалттай сайн	Хангалттай	Хангалтгүй	Туйлын хангалтгүй	Мэдэхгүй
		(4)	(3)	(2)	(1)	(88)
1	Дотоодын хууль тогтоомжийн хэрэгжилт	1 (5.6%)	6 (33.3%)	8 (44.4%)		3 (16.7%)
2	Олон улсын стандарт, гэрээ, конвенцийн хэрэгжилт	1 (5.6%)	6 (33.3%)	8 (44.4%)		3 (16.7%)
3	Хохирогчийн нэр төрийг хүндэтгэх		5 (27.8%)	5 (27.8%)	5 (27.8%)	3 (16.7%)
4	Хохирогчдыг хүйс, бэлгийн чиг хандлага, иргэншил, үндэс угсаагаар нь ялгаварлан гадуурхахгүй байх	1 (5.6%)	5 (27.8%)	7 (38.9%)	3 (16.7%)	2 (11.1%)
5	Хохирогчийг үл буруутгах	1 (5.6%)	5 (27.8%)	7 (38.9%)	2 (11.1%)	3 (16.7%)
6	Хохирогчийн аюулгүй байдлыг хангах	1 (5.6%)	3 (16.7%)	5 (27.8%)	5 (27.8%)	4 (22.2%)

7	Хувийн нууцыг нь хамгаалах	6 (33.3%)	3 (16.7%)	6 (33.3%)	3 (16.7%)
8	Олон улсын хамтын ажиллагаа, иргэний нийгмийн оролцоонд түшиглэх	5 (27.8%)	8 (44.4%)	2 (11.1%)	3 (16.7%)

ХХГХ-тэй тэмцэх хуулийн зарчмуудын хэрэгжилт болон хохирогчийг хамгаалах хүний эрхэд суурилсан хэм хэмжээ, стандартын хэрэгжилтэд өгсөн үнэлгээний дүнгээс харахад дотоодын хууль тогтоомж, олон улсын гэрээ, конвенц, ялгаварлан гадуурхахгүй байх, хохирогчийг үл буруутгах, хохирогчийн аюулгүй байдлыг хангах гэсэн зарчмуудын хэрэгжилтийг “хангалттай сайн” гэж судалгаанд оролцогчдын дөнгөж 5.6% (1) нь үзсэн байна. Олон улсын стандарт, гэрээ, конвенц, дотоодын хууль тогтоомжийн дээрх хүснэгтэд үзүүлсэн зарчмуудын хэрэгжилтийг “хангалттай” гэж алба хаагчдын дунджаар дөнгөж 28.48% (5.13) нь үнэлжээ. Хүн худалдаалахтай тэмцэх хуулийн хүснэгтэд үзүүлсэн нийт зарчмуудын хэрэгжилтийг “хангалтгүй” гэж алба хаагчдын дунджаар 35.41% (6.37) үнэлсэн байгаа нь анхаарал татахуйц мэдээлэл болж байна. Судалгаанд оролцогчид хохирогчийг үл буруутгах, иргэний нийгмийн оролцоонд түшиглэх, ялгаварлан гадуурхахгүй байх, хохирогчийн нэр


төрийг хүндэтгэх, хохирогчийн аюулгүй байдлыг хангах гэсэн зарчмуудын хэрэгжилт “туйлын хангалтгүй” байна гэж үзсэн байна. Ялангуяа “хувийн нууцыг нь хамгаалах” зарчмын хэрэгжилт “туйлын хангалтгүй” гэж оролцогчдын 33.3% (6) үзсэн байгаа нь хамгийн өндөр түвшин байна. ХХГХ-тэй тэмцэх хуулийн зарчмууд хэр хэрэгжиж байгааг судалгаанд оролцсон алба хаагчдын дунджаар 16.67% нь (3) “мэдэхгүй” гэж хариулжээ.

ХХГХ-ТЭЙ ТЭМЦЭХ ЧИГЛЭЛЭЭР ЯВУУЛЖ БУЙ СУРГАЛТЫН ЧАНАР, ҮР ДҮН

Төрийн байгууллагаас зохион байгуулсан сургалт

ГИХГ-ын газраас судалгаанд оролцсон алба хаагчдын 55.6% (10) нь ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр төрийн зүгээс явуулж буй мэргэшүүлэх ямар ч сургалтад хамрагдаж байгаагүй гэжээ.

Зураг 5.4. Төрөөс явуулж буй сургалтын чанар, үр дүн сайн байсан эсэх




Сургалтад оролцсон хүмүүсийн 62.5% (5) нь сургалтын чанарыг “сайн” гэж үнэлсэн байна. Сургалтын чанарыг сайн гэж үзэхгүй байгаа 3 (37.5%) алба хаагчид дараах шалтгааны улмаас сургалт үр дүнд хүрэхгүй байна гэж үзсэн байна. Үүнд:

1. Сургалтад оролцсон алба хаагчид тогтвор суурьшилтай ажилладаггүй.
2. Сургалт цөөн зохион байгуулагдаж, хэдхэн тооны алба хаагч л оролцдог.
3. Сургалтын дараа хэрэгжүүлэх арга хэмжээ байдаггүй учир үр дүн муутай.

Судалгаанд оролцогчдын дээрх саналыг цаашид зохион байгуулах сургалтын төлөвлөлтөд тусгах хэрэгтэй байна. Сургалтын чанар, үр дүнг хянах шалгуур үзүүлэлтийг

тодорхойлж, явцын үнэлгээ хийснээр төслийн хэрэгжилтийг сайжруулахад зохих хувь нэмэр оруулна. Сургалтад оролцогчид сургалтын үргэлжлэх хугацаа хангалтгүй тухайлбал, ХХГХ-ийн холбогдолтой бүх хууль, тогтоомжийг 2 өдөрт багтаан заах боломжгүй байсан гэжээ. Сургалтын агуулгын тухайд бусад улсын туршлага 11.1% (2), дотоодын хууль эрх зүй 5.6% (1) хэрэгцээтэй байсан гэж оролцогчдын маш бага хувь нь хариулсан боловч яагаад хэрэгцээгүй гэж үзэж байгаагаа хэн ч тайлбарлаагүй болно. Мөн сургалтын давуу болон сул талын тухайд ч санал бодлоо илэрхийлсэнгүй. Сургалтыг ямар хэлбэрээр зохион байгуулбал илүү үр дүнтэй болно гэж үзэж байгаа талаар нь судалгаанд оролцогчдоос авсан санал асуулгын дүнг дараах зургаар үзүүлээ.

Зураг 5.5. Сургалтыг ямар аргачлалаар хүргэвэл илүү үр дүнтэй вэ?



*Олон сонголттой хариулт тул дүн 100%-д барихгүй.


Судалгаанд оролцсон алба хаагчид “бодит кейсүүд дээр ажиллах” хэлбэрийн сургалтад илүү ач холбогдол өгч байгааг сургалтыг үр дүнтэй болгох асуудалд оролцогчдын өгсөн 77.8%-н (14) санал харуулж байна. Мөн “багаар ажиллах” хэлбэрийг оролцогчдын 55.6% (10) нь дэмжиж байгаагаа илэрхийлсэн байна. Сургалтын интерактив арга 27.8%-ийн (5) санал авчээ. Судалгаанд оролцсон алба хаагчид “**гадагшаа танилцах аялал хийх**”, “**бусад орны туршлагаас суралцах**” саналаа “**бусад**” гэсэн хэлбэрт илэрхийлсэн байна. Багш лекц унших уламжлалт аргыг төдийлөн дэмжээгүй байгаа нь сургалтыг суралцагчдад дадлага олгох, бодит туршлагаас суралцах хэлбэрээр зохион байгуулах, хамтран ажиллах, сайн харилцаа бий болгох нөхцөлийг бүрдүүлэхэд чиглүүлэх хэрэгтэй байгааг харууллаа.

Төрийн бус болон олон улсын байгууллагаас явуулсан сургалт

ГИХГ-аас судалгаанд оролцсон алба хаагчдын 55.6% (10) нь

ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр төрийн бус болон ОУБ-аас зохион байгуулсан сургалтад хамрагдаж, 44.4% (8) нь энэ төрлийн сургалтад хамрагдаагүй байна. Сургалтад хамрагдсан алба хаагчдын 90% (9) нь сургалтыг чанартай болсон гэж үзэж байна. Сургалтууд хагас өдрөөс 7 хоногийн хугацаатай зохион байгуулагдаж байсан ба ихэвчлэн 1–2 өдөрт явагддаг ажээ. Сургалтын үргэлжлэх хугацааг оролцогчид хангалттай гэж үзсэн байна. Сургалтад оролцогчдын 70% (7) нь сургалтын агуулга тодорхой, хэрэгцээтэй байсан гээд сонирхолтой сэдвээр ярьж, үр өгөөжтэй байсан, хуулийн хэрэгжих арга зам зэрэг хэрэгтэй сэдэв байсан гэжээ. Мөн агуулга нь тодорхой ч хэрэгцээнд суурилагүй гэсэн санал ч гарсан байна. Суралцагчид идэвхгүй байсан нь сургалтын агуулгатай холбоотой гэж үзжээ. Зарим сургалт хэлбэр төдий хэрэгцээнд суурилагүй, олон цагийн онолын лекц нь үлдэц багатай байсан гэж сургалтад оролцогчдын 20% (2) үзсэн байна.

Зураг 5.6. ХХГХ-ийн талаарх ном, гарын авлага, нэг сэдэвт бүтээлийн чанар, хүртээмж



ХХГХ-ийн талаарх ном, гарын авлага, нэг сэдэвт бүтээлийн чанар, хүртээмжийг судалгаанд оролцогчдын 50% (9) нь ойлгомжтой гэж үзжээ. Оролцогчдын 38.8% (7) нь “мэдэхгүй” гэж хариулсан байгаа нь мэдээлэл хүртээмжтэй биш байжээ гэж үзэхээр байна. ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр ГИХГ-ын алба хаагчдад зориулсан тусгайлан сургалт

явуулсан гэж судалгаанд оролцогчдын дөнгөж 22.2% (4) хариулсан байгаа нь “ХХГХ-ийн хохирогч төвтэй мөрдөн шалгах ажиллагаа, прокурорын хяналтыг сайжруулах нь” төслийн үйл ажиллагааны хүрээнд зохих анхаарал хандуулах хэрэгтэй байна.

Зураг 5.7. ХХГХ-тэй тэмцэх чиглэлийн ямар сургалтанд хамрагдахыг хүсч буй байдал



Зураг 5.7-д ХХГХ-тэй тэмцэх чиглэлийн аль сэдвийг ГИХГ-ын алба хаагчид хамгийн чухал гэж үзэж байгаа талаарх мэдээллийг үзүүлээ.

Судалгаанд оролцогчдын олонх буюу 83.3% (15) нь ХХГХ-ийн талаарх ерөнхий ойлголт өгөх сургалт мэдээлэл авахыг хүсэж байна. Хохирогчийг хамгаалах стандартын талаар сайтар ойлголттой болох нь нэн чухал байна гэж оролцогчдын 61.1% (11) үзэж байгаа нь ХХГХ-ийн холбогдолтой мэдлэг, мэдээлэл чухал байгааг бодитой харуулж байна.

Судалгаанд оролцсон алба хаагчид ХХГХ-тэй тэмцэх байгууллагуудын хамтын ажиллагаа, ХХГХ-ийн хохирогч, гэрчийг хамгаалах болон ХХГХ-тэй тэмцэх үйл ажиллагааг хамгийн чухал асуудлууд гэж 100%-н (18) саналаар илэрхийлсэн байна. Нэн ялангуяа ХХГХ-ийн хохирогч, гэрчийг хамгаалах, харилцах асуудал “нэн чухал” гэж

судалгаанд оролцогчдын 66.7% (12) нь үзсэн байна. ГИХГ-т ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр мэргэшсэн албан тушаалтан бэлтгэх шаардлагатай гэж судалгаанд оролцогчдын 88.9% (16) үзсэн байна. Судалгаанд оролцогчдын 83.3% (15) нь ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр зохион байгуулалтын дараах арга хэмжээ авах ёстой гэж үзэж байгаагаа илэрхийлжээ. Үүнд:

1. Сургалт зохион байгуулж, холбогдох бүх алба хаагчдыг хамруулах,
2. Мэргэшсэн алба хаагчид бий болгох, тогтвор суурьшилтай ажиллуулах,
3. Олон улсын туршлага судлах боломж олгох,
4. Урьдчилан сэргийлэх ажиллагааг тогтмол явуулах.

5.6 ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧДООС АВСАН САНАЛ АСУУЛГЫН ДҮН


ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ БАЙДАЛ

Судалгаанд 18–35 насны ХХГХ–ийн хохирогч болсон 20 эмэгтэйг оролцуулан саналыг авлаа. Оролцогчдыг Хүйсийн тэгш эрхийн төвийн (ХТЭТ) үйлчлүүлэгчдээс санамсаргүй түүвэрлэлтээр сонгосон ба тэд 1–10 жилийн өмнө эх орон дотроо болон хилийн чанад дахь 5 улсад худалдаалагдаж, ХХГХ–ийн хохирогч болж байсан байна. Судалгаа авахад “мартахыг хүсдэг муу дурсамж”–ийг сэдрээх нь бэрхшээлтэй байсан ч тэдэнд туслалцаа үзүүлж ажиллаж

байсан, ажиллаж байгаа мэргэжлийн нийгмийн ажилтнууд мэдээллийг цуглуулсан.

Судалгаагаар зөвхөн хуулийн байгууллагад хандаж байсан эсэх, асуудал нь хэрхэн шийдвэрлэгдсэн, хэргийг шийдвэрлүүлэх явцад юу хамгийн бэрхшээлтэй байсныг тодруулахыг зорьсон. Эдгээр эмэгтэйчүүдийн 20% (4) нь насанд хүрээгүй байхдаа энэ гэмт хэргийн хохирогч болж байсан бол 45% (9) нь эх орон дотроо, 55% (11) нь хилийн чанад ХХГХ–ийн хохирогч болж байжээ.

Зураг 6.1. Судалгаанд оролцогчдын нас



Зураг 6.2. ХХГХ–ийн хэв шинжүүдтэй тулгарч байсан эсэх



Зураг 2–оос харахад ХХГХ–ийн хохирогчид эх орон дотроо болон хилийн чанадад хохирогч болсноос үл хамааран ХХГХ–ийн үндсэн хэв шинжүүдтэй тулгардаг. Тэдний 80%–д (16) цалин хөлс өгөлгүй ажиллуулж, 70%–д (14) нь ар гэр, ойр дотнын хүнтэй нь холбоо бариулдаггүй, 85% (17) нь бэлгийн хүчирхийлэлд өртдөг байна. Харин эх орон дотроо худалдаалагдаж байгаа хохирогчийн бичиг баримтыг хурааж авах хэрэгцээ байдаггүй бол хилийн чанадад худалдаалагдсан хохирогчдын бичиг баримтыг хурааж авч, тухайн газраас явах, холдох тал дээр хяналт багатай байсан


байна. Бичиг баримтгүй хүмүүс хол явж чадахгүй, бичиг баримтаа авахын тулд, эсвэл ямар нэг хэлбэрээр эрхшээл хяналтад нь бүрэн орсон байдгаас байнгын хяналт тавих шаардлагагүй болдог гэж хариулсан ч бодит байдал дээр хяналт нь далд болдог байх магадлалтай.

Хохирогчдоос зөвхөн 2 хүнд л биеийг нь үнэлүүлэх тухай хэлж байсан бол үлдсэн 90% (18) нь тухайн газарт очоод, бичиг баримтыг хурааж, цоожилж түгжин хүчээр биеийг нь үнэлүүлж эхлэхэд мэдсэн байна.

“Бид нарыг эхэндээ гарч, орох бүрд хүн дагадаг, эзнээс асуухгүйгээр хаашаа ч явж болдоггүй, жижиг мухлаг орсон ч хүн дагадаг байсан. Сүүлдээ бид нарыг зугтаагаад хаашаа ч явж чадахгүйг ойлгоод хэтэрхий их хянахаа больж эхэлсэн. Зөвхөн хаашаа явж байгаагаа хэл, утсаа байнга асаалттай байлга гэж шаарддаг. Гараад удаагүй л хойноос залгаад дуудаад эхэлдэг. Ер нь хүний эрхэнд байгаа хүмүүс чинь өөрийнхөөрөө байна гэж хэзээ ч байхгүй шүү дээ.”

Хохирогч (26 настай, эмэгтэй)

Зураг 6.3. Аль улсад худалдаалагдсан бэ?



ХТЭТ–ийн судалгааны сангаас харахад нийт үйлчлүүлэгчдийн 32% нь эх орон дотроо худалдаалагдсан байгаагийн 53% нь насанд хүрээгүй бэлгийн мөлжлөгт өртсөн хохирогчид байдаг⁶⁰. Судалгаанд оролцогчдын мэдээллээс харахад 3 хүн тутмын 1 нь БНХАУ–д, ойролцоогоор 2 хүн тутмын 1 нь эх орон дотроо худалдаалагдсан байгаа нь эрсдэл өндөр байгааг харуулж байна.

ХХГХ–т өртөхөд нөлөөлж буй олон төрлийн шалтгааныг дурдаж байснаас дийлэнх нь гэр бүлийн таагүй орчин, гэр бүлийн хүчирхийлэл хамгийн ихээр 85% (17) нь нөлөөлж байна гэж үзсэн. Мөн ажилгүйдэл, архидалт, эдийн засгийн хүндрэлүүд болон найз нөхөд, орчны нөлөө, хувь хүний төлөвшил тодорхой хэмжээний нөлөөллийг үзүүлж байгааг дурдсан.

⁶⁰ ХТЭТ–ийн судалгааны сан, 2003–2017.08 сар

Хүснэгт 6.1. Хүн худалдаалах гэмт хэрэгт өртөхөд нөлөөлж буй хүчин зүйл

№	Шалтгаан, нөхцөл	Тоо	Хувь
1	Гэр бүлийн таагүй орчин (эцэг эхийн таарамжгүй байдал, хойд эцэг эх, гэр бүл салалт, гэр оронгүй)	14	70.0%
2	Ажилгүйдэл	9	45.0%
3	Нийгэмд үүсээд байгаа архидалт	6	30.0%
4	Эдийн засгийн хүндрэл	8	40.0%
5	Зар сурталчилгаа	3	15.0%
6	Гэр бүлийн хүчирхийлэл	3	15.0%
7	Найз нөхөд, орчны нөлөө	6	30.0%
8	Хувь хүний төлөвшил (бусдад хэт итгэх, хялбар аргаар мөнгө олох, зорилгогүй гадуур сэлгүүцэх г.м)	5	25.0%

Зураг 6.4. ХХГХ–ийн хохирогчийн нөхцөл байдлаасаа зугтаж, аврагдсан байдал



Хохирогчид хэрхэн яаж ХХГХ–ийн нөхцөл байдлаасаа зугтаж, аврагдаж чадсан гэсэн асуултад нийтлэг хариулт байхгүй нь анхаарал татаж байлаа. Тухайн хүн аврагдахад хохирогчийн хүчин чармайлтаас гадна, орчны болон тухайн үеийн нөхцөл байдлууд ихээхэн нөлөөлдгийг 20 хохирогч 14 өөр өөр аргаар аврагдаж, зугтсанаас харж болно. Тэд хамгийн боломжтой, эрсдэл багатай хувилбарыг байнга хайж, хүлээж байдаг нь энэхүү мэдээллээс харагдаж байна. Доорх хүснэгтэд дурдсан “багана тойрох”⁶¹ гэдэг ойлголтыг энэ нүүрийн хамгийн доор тайлбарлав.

Хохирогчдын 80% (16) нь хуулийн аль нэг шатны

⁶¹ Багана тойрохдоо зугтана гэдэг нь: БНХАУ–д Монгол улсын иргэд 30 хоног визгүй зорчих боломжтой бөгөөд энэ хугацаа дуусахаас өмнө Монгол улсын хилээр нэвтрүүлж, хил нэвтэрсэн тамга даруулдаг. Хохирогчдын ганцаар нь явуулдаггүй, ихэвчлэн хүн дагуулж явдаг, эсвэл ард нь үлдэж байгаа хэн нэгнийг барьцаалж үлддэг тул зугтах боломж маш багатай, бусдаас туслалцаа хүсэх боломжгүйгээр хянадаг.


байгууллагад гэмт хэргийг таслан зогсоож, хохирлоо төлүүлэхээр гомдол гаргаж ханджээ. Хуулийн байгууллагад хандсан хохирогчдын 75% (15) нь ТББ, найз нөхөд, гэр бүлийн тусламжийг авч, харин 25% (5) нь бусдын туслалцаагүй өөрөө хандсан байна. Эдгээр гомдлын 75%–д (15) шүүхээс гэм буруутай этгээдүүдэд ял оногдуулсан бол нэг хэрэг дээр цагдаагийн байгууллага эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж, нэг тохиолдлыг гэмт хэрэг биш гэж үзэж прокуророос хэрэгсэхгүй болгосон, нэг хэрэг гэмт хэрэг үйлдсэн этгээд нь гадаад улсад байгаагаас түдгэлзүүлсэн байна. Үүнээс харахад хохирогчид хуулийн байгууллагад хандахад хэрэг нь ямар нэг хэмжээнд эцэслэн шийдвэрлэгдэх боломжтой гэж үзэж болохоор байна.

Харин хуулийн байгууллагад хандаагүй 4 хохирогчийн хувьд цаад талтайгаа тохиролцоод эмчилгээний зардалд бага

хэмжээний мөнгө авсан, гэмт хэрэгтнүүд нь монголд байхгүй болохоор гомдол гаргаж чадаагүй, хуулийн байгууллагаар яваад асуудал нааштайгаар шийдвэрлэгдэж чадна гэдэгт итгээгүй зэргээс шалтгаалсан гэжээ. Хуулийн байгууллагад хандсан хохирогчдоос тэдэнтэй харьцаж байсан харьцаа, хандлагын талаар лавлахад цагдаагийн байгууллагын албан

хаагчдын 60% (12), прокуроруудын 65% (13), шүүгчдийн 65% (13) нь эерэг хандлагатай харьцаж байсан гэж хариулсан ч яг ямар харьцаа хандлага нь эерэг санагдсан тал дээр сонголтууд нь маш цөөн байлаа.

Зураг 6.5. Хуулийн байгууллагад хандаж гомдол гаргасан байдал



Эерэг хандлагад хугацаа алдалгүй мэдээлэл сайн авдаг байсан, ТББ-аас өмгөөлөгчтэй байсан тул хүндрэл байгаагүй, мэдээллийн дагуу хэрэгтнүүдийг хурдан баривчилсан, хуулийн зөвлөгөө өгч байсан гэсэн бол шүүхийн байгууллагад эерэг хандлагатай байгаа үндэслэл

нь гэмт хэрэгтэнд үнэн зөв ял шийтгэл оногдуулсан гэж талаас илүү хувь нь үзсэн. Хохирогчид тэдэнтэй харьцаж буй харьцаа хандлагаас илүүтэй гарсан шийдвэр, үр дүнг илүү үнэлж ярьж байлаа.

Хүснэгт 6.2. Хохирогч хуулийн байгууллагад гомдол гаргахад тухайн байгууллагын ажилтнуудын харьцаа, хандлага хэр байсан талаар


	Эерэг	Сөрөг
Цагдаагийн байгууллага	<ul style="list-style-type: none"> Хугацаа алдалгүй мэдээлэл сайн авдаг байсан ТББ-аас өмгөөлөгчтэй байсан тул хүндрэлгүй Хэрэгтнүүдийг хурдан баривчилсан 	<ul style="list-style-type: none"> Олон хүн хэргийг дамжуулж шалгасан Удсан, хэргийг удаашруулсан Шинээр авсан байцаагч нь хэргээ ойлгохгүй цаг их алдсан Яг хэрэг дээрээ ажиллахгүй, цааргалж хойшлуулж байсан Байцаалтыг гаднын хүний дэргэд авдаг
Прокурорын байгууллага	<ul style="list-style-type: none"> Мэдээлэл сайн өгч байсан Хуулийн зөвлөгөө өгч байсан 	<ul style="list-style-type: none"> Хүнд сурталтай Хэргийг хэт их сунжруулсан Чи өөрөө зөвшөөрөөд биеэ үнэлж байна гэсэн
Шүүх байгууллага	<ul style="list-style-type: none"> Гэмт хэрэгтэнд үнэн зөв ял шийтгэл оногдуулсан Хуулийн зөвлөгөө өгч байсан 	<ul style="list-style-type: none"> Харьцаа маш муу, үл тоомсорлодог Чамд зугтах боломж байсан, чи өөрөө зөвшөөрөөд ажилласан уу гэсэн нь муухай байсан Илэрхий байгаа хэргийг удаан шийдсэн Шүүх хурлыг удаа дараа хойшлуулсан Зарим шүүгдэгчийн зүйл ангийг хэрэгсэхгүй болгосон, төлбөрийн чадваргүй гээд хохирлыг авч хэлэлцээгүй

Сөрөг сэтгэгдэлтэй оролцогчид нэгээс дээш сөрөг сэтгэгдэл үлдээсэн байсан бөгөөд хэргийг удаадаг, олон дахин явуулдаг, хохирогчийг өөрийг нь буруутгадаг хандлага нь тэдэнд сөрөг сэтгэгдэл төрүүлдгийг илэрхийлсэн. Ялангуяа гаднын хүний хажууд байцаалт авах нь тэд хэргийн талаар

үнэн зөв мэдүүлэх эсэхдээ эргэлзэхэд хүргэж байсан тухайгаа дурссан.

Хуулийн байгууллагаас хохирогчийн эрсдэлийн түвшнийг тогтоосон эсэхийг лавлахад 10% буюу 2 хүн л тогтоолгосон байсан нь хангалтгүй үзүүлэлт юм.

Зураг 6.6. Хуулийн байгууллагаас хохирогчийн аюулгүй эрсдлийн түвшинг тогтоосон эсэх



Хэн эрсдэлийн түвшнийг тогтоосон талаар асуухад нэг удаа нийгмийн ажилтан, нөгөө тохиолдолд мөрдөн байцаагч байсан гэж хариулсан. Цагдаагийн байгууллагад аюулгүй байдлаа хамгаалуулахаар нэг хүн хүсэлт гаргаж ТББ-ын хамгаалах байранд байрлах туслалцаа авч байсан байна.

Харин эдгээр хохирогчдын 90% (18) нь ТББ-аас 4-өөс дээш төрлийн туслалцаа дэмжлэг авч байсан байна. Туслалцаа авсан хохирогч бүрд сэтгэлзүй, эрүүл мэнд, хууль эрхзүй болон хамгаалах байрны хэрэгцээ өндөр байдгийг доорх зургаас харж болно.


Зураг 6.7. ТББ-аас хохирогчийн аюулгүй байдлыг хангахаар авсан арга хэмжээ



ХХГХ–ийн хохирогчид нэг доор олон төрлийн гэмт хэргийн хохирогч болдгоороо онцлогтой бөгөөд тэдэнд учирсан хохирлын дийлэнх нь удаан хугацааны сөрөг үр дагавартай, нөхөн төлөгдөх боломж багатай, боломжгүй байдгаараа хор уршиг ихтэй юм. Судалгаанд хамрагдсан хохирогчдод ямар төрлийн хохирол хамгийн ихээр учирсныг тодруулахад бүх хохирогчид доор дурдсан олон төрлийн хохирол давхар давхар учирдаг тухайгаа өгүүлсэн. Тухайлбал, эрүүл мэнд, сэтгэлзүй, санхүү, сэтгэл санааны хохирлуудаас гадна

хувийн амьдрах орчинд өөрчлөлт орж гэр бүлийнхнийх нь харьцаа хандлага өөрчлөгдөн, хохирогчийг буруутгах нь ихэсдэг. Мөн хэзээ нэгэн цагт юу хийж явсныг нь хүмүүс мэдчих вий гэдгээс байнгын айдас түгшүүртэй, хар тамхи хүчээр хэрэглүүлснээс эрүүл мэндэд сөргөөр нөлөөлсөн зэрэг хохирлууд учирсан байна. Нэг хохирогч аав ээжийгээ бие нь муу байхад нь уулзаж, оршуулгад нь ч оролцож чадаагүйгээс ах дүү нар нь буруутгаж холбоо харилцаагаа тасалсан гэжээ.

Зураг 6.8. ХХГХ–ийн хохирогчид учирсан хамгийн их хохирол



ХХГХ–ийн хор хохирлыг хэмжих боломжгүй ч тэдний амьдралд шууд болон шууд бусаар учруулж буй хор уршиг нь удаан хугацаанд үргэлжилж, насан туршийн сэтгэлийн зовлон шаналлыг дагуулж байгааг дээрх тоо мэдээнээс харж болохоор байна. Эдгээр хор хохирлыг бүрэн төлж, барагдуулж чадахгүй ч тухайн үед учирсан хохирлыг нөхөн төлүүлэх нь тэдний сэтгэлзүйд эергээр нөлөөлдөг. Хохирогчдын 60% (12) нь шүүхэд хохирлоо төлүүлэх нэхэмжлэх гаргасан ч тэдний 50%–д (10) нь нэхэмжлэлийн

тодорхой хувийг гаргуулж нөхөн төлүүлсэн бол 30%–д (6) нь нэхэмжлэхийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар гаргуулахаар шийдвэрлэж, 25%–д (5) нь нэхэмжлэхийг үндэслэлгүй, нотлох баримт дутуу хэмээн хэрэгсэхгүй болгосон байна. 2 (10%) тохиолдолд нэхэмжлэлийн тодорхой хувийг нөхөн төлүүлэх шийдвэр гаргасан ч гэмт хэрэг үйлдсэн этгээд нь төлбөрийн чадваргүйн улмаас нөхөн төлөгдөөгүй байна.

Зураг 6.9. Хохирогчдын зүгээс хууль, төрийн байгууллагад өгөх санал, хүсэлт



Цаашид ХХГХ-ийн хохирогч, гэрчийг хамгаалах, гаргасан гомдол нэхэмжлэлийг хангах талаар хуулийн болон төрийн байгууллагууд яаж ажиллавал илүү үр дүнтэй байх талаар хувь хүний үзэл бодлыг тодруулахад 80% (16) нь нэгээс дээш санал, хүсэлтээ илэрхийлсэн. Үүнд:

- хуулийн байгууллагаар хэт удаан явдаг асуудлыг багасгах,
- асуудлыг шуурхай шийдэж өгч байх,
- гэмт хэргийн хохирлыг цаг алдалгүй түргэн барагдуулах,

- гэмт хэрэгтнүүдийн олсон орлогыг хураан авч хохирогчдод өгөх,
- Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайдын яам, консул, өргөмжит консулуудын үйл ажиллагааг сайжруулж, байнгын хяналт тавьж байх,
- энэ чиглэлээр ажилладаг ТББ-ын ажилтнуудын аюулгүй байдлыг хангаж ажиллах гэх мэт олон үнэтэй саналуудыг өглөө.

ДҮГНЭЛТ

АС, ХЗДХЯ, ХСИС–тай хамтран “ХХГХ–ийн хохирогч төвтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа: Албан хаагчдыг чадавхжуулах нь” төслийн сургалтуудад ашиглагдах ХХГХ–ийн хохирогч төвтэй сургалтын материал боловсруулахад мэдээлэл цуглуулах зорилгоор хууль сахиулах байгууллагын алба хаагчид, прокурор, шүүгч, хил хамгаалах болон ГИХГ–ын алба хаагчдын хохирогч төвтэй аргачлалыг хэрэглэх чадавхыг үнэлэх судалгааг амжилттай гүйцэтгэж дууслаа.

Энэхүү судалгааны зорилго нь хууль хяналтын байгууллага, шүүх эрх мэдлийн байгууллагын алба хаагчдаас ХХГХ–ийн талаарх ойлголт мэдлэг, хандлагыг тодорхойлох, энэ төрлийн гэмт хэрэгтэй холбоотой эрүүгийн хэргийн хянан шийдвэрлэх ажиллагаа, хохирогч, гэрчийг хамгаалахад ажиллаж буй өнөөгийн нөхцөл байдал, түүнчлэн ХХГХ–ийн асуудлаар алба хаагчдыг мэргэшүүлэх сургах сургалтын чанар, үр дүнг үнэлэх, төрийн байгууллагуудын хамтын ажиллагаанд гарч буй хүндрэл, бэрхшээлийг тодруулах, сургалтын аргачлалыг сайжруулахад цаашид анхаарах зөвлөмжийг боловсруулан гаргахад чиглэсэн.

Судалгаанд шүүгч, прокурор, цагдаа, хил хамгаалах, ГИХГ–ын алба хаагчдаас санамсаргүй түүврийн аргаар нийт 381 хүнийг хамруулсны 107 нь орон нутгаас оролцлоо.

1. ХХГХ–ийн ойлголт, мэдлэгийн хүрээнд:

Судалгаанд оролцсон хууль сахиулах байгууллага, шүүх эрх мэдлийн байгууллагын албан хаагчдын ХХГХ–ийн талаарх ойлголт, мэдлэг харилцан адилгүй түвшинд байлаа. Нийт судалгаанд оролцогчдын 70% (253) нь ХХГХ–ийг бэлгийн мөлжлөг, биеийг нь хүчээр үнэлүүлэх гэдгээр хязгаарлан ойлгож, маш цөөн хувь нь бусад төрөл, хэлбэрүүдийн талаар мэдээлэлтэй байна. ХХГХ–ийн төрлүүдийн талаарх ойлголтыг Палермогийн конвенц, орчин үеийн боолчлолын тодорхойлолтуудтай харьцуулан нэгдмэл ойлголтыг бий болгох хэрэгцээ, шаардлага бий болсон байгаа нь харагдаж байна. Тиймээс ч өнөөдрийг хүртэл бэлгийн мөлжлөг, биеийг нь хүчээр үнэлүүлэхээс өөр төрлийн хүн худалдаалах эрүүгийн гэмт хэргийг шүүхээр шийдвэрлээгүй байна.

Энэ төрлийн гэмт хэргийг гаргахад нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар нийт судалгаанд хариулагчид *нийгэм болон хувь хүний хүчин зүйлүүд адил нөлөөлж байна* гэж үзсэн. Тухайлбал нийгмийн хүчин зүйлээс эдийн засаг, ядуурал, нийгмийн тогтворгүй байдал, цахим орчин, хэвлэл мэдээллээр замбараагүй мэдээлэл тараах, тусгай чиг үүргийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо сул, чиг үүрэг нь тодорхойгүй зэрэг дурдагджээ. Харин хувийн хүчин зүйлээс ар гэрийн хараа хяналт сул, иргэдийн эрх зүйн

мэдлэг, мэдээлэл дутмаг, хувь хүний зан заншил, төлөвшил зэрэг байдал нь их нөлөөлж байгааг илэрхийлсэн. Харин ХХГХ–ийн хохирогчдын 85% (17) нь гэр бүлийн таагүй орчин, гэр бүл салалт, хойд эцэг, эх, гэр бүлийн хүчирхийлэл, хүчин болон бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан зэрэг нь нөлөөлөх хүчин зүйлст тусгагдсан байгаа нь анхаарал татаж байлаа.

2. Хохирогч хамгаалал, хуулийн хэрэгжилтийн хүрээнд:

Энэ судалгааны гол зорилго нь хохирогч төвтэй үйл ажиллагааг сайжруулахад чиглэгдэж байгаа учраас судалгаанд оролцогчдоос тухайн салбар бүрд одоо мөрдөгдөж буй ХХГХ–ийн хохирогчтой ажилладаг тусгай арга, техник, журам байдаг эсэхийг тодруулахад дийлэнх оролцогчид байхгүй, мэдэхгүй гэж хариулсан. Хариултуудад дүгнэлт хийж үзвэл холбогдох хуулийн хүрээнд ажилладаг гэж хариулсан нь онцгой, зохион байгуулалттай гэмт хэргийн хохирогчидтой ажиллах нэгдсэн зохицуулалт дутмаг байна гэж дүгнэж болохоор байна. Харин үйл ажиллагаанд хохирогчтой ажиллахдаа хэрэглэдэг стандарт, журмыг дурдахдаа “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам”, “ЭХХШТХ”, “насанд хүрээгүй хохирогчоос тусгайлан мэдүүлэг авах журам”, “хууль, прокурорын аргачилсан заавар”, байдаг гэж хариулсан нь ХХГХ–ийн хохирогчтой ажиллах тусгайлан техник, журам, стандарт гэж үзэж болохооргүй байна.

2012 онд Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль батлагдан гарсан. Уг хууль батлагдаад даруй зургаа дахь жилийн нүүрийг үзэж байгаа бөгөөд хуулийн хэрэгжилтийг Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн найман зарчмын хүрээнд үнэлэхэд дотоодын хууль тогтоомжийн хэрэгжилт хангалттай, хангалттай сайн гэж нийт оролцогчдын 32.6% (118) нь, олон улсын стандарт, гэрээ конвенцийн хэрэгжилт 32% (116) хангалттай, сайн хэрэгждэг гэж үнэлсэн. Харин хохирогчийн нэр төрийг хүндэтгэх асуудал хангалтгүй гэж 72% (260), хохирогчийг үл буруутгах, хохирогчийн аюулгүй байдлыг хангах, хувийн нууцыг хамгаалах асуудал хангалттай бус гэж 62.6% (226) нь хариулснаас харахад хуулийн хэрэгжилт хангалтгүй байна гэж үзэж болохоор байна.

Хохирогчийн аюулгүй байдал, хувийн нууц, эрх ашиг, нэр төрийг хамгаалахаар Цагдаагийн газар, хэлтсүүдэд “Хохирогчоос мэдүүлэг авах тусгай өрөө”-г 2003 оноос эхлэн байгуулан ажиллаж эхэлсэн. Судалгаанд хамрагдсан цагдаагийн газар, хэлтсүүдийн тал хувьд хохирогчоос

мэдүүлэг авах тусгай өрөө байгаа гэсэн боловч 47.5% (95) нь л тогтмол ашигладаг гэж хариулсан нь өрөөний ашиглалт хангалтгүй байгааг харуулж байна. ХХГХ-ийн хохирогч, гэрчийн мэдээллийн аюулгүй байдлыг хангахад мэдүүлэг авах тусгай өрөө нь чухал ач холбогдолтой учраас энэхүү өрөөний ашиглалтыг сайжруулах шаардлагатай байна.


Мөн судалгаанд оролцогчдын бусад төлөөлөл болох шүүх, прокурор, хил хамгаалах, ГИХГ-ын алба хаагч нарт хохирогч хамгаалал, түүний эрх зүйн орчныг таниулах, сурталчлах, нэгдсэн ойлголт өгөх сургалтыг зохион байгуулах хэрэгцээ шаардлага бий байгааг харуулж байна. Түүнчлэн хохирогч төвтэй мөрдөн байцаалт, прокурорын хяналтыг сайжруулах

чиглэлээр бусад орны сайн туршлагаас суралцах, улмаар Монгол Улсад сайн туршлагыг нутагшуулах ажлыг хэрэгжүүлж эхлэх нь зүйтэй юм.

3. Төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагын зүгээс зохион байгуулж буй сургалтын чанар, үр дүн

2003 оноос эхлэн ХХГХ-тэй тэмцэх, улмаар мэргэжлийн бүлгүүдийг мэргэшүүлэх сургах үйл ажиллагаа төрийн бус болон олон улсын байгууллагууд хамтран зохион байгуулж ирсэн байдаг. Судалгааны нэг зорилт нь төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагуудын хүн худалдаалахтай тэмцэх чиглэлийн сургалтын чанар, үр дүнг үнэлэх байсан.

Сургалтанд огт хамрагдаагүй, хувиар



Энэ хүрээнд хууль сахиулах, шүүгч, прокурор, хил хамгаалах, ГИХГ-ын алба хаагчдыг хэрхэн бүрэн хамруулах, зөв оновчтой арга зүй, аргачлалаар сургалтыг зохион байгуулах, тэдний хэрэгцээ шаардлагыг үндэслэн цаашдын сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулахад оролцогчдын санал чухал байдаг ба төслийн эхэн үед хэрэгцээнд суурилсан үндсэн суурь судалгааг авч байгаа нь маш чухал арга хэмжээ гэж үзэж байна. Энэ ч үүднээс төслийг амжилттай, үр дүнтэй хэрэгжүүлэхэд чухал үр нөлөөтэй юм.

Судалгаанд оролцогчдоос ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр төрийн байгууллагаас явуулж буй сургалтын чанар, үр дүнг судлахад судалгаанд хамрагдсан 5 байгууллагын алба хаагчдын 66.3% (239) нь энэ төрлийн сургалтад огт хамрагдаагүй байлаа. Харин энэ чиглэлээр төрийн бус болон ОУБ-аас явуулсан сургалтад 69% (249) нь огт хамрагдаагүй гэсэн үр дүн гарсан. Эндээс дүгнэхэд хууль сахиулах, шүүгч, прокурор, хил хамгаалах, ГИХГ-ын алба хаагчдад ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр нэгдсэн ойлголт өгөх, мэргэшүүлэн сургах, бүх алба хаагчдыг бүрэн хамруулах замаар шаталсан сургалтуудыг зохион байгуулах хэрэгцээ шаардлага бий байгаа нь харагдаж байна.

Цагдаагийн байгууллагаас судалгаанд оролцогчдын 80% (160) нь шинээр боловсруулах гарын авлагад ХХГХ-ийг нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх ажиллагаа, энэ гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах, таслан зогсоох ажиллагаа, байгууллагуудын хамтын ажиллагааны талаарх мэдээлэл авах сургалтад хамрагдах хүсэлтэй байгаагаа илүүтэй илэрхийлсэн нь гарын авлагад

зайлшгүй тусгай ёстой саналууд гэж үзэн дүгнэлт хэсэгт оруулж байна. Түүнчлэн эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээг сайжруулах, нэмэлтээр бусад улс оронтой байгуулах, тухайн гэрээг энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэхэд хэрхэн хэрэгжүүлэх талаарх онолын болон практик ойлголтыг өгөх асуудлыг гарын авлагад тусгахыг илэрхийлж байсан.

Нийт судалгаанд оролцогчдоос ямар аргачлалаар сургалт явуулбал илүү оновчтойг тодруулахад 82.6% (298) нь бодит кейсүүд дээр ажиллах, 43.1% (156) нь багаар ажиллах, 32.3% (117) нь оролцоонд суурилсан хэлбэрээр явуулах нь зүйтэй гэж үзсэн. Харин оролцогчдын дийлэнх нь багш лекц унших арга зүйгээр сургалт зохион байгуулах нь үр дүнгүй гэж үзсэн байна. Тиймээс гарын авлагыг боловсруулахдаа кейс дээр ажиллуулах, оролцооны хэлбэрийг түлхүү ашиглах хэлбэрийг тусгавал тэдний сонирхол, хэрэгцээнд нийцэхүйц, ашиглагдах боломжтой юм.

ХХГХ-ийн талаарх ном, гарын авлага, нэг сэдэвт бүтээлийн чанар, хүртээмжийн талаар судалгаанд оролцогчдын 36.5% (132) нь мэдэхгүй гэж хариулжээ. Энэ нь гарын авлагын хүртээмж хангалтгүй байгааг, эсвэл алба хаагчид мэргэшээгүй учир сонирхож хэрэглэдэггүй байх хандлагыг харуулж байна.

Хууль сахиулах, шүүгч, прокурор, хил хамгаалах, ГИХГ-ын алба хаагчдын 91.5% (330) нь ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр мэргэшсэн албан тушаалтан бэлтгэх шаардлагатай гэж хариулснаас харахад энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх, мөрдөн шалгахад мэргэшсэн албан хаагчдын оролцоо чухал үр дүнтэйг илэрхийлж байна.

4. ХХГХ-ийг илрүүлэх, хянан шийдвэрлэхэд тулгарч буй хүндрэл, бэрхшээл

ХХГХ-ийг илрүүлэх, хянан шийдвэрлэхэд хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллага, хил хамгаалах, ГИХГ-ын алба хаагчдад тулгарч буй бэрхшээлийг тодруулахаас гадна энэ төрлийн гэмт хэрэгт өртсөн хохирогчдын хувьд хуулийн хяналтын байгууллагаар асуудлаа шийдвэрлүүлэхэд гардаг нийтлэг хүндрэлүүдийг мөн адил энэхүү судалгаагаар гаргахыг зорьсон.

Судалгаанд оролцогчид хүн худалдаалахтай холбоотой гэмт хэргийг илрүүлэх, хянан шийдвэрлэхэд тулгардаг хүндрэл бэрхшээлийн талаар практик тогтоогүй, нотлох баримт хангалтгүй, гадаад улсад үйлдэгддэг, зохион байгуулалттай үйлдэгдэж, байнга хувьсан өөрчлөгддөг, эрх зүйн харилцан туслалцааны хүрээнд мөрдөн шалгах ажиллагаа явуулахад хүндрэлтэй байдаг нь үндсэн шалтгаануудын нэг гэж үзжээ. Түүнчлэн хохирогчид мэдүүлгээсээ буцдаг, хохирогчийн хувийн байдлаас шалтгаалан бодит үнэнийг тогтооход эргэлзээ төрдөг, хохирогч эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалздаг, шүүгдэгч болон хохирогчид оргон зайлдаг зэрэг хүндрэлүүдийг дурдсан байна. Эндээс үзэхэд гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх, нөхөн сэргээх асуудал хангалтгүй, хохирогчид олгох нөхөн олговрын асуудал шийдвэрлэгдээгүй, хохирогч нэхэмжилсэн хохирлынхоо дөнгөж 6%-ийг⁶² олж авч байгаа нөхцөлд эдгээр шалтгаанууд үгүй болно гэдэг эргэлзээтэй юм.

Хохирогчдын үзэж байгаагаар хохирол барагдуулалт хангалтгүй, зарим тохиолдолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар гаргуулахаар шийдвэрлэдэг боловч амжилттай шийдвэрлүүлсэн тохиолдол байхгүй байгаа нь хүндрэл учруулдаг. Хохирогчид энэ гэмт хэргийн хохирлыг барагдуулж өгөх, хуулийн байгууллагын урт удаан процессыг халж өгөхийг хууль, хяналтын болон төрийн байгууллагуудаас хүсэж байлаа. Мөн хохирогчдоод хуулийн байгууллагын ажилтнууд өөрсдийг нь буруутгах, байцаалт өгөхөөр хоёроос дээш удаа байнга давтан дуудах, байцаалт авахдаа олон хүмүүсийн дэргэд байцаадаг зэрэг нь тэдэнд сөрөг сэтгэгдэл төрүүлж, дахин хуулийн байгууллагад хандах сонирхолгүй болгодог талаар илэрхийлж байсан.

2017 онд шинэчилсэн ЭХ, ЭХХШТХ хэрэгжиж эхлээд удаагүй ч бэрхшээлүүд учирч эхэлсэн байна гэж хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагууд үзсэн байна. Учир нь тэдний хувьд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа олон үе шаттай болсон, прокурорын ажлын ачаалал ихэссэн, ХХГХ-ийн зүйл анги нь 2002 оны зохицуулалтаас дордсон, биеэ үнэлэх, зохион байгуулах явцад ашиг олж, хүнийг мөлжсөн бол хэрхэн шийдвэрлэх нь тодорхой бус, гэмт хэрэгт

⁶² Нээлттэй нийгэм хүрээлэн, ХТЭТ, "Тодорхой төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны өртөг: Хүн худалдаалах гэмт хэргийн жишээн дээр", судалгааны тайлан, 2016 он

тооцохгүй, зөрчил гэж үзэх болсон зэрэг хүндрэлүүдийг онцлон илэрхийлж байсныг анхааралдаа авч, эрх зүйн орчны өнөөгийн нөхцөл байдлын судалгааг хийх улмаар, холбогдох хууль тогтоомжийг засан сайжруулах хэрэгцээ шаардлага бий болсныг харуулж байлаа.

5. Хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллага, хил хамгаалах болон гадаадын иргэн, харьяатын газрын хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр

ХХГХ-ийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, ялангуяа шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр судалгаанд хамрагдсан бүх газруудын алба хаагчид мэргэшсэн ажилтнуудын тогтвортой байдлыг хангах асуудлыг чухалчлан тавьсан.

Судалгаанд оролцсон нэр бүхий байгууллагуудын алба хаагчдаас байгууллага хоорондын хамтын ажиллагааг сайжруулахын тулд дараах саналуудыг гаргасан. Үүнд:

- 1) Цагдаагийн байгууллагын алба хаагчдын 81.8% (164) нь сургалт зохион байгуулах, 91% (182) нь манай улсын иргэд холбогдсон, хохирсон бодит хэргийн кейс танилцуулж түүн дээр хамтран ажиллуулах, харилцан туршлага солилцох, иргэдэд мэдээлэл өгөх,
- 2) Шүүгчдийн 43.5% (17) нь эрх зүйн орчныг сайжруулах, алба хаагчдын мэргэшлийн ур чадварыг дээшлүүлэх, шаталсан сургалтыг зохион байгуулах, ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр нэгдсэн ойлголттой болох, бусад улс орны сайн туршлагыг судлах,
- 3) Прокуроруудын 52.9% (27) нь нэгдсэн ойлголт өгөх, практик дадлага олгох, нэгдсэн стандарт бүхий сургалтуудыг тодорхой үе шаттай зохион байгуулах, гадаад улс орны туршлагыг судлах, албан хаагчдыг мэргэшүүлэх чиглэлээр ажиллах,
- 4) ХШНА-ны алба хаагчдын 60.4% (32) нь сургагч багш бэлтгэх, туршлага солилцох, хууль эрх зүйн орчныг сайжруулах, сургалт зохион байгуулж хамтын ажиллагааг сайжруулах,
- 5) ГИХГ-ын алба хаагчдын 83.3% (15) нь сургалт зохион байгуулах, бүх алба хаагчдыг бүрэн хамруулах, мэргэшсэн алба хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, олон улсын туршлага судлах, урьдчилан сэргийлэх ажиллагааг тогтмол явуулах гэсэн саналуудыг дэвшүүлсэн.

Эндээс үзэхэд бүхий л салбарт ялангуяа алба хаагчид нь ХХГХ-ийн талаар нэгдсэн ойлголттой болох, илүү мэргэшин ажиллах, шаталсан сургалтуудад хамрагдах, байгууллагын хоорондын үйл ажиллагааг сайжруулах болон хохирогч төвтэй ажиллах олон улсын туршлага судлахыг хүсэж байгаа

ба тэдэнд бодитоор бий болсон хэрэгцээ, шаардлага байна гэж дүгнэгдэж байна.

6. Хохирогчийн судалгааны дүгнэлт

Судалгаанд оролцогчдын 45% (9) нь эх орон дотроо, 55% (11) нь хилийн чанадад ХХГХ-ийн хохирогч болж байжээ. Тэдний 20% (4) нь насанд хүрээгүй байхдаа улс дотроо бэлгийн мөлжлөгийн хохирогч болсон. Хохирогчид өөрийн эх орон дотроо болон хилийн чанадад байгаагаасаа үл хамаарч цалин хөлсгүй ажиллаж, ар гэр, ойр дотынх нь хүнтэй нь холбоо бариулахгүй, бэлгийн болон бие махбодын хүчирхийлэлд өртөж, анх амлаж байснаас өөр ажлыг хүчээр хийлгэсэн байна. Ганц ялгаатай байгаа шинж нь Монгол улс дотроо худалдаалагдсан хохирогчдын бичиг баримтыг хураах шаардлага байдаггүй. Хохирогчдын 90% (18) нь тухайн газарт очиж, хүчээр биеэ үнэлэх нөхцөл, байдалд орсныхоо дараа л ХХГХ-ийн хохирогч болсноо мэдсэн байгаа нь хохирогчид мэдээлэл муутай, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа хангалтгүй байгаатай холбоотой гэж үзэж болохоор байна.

Хохирогчид ХХГХ-ийн нөхцөл байдлаасаа аврагдсан, зугтаж гарах нийтлэг арга зам, төгс арга байдаггүй гэдгийг 20 хохирогч 14 өөр аргаар аврагдаж, зугтсанаас харж болно. Тэд боломжтой хугацааг байнга хүлээж, тооцож, судалж байдаг бөгөөд үүнд зөвхөн хохирогчийн тооцоолол, төлөвлөгөөнөөс гадна бусад гаднын хүчин зүйлс нөлөөлж биеллээ олдог гэж

үзэж болно.

Хохирогчдын 5 хүн тутмын 4 нь хуулийн аль нэг шатны байгууллагад гомдол гаргаж, эдгээр гомдлын 4 хэрэг тутмын 3-т шүүхээс гэмт буруутай этгээдүүдэд ял шийтгэл оногдуулсан. Энэ тооноос харвал ямар нэг байдлаар шүүхийн шат хүртлээ явсан хэрэг шийдвэрлэгдэх боломжтой гэж үзэж болохоор байна. Гэвч судалгаанд оролцохыг зөвшөөрсөн хохирогчдын дийлэнх нь хуулийн байгууллагаар асуудлаа шийдвэрлүүлж чадсан хохирогчид байсан тул үр дүн ингэж гарсан байх магадлалтай.

Хохирогчдын 10 хүний 9 нь ТББ-аас дөрвөөс дээш төрлийн туслалцаа авсан нь ТББ-ын үзүүлж буй үйлчилгээ цогц байгааг харуулж байгаа хэдий ч санхүүгийн тогтворгүй байдлаас шалтгаалан хүн бүрд шаардлагатай үйлчилгээг тэгш хүргэж чадахгүй байна.

Бүх хохирогчид эдийн засаг, сэтгэл санаа, эрүүл мэнд сэтгэлзүйн өвчлөл учирснаас гадна нэр төрөө алдаж, гэр бүлийн гишүүдийн зүгээс харьцах харьцаа нь өөрчлөгдөж, зарим ах дүүстэйгээ холбоогоо тасалсан. Мөн нэг тохиолдолд хар тамхи хүчээр хэрэглүүлж байснаас одоо хамаарлаасаа салж, эрүүл мэндээ эмчлүүлэх гэж асар их цаг, хөрөнгө мөнгө шаардлагатай болсон тухайгаа ярьсан нь хохирогчийг нөхөн сэргээх удаан хугацааны тогтвортой туслалцаа шаардлагатай байдгийг харуулж байна.

ЗӨВЛӨМЖ

Судалгааны ажлын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Үүнд:

Хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, сайжруулах чиглэлээр

1. 2012 онд батлагдсан “Хүн худалдаалахтай тэмцэх тухай” хуулийг 2017 онд шинэчлэн батлагдсан хууль тогтоомжтой нийцүүлэх, сайжруулах, боловсронгуй болгох;
2. Үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэг, ялангуяа ХХГХ–тэй тэмцэхийн тулд гадаад улс оронтой эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээг байгуулах, сайжруулах;
3. ХХГХ–ийн хэргийг мөрдөн шалгах, хянах, шийдвэрлэх хугацааг богиносгох, хохирогчид дахин түвэг, чирэгдэл үүсгэхээс хамгаалах, урьдчилан сэргийлэх;
4. Байгууллага тус бүр алба хаагчдад зориулсан сургалтын төлөвлөгөөндөө ХХГХ–тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах талаар тусгах.

Хохирогч хамгаалал чиглэлээр

1. ХХГХ–ийн хохирогчийг илрүүлэх, мөрдөн шалгах, нотлох, гэрч хохирогчийг хамгаалах тусгай тогтсон стандарт арга техник, журам, асуумжийг сайжруулах, боловсруулах, хэрэгжүүлэх;
2. ХХГХ–ийн хохирогчийн хамгааллыг сайжруулах, Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль (2014), Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль (2012), ЭХ (2017), ЭХХШТХ–ийн (2017) нийцлийг хангаж, бодитоор хэрэгжүүлэх;
3. “Хохирогчоос мэдүүлэг авах өрөө”–ний ашиглалтыг сайжруулах, зориулалтын дагуу тогтмол ашиглах, үйл ажиллагааны нэгдсэн стандарттай болох;
4. Хохирогчийн хохирлыг нөхөн төлүүлэх тусгай сантай болох, учирсан хохирлыг тухайн хэрэг шалгагдаж эхэлсэн цагаас эхлэн барагдуулж байх, гэмт хэрэгтнээс хураасан хөрөнгө, гэмт хэргийн нөхөн төлбөрөөс сандаа төвлөрүүлж ажиллах;
5. ХХГХ–ийн хохирогчид туслалцаа үзүүлэх, хүндрэл чирэгдэлгүй төрийн цогц үйлчилгээг бий болгох, хэрэгжүүлэх;
6. ХХГХ–ийн хохирогчдод туслалцаа, үйлчилгээ үзүүлдэг мэргэшсэн ТББ–ын үйл ажиллагааг төрөөс дэмжиж ажиллах, хуульд заасны дагуу гэрээгээр зарим чиг үүргийг гүйцэтгүүлж,

хохирогчдод зориулсан үйлчилгээг санхүүжүүлж, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, ажиллагсдын аюулгүй байдлын хамгаалалт зэрэгт анхаарлаа хандуулах.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх гарын авлага боловсруулах, сургалт зохион байгуулах чиглэлээр

1. Мэргэшүүлэх гарын авлагыг боловсруулахдаа судалгаанд хамрагдсан алба хаагчдаас гаргасан саналыг тусгах, ялангуяа үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргүүдтэй хамт үйлдэгдэж буй тохиолдлууд, хамаарлыг хэрхэн илрүүлж, мөрдөн шалгах талаар тусгах, 2017 оны шинэчилсэн Эрүүгийн болон ЭХХШТХ–ийн ХХГХ–тэй холбоотой зүйлчлэлийн хэрэгжилтээр хэлэлцүүлгийг зохион байгуулах, кейс судалгаа хийх, төсөөтэй хэргүүдийг хэрхэн зүйлчлэх талаар сургалтын гарын авлагад оруулах;
2. Гарын авлагыг боловсруулахад хууль сахиулах, шүүгч, прокурор, хил хамгаалах, ГИХГ–ын албан хаагчдын төлөөллийг оролцуулах;
3. Сургалтыг судалгаанд оролцогчдын хүсэж буй ялангуяа “бодит кейс дээр ажиллах”, “багаар ажиллах”, “оролцоонд суурилсан” арга зүй, аргачлалаар зохион байгуулах, мэргэжлийн мэргэшсэн сургагч багш нараар хичээл заалгах;
4. Боловсруулагдан гарсан гарын авлагаар салбар тус бүрд сургалт зохион байгуулах улмаар мэргэшсэн алба хаагчдыг бэлтгэх;
5. Сургалтын чанар, үр дүнг хянах шалгуур үзүүлэлт бий болгох.

Хамтын ажиллагааны чиглэлээр

1. ХХГХ–тэй тэмцэх чиглэлээр бусад орны сайн туршлагаас суралцах, судлах;
2. Хилийн чанадад үйлдэгдсэн гэмт хэргийн нотлох баримтыг бэхжүүлэх, цуглуулах үйл ажиллагаанд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;
3. Гадаад улс орны туршлагыг судлах, сайн туршлагыг нэвтрүүлэх, түүнчлэн алба хаагчдыг мэргэшүүлэн сургах чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлэх.

ХҮН, ЯЛАНГУЯА ЭМЭГТЭЙЧҮҮД, ХҮҮХЭД ХУДАЛДААЛАХААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТАСЛАН ЗОГСООХ, ШИЙТГЭХ
ТУХАЙ ПРОТОКОЛ БОЛОН МОНГОЛ УЛСЫН ЗАРИМ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХАРЬЦУУЛАЛТЫН ХАВСРАЛТ

Хавсралт: № 1

Судлагдсан хууль, хөтөлбөрүүд

	Хууль, тогтоомжууд	Батлагдсан огноо	Дагаж мөрдөх огноо	Төрийн эмхэтгэл	мэдээлэл
Монгол Улсын олон улсын гэрээ					
1	Хүний эрхийн түгээмэл тунхаглал	1946.12.10	1946.12.10	Legalinfo.mn	
2	Иргэний болон Улс төрийн эрхийн олон улсын пакт	1966.12.16	1976.03.23	Legalinfo.mn	
3	Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол	2008.05.16			2012 он №17
4	Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцэд оруулах нэмэлт протокол	2000.05.25	2002.01.18	Legalinfo.mn	
Монгол Улсын хуулиуд					
1	Монгол Улсын Үндсэн хууль	1992.01.03	1992.02.12		1992 он. №1
2	Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль	2012.01.19	2012.01.19		2012 он №7
3	Монгол Улсын Эрүүгийн хууль /хүчингүй болсон/	2002.01.03	2002.09.01		2002 он №5
4	Монгол Улсын Эрүүгийн хууль	2015.12.03	2017.07.01		2016 он №7
5	Эрүүгийн байцаан шийтгэх хууль /хүчингүй болсон/	2002.01.10	2002.09.01		2012 он №6
6	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль	2017.05.18	2017.07.01		2017 он №23
7	Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль	2013.07.05	2014.01.01		2013 он №30
8	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль	1997.05.12	1998.01.19		1998 он №1
9	Зөрчлийн тухай хууль	2017.05.18	2017.07.01		2017 он №24
10	Захиргааны хариуцлагын тухай хууль /хүчингүй болсон/	1992.11.27	1992.12.15		1993 он №4–5
11	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль	2017.05.11	2017.07.01		2017 он №24
12	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль /хүчингүй болсон/	2004.05.13	2005.01.01		2004 он №23
13	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль	2016.12.22	2017.02.01		2017 он №5
14	Хүүхдийн эрхийн тухай хууль	2016.02.05	2016.09.01		2016 он №9
15	Хүүхэд хамгааллын тухай хууль	2016.02.05	2016.09.01		2016 он №9
16	Зар сурталчилгааны тухай хууль	2002.05.30	2002.06.01		2002 он №23
17	Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль	2017.05.18	2018.01.01		2017 он №29
18	Хилийн тухай хууль	2016.12.28	2017.02.01		2017 он №6

19	Улсын бүртгэлийн ерөнхий хууль	2009.06.25	2009.06.25	2009 он №26
20	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль	2010.07.08	2010.09.01	2010 он №32
21	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль	2015.11.26	2016.01.01	2015 он №47
22	Хууль тогтоомжийн тухай хууль	2015.05.29	2016.02.10	2015 он №25
23	Садар самуунтай тэмцэх тухай хууль	1998.01.22	1998.07.01	1998 он №3
25	Донорын тухай хууль	2000.01.28	2000.02.28	2000 он №6
26	Харьяатын тухай хууль	1995.06.05	1995.07.15	1995 он №10,11
27	Жендерийн тэгш байдлыг хангах тухай хууль	2011.02.02	2011.02.02	2011 он №8
28	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай тухай хууль	2011.06.17	2013.01.01	2011 он №40
29	Гүйцэтгэх ажлын тухай хууль	1997.12.19	1997.12.19	1998 он №3
Засгийн газрын хөтөлбөрүүд		Батлагдсан	Хэрэгжсэн хугацаа	
1	Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал	2010.07.15	2010.07.15	
2	“Жендерийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр” ЗГ-ын тогтоол №274	2002.12.30	2003–2015 он хүртэл /дууссан/	
3	Хүн худалдах ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр ЗГ-ын тогтоол №234	2005.11.30	2006–2014 он хүртэл /дууссан/	
4	“Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөр” ЗГ-ын тогтоол №252	2012.07.25	2012–2016 он хүртэл /дууссан/	
5	“Гэрч хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр” ЗГ-ын тогтоол №346	2015.08.24	2016–2024 он хүртэл	
6	“Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр” ЗГ-ын тогтоол №148	2017.05.24	2017–2021 он хүртэл	
		Стандарт		
1	Хохирогчийг хамгаалах байрны үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага	Ангиллын 03.6040.99	код	MNS 6040:2009

ПАЛЕРМОГИЙН ПРОТОКОЛЫН I ЕРӨНХИЙ ЗААЛТУУД

3 дугаар зүйл. **Нэр томьёо**

Энэхүү протоколын зорилгоор:

(а) “хүн худалдаалах” гэдэг нь хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэхээр заналхийлэх буюу хүч хэрэглэх, эсхүл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эмзэг байдлыг нь ашиглах, эсхүл өөр этгээдийг хяналтдаа байлгаж буй этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр хийж буюу ашиг олгон хахуульдах зэрэг аргаар хүмүүсийг урвуулан элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуугдуулах буюу хүлээж авах үйлдлийг хэлнэ.

Мөлжих гэдэгт наад зах нь бусдын биеийг нь үнэлүүлэх буюу бэлгийн харилцаанд оруулан мөлжих бусад хэлбэрүүд, албадан ажиллуулах буюу үйлчлүүлэх, боолчлох буюу боолчлолтой төсөөтэй заншил, эрх чөлөөгүй байлгах буюу эрхтнийг нь авах зэргийг ойлгоно.

(b) Энэ зүйлийн (а) дэд хэсэгт дурдсан аргуудын аль нэгийг ашигласан байх тохиолдолд хүн худалдаалах хэргийн хохирогч өөрийг нь (а) дэд хэсэгт дурдсанаар мөлжих гэж байгааг өөрөө зөвшөөрснийг хэрэгсэхгүй;

(c) Энэ зүйлийн (а) дэд хэсэгт дурдсан аргуудыг хэрэглээгүй байсан ч мөлжих зорилгоор хүүхдийг урвуулан элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуугдуулах буюу хүлээж авах үйлдлийг “хүн худалдаалах” гэж үзнэ;

5 дугаар зүйл.

Эрүүгийн шинж

1. Орлоцогч улс бүр хэрэв энэ протоколын 3 дугаар зүйлд дурдсан үйлдлүүдийг санаатайгаар үйлдсэн бол тэдгээрийг эрүүгийн гэмт хэрэгт тооцоход шаардлагатай байж болох хууль тогтоох болон бусад арга хэмжээг авна.

2002 оны Эрүүгийн хууль

УИХ 2013 оны 01 дүгээр сарын 03–ны өдөр батлагдаж 2012 оны 09 дүгээр сарын 01–ний өдрөөс мөрдөгдсөн.

2015 оны Эрүүгийн хууль

УИХ 2015 оны 12 дүгээр сарын 03–ны өдөр батлагдаж 2017 оны 07 дугаар сарын 01–ний өдрөөс мөрдөгдсөн

Хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэг

113 дугаар зүйл. Хүн худалдаалах

113.1. Хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, эсхүл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, түүнчлэн өөр хүнийг эрхшээлдээ байлгаж буй этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, ашиг олгон хахуульдах аргаар хүнийг хүн худалдаалах гэмт үйлдэлд элсүүлсэн, тээвэрлэсэн, нуун далдалсан дамжуулсан, хүлээн авсан бол эд хөрөнгийг хурааж, гурваас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

113.2. Энэ хэргийг:

113.2.1. давтан;

113.2.2. хоёр буюу түүнээс олон хүнийг;

113.2.3. насанд хүрээгүй хүнийг;

113.2.4. хүний эд эрхтнийг авах зорилгоор;

113.2.5. сэтгэцийн өвчний улмаас эрх зүйн чадамжгүйд тооцогдсон хүнийг;

113.2.6. хөгжлийн бэрхшээлтэй хүнийг;

113.2.7. албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эрхшээлдээ байгаа хүнийг;

113.2.8. хуурамч бичиг баримт ашиглан;

113.2.9. хохирогчийн бичиг баримтыг авах, нуух, устгах арга хэрэглэж;

113.2.10. улсын хил давуулан;

113.2.11. илтэд жирэмсэн хүнийг худалдаалсан бол эд хөрөнгийг хурааж, таваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

113.3. Энэ хэргийг урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, түүнчлэн энэ хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан бол эд хөрөнгийг хурааж, арваас арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Арван гуравдугаар бүлэг хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг

13.1 дүгээр зүйл. Хүн худалдаалах

1. Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн; тээвэрлэсэн; орогнуулсан; дамжуулсан; хүлээн авсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

<p><i>Тайлбар:1.Энэ хуулийн 113.1–д заасан “мөлжих” гэдгийг худалдаалагдсан хүнийг биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох болон түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, албадан хөдөлмөрлүүлэх, эд эрхтнийг нь авч ашиглах гэсэн утгаар ойлгоно.</i></p> <p><i>2.Энэ хэргийг үйлдэхдээ хохирогчийн эсрэг хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эсхүл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашигласан, эмзэг байдлыг нь далимдуулах, эсхүл өөр хүнийг эрхшээлдээ байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлж буюу ашиг олгон хахуульдах аргын аль нэгийг хэрэглэсэн тохиолдолд хохирогч өөрийг нь мөлжихийг зөвшөөрсөн эсэхийг үл харгалзан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.</i></p> <p><i>3.Энэ хуулийн 113.1–д заасан аргыг хэрэглээгүй байсан ч арван найман насанд хүрээгүй хүнийг хүн худалдаалах гэмт хэргийн зорилгоор элсүүлсэн, тээвэрлэсэн, нуун дарагдуулсан, дамжуулсан, хүлээн авсан бол хүн худалдаалсан гэж үзнэ./Энэ зүйлийг 2008 оны 02 дугаар сарын 01–ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан//Энэ зүйлийг 2012 оны 01 дүгээр сарын 19–ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/</i></p>	<p>2.Энэ гэмт хэргийг:</p> <p>2.1.хүүхэд, жирэмсэн эмэгтэйг мэдсээр байж;</p> <p>2.2.хоёр, түүнээс олон хүнийг худалдаалж;</p> <p>2.3.Монгол Улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>3.Энэ гэмт хэргийг:</p> <p>3.1.байнга тогтвортой;</p> <p>3.2.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ.</p> <p>Тайлбар: –Хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй.</p> <p>–Энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход хохирогч өөрийг нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар хохироож байгааг өөрөө зөвшөөрсөн эсэх нь гэмт хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй.</p>
<p>2015 оны Эрүүгийн хуулийн 12.3 дугаар зүйл.Бэлгийн мөлжлөг</p>	
<p>1.Хохирогчид хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан зорчих эрхийг хязгаарлахгүйгээр бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>2.Энэ гэмт хэргийг хохирогчийн биеийг үнэлүүлж ашиг олох зорилгоор:</p> <p>2.1.арван дөрвөөс арван найман насанд хүрээгүй хүнийг албадан оруулж;</p> <p>2.2.урьд энэ бүлэгт заасан гэмт хэрэг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн;</p> <p>2.3.хохирогчид мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглүүлж;</p> <p>2.4.хохирогчийг жирэмсэн болгож;</p> <p>2.5.хоёр, түүнээс олон хүний эсрэг;</p> <p>2.6.байнга тогтвортой үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>3.Энэ гэмт хэргийн улмаас:</p> <p>3.1.ураг зулбасан;</p> <p>3.2.арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>4.Энэ гэмт хэргийг хохирогчийн биеийг үнэлүүлж ашиг олох зорилгоор:</p> <p>4.1.бага насны хүүхдийг албадан оруулж;</p> <p>4.2.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ.</p> <p>Тайлбар: –Бага насны хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй.</p>	
<p>2015 оны Эрүүгийн хуулийн 13.13 дугаар зүйл.Албадан хөдөлмөрлүүлэх</p>	
<p>1.Бусдад хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, илт хохиролтой болзол, нөхцөл тулгаж, эсхүл хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдлыг далимдуулан эрхшээлдээ оруулж цалин хөлсгүй хөдөлмөр эрхлүүлсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>	
<p>2. Оролцогч улс бүр дараах үйлдлийг эрүүгийн гэмт хэрэгт тооцоход шаардлагатай байж болох хууль тогтоох болон бусад арга хэмжээг мөн авна.</p> <p>(a) хууль зүйн тогтолцооны үндсэн зарчмуудыг дагаж мөрдсөн нөхцөлд, энэхүү зүйлийн 1 дэх хэсгийн дагуу тодорхойлсон гэмт хэргийг үйлдэхийг завдах;</p> <p>(b) энэхүү зүйлийн 1 дэх хэсгийн дагуу тодорхойлсон гэмт хэргийг үйлдэхэд хамтран оролцох;</p> <p>(c) энэхүү зүйлийн 1 дэх хэсгийн дагуу тодорхойлсон гэмт хэргийг үйлдэх зорилгоор бусад этгээдийг зохион байгуулах буюу удирдах.</p>	

2015 оны Эрүүгийн хуулийн 1.2 дугаар зүйл. Хууль ёсны зарчим

4.Энэ хуулийн нэр томьёо, ухагдахууныг тайлбарлахад Монгол Улсын хууль, Монгол Улсын хуулиар соёрхон баталсан, нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан тодорхойлолт, хэм хэмжээг баримтална.

2.7 дугаар зүйл.Гэмт хэрэгт бэлтгэх

1.Зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйлийг хайж олсон, шинээр хийсэн, засаж тохируулсан, гэмт хэрэг үйлдэх талаар урьдчилан үгсэж тохиролцсон, гэмт хэрэг үйлдэхэд тохиромжтой нөхцөл зориуд бүрдүүлснийг гэмт хэрэг үйлдэхэд бэлтгэх гэнэ.

2.Энэ хуульд гурван жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэгт бэлтгэсэн үйлдэл, эс үйлдэхүйд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.

4.Шүүх энэ зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад гэмт хэрэгт бэлтгэсэн үйлдэл, эс үйлдэхүйн шинж ба гэмт хэргийг төгсгөж чадаагүй нөхцөл байдлыг харгалзан энэ хуульд тухайн гэмт хэрэгт оногдуулахаар заасан ялын дээд хэмжээний гуравны нэгээс хэтрүүлэхгүйгээр ял оногдуулж болно.

2.8 дугаар зүйл.Гэмт хэрэг үйлдэхээр завдах, гэмт хэрэг үйлдэхээс татгалзах

1.Гэмт хэрэг үйлдэхэд шууд чиглэсэн үйлдэл, эс үйлдэхүйг санаатай хийсэн боловч тухайн хүний хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлын улмаас гэмт хэрэг төгсөөгүй бол гэмт хэрэг үйлдэхээр завдах гэнэ.

2.Шүүх гэмт хэрэг үйлдэхээр завдсан үйлдлийн шинж ба гэмт хэргийг төгсгөж чадаагүй нөхцөл байдлыг харгалзан энэ хуулийн тусгай ангид тухайн гэмт хэрэгт оногдуулахаар заасан ялын дээд хэмжээний гуравны хоёроос хэтрүүлэхгүйгээр ял оногдуулна.

3.Гэмт хэргийг үйлдэж төгсгөх боломжтойг ойлгож байсан боловч туйлд нь хүргэхээс сайн дураараа татгалзсан хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.

3.1 дүгээр зүйл. Гэмт хэрэгт хамтран оролцох

1.Хоёр, түүнээс олон хүн гэмт хэрэг үйлдэхэд санаатай нэгдсэнийг гэмт хэрэгт хамтран оролцох гэнэ.

2.Гүйцэтгэгч, зохион байгуулагч, хатгагч, хамжигчийг гэмт хэрэг гэмт хэрэгт хамтран оролцогчид тооцно.

3.Гэмт хэргийг үйлдэх талаар урьдчилан үгсэн тохиролцсоныг, эсхүл урьдчилан үгсэн тохиролцоогүй боловч үйлдлээрээ санаатай нэгдсэнийг гэмт хэрэгт хамтран оролцсонд тооцно.

3.2 дугаар зүйл.Гэмт хэргийн гүйцэтгэгч

1.Энэ хуульд заасан гэмт хэргийг өөрөө, бусадтай бүлэглэн, ял оногдуулах насанд хүрээгүй хүнийг, хэрэг хариуцах чадваргүй хүнийг, гэмт хэргийг хамтран үйлдээгүй ба гэмт хэрэг үйлдэгдэж байгааг ойлгож мэдээгүй бусад хүнийг, мал, амьтан ашиглан үйлдсэн хүнийг гэмт хэргийн гүйцэтгэгч гэнэ.

2.Хуулийн этгээдийг төлөөлөн шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө шийдвэр гаргаж, зөвшөөрөл өгч энэ хуульд заасан гэмт хэргийг бусдаар үйлдүүлсэн, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө энэ хуульд заасан гэмт хэргийн шинжийг өөрийн үйлдэл, эс үйлдэхгүйгээр хангасан бол гэмт хэргийн гүйцэтгэгчид тооцно.

3.Хуулийн этгээдийн гүйцэтгэх албан тушаалтан удирдлагаас өгсөн шийдвэрийг хууль бус болохыг мэдсээр байж үйлдсэн бол хамтран үйлдсэн гүйцэтгэгчид тооцно.

3.3 дугаар зүйл.Гэмт хэргийн зохион байгуулагч

1.Гэмт хэрэг үйлдэхийг санаачилсан, удирдсан, төлөвлөсөн, гэмт хэрэг хамтран үйлдэгчдийн үүрэг, оролцоог хуваарилсан, зохион байгуулалттай гэмт бүлэг байгуулсан хүнийг гэмт хэргийн зохион байгуулагч гэнэ.

2.Гэмт хэргийн зохион байгуулагчийг тухайн гэмт хэргийг хамтран үйлдсэн гүйцэтгэгчид тооцно.

3.8 дугаар зүйл.Зохион байгуулалттай гэмт бүлэг

1.Гэмт хэрэг байнга үйлдэж ашиг олох зорилгоор урьдчилан нэгдсэн гурав, түүнээс олон хүний тогтвортой нэгдлийг зохион байгуулалттай гэмт бүлэг гэнэ.

2.Зохион байгуулалттай гэмт бүлэг байгуулсан, удирдсан хүнийг зохион байгуулалттай гэмт бүлэг байгуулсан, удирдсан үйлдэлд нь ба зохион байгуулалттай гэмт бүлгийн бусад гишүүний үйлдсэн гэмт хэргийн гүйцэтгэгчид тооцож ял оногдуулна.

3.Зохион байгуулалттай гэмт бүлгийн гишүүнийг зохион байгуулалттай гэмт бүлэгт элссэн үйлдэлд ба өөрийнх нь үйлдсэн гэмт хэрэгт ял оногдуулна.

4.Зохион байгуулалттай гэмт бүлгийн үйл ажиллагаанд нэгдэж гэмт хэрэг үйлдсэн хүнийг зохион байгуулалттай гэмт бүлгийн гишүүнд тооцож өөрийнх нь үйлдсэн гэмт хэрэгт ял оногдуулна.

5.Зохион байгуулалттай гэмт бүлгийн үйл ажиллагаанд нэгдэж гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулахад уг гэмт бүлгийг байгуулсан, удирдсан, уг гэмт хэрэгт хамтран оролцсон бусад гишүүнд ял оногдуулсан эсэх нь саад болохгүй.

6.Зохион байгуулалттай гэмт бүлгийн гишүүн гэмт хэргээ илчлэн ирсэн, зохион байгуулалттай гэмт бүлгийн үйлдсэн гэмт хэргийг илрүүлэхэд туслалцаа үзүүлсэн, мэдээлэл өгсөн, эрх бүхий байгууллагатай хамтран ажилласан бол түүнийг гэм буруугаа хүлээсэнд тооцон ял оногдуулж, хөнгөрүүлж, чөлөөлж болно.

ПАЛЕРМОГИЙН ПРОТОКОЛЫН II. ХҮН ХУДАЛДААЛАХ ХЭРГИЙН ХОХИРОГЧДЫГ ХАМГААЛАХ

6 дугаар зүйл. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах болон туслах

Зохих тохиолдолд оролцогч улс бүр хүн худалдаалах хэргийн хохирогчдын хувийн амьдралыг ба тэдгээрийг бие хүний хувьд, тухайлбал, хүн худалдаалахтай холбогдох тухайн хэргийн шүүн таслах ажиллагааг нууц байлгах арга замаар, дотоодын хууль тогтоомжоор байж болох хэмжээнд хамгаална.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн Гэрч, хохирогчийг хамгаалах бүлэг**13.1 дүгээр зүйл. Гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах шүүхийн шийдвэр гаргах үндэслэл**

1. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд мөрдөгчийн санал, гэрч, хохирогч, өмгөөлөгчийн хүсэлтийг үндэслэн прокурор, шүүхийн шатанд прокурорын санал, гэрч, хохирогч, өмгөөлөгчийн хүсэлтийг үндэслэн шүүгч Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан дараах аюулгүй байдлын хамгаалалтыг хэрэглэх шийдвэр гаргана:

- 1.1. тодорхой үйлдлийг хязгаарлах;
- 1.2. биечилсэн хамгаалалтад авах;
- 1.3. мэдээллийн нууцлалыг хангах;
- 1.4. нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, холбооны хэрэгслээр хангах.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аюулгүй байдлын хамгаалалтыг хэрэглэх хүрээнд прокурор, шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилгод нийцүүлэн дараах арга хэмжээг авах тухай шийдвэр гаргаж болно:

- 2.1. нийтэд мэдээлэх мэдээллээс гэрч, хохирогчийг танихад ашиглагдаж болох нэр, хаяг, ажлын газар, мэргэжил, бусад баримт мэдээ, мэдээллийг нууцлах, өөрчлөх, арилгах;
- 2.2. нэрийг нь нууцалсан гэрч, хохирогчийн талаарх мэдээ, мэдээллийг хайх, задруулахыг хориглох;
- 2.3. шүүхээс тогтоосон хугацаанд мэдээллийг задруулахыг хориглох;
- 2.4. гэрч, хохирогчийн нэрийг ил болгон танилцуулах хүртэл гэрч, хохирогчид зохиомол нэр өгч хамгаалах.

3. Тухайн хэргийг гэрчлэхтэй холбоотойгоор гэрч, хохирогч, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэндэд аюул учрах бодит үндэслэл байгаа тухай прокурорын санал, өмгөөлөгчийн хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл шүүх дараах нэмэлт арга хэмжээ авч болно:

- 3.1. гэрч, хохирогчийг шүүх хуралдааны танхимд байлцуулахгүйгээр харилцаа холбооны хэрэгсэл ашиглан шүүхийн хэлэлцүүлэгт оролцуулах;
- 3.2. яллагдагч, шүүгдэгчийн өмгөөлөгчийг оролцуулж авсан гэрч, хохирогчийн мэдүүлгийн тэмдэглэл, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгтэй танилцах ажиллагааг гэрчийг байлцуулахгүйгээр хийх;
- 3.3. шүүгдэгчийг шүүх хуралдааны танхимд байгаа үед гэрч, хохирогч мэдүүлэг өгөхөөс татгалзсан, эсхүл түүнийг байлцуулах үед гэрч, хохирогч үнэнийг мэдүүлэхгүй байх нөхцөл байдал үүсэж болохоор бол шүүх хуралдааны танхимаас шүүгдэгчийг түр гаргах.

4. Шүүх энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан арга хэмжээг авахад яллах талд давуу байдал олгохгүй, эсхүл шүүгдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг дордуулахгүй, талуудад мэтгэлцэх боломжийг тэгш хангана.

5. Шүүх энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндэслэлээр шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааныг бүхэлд нь, эсхүл хэсэгчилсэн байдлаар хаалттай явуулж болно.

6. Гэрч, хохирогчийг хамгаалах шийдвэрийг цуцлах тухай албан тушаалтны санал, гэрч, хохирогчийн хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл шүүх гэрч, хохирогчийг хамгаалах тухай шийдвэрээ хүчингүй болгож, өөрчилж болно.

7. Шүүхээс гэмт хэргийг илрүүлэх, бусад яллагдагч, шүүгдэгчийн гэм бурууг нотлох чиглэлээр мэдүүлэг өгч байгаа шүүгдэгч, эсхүл шинжээчийг энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндэслэлээр хамгаалах шийдвэр гаргаж болно.

8. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай болон хамгаалалтыг цуцлах тухай шүүхийн шийдвэрт гомдол гаргаж болно.

9. Гэрч, хохирогчийн нууцлал, аюулгүй байдлыг хангах зорилгоор мөрдөгч өөрийн санаачилгаар, эсхүл гэрч, хохирогчийн хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл гэрч, хохирогчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрээс бусад биеийн байцаалтыг мөрдөн шалгах ажиллагааны тэмдэглэлд тусгахгүйгээр тусад нь бичиж битүүмжлэн хавтаст хэрэгт хавсаргана.

10. Энэ зүйлийн 9 дэх хэсэгт заасан мэдээллийг шүүх хуралдааны явцад ил болгоно.

2. Гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндэд заналхийлсэн, халдахаар завдсан, бэлтгэсэн, эсхүл халдлага бодитой эхэлсэн тохиолдолд мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, албан тушаалтан Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ авч, энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шийдвэр гаргуулахаар шүүхэд даруй хандана.

3. Шүүх нь прокурор, өмгөөлөгч, мөрдөгчийн аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээг энэ хуулийн 13.1 дүгээр зүйлд заасны дагуу авч болно.

1. Орлогч улс бүр дотоодын хууль зүйн буюу захиргааны тогтолцооны хүрээнд хүн худалдаалах хэргийн хохирогчдод, зохих тохиолдлуудад:

(а) шүүхийн болон захиргааны хянан хэлэлцэх ажиллагааны талаар мэдээлэл өгөх;

гэмт хэрэг үйлдсэн этгээдэд холбогдох эрүүгийн шүүн таслах ажиллагааны зохих үе шатуудад өмгөөлөх талын эрхэд хохирол учруулахгүй байх хэлбэрээр санал бодол, болгоомжлолыг нь илэрхийлэх, хэлэлцүүлэх боломжийг бүрдүүлэх талаар тусалцаа үзүүлэх арга хэмжээнүүдийг тусгасан байх нөхцөлийг хангана.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.3 дугаар зүйл. Мэдээллээр хангуулах

1.Хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийн дагуу дараах ажиллагааг явуулахаас 3-аас доошгүй хоногийн өмнө прокурор түүнд энэ тухай мэдэгдэнэ:

- 1.1.яллагдагчид авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх эсэхийг шийдвэрлэх шүүхийн хэлэлцүүлэг;
- 1.2.хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг харьяаллын дагуу шилжүүлэх;
- 1.3.ялтныг хорих ялаас хугацааны өмнө суллах асуудлыг шийдвэрлэх хуралдаан.

2.Хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийн дагуу яллагдагчид таслан сэргийлэх арга хэмжээ авсан, өөрчилсөн, хүчингүй болгосон, хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн, хаасан, мөрдөн байцаалтыг түдгэлзүүлсэн, сэргээсэн, хэргийг прокурорт шилжүүлсэн талаар мөрдөгч түүнд мэдэгдэнэ.

3.Прокурор, мөрдөгч хуулиар хамгаалагдсан төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой асуудлаар хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид мэдээлэл өгөхгүй.

4.Прокурор, мөрдөгч нь гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагчийн аюулгүй байдалд эрсдэл учруулж болох, эсхүл мөрдөн шалгах ажиллагаа явуулахад саад учруулж болох үндэслэл бүхий сэжиг байгаа бол энэ зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас гадна бусад мэдээллийг нууцалж болно.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.2 дугаар зүйл.Хохирогчийн эрх

1.Хохирогч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад дараах эрхтэй:

- 1.1. өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх, хууль зүйн тусалцаа авах;
- 1.3. мөрдөн шалгах тодорхой ажиллагаа явуулах, нотлох баримт шалгуулах хүсэлт гаргах;
- 1.6. шүүх, прокурор, мөрдөгчийн ажиллагаа, шийдвэрт энэ хуульд заасан журмын дагуу гомдол гаргах;
- 1.7. эх хэлээрээ, эсхүл сайн мэдэх хэлээрээ мэдүүлэг өгөх, орчуулагч, хэлмэрч авах;
- 1.8. хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, мөрдөн байцаалт дууссан бол хавтаст хэргээс өөрт хамааралтай хэсэгтэй танилцах, нэмэлт ажиллагаа хийлгэх тухай хүсэлт гаргах;

1.9.гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг нэхэмжлэх, нөхөн төлүүлэх хүсэлт гаргах;

1.11.шүүгч, прокурор, мөрдөгч, орчуулагч, хэлмэрч, шинжээч, мэргэжилтэн, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах тухай хүсэлт гаргах;

1.12.эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүх, прокурор, мөрдөгчийн хууль зөрчиж учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх гомдол гаргах;

1. Орлогч улс бүр хүн худалдаалах хэргийн хохирогчдыг бие бялдар, сэтгэл зүй болон нийгэмд эзлэх байр суурийн хувьд нөхөн сэргээх арга хэмжээг, тухайлбал зохих тохиолдлуудад дор дурдсан арга хэмжээг засгийн газрын бус байгууллагууд, бусад холбогдох байгууллагууд болон иргэний нийгмийн бусад хэсэгтэй хамтран хэрэгжүүлэх асуудлыг авч үзнэ:

(а) зохих орон байраар хангах;

(б) хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод ойлгогдох хэлээр, ялангуяа хуулиар тогтоосон эрхийн талаар зөвлөгөө ба мэдээлэл өгөх;

(с) эмнэлгийн, сэтгэл зүйн ба материаллаг тусалцаа үзүүлэх хөдөлмөрлөх, боловсрол эзэмших болон суралцах бололцоогоор хангах.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйл. Хүн худалдаалахтай тэмцэх талаарх төрийн байгууллагын бүрэн эрх

5.1.Хүн худалдаалахтай тэмцэх талаар Засгийн газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.1.3.хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.2 дугаар зүйл.Хохирогчийн эрх

1.Хохирогч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад дараах эрхтэй:

1.1.өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах;

Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйл. Хамгаалалтад байгаа гэрч, хохирогчид үзүүлэх туслалцаа

18.1.Хамгаалалтад байгаа гэрч, хохирогчид дараах туслалцаа үзүүлж болно:

18.1.1.хууль зүйн туслалцаа;

18.1.2.сэтгэл зүйн туслалцаа;

18.1.3.эрүүл мэндийн туслалцаа.

18.2.Гэрч, хохирогчид энэ хуулийн 18.1.1, 18.1.2–т заасан туслалцаа болон гэмт хэргийн улмаас эрүүл мэнд нь хохирсон бол эрүүл мэндийн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлнэ.

18.3.Эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх журмыг эрүүл мэндийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

18.4.Энэ хуулийн 18.1.1–д заасан хууль зүйн болон 18.1.2–т заасан сэтгэл зүйн туслалцааг энэ хуулийн 23.4–т заасан нэгж тус тус хариуцан хэрэгжүүлнэ.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйл.Хохирогчид үзүүлэх халамж, үйлчилгээ

12.1.Хохирогчид дараах халамж, үйлчилгээг үзүүлнэ:

12.1.4.хууль зүйн туслалцаа;

12 дугаар зүйл.Хохирогчид үзүүлэх халамж, үйлчилгээ

12.1.Хохирогчид дараах халамж, үйлчилгээг үзүүлнэ:

12.1.1.эрүүл мэндийн нөхөн сэргээх эмчилгээ;

12.1.2.сэтгэцийн нөхөн сэргээх эмчилгээ;

9 дүгээр зүйл.Хамгаалах байр

9.1.Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нэр төр, алдар хүндийг хамгаалах, аюулгүй байдлыг нь хангах зорилгоор хамгаалах байр ажиллана.

9.5.Засгийн газрын шийдвэрээр хамгаалах байрны үйл ажиллагааг төрийн бус байгууллагад хариуцуулж болно.

12 дугаар зүйл.Хохирогчид үзүүлэх халамж, үйлчилгээ

12.1.Хохирогчид дараах халамж, үйлчилгээг үзүүлнэ:

12.1.3.ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах;

3.Оролцогч улс бүр энэхүү зүйлийн заалтуудыг хэрэгжүүлэхдээ хүн худалдаалах хэргийн хохирогчдын нас, хүйс ба тусгай хэрэгцээг, тухайлбал хүүхдийн тусгай хэрэгцээг, үүнд зохих орон байр, боловсрол болон асран халамжлахын асуудлыг харгалзан үзнэ.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийн 13 дугаар зүйл.Хохирогч хүүхдийг хамгаалах

13.1.Хүүхэд хохирогч болсон бол цагдаагийн байгууллага болон энэ хуулийн 9.1–д заасан хамгаалах байрны ажилтан нь түүний эцэг, эхийг нэн даруй олж тогтоох арга хэмжээ авна.

13.2.Хохирогч хүүхдийн эцэг, эхийг олж тогтоогоогүй тохиолдолд түүнийг асран хамгаалах, харгалзан дэмжих этгээдийг тухайн сум, дүүргийн Засаг дарга томилно.

13.3.Хохирогч хүүхдийг энэ хуулийн 9.1–д заасан хамгаалах байранд насанд хүрсэн хохирогчоос тусад нь байрлуулна.

13.4.Хохирогч хүүхдийг зохих шатны сургуульд хамруулах үүргийг тухайн сум, дүүргийн Засаг дарга хариуцна.

Оролцогч улс бүр хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нутаг дэвсгэрт нь байх хугацаанд тэдний биеийн аюулгүй байдлыг хангахыг эрмэлзэнэ.

Оролцогч улс бүр дотоодын хууль зүйн тогтолцооны хүрээнд хүн худалдаалах хэргийн хохирогчид учирсан хохиролдоо нөхөн төлбөр авах боломж олгож байх арга хэмжээг харгалзсан нөхцөлийг хангана.

<p>Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйл. Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох</p> <p>26.1.Гэмт хэргийн хохирогчид Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21³ дугаар зүйлд заасан журмын дагуу нөхөн төлбөр олгоно.</p>
<p>7 дугаар зүйл. Хүлээн авагч улс дахь хүн худалдаалах хэргийн хохирогчдын эрх зүйн байдал</p> <p>1.Оролцогч улс бүр энэхүү протоколын 6 дугаар зүйлийн дагуу арга хэмжээ авахын зэрэгцээ хүн худалдаалах хэргийн хохирогчид, зохих тохиолдолд, түүний нутаг дэвсгэрт нь түр буюу байнга байх бололцоо олгох талаар хууль тогтоох буюу бусад зохих арга хэмжээ авах асуудлыг авч үзнэ.</p> <p>Энэхүү протоколын 1 дүгээр зүйлд заасныг хэрэгжүүлэхдээ оролцогч улс бүр хүмүүнлэг ба нигүүлсэх хүчин зүйлийг зохих ёсоор харгалзан авч үзнэ.</p>
<p>Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийн 11 дүгээр зүйл.Гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг хамгаалах</p> <p>11.1.Гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон тохиолдолд түүнийг тус улсад зорчих, оршин суух, цагаачлах журам зөрчсөн гэсэн үндэслэлээр албадан гаргах арга хэмжээ авахыг хориглоно.</p> <p>11.2.Гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон тохиолдолд тухайн гэмт хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх хүртэл тус улсад оршин суух зөвшөөрлийг холбогдох байгууллагын саналыг үндэслэн гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, эсхүл гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгох буюу сунгана.</p>
<p>8 дугаар зүйл.Хүн худалдаалах хэргийн хохирогчдыг нутагт нь буцаах</p> <p>Оролцогч улс хүн худалдаалах хэргийн хохирогч нь түүний иргэн, эсхүл хүлээн авагч Оролцогч улсын нутаг дэвсгэрт орох үедээ байнгын оршин суугчийн эрхтэй байсан этгээд бол тухайн этгээдийг буцааж ирүүлэхэд туслалцаа үзүүлж, аюулгүй байдлыг нь хангах асуудлыг зохих ёсоор харгалзаж үзэн, учир шалтгаан буюу үндэслэл үгүйгээр үл хойшлуулан хүлээн авч байх болно.</p>
<p>Хүн худалдаалах хэргийн хохирогч нь иргэн нь, эсхүл хүлээн авагч оролцогч улсын нутаг дэвсгэрт орох үедээ байнгын оршин суугчийнх нь эрхтэй байсан этгээд болох оролцогч улсад уг этгээдийг оролцогч улс буцааж өгөх тохиолдолд ийнхүү буцаах үйлдлийг тухайн этгээдийн аюулгүй байдлыг хангах асуудлыг, түүнчлэн уг этгээд нь хүн худалдаалах хэргийн хохирогч болсонтой холбогдох аливаа шүүн таслах ажиллагааны шинж байдлыг зохих ёсоор харгалзан, аль болохоор сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлнэ.</p>
<p>Хүсэлт хүлээн авагч оролцогч улс нь хүн худалдаалах хэргийн хохирогч болсон этгээд түүний иргэн мөн болох, эсхүл хүлээн авагч оролцогч улсын нутаг дэвсгэрт орох үедээ нутагт нь байнга оршин суух эрхтэй байсан эсэхийг хүлээн авагч оролцогч улсын хүсэлтээр учир шалтгаан буюу үндэслэл үгүйгээр үл хойшлуулан шалгаж байх болно.</p>
<p>Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйл.Хүн худалдаалахтай тэмцэх талаарх төрийн байгууллагын бүрэн эрх</p> <p>5.1.Хүн худалдаалахтай тэмцэх талаар Засгийн газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>5.1.2.хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр гадаад улс, олон улсын байгууллагатай хамтран ажиллах;</p>
<p>Зохих баримт бичиггүй, хүн худалдаалах хэргийн хохирогчийг буцаахад тус дөхөм болох үүднээс уг этгээд иргэн нь, эсхүл хүлээн авагч Оролцогч улсын нутаг дэвсгэрт орох үедээ байнга оршин суугчийнх нь эрхтэй байсан этгээд болох оролцогч улс нь хүлээн авагч оролцогч улсын хүсэлтээр холбогдох этгээдэд өөрийнх нь нутаг дэвсгэрт буцаж ирэхэд нь шаардагдахуйц зорчин явах баримт бичиг буюу бусад зөвшөөрлийг олгож байхаар зөвшөөрч байгаа болно.</p>
<p>Энэ зүйл нь хүн худалдаалах хэргийн хохирогчдод хүлээн авагч оролцогч улсын дотоодын аливаа хууль тогтоомжоор олгосон аливаа эрхэд хохирол үл учруулна.</p>
<p>Энэ зүйл нь хүн худалдаалах хэргийн хохирогчдыг буцаах асуудлыг бүрэн буюу хэсэгчлэн зохицуулж буй аливаа хэрэглэхүйц хоёр буюу олон талын хэлэлцээр буюу тохиролцоонуудад хохирол үл учруулна.</p>

ПАЛЕРМОГИЙН ПРОТОКОЛЫН III. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТ, ХАМТЫН АЖИЛЛАГАА БОЛОН БУСАД АРГА ХЭМЖЭЭ
<p>9 дүгээр зүйл. Хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх</p> <p>1. Оролцогч улсууд дараах асуудлаар бүрэн цогц бодлого, хөтөлбөрүүд болон бусад арга хэмжээг тодорхойлно:</p> <p>(a) хүн худалдаалах хэргээс урьдчилан сэргийлэх ба түүнтэй тэмцэх;</p> <p>(b) хүн худалдаалах хэргийн хохирогчид, ялангуяа эмэгтэйчүүд ба хүүхдүүдийг дахин хэлмэгдэхээс хамгаалах.</p>
<p>Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйл. Хүн худалдаалахтай тэмцэх талаарх төрийн байгууллагын бүрэн эрх</p> <p>5.1. Хүн худалдаалахтай тэмцэх талаар Засгийн газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>5.1.1. хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах;</p> <p>2002 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн ЗГ-ын 274 дугаар тогтоолоор “Жендерийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр”-ийг 2003–2015 он хүртэл хэрэгжүүлжээ.</p> <p>2005 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн ЗГ-ын 234 дугаар тогтоолоор “Хүн худалдах ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг 2006–2014 он хүртэл хэрэгжүүлжээ.</p> <p>2012 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн ЗГ-ын 252 дугаар тогтоолоор “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөр”-ийг 2012–2016 он хүртэл хэрэгжүүлжээ.</p> <p>2015 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн Засгийн газрын 346 дугаар тогтоолоор 2016–2024 он хүртэл “Гэрч хохирогчийг хамгаалах, тусалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр” хэрэгжүүлж байна.</p> <p>2017 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн Засгийн газрын 148 дугаар тогтоолоор 2017–2021 он хүртэл “Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг баталж хэрэгжүүлэн ажиллаж байна.</p>
<p>2. Оролцогч улсууд хүн худалдаалах хэргээс урьдчилан сэргийлэх ба түүнтэй тэмцэх зорилгоор судалгаа олон нийтийн хэвлэл мэдээллийн компани ажил явуулах, түүнчлэн нийгэм, эдийн засгийн холбогдох санаачилгуудыг хэрэгжүүлэх зэрэг арга хэмжээ авахыг эрмэлзэнэ.</p>
<p>Хүн худалдаалах хэргээс урьдчилан сэргийлэх ба түүнтэй тэмцэх зорилгоор нийгэм, эдийн засгийн холбогдох санаачилгуудыг хэрэгжүүлэх зэрэг арга хэмжээ авах хүрээнд Монгол Улсын Улсын Их хурал болон Засгийн газраас олон талт арга хэмжээ авч байна.</p> <p>Тухайлбал, 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдөр Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль батлагдан 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөх бөгөөд тус хуулийн 12 дугаар зүйлд залуучуудын аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх үйл ажиллагааг чиглэлийг тодорхойлж, 17 зүйлд УИХ хурлаас залуучуудын хөгжлийн төрийг бодлогыг тодорхойлох, 18 дугаар зүйлд Засгийн газраас залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр, төлөвлөгөөг батлахаар тусгагдсан нь Палермогийн протоколын агуулгад нийцжээ.</p>
<p>3. Энэхүү зүйлийн дагуу тодорхойлсон бодлого, хөтөлбөрүүд болон бусад арга хэмжээ нь зохих нөхцөлд засгийн газрын бус байгууллагууд, бусад холбогдох байгууллага болон иргэний нийгмийн бусад хэсэгтэй хамтран ажиллах асуудлыг хамарна.</p>
<p>Батлагдсан гарсан хууль тогтоомж бүрд төрийн болон төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллага, олон нийт, иргэдтэй хамтран ажиллах талаар тусгасан байна.</p> <p>Тухайлбал, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 хэсэгт Залуучуудын хөгжлийн үндэсний болон салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийн байгууллага, залуучуудын иргэний нийгмийн байгууллага, залуучуудын төлөөллийг оролцуулахаас гадна 22.4.2 дахь заалтад залуучуудын хөгжлийг дэмжих, эрх ашгийг хамгаалах асуудлыг шийдвэрлэхэд залуучууд, залуучуудын иргэний нийгмийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагыг оролцуулах, гаргасан санаачилгыг дэмжих агуулга тусгагджээ.</p>
<p>4. Оролцогч улсууд хүн худалдаалахад хүргэж буй, хүн, ялангуяа эмэгтэйчүүд болон хүүхдүүдийг бүх хэлбэрээр мөлжих явдлыг бий болгодог эрэлт хэрэгцээний эсрэг чиглэсэн хууль тогтоох буюу боловсрол, нийгэм, соёлын гэсэн бусад арга хэмжээнүүдийг, тухайлбал, хоёр буюу олон талаар хамтран ажиллах замаар авах буюу боловсронгуй болгох болно.</p>
<p>Зар сурталчилгааны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.дах хэсэгт Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчих үйлдэл, үйл ажиллагаанд хүргэж болох эсхүл хүчирхийлэл, садар самуунд уруу татах, түүнчлэн хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд гэм хор учруулах үйлдэл, үйл ажиллагаанд хүргэж болох зар сурталчилгааг хориглосон байна.</p> <p>Садар самуунтай тэмцэх тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Энэ хуулийн зорилт нь садар самууныг сурталчлах, биеэ үнэлж явалдахтай тэмцэх болон эротик сурталчилгаа, үйлчилгээг журамлахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэж тодорхойлжээ.</p> <p>Донорын тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Энэ хуулийн зорилт нь бусдын эрүүл мэндийг сайжруулах, амь насыг аврахын тулд хүмүүнлэг сэтгэлээр сайн дураараа цус, эд эрхтнээ үнэ төлбөргүй өгөх, амьд болон амьгүй донорын эд, эрхтнийг шилжүүлэн суулгах зорилгоор авах, цус, цусан бүтээгдэхүүн, эд эрхтнийг эмчилгээний зориулалтаар хэрэглэхээр авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, хэрэглэх, экспортлох, импортлох, донорын үйлсийг сурталчлах, түүнд иргэдийг татан оролцуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэж тодорхойлжээ.</p> <p>Харьяатын тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Энэ хуулийн зорилт нь иргэний харьяалал хийгээд Монгол Улсын харьяат болох, иргэний харьяаллыг сэргээн тогтоох, харьяатаас гарахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэж тодорхойлжээ.</p>

5. Оролцогч улсууд хүмүүсийг, ялангуяа эмэгтэйчүүд болон хүүхдүүдийг хүн худалдаалах хэрэгт өртөмтгий болгож буй ядуурал, буурай хөгжил, тэгш бололцоогүй байх зэрэг хүчин зүйлийн нөлөөг бууруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг, тухайлбал, хоёр буюу олон талаар хамтран ажиллах замаар хэрэгжүүлэх буюу боловсронгуй болгох болно.

Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Энэ хуулийн зорилт нь улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд жендерийн эрх тэгш байдлыг хангах нөхцөл бүрдүүлэх эрх зүйн үндсийг тодорхойлж, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэж тодорхойлсон.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Энэ хуулийн зорилт нь хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлж, түүний төрөл, хэлбэр, хамрах хүрээ, санхүүжилт, хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын тогтолцоотой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэж тодорхойлжээ.

10 дугаар зүйл. **Мэдээлэл солилцоо болон сургалт**

1. Дараах зүйлийг тодорхойлон тогтоодог болох үүднээс Оролцогч улсуудын хууль сахиулах, цагаачлалын буюу бусад холбогдох байгууллагууд дотоодынхоо хууль тогтоомжийн дагуу зохих тохиолдолд нэг нэгэнтэйгээ мэдээлэл харилцан солилцох замаар хамтран ажиллана:

(а) зорчин явах баримт бичиггүйгээр буюу өөр этгээдийн зорчин явах баримт бичгээр олон улсын хилийг нэвтрэн өнгөрч буй буюу нэвтрэн өнгөрөхөөр завдаж буй хүмүүс нь хүн худалдаалагчид буюу хүн худалдаалах хэргийн хохирогчид болох эсэхийг;

(б) эдгээр хүмүүс хүн худалдаалах хэргээр олон улсын хил нэвтрэхийн тулд ашигласан буюу ашиглахаар завдсан зорчин явах баримт бичгийн төрлүүд;

(с) зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүд хүн худалдаалах зорилгоор ашиглаж буй хэрэгсэл ба аргууд, түүнчлэн хохирогчдыг урвуулан элсүүлэх ба тээвэрлэх, ийм худалдаа явуулж буй хүмүүс ба бүлэглэлүүд хоорондоо буюу дотроо харилцах зам чиглэл ба холбоо, мөн тэдгээрийг илрүүлэх боломж бүхий арга хэмжээ.

2. Оролцогч улсууд хууль сахиулах, цагаачлалын буюу бусад холбогдох байгууллагуудын ажилтнуудад хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх асуудлаар сургалт явуулах буюу эрчимжүүлэх болно. Сургалтыг хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх, худалдаа хийгчдийг мөрдөн мөшгөх, хохирогчдын эрхийг хамгаалах, түүнчлэн тэднийг худалдаа хийгчдээс хамгаалах арга хэлбэрийн асуудалд төвлөрүүлэх нь зохистой болно. Түүнчлэн сургалтын явцад хүний эрх, хүүхэд ба жендерт холбогдолтой эмзэг асуудлуудыг авч үзэх шаардлагыг анхаарах хэрэгтэй бөгөөд сургалт нь засгийн газрын бус байгууллагууд, бусад холбогдох байгууллага болон иргэний нийгмийн бусад хэсэгтэй хамтын ажиллагаа явуулахад тус дөхөм болох ёстой болно.

Мэдээлэл хүлээн авч буй оролцогч улс нь мэдээлэл өгсөн оролцогч улсын зүгээс мэдээллийг ашиглах талаар хязгаарлалт тавьсан аливаа хүсэлтийг биелүүлнэ.

11-р зүйл. **Хилийн хяналтын арга хэмжээ**

1. Хүмүүс чөлөөтэй шилжин явах талаар олон улсын хэмжээнд хүлээсэн үүргийн хувьд хохирол учруулахгүйгээр оролцогч улсууд хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх, түүнийг илрүүлэхэд шаардлагатай байж болох байдлаар хилийн хяналтыг боломжийн хирээр бэхжүүлнэ.

2. Оролцогч улс бүр энэхүү протоколын 5 дугаар зүйлийн дагуу тодорхойлсон гэмт хэргийг үйлдэхэд арилжааны тээвэрлэгчдийн ашиглалтад байгаа тээврийн хэрэгслүүдийг ашиглах явдлаас аль болохоор урьдчилан сэргийлэх талаар хууль тогтоох буюу бусад зохих арга хэмжээг авна.

3. Зохих тохиолдлуудад, хэрэглэгдэхүйц олон улсын конвенцүүдэд хохирол учруулахгүйгээр, эдгээр арга хэмжээний хүрээнд арилжааны тээвэрлэгчид, тухайлбал аливаа тээврийн компани буюу аливаа тээврийн хэрэгслийн эзэмшигч буюу операторт бүх зорчигчид нь хүлээн авагч Улсад нэвтрэн ороход шаардагдах зорчин явах баримт бичигтэй гэдгийг тогтоож байх үүргийг хүлээлгэнэ.

4. Оролцогч улс бүр энэхүү зүйлийн 3 дахь хэсэгт заасан үүргийг зөрчсөн тохиолдолд хариуцлагын арга хэмжээ оногдуулж байх талаар дотоодынхоо хууль тогтоомжийн дагуу шаардагдах арга хэмжээг авна.

5. Оролцогч улс бүр энэхүү протоколоор тодорхойлсон гэмт хэргийг үйлдэхэд оролцсон этгээдэд нэвтрэн орохыг нь татгалзах буюу визийг нь хүчингүй болгохыг дотоодынх нь хууль тогтоомжийн дагуу зөвшөөрч байх талаар арга хэмжээ авах асуудлыг авч үзнэ.

6. Конвенцийн 27 дугаар зүйлд хохирол учруулахгүйгээр оролцогч улсууд хилийн хяналтын байгууллагуудын хоорондын хамтын ажиллагааг, тухайлбал, шууд холбоотой байх сувгуудыг бий болгож, ажиллуулах замаар бэхжүүлэх асуудлыг авч үзнэ.

12 дугаар зүйл. **Баримт бичгийн баталгаа болон хяналт**

Оролцогч улс бүр байгаа бололцооныхоо хэмжээнд:

(а) түүний олгож буй зорчин явах буюу хувийн баримт бичгүүд нь тэдгээрийг зүй бусаар хялбар ашиглаж чадахааргүй, хуурамчаар чөлөөтэй үйлдэх буюу хууль бусаар өөрчлөх, хуулбарлах буюу олгох боломжгүй байхаар тийм чанартай байх явдлыг хангахад, болон

(б) түүний буюу түүний нэрийн өмнөөс олгож буй зорчин явах буюу хувийн баримт бичгүүд нь бүрэн бүтэн, баталгаатай байх явдлыг хангахад, тэдгээрийг хууль бусаар үйлдэх, олгох ба ашиглахаас урьдчилан сэргийлэхэд шаардлагатай байж болох тийм арга хэмжээнүүдийг авна.

13 дугаар зүйл. **Баримт бичнүүд нь хууль ёсны бөгөөд хүчинтэй байх**

Оролцогч улс нь түүний нэрийн өмнөөс олгосон буюу олгосон гэгдэж буй, хүн худалдаалах хэргээр ашиглагдаж байгаа гэсэн сэжиг бүхий зорчин явах буюу хувийн баримт бичгүүд нь хууль ёсны бөгөөд хүчинтэй эсэхийг өөр оролцогч улсын хүсэлтээр боломжийн хугацаанд дотоодын хуулийн дагуу шалгана.

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ТАЛААРХ СУРГАЛТЫН ГАРЫН АВЛАГА, БҮТЭЭЛҮҮДИЙН ХАРЬЦУУЛАЛТЫН ХАВСРАЛТ

Нэг. Харьцуулалт хийхэд ашигласан сургалтын гарын авлага, бүтээлийн жагсаалт

1. Хууль зүйн яам, АНУ–ын Азийн сан, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхэд мөрдөн байцаагчдын ур чадварыг дээшлүүлэх модуль сургалтын гарын авлага, УБ.,2015.
2. АНУ–ын Азийн сан, Хүйсийн тэгш эрхийн төвийн хамтын бүтээл, Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь, сургагч багшийн гарын авлага
3. АНУ–ын Элчин сайдын яам, АНУ–ын Азийн сан, Дэлхийн зөн ОУБ–ын хамтын бүтээл, Монгол Улсад хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх нь асуудал ба арга зам
4. Австралийн хөгжлийн агентлаг, Хүйсийн тэгш эрхийн төвийн хамтын бүтээл, Бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэргийн хохирогчид туслалцаа үзүүлэх гарын авлага, УБ.,2016.
5. Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам, НҮБ–ын Хүүхдийн сан, Хүйсийн тэгш эрхийн төв, Цагдаагийн академи, Хилийн цэргийн дээд сургуулийн хамтын бүтээл, Хүн худалдаалах гэмт хэрэг /суралцагсдын гарын авлага/, УБ.,2009.
6. Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам, НҮБ–ын Хүүхдийн сан, Хүйсийн тэгш эрхийн төв, Цагдаагийн академи, Хилийн цэргийн дээд сургуулийн хамтын бүтээл, Хүн худалдаалах гэмт хэрэг /сургагч багшийн гарын авлага/, УБ.,2009.
7. Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хүйсийн тэгш эрхийн төв, Швейцарын хөгжлийн агентлаг, Хүний аюулгүй байдлын судалгааны төвийн хамтын бүтээл, Хүн худалдаалах гэмт хэргийн шийдвэрлэлт–судалгааны тайлан, УБ.,2009.
8. Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хүний аюулгүй байдлын судалгааны төвийн хамтын бүтээл, Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэхэд зар сурталчилгаа нөлөөлж байгаа байдал /судалгааны тайлан/, УБ.,2010.
9. Хүйсийн тэгш эрхийн төв, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх гарын авлага /Цагдаа, хилийн шалган нэвтрүүлэх албаны ажилтнуудад зориулав/, УБ.,2011.
10. Хүйсийн тэгш эрхийн төв, Хүний аюулгүй байдлын судалгааны төвийн хамтын бүтээл, Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн зураглал, УБ.,2012.
11. Хүүхдийн төлөө газар, Хүйсийн тэгш эрхийн төвийн хамтын бүтээл, Хүүхэд худалдаалах гэмт хэрэг /нийгмийн ажилтнуудад зориулсан гарын авлага/, УБ.,2012.
12. Ж.Нямдулам, С.Гантулга, О.Амарсайхан, Л.Бат–Очир, Э.Золбоо, Б.Мөнхзул нарын хамтын бүтээл, Хүний эрх, эрх чөлөө, албар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэг, УБ.,2014.
13. С.Гантулга, Хүн худалдаалах гэмт хэрэг, УБ.,2008.
14. С.Гантулга, Хүн худалдаалах гэмт хэрэг, УБ.,2013.
15. С.Гантулга, Хүн худалдаалах гэмт хэрэг, УБ.,2015.
16. С.Ю.Журавлев нарын хамтын бүтээл, Хүн худалдаалах гэмт хэрэг мөрдөх ажиллагааны арга зүй, тактик /орчуулгын бүтээл/ УБ.,2012.
17. Олон улсын шилжин суурьшлын байгууллага, Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх шууд тусламжийн гарын авлага
18. Хүний эрх Хөгжил Төв. Хүн худалдаалах гэмт хэргийн асуудлаар ажилладаг хуулийн байгууллагын ажилтнуудад зориулсан гарын авлага. УБ., 2009 он.
19. Хүний аюулгүй байдлын судалгааны төв. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбогдуулан үндэсний хууль тогтоомжид хийсэн судалгааны тайлан. УБ., 2010 он.
20. Азийн сан, Хууль зүйн үндэсний хүрээлэн. Хүн худалдаалах гэмт хэрэг. Шүүгч, прокурорт зориулсан гарын авлага. УБ., 2011 он.
21. Хүйсийн тэгш эрхийн төв. Тодорхой төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны өртөг: Хүн худалдаалах гэмт хэргийн жишээн дээр. УБ., 2016 он.

Хоёр. Сургалтын гарын авлага, судалгааны тайлангийн үндсэн агуулга:

№	Зохиогч	Номын нэр	Агуулга
1.	АНУ-ын Элчин сайдын яам, АНУ-ын Азийн сан, Дэлхийн зөн ОУБ-ын хамтын бүтээл	Нэг: Ерөнхий бүтээлүүдийн тухай /нийтийн хүртээл болсон бүтээл, судалгааны ажил/	<p>Уг судалгааны бүтээл нь ХХГХ-ийн чиглэлээр боловсруулсан анхдагч судалгааны тайлан бөгөөд Монгол Улсад уг гэмт хэрэг үйлдэгдэж буй нөхцөл байдлыг жишээ баримтад тулгуурлан авч үзсэн онцлогтой. ХХГХ-тэй тэмцэхэд анхаарал хандуулах шаардлагатай хүчин зүйлсийг тоочин гаргаж, тэдгээрт дүгнэлт хийсэн нь уг судалгааны ажил нэлээд ач холбогдолтой болжээ. Хэдийгээр ХХГХ-ийн бүхий л нөхцөл байдлыг иж бүрэн судлаагүй боловч анхдагч судалгаа учир түүний дотор агуулагдаж байгаа мэдээлэл, судалгааны дүгнэлтүүд үнэ цэнэтэй гэдэг нь ойлгомжтой байна. Тухайлбал: эмэгтэйчүүд ХХГХ-т өртөх эрсдэлтэй байгааг бататгах зорилт бүхий 18 судалгааны асуултын хүснэгтээс үзвэл нэлээн чамбай судалгаа болжээ. Энэ нь хохирогчоор дамжуулан уг гэмт хэрэгтэй тэмцэх механизмыг боловсронгуй болгох шинэлэг ололтой судалгааны асуулта гэж үзэж байна. Судалгааг хийхдээ хохирогчийн боловсрол, нас, амьдардаг газар, хаана ямар ажил хийдэг тухай, гэр бүл, гэрлэлтийн байдал, шилжилт хөдөлгөөн зэргийг нарийвчлан авч чадсан нь судалгааны тайлан зохих хэмжээнд сайн боловсруулагдсан гэдгийг илтгэн харуулж байна. Энэ нь ХХГХ-тэй тэмцэх гол чиглэлийг боловсруулахад нэн чухал болно.</p> <p>Хуулийн болон хууль сахиулах байгууллагын зүгээс ХХГХ-тэй тэмцэхэд чухам ямар асуудал тулгарч байгааг харуулах зорилгоор бүлгийн ярилцлага хийх асуултын жагсаалт гаргах зэргээр судалгааны тайлан гарчээ.</p> <p>Судалгааны тайлангийн нэгтгэл нь ХХГХ-ийн ойлголт, эрүүгийн эрх зүйн шинж гэж авч үзэхээсээ шууд баримтад мэдээлэл дүн шинжилгээ хийх, судалгааны эх сурвалж болох хүнтэй шууд харилцах, бодит нөхцөл байдлыг шууд илтгэн бичих байдлаар боловсруулагдсан байна. Тухайлбал: Монгол эмэгтэйчүүдийг худалдсан /хохилогчдын гашуун туршлага/ тухай бүлэг нь ХХГХ-ийн хохирогчтой шууд холбоо тогтоож ярилцлага хийх, уг гэмт хэрэг хэрхэн үйлдэгдэж, ямар үе шаттай явагдсан зэрэг нийтлэг зүй тогтлыг нь авч үзсэн байна.</p> <p>Мөн ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх талаар авч үзэхдээ голчлон хэн элсэх бололцоотой вэ? гэсэн хамгийн оновчтой асуултыг тавьж түүний шалтгааныг олж илрүүлснээр энэ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндсэн чиглэлийг тов тодорхой гаргаж өгчээ.</p> <p>Уг судалгааны бүтээл нь хэдийгээр дээр дурдсан онцлогтой хэдий ч зарим агуулгаараа бусад бүтээл, судалгааны тайлангаас дутмаг зүйлс байгаа юм. Тухайлбал: Мөрдөн шалгах ажиллагааны онцлог, шүүн таслах ажиллагааны онцлог, энэ гэмт хэрэгтэй тэмцэх бусад механизмыг иж бүрэн авч үзээгүй гэх үндэслэл бүхий байна. Нийтлэг агуулгаараа бусад ном, гарын авлагад байгаа зарим хэсэгтэй давхцах зүйл харьцангуй бага байгаа нь ажиглагдаж байна.</p> <p>Уг судалгааны бүтээлээс ХХГХ-ийн талаар мэдээлэл авах боломжтойн дээр бичилт, найруулга зүй талаасаа хэрэглэхэд хялбар, ойлгомжтой, зарим судалгаа нь уг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийн мэдээлэл нэмэлтээр авах боломжтой.</p>

2.	Хууль зүйн яам, АНУ–ын Азийн сан	Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхэд мөрдөн байцаагчдын үр чадварыг дээшлүүлэх модуль сургалтын гарын авлага	<p>Хууль зүйн яам, АНУ–ын Азийн сангаас хамтран Монгол улсад хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааг хэрэгжүүлж буй мөрдөн байцаагчдын үр чадварыг дээшлүүлэх сургалтад зориулсан энэхүү гарын авлага нь 6 модуль хэсгээс бүрдэх дараах агуулгатай байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> – Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг таних, тэдэнтэй харьцах хэсэгт худалдагдсан хохирогчийн гэмтлийн нөлөөлөл ба үр дагаврууд, ярилцлага, авагч ба мөрдөн байцаагчийн нөлөөлөл, гэмтлийн үр дагаврыг удирдах гол хүчин зүйлүүд, хохирогчийг таньж олон ажиллагааны 4 үе шат, худалдагдсан хохирогчидтой харилцах, тэдгээрийн хэрэгцээг тодорхойлох тухай; – Урьдчилсан мөрдөн байцаалт хэсэгт урьдчилсан мөрдөн шалгалт, урьдчилсан мөрдөн шалгах аргыг сонгох, энэ ажиллагааны үр дүн, үйл ажиллагааны үндэслэл, мөрдөн шалгах үйл ажиллагааны гол цэг, мөрдөн шалгах ажиллагаа дахь хамтын ажиллагааны тухай; – Таслан зогсоох арга хэсэгт таслан зогсоох арга техниктэй холбоотой үндсэн асуудлууд, таслан зогсоох арга техникийн зорилт, таслан зогсоох арга техникийн ашиглах, байгууллага хоорондын хамтын ажиллагаа, таслан зогсоох арга техникийн тэргүүн туршлага, энэ үйл ажиллагааг явуулахад анхаарах асуудал зэргийг; – Эрүүгийн хэрэгт холбоотой гүйцэтгэх ажлын мэдээлэл цуглуулах–урьдчилсан мөрдөн шалгах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх нь хэсэгт урьдчилсан операцыг төлөвлөх, хүн худалдаалахтай холбоотой мэдээлэл цуглуулах арга зүй, мэдээллээ боловсруулах, ашиглах, байгууллагын болон байгууллагын бус мониторинг зэрэг агуулгыг; – Баривчлах, түр саатуулах хэсэгт төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус процессын ажиллагаа, баривчлах, аврах, нэгжлэг хийх, хураан авах ажиллагаа, орон байранд нэвтрэн орох, баривчлах, саатуулах ажиллагааны тухай; – Баривчлан саатуулсны дараах үе шат хэсэгт хүн худалдаалах гэмт хэргийн нотолгоо, нотлох баримтын ойлголт, эх сурвалж, нотолгооны төрөл, баримтжуулалт зэрэг агуулгыг тусгажээ. <p>Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр гарсан энэхүү сургалтын гарын авлага нь модуль сургалтын арга зүйд тулгуурлан бичигдсэн, ашиглагдаж буй эх материалыг дасгал, дадлагын ажлаар баталгаажуулан эзэмшсэн мэдлэгээ практикт ашиглах боломжийг бүрдүүлсэн байна.</p>
----	----------------------------------	--	--

	<p>АНУ–ын Азийн сан, Хүйсийн тэгш эрхийн төвийн хамтын бүтээл</p>	<p>Хүн худалдах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь, сургагч багшийн гарын авлага</p>	<p>Энэхүү сургалтын гарын авлага нь 7 бүлэг, 2 хавсралттай бөгөөд дараах агуулгуудыг багтаажээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> – Хүн худалдах гэмт хэргийн ойлголт хэсэгт Хүн худалдах гэмт хэрэгтэй тэмцэж ирсэн уламжлал, хүн худалдах гэмт хэргийн ангилал, Монгол улс дахь нөхцөл байдал, эрх зүйн зохицуулалтын тухай; – Хүн худалдах гэмт хэрэг үйлдэгдэх үйл явц хэсэгт хүн худалдах гэмт хэргийн үе шат болон элсүүлэлт, тээвэрлэлт, худалдагдах гэсэн үе шатуудын талаар ; – Хүн худалдах гэмт хэрэг хэсэгт хүн худалдах гэмт хэргийн төрөл, хэлбэр, зорилго, арга замын тухай; – Хүн худалдах гэмт хэргийн шалтгаан нөхцөл хэсэгт энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэж буй нөхцөл, шалтгаан, эмэгтэйчүүд хүн худалдах гэмт хэрэгт өртөмтгий байх шалтгаануудын талаар ; – Хүний наймаа ба хууль бусаар хил давуулах хэсэгт хүнийг хууль бусаар хил давуулах болон хүн худалдах гэмт хэргийн ялгагдах шинж, онцлогийн тухай; – Хохирогчийн тухай хэсэгт хохирогчийн эрх, үүрэг, хүн худалдах гэмт хэргийн хандлага, хэмжигдэхүүний талаар тус тус авч үзжээ. <p>Сургагч багшийн гарын авлагад ойлголт, нэр томъёоны тайлбар, түгээмэл асуулт, хариулт, хүн худалдах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр гарсан үндэсний хөтөлбөр, олон улсын гэрээ, протоколыг хавсаргасан нь гарын авлагыг ашиглах багшлах бүрэлдэхүүнд чухал хэрэгцээтэй болжээ.</p> <p>Түүнчлэн сургалт зохион байгуулах цаг сэдвийн төлөвлөгөө, хичээлийг явуулах хэлбэр, зорилго, агуулга, бодлого, сорил, кейс, ярилцлагын болон хяналтын асуулт, ашиглах материалын жагсаалт бүхий сургалтын төлөвлөгөөг боловсруулан, хичээлийн агуулгыг гарын авлагад тусгасан нь Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам, НҮБ–ын Хүүхдийн сан, Хүйсийн тэгш эрхийн төв, Цагдаагийн академи, Хилийн цэргийн дээд сургуулийн хамтын бүтээл Хүн худалдаалах гэмт хэрэг–сургагч багшийн гарын авлагаас ялгаатай болсон байна. Гарын авлагыг бичихдээ бакалаврын хөтөлбөрийн агуулгын багтаамж, загварын дагуу бичсэн нь сургагч багш нарт зориулагдсан, сургалтыг чанартай, үр дүнтэй зохион байгуулахад нэлээдгүй ач холбогдолтой болсон гэж үзэх үндэслэлтэй байна.</p>
	<p>Австралийн хөгжлийн агентлаг, Хүйсийн тэгш эрхийн төвийн хамтын бүтээл</p>	<p>Бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэргийн хохирогчид туслалцаа үзүүлэх гарын авлага</p>	<p>Уг гарын авлага нь арван нэгэн бүлэг, дэд хэсгээс бүрдэнэ. Уг гарын авлагад хэдийгээр ХХГХ–ийн шинж, онцлог нөхцөл байдлын талаар авч үзээгүй боловч хохирогчид зөвлөх, туслалцаа, дэмжлэг үзүүлэх талаар нарийвчлан авч үзсэн байна. Хүчирхийлэл түүний шалтгаан нөхцөл, хэлбэр, төрөл, хохирогчид тусламж үзүүлэх, ижил хүйстнүүдийн дундах хүчирхийлэл гэх зэргээр судалгаа хийсэн байна.</p> <p>ХХГХ–ийн улмаас хохирсон хүн хүчирхийлэлд өртсөн байх эрсдэл ихтэй тул уг гарын авлагаас хохирогч, холбогдогч тэдгэртэй хэрхэн харилцах талаар мэдээлэл авч болох юм.</p> <p>Бусад бүтээлээс ялгаатай тал нь хүчирхийлэл түүний төрөл, хэлбэрийн талаар илүү дэлгэрэнгүй авч үзсэн байгаагаараа ялгагдах онцлогтой болжээ.</p>

5.	<p>Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам, НУБ-ын Хүүхдийн сан, Хүйсийн тэгш эрхийн төв, Цаг даагийн академи, Хилийн цэргийн дээд сургуулийн хамтын бүтээл</p>	<p>Хүн худалдаалах гэмт хэрэг /суралцагсдын гарын авлага/</p>	<p>Энэхүү бүтээл нь 3 бүлэг, 13 дэд хэсгээс бүрдсэн, Хүн худалдаалах гэмт хэргийн чиглэлээр суралцагчдад зориулсан сургалтын анхдагч гарын авлагад дараах агуулгуудыг тусгажээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Хүн худалдаалах гэмт хэргийн тухай ойлголт, түүнтэй хийх олон улсын тэмцэл, кримнологийн асуудал хэсэгт Хүний наймааны түүх, түүнтэй тэмцэх олон улсын жишиг, Хүн худалдаалах гэмт хэргийн онцлог, кримнологийн шинжийн тухай; - Хүн худалдаалах гэмт хэргийн эрх зүйн шинж хэсэгт Хүн худалдаалах гэмт хэргийн шинж, үндсэн, хүндрүүлэх, онц хүндрүүлэх бүрэлдэхүүний асуудал, ижил төстэй гэмт хэргээс ялган зүйчлэх, энэ төрлийн гэмт хэргийн талаар олон улсын хууль тогтоомжид хуульчилсан байдлыг харьцуулан судлах тухай; - Хүн худалдаалах гэмт хэргийг нотлох ажиллагаа хэсэгт Хүн худалдаалах гэмт хэргийн нотлох баримт, нотлогдвол зохих нөхцөл байдлуудын харилцан хамаарал, эрүүгийн хэрэг үүсгэх үе шатанд Хүн худалдаалах гэмт хэргийн шинжийг илрүүлэх, тогтоох ажиллагаа, мөрдөн байцаалтын үе шатанд Хүн худалдаалах гэмт хэргийг нотлох ажиллагааны онцлог, эрүүгийн процессын ажиллагаа дахь хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааны талаар тус тус дэлгэрэнгүй бичжээ. <p>Сургалтын гарын авлагад онолын мэдлэг олгох үндсэн мэдээллээс гадна олон улсын гэрээ, конвенцүүдийн зохицуулалт, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын хууль тогтоомжийн харьцуулалт зэргийг дэлгэрэнгүй бичиж, судалгааны материал ашиглан асуудлыг тодорхойлон тусгасан нь суралцагчид энэ төрлийн гэмт хэргийн талаар нэлээн дэлгэрэнгүй ойлголттой болох, хүний наймаатай үр дүнтэй тэмцэл явуулах, уг үзэгдлийн мөн чанар, хор уршгийг сайтар ойлгох, тэмцэх арга зүй, ур чадвар эзэмшүүлэх өндөр ач холбогдолтой болох нь ажиглагдаж байна.</p>
6.	<p>Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам, НУБ-ын Хүүхдийн сан, Хүйсийн тэгш эрхийн төв, Цаг даагийн академи, Хилийн цэргийн дээд сургуулийн хамтын бүтээл</p>	<p>Хүн худалдаалах гэмт хэрэг /сургагч багшийн гарын авлага/</p>	<p>Энэхүү бүтээл нь 3 бүлэг, 13 дэд хэсгээс бүрдсэн, Хүн худалдаалах гэмт хэргийн чиглэлээр сургалт явуулах сургагч багш нарт зориулагдсан анхдагч гарын авлагуудын нэг юм. Сургагч багш нарын гарын авлагад дараах агуулгуудыг тусгажээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Хүн худалдаалах гэмт хэргийн тухай ойлголт, түүнтэй хийх олон улсын тэмцэл, кримнологийн асуудал хэсэгт Хүний наймааны түүх, түүнтэй тэмцэх олон улсын жишиг, Хүн худалдаалах гэмт хэргийн онцлог, кримнологийн шинжийн тухай; - Хүн худалдаалах гэмт хэргийн эрх зүйн шинж хэсэгт Хүн худалдаалах гэмт хэргийн шинж, үндсэн, хүндрүүлэх, онц хүндрүүлэх бүрэлдэхүүний асуудал, ижил төстэй гэмт хэргээс ялган зүйчлэх, энэ төрлийн гэмт хэргийн талаар олон улсын хууль тогтоомжид хуульчилсан байдлыг харьцуулан судлах тухай; - Хүн худалдаалах гэмт хэргийг нотлох ажиллагаа хэсэгт Хүн худалдаалах гэмт хэргийн нотлох баримт, нотлогдвол зохих нөхцөл байдлуудын харилцан хамаарал, эрүүгийн хэрэг үүсгэх үе шатанд Хүн худалдаалах гэмт хэргийн шинжийг илрүүлэх, тогтоох ажиллагаа, мөрдөн байцаалтын үе шатанд Хүн худалдаалах гэмт хэргийг нотлох ажиллагааны онцлог, эрүүгийн процессын ажиллагаа дахь хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааны талаар тус тус дэлгэрэнгүй бичжээ. <p>Сургагч багшийн гарын авлагад цагдаа, хилийн цэргийн алба хаагч, сонсогчдод сургалт явуулахад анхаарах асуудал, сургагч багш сургалтыг зохион байгуулахдаа анхаарах асуудлуудын талаар оруулсан нь бусад гарын авлагаас ялгагдах онцлог болжээ.</p> <p>Түүнчлэн сургалт зохион байгуулах цаг сэдвийн төлөвлөгөө, хичээлийг явуулах хэлбэр, зорилго, агуулга, бодлого, сорил, кейс, ярилцлагын болон хяналтын асуулт, ашиглах материалын жагсаалт бүхий сургалтын төлөвлөгөөг боловсруулсан нь энэ гарын авлагын ач холбогдлыг илэрхийлж байна.</p>

7.	<p>Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хүйсийн тэгш эрхийн төв, Швейцарын хөгжлийн агентлаг, Хүний аюулгүй байдлын судалгааны төвийн хамтын бүтээл</p>	<p>Хүн худалдаалах гэмт хэргийн шийдвэрлэлт – судалгааны тайлан</p>	<p>Судалгааны тайлан нь 3 бүлэг, хавсралтаас бүрдэнэ. Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хөтөлбөрийн хүрээнд Хүйсийн тэгш эрхийн төвийн захиалгаар Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн судалгааны баг энэхүү судалгааг хийж гүйцэтгэсэн байна.</p> <p>ХХГХ–ийн шийдвэрлэлт Монгол Улсад 2002–2007 онд хэрхэн шийдвэрлэсэн тухай судалгааны тайлан нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн практикт онцгой ач холбогдолтой. Уг тайлан нь Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйл, 124 дүгээр зүйлд заасан эрүүгийн хэргийн судалгаа юм. Үндсэндээ ХХГХ–ийн үндсэн ойлголт, түүний төрөл, хэлбэр, үйлдлийн арга зэргийг онолын түвшинд нарийн судлаагүй боловч, дурдан байгаа хугацаанд үйлдэгдсэн эрүүгийн хэргийн материалыудыг судлах, ЦЕГ –ын статистик, мэдээ баримтууд болон шүүхээр шийдвэрлэсэн хэргийн тоо зэрэгт үндэслэн тайлагнасан судалгааны эмхэтгэл болсон.</p> <p>Судалгааны тайлангийн хавсралтад хууль зүйн ухааны докторуудаар дүгнэлт, санал хийлгэсэн нь түүний агуулга, мөн чанар, ач холбогдлыг нэмэгдүүлж байна. Өөрөөр хэлбэл эрдэмтдээс өгсөн дүгнэлт, саналууд нь ХХГХ–ийн нөхцөл байдлыг тодорхойлох, эрүүгийн эрх зүйн болон бусад шинжийг онолын үүднээс товч авч үзсэн зэрэг онцлогтой. Энэ нь бусад судалгааны бүтээлд төдий л дурдагдаагүй болохыг тэмдэглэх нь зүйтэй.</p>
8.	<p>Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хүний аюулгүй байдлын судалгааны төвийн хамтын бүтээл</p>	<p>Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэхэд зар сурталчилгаа нөлөөлж байгаа байдал /судалгааны тайлан/</p>	<p>Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хүний аюулгүй байдлын төв төрийн бус байгууллагаас хамтран явуулсан Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэхэд зар сурталчилгаа нөлөөлж байгаа байдлын талаарх судалгааны тайлан нь судалгааны хэрэгцээ шаардлага, зорилго, зорилт, судалгааны арга зүй, судалгааны үр дүн, хүн худалдаалах гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх зар сурталчилгааны эрх зүйн орчин, энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэхэд зар сурталчилгааны үзүүлж буй нөлөө, нөхцөл байдлуудын талаар дэлгэрэнгүй тусгажээ.</p> <p>Судалгаанд 2004–2007 онд улсын хэмжээнд шийдвэрлэгдсэн Хүн худалдаалах гэмт хэргийн шийдвэрлэсэн байдал, 2006–2008 онд Нийслэлийн хэмжээнд шүүхээр шийдвэрлэгдсэн иргэний хэрэг, урьд нь хийгдэж байсан /2010 оноос өмнө/ судалгаа, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр түгээгдсэн мэдээ, мэдээлэл зэргийг судалж, зар сурталчилгааны харилцааг зохицуулж буй эрх зүйн баримт бичгийн давхардал, хийдэл, уялдаа холбоог тогтоож, уулзалт ярилцлага хийх, асуулга авч, хууль бус зар сурталчилгааны өнөөгийн нөхцөл байдлыг тогтоохоор телевиз, чатаар мессеж илгээх, сонинд зар өгөх зэрэг туршилтын аргуудыг ашиглажээ.</p>

		<p>Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх гарын авлага /Цагдаа, хилийн шалган нэвтрүүлэх албаны ажилтнуудад зориулав/</p>	<p>Уг гарын авлага нь таван бүлэг, 28 дэд хэсэгтэй, ХХГХ-ийн ойлголт, түүний түүхтэй холбоотой асуудал хийгээд хууль тогтоомжийг хэрхэн тусгасан, ХХГХ-ийн талаар мэдээлэл авсан нөхцөлд цагдаа, хилийн шалган нэвтрүүлэх албанаас явуулах үйл ажиллагааны талаар авч үзсэн шинэлэг хэлбэртэй бүтээл болсон юм.</p> <p>Бүтээлд тусгалаа олсон дурдан байгаа онцлог нэг бүрийг энд авч үзэхгүй. Гэвч бусад бүтээлд байхгүй онцгой агуулгыг дараах байдлаар цохон тэмдэглэх нь зүйтэй. Үүнд:</p> <p>а/ Түүхэнд ХХГХ-ийн талаар хэрхэн тэмдэглэгдэн үлдсэн талаар маш товчоор авч үзсэн нь тохиолдоно. Энэ нь бусад ном, гарын авлагад /Монгол Улс дахь ХХГХ-ийн зураглал бүтээлд/ тусгалаа олсон хэдий ч зориулалтын ялгаатай байдлаас шалтгаалан ийнхүү оруулж өгсөн нь онцгой ач холбогдолтой болжээ. Гарын авлага хэрэглэх субьект нь цагдаа, хилийн шалган нэвтрүүлэх албаны алба хаагчид байх учир үндсэн ойлголтыг өгөх зайлшгүй шаардлагаар нөхцөлдсөн гэж үзэж байна. Хил, цагдаагийн алба хаагч хуулиар хүлээн үүргээ гүйцэтгэхдээ ХХГХ-ийн талаар мэдээлэл авсан, өөрөө илрүүлсэн бол ямар ажиллагаа явуулах боломжтойг уг бүтээлд түлхүү оруулж өгсөн. Түүнчлэн үүргээ гүйцэтгэхэд нь шаардлагатай эрх зүйн актуудыг хавсралтаар оруулж өгсөн нь сайшаалтай болжээ.</p> <p>б/ Практик байгууллагуудын ажилтнуудад зориулсан ХХГХ-ийг тодорхойлох дасгал ажлуудыг жагсаасан нь бүтээлийн давуу тал болжээ. Өөрөөр хэлбэл цагдаа, хилийн алба хаагч бие даан ажиллах, ХХГХ-ийн шинжийг тодорхойлох боломж бүрдсэн байна.</p> <p>в/ ХХГХ-ийн төрөл, хэлбэрүүдийн талаар мөн товч мэдээлэл агуулсан бүтээл болсон. Энэ нь тодорхой жишээ, баримтад тулгуурласан байгаа нь хэрэглэхэд хялбар байх нөхцөл боломжийг бүрдүүлсэн байна.</p> <p>г/ Эрүүгийн хэрэгт харилцан туслалцаа үзүүлэх талаар мөн уг бүтээлд тусгаж өгсөн нь онцгой ач холбогдолтой. Учир нь ХХГХ улс үндэстэн дамжиж үйлдэгддэг тул уг агуулгыг оруулсан нь нэлээд чухал. Түүнчлэн цагдаа, хилийн албан тушаалтнууд энэ талаар зохих мэдлэгтэй болох нь зайлшгүй шаардлагатай учир уг бүтээлд энэ тухай авч үзсэн байна.</p> <p>д/ ХХГХ-ийн шинжийг илрүүлсэн тохиолдолд эрүүгийн процессыг хэрхэн явуулах, тодорхой ажиллагааны талаар дурдсан байна. Хэдийгээр тактикийн шижтэй ажиллагааны талаар дэлгэрэнгүй авч үзээгүй боловч энэ нь бүтээлийн үндсэн зорилтоос харахад төдий л ач холбогдолтой биш байна.</p> <p>Уг бүтээл нь бусад бүтээлтэй харьцуулахад товч, тодорхой болжээ. Хэдийгээр зарим агуулга, нэр томъёоны тодорхойлолт давхцаж буй боловч энэ нь бидний үзэж байгаагаар бүтээлийн зориулалтаас шалтгаалсан гэдгийг тэмдэглэсэн.</p>
<p>9.</p>	<p>Хүйсийн тэгш эрхийн төв</p>	<p>Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн зураглал</p>	<p>Уг бүтээл нь таван бүлэгтэй, дэд хэсгүүдээс бүрдэнэ. ХХГХ-ийн зураглал нь уг бүтээлээс тодорхой харагдаж байгаа хэдий ч агуулгад байгаа мэдээлэл нь бусад бүтээлтэй нэлээд давхцаж байгаа нь ажиглагдана. Статистик мэдээлэл нь шинэлэг байгааг дурдах нь зүйтэй.</p> <p>Уг бүтээлд байгаа олон тооны зургууд нь бодит нөхцөл байдлыг илтгэж байгаа нь ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл тухайн газрын фото зургийг оруулж өгснөөр ХХГХ хаана, хэрхэн үйлдэгдэж байгааг харуулж байгаа хэлбэр гэж үзэх үндэслэлтэй.</p> <p>ХХГХ-ийн зураглал нь англи хэлээр орчуулагдсан нь шинэлэг бөгөөд Монгол Улс дахь нөхцөл байдлыг олон улсад харуулах, цаашид уг гэмт хэрэгтэй тэмцэхэд хамтын ажиллагааг өрнүүлэх нөхцөл байдлыг бүрдүүлэх ач холбогдолтой юм.</p>
<p>10.</p>	<p>Хүйсийн тэгш эрхийн төв, Хүний аюулгүй байдлын судалгааны төвийн хамтын бүтээл</p>		

<p>Уг бүтээл нь найман бүлэгтэй, дэд хэсгээс бүрдэх бөгөөд хүүхэд худалдаалах гэмт хэргийн талаар авч үзсэн онцлогтой. Ялангуяа хүүхэд/хүн/ худалдаалах гэмт хэргийн шинжийг зөв таньж, хэрхэн урьдчилан сэргийлэх, тэдгээрийг хамгаалах, тусламж үзүүлэх талаар мэдээлэл агуулсан байна. Нийгмийн ажилтнуудад зориулан гаргасан уг бүтээлийн агуулгад хүүхэдтэй холбоотой олон улсын гэрээ конвенцийг оруулж өгөхийн зэрэгцээ тэдгээрийн онцлог, мөн чанарт тайлбар хийж, харьцуулах зэргээр авч үзсэн байна.</p>	<p>Хүүхэд худалдаалах гэмт хэрэг /нийгмийн ажилтнуудад зориулсан гарын авлага/</p>	<p>Хүүхдийн төлөө газар, Хүйсийн тэгш эрхийн төвийн хамтын бүтээл</p>	<p>Уг бүтээл нь найман бүлэгтэй, дэд хэсгээс бүрдэх бөгөөд хүүхэд худалдаалах гэмт хэргийн талаар авч үзсэн онцлогтой. Ялангуяа хүүхэд/хүн/ худалдаалах гэмт хэргийн шинжийг зөв таньж, хэрхэн урьдчилан сэргийлэх, тэдгээрийг хамгаалах, тусламж үзүүлэх талаар мэдээлэл агуулсан байна. Нийгмийн ажилтнуудад зориулан гаргасан уг бүтээлийн агуулгад хүүхэдтэй холбоотой олон улсын гэрээ конвенцийг оруулж өгөхийн зэрэгцээ тэдгээрийн онцлог, мөн чанарт тайлбар хийж, харьцуулах зэргээр авч үзсэн байна.</p> <p>Хүүхэд худалдаалах талаар авч үзэхдээ түүний онцлог байдлыг харгалзан үзэж бичсэн нь сайшаалтай байна. Тухайлбал: хүүхдийн бичиг баримтыг хуурамчаар үйлдэх, тэднийг элсүүлэхэд оюун санааны хувьд нөлөөлж хуурч мэхлэх, үрчлэн авахтай холбогдсон асуудлуудыг тэмдэглэсэн байна.</p> <p>Гарын авлагад ХХГХ-ийн хохирогч болсон хүүхдэд тусламж үзүүлэх, сэтгэл зүйн болон гэр бүлийн талаасаа анхаарах асуудал зэргийг тодорхой оруулсан нь зүй ёсоор хөндөх асуудал мөн гэж үзэж байна.</p> <p>Хавсралт хэсэгт эрх зүйн актуудыг оруулж өгсөн нь бусад бүтээлүүдэд агуулагдаж байгаа мэдээлэлтэй давхцаж байна. Гэвч энэ гарын авлага нь нийгмийн ажилтнуудад зориулагдсан тул оруулж өгсөн нь зүйтэй болсон.</p>
<p>Энэхүү бүтээл нь 6 бүлгээс бүрдэх Хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэргийг бүхэлд нь авч үзсэн. Гарын авлагын 6 дугаар бүлэгт Хүн худалдаалах гэмт хэргийн тухай дараах агуулгыг багтаан бичжээ. Үүнд:</p>	<p>Хүний эрх, эрх чөлөө, албар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэг</p>	<p>Ж.Нямдулам, С.Гантулга, О.Амарсайхан, Л.Бат-Очир, Э.Золбоо, Б.Мөнхзул нарын хамтын бүтээл</p>	<p>– Хүн худалдаалах гэмт хэргийн ойлголт, бүрэлдэхүүн – Хүн худалдаалах гэмт хэргийн зүйлчлэлийн асуудал</p> <p>Хүн худалдаалах гэмт хэргийн ойлголт, бүрэлдэхүүн хэсэгт тус гэмт хэргийн үндсэн, хүндрүүлэх, онц хүндрүүлэх бүрэлдэхүүн, объектив болон субъектив шинжүүд, энэ төрлийн гэмт хэргийн зорилго, үйлдлийн арга, үе шатыг дэлгэрэнгүй тусгасан байна.</p> <p>Хүн худалдаалах гэмт хэргийн зүйлчлэлийн асуудал хэсэгт Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах, Хүн хулгайлах, Насанд хүрээгүй хүнийг согтуурал, мансуурал, тэнүүчлэл, гуйланчлалд татан оруулах, Хүн барьцаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжүүдтэй харьцуулан, нийтлэг болон ялгагдах шинжүүдийн талаар дэлгэрэнгүй тусгажээ.</p> <p>Түүнчлэн агуулууудыг баталгаажуулах зорилгоор бодлого, дасгал, сорилын санг шигтгэж өгчээ.</p> <p>Дээрх бүтээлд тусгагдсан агуулга, хяналтын асуулт, бодлого, дасгал, сорилын сан нь суралцагчдад олгосон мэдлэгийг баталгаажуулах, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, ижил төстэй гэмт хэргээс ялгахур чадвар эзэмшүүлэх практик ач холбогдолтой бүтээл гэж судлаачийн зүгээс үзэж байна.</p>

13.	С.Гантулга	Хүн худалдаалах гэмт хэрэг, 2008	<p>Уг бүтээлүүд нь 3 бүлэгтэй, бөгөөд ХХГХ-ийн эрүүгийн эрх зүйн шинж, бүрэлдэхүүний онцлог, төсөөтэй гэмт хэргээс ялган зүйлчлэх асуудлыг иж бүрэн авч үзэхийн сацуу криминологийн зарим асуудал, ХХГХ-ийн цаашдын чиг хандлага, шалтгаан нөхцөлийн талаар авч үзсэн нь ач холбогдолтой юм. Уг бүтээлд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны талаар авч үзсэн нь бүтээлийн иж бүрэн байдлыг бататгасан шинжтэй болсон. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны талаар авч үзэхдээ тухайн ажиллагааг явуулж нотлох баримтыг хэрхэн цуглуулж, бэхжүүлэх тухайд товч авч үзсэн байна.</p>
14.	С.Гантулга	Хүн худалдаалах гэмт хэрэг, 2013	<p>Мөн уг бүтээл нь гадаад орнуудтай байгуулсан эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээний талаарх мэдээллийг оруулж өгсөн байна. Энэ нь хэдийгээр бусад бүтээлд дурдагдсантай давхцаж байгаа хэдий ч бүтээлийг зохиогчийн бүтээлдээ хандсан хандлага нь ХХГХ-ийг судлахдаа иж бүрэн хандах гэсэн сэдэлтэй хамааралтай байна.</p> <p>Бүтээлд нэлээд олон жишээ баримт, тоо, статистик оруулж өгсөн нь зөв болжээ. Тодруулбал: ХХГХ-ийн үйлдлийн шинж, гадаад улс орнуудад уг гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчидтой ярилцлага хийж баримтжуулжээ. Энэ нь бүтээлийн чанар чансаа сайтайг илтгэн харуулж байгаа билээ.</p>
15.	С.Гантулга	Хүн худалдаалах гэмт хэрэг, 2015	<p>2013 оны бүтээлд байгаа мэдээллийг 2015 оны бүтээлдээ илүү дэлгэрүүлж, зарим орхигдуулсан байсан тайлбар зүүлтүүдийг хийж гүйцэтгэсэн байна. Тухайлбал: зарим мэдээллийг шинэчлэх, судалгаагаа эргэж авч үзсэн нь анзаарагдана. ХХГХ-ийн түүхэн тоймыг илүү дэлгэрэнгүй авч үзсэн, мөн ХХГХ-ийн шалтгаан нөхцөл, нөлөөлж байгаа хүчин зүйлсийг нарийвчлан авч үзсэн, гадаад орнуудтай харилцан хамтран ажиллах талаар авч үзсэн зэрэг нь бүтээлүүдийн ялгагдах шинж болжээ.</p> <p>Монгол Улс дахь ХХГХ-ийн цаашдын чиг хандлага ямар байх вэ? гэсэн асуултын хариуг олохоор чармайсан нь анхаарал татна. Ер нь уг гэмт хэрэг үйлдэгдэх бүхий л нөхцөл суурь манай улсад байгаа судлаач харуулсан нь сайшаалтай.</p>

16.	С.Ю.Журавлев нарын хамтын бүтээл	Хүн худалдаалах гэмт хэрэг мөрдөх ажиллагааны арга зүй, тактик /орчуулгын бүтээл/	<p>Уг бүтээл нь зургаан бүлэг, дэд хэсгээс бүрдэх бөгөөд ХХГХ–ийн талаар гарсан нэлээд дорвитой бүтээлд зүй ёсоор тооцогдоно. 2012 онд Орос хэлнээс орчуулан хэвлүүлсэн байх ба зориулалт нь ХХГХ–ээс урьдчилан сэргийлэх, нэгэнт үйлдэгдсэн нөхцөлд түүнийг хэрхэн илрүүлэх, таслан зогсоох, мөрдөх арга зүй, тактик зүйн талаар олон жишээ баримтад тулгуурлан дэлгэрэнгүй өгүүлжээ. Мөн бүтээлийн зохиогчдын зүгээс цагдаа, тагнуул, шүүх, прокурорын болон бусад холбогдох байгууллагын ажилтан, эрдэмтэн, судлаач нарт зориулан гаргасан нь түүний чанар чансааг илтгэж байна.</p> <p>Уг бүтээлд ХХГХ–ийн талаарх олон улсын гэрээ, эрүүгийн эрх зүйн тодорхойлолтыг авч үзсэн нь бусад бүтээлд дурдсангай давхцана. Хэдийгээр давхцах боловч нөхцөл байдлын хувьд судалгаа нь ОХУ–ын эрх зүйн орчин, баримт материалд тулгуурлан авч үзсэн нь түүний онцлог болж байна.</p> <p>Бүтээлийн хамгийн давуу тал, онцлог нь ХХГХ–ийг хэрхэн мөрдөж нотлох, түүнчлэн нууц далд аргаар үйлдэгддэг уг гэмт хэргийг гүйцэтгэх ажлын арга, хүч хэрэгслээр илрүүлэх, талаар авч үзсэн зэргээс харж болно. Мөн ХХГХ–ийн шинж тэмдгийг илрүүлсэн тохиолдолд тодорхой ажиллагаа явуулах арга барил, арга зүй, тактикийн шинжтэй зөвлөмжүүд байгаа нь сайшаалтай байна. Уг бүтээлд байгаа шинжилгээ хийхтэй холбоотой бүлэг нь бусад бүтээлд дурдаг даагүй нь онцлогтой болжээ. Энэ нь ХХГХ–ийг мөрдөх явцад нотлох баримт цуглуулж бэхжүүлэх ажиллагаа зайлшгүй шүүхийн шинжилгээтэй хамааралтай байдгийг илтгэн харуулсан юм. Шинжилгээ хийхтэй холбоотой асуудал нэлээд чухал бөгөөд нотлох баримтын эх сурвалжийн хувьд түүний ач холбогдол хийгээд хууль зүйн учир холбогдол талаасаа ч зайлшгүй авч үзэх асуудал юм.</p> <p>ХХГХ–ийг мөрдөн шалгах ажиллагааг дараах хандлагаар авч үзэх нь зүй гээд үүнд: а/ ХХГХ–ийн баримт мэдээлэл уг гэмт хэрэгт өртсөн этгээдийн төрөл саднаас мөрдөн шалгах ажиллагаа хийх, б/ гүйцэтгэх ажлын арга хэрэгслээр мөрдөн шалгах ажиллагаа явуулах хандлагыг баримтлах зэргээр нэлээд бодитой зөвлөмжүүдийг өгч байгаа нь анхаарал татсан. Эдгээрийн талаар бусад бүтээлд төдий л дурдаагүй байгааг тэмдэглэх нь зүйтэй.</p>
17.	Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагаас эрхлэн хэвлүүлсэн	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх шууд тусламжийн гарын авлага	<p>ХХГХ–ийн хохирогч нь сэтгэл зүй, бие эрхтэн, нэр төрөөрөө хохирч амьдрах итгэл, найдвараа алддаг талаар нарийн авч үзсэн. Энэ нь хохирогчтой харилцах, тэдгээрийн сэтгэл зүйд эергээр нөлөөлж эмчлэх, дэмжлэг үзүүлэх, хамгаалах талаар маш нарийн тусгаж өгсөн нь ач холбогдолтой болжээ.</p> <p>Бусад бүтээлд дурдагдсан агуулгаас ялгагдах шинж нь хамгаалах байрны талаар тал бүрээс нь авч үзсэнд оршиж байна. Хохирогч хамгаалах байранд байх, түүнийг хамгаалах дүрэм, стандарт, эрх үүргийн талаар бичсэн нь анхаарал татаж байна.</p>

18.	Хүний Эрх Хөгжил Төв	Хүн худалдаалах гэмт хэргийн асуудлаар ажилладаг хуулийн байгууллагын ажилтнуудад зориулсан гарын авлага	<p>Уг гарын авлага нь зургаан хэсэгтэй бөгөөд ерөнхий агуулгаараа бусад бүтээл, судалгааны тайланд буй мэдээллийг агуулсан байна.</p> <p>Нэгдүгээр хэсэгт: Олон улсын гэрээ, конвенцүүд, Эмэгтэйтчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протоколуудыг тусгаж өгсөн байна. Мөн уг гэрээ, конвенцийг тухайн улс орон үндэсний хууль тогтоомждоо тусгаж, зарчим, үзэл санааг нь хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлэхийн чухал болохыг авч үзсэн байна.</p> <p>Дээрх хэсгийн агуулгыг дараа дараагийн хэсгүүдэд авч үзэхдээ үндэсний хууль тогтоомж түүний агуулга, үзэл санаанд хэрхэн тусгаж, хэрэгжүүлэх талаар авч буй эрх зүйн орчны мэдээллийг багтааж өгсөн байна. Тухайлбал: Монгол Улсын Эрүүгийн Хуулийн 113 дугаар зүйл, түүний тайлбар /УДШ–ийн тогтоол/ зэргийг тусгаж өгсөн.</p> <p>ХХГХ–тэй тэмцэх Европын холбооны гишүүн орнууд болон элсэх гэж буй орнуудын шүүгч, прокурор нарт зориулсан гарын авлагаас хэсэгчлэн оруулж өгсөн. Мөн ХХГХ–ийн хохирогчийг ялган таних, тэдэнд тусламж үзүүлэх талаар мэдээлэл оруулж өгсөн нь ач холбогдолтой байна.</p>
19.	Хүний аюулгүй байдлын судалгааны төв	Хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбогдуулан үндэсний хууль тогтоомжид хийсэн судалгааны тайлан	<p>Уг судалгааны тайлан нь 11 хэсэгтэй бөгөөд ХХГХ–тэй тэмцэхэд дотоодын хууль тогтоомжуудын өнөөгийн байдал, хэрэгжилт, цаашид анхаарах асуудлын талаар авч үзсэнээрээ онцлог. ХХГХ үйлдэгдсэн үеэс дотоодын хууль зүйн механизм хэрхэн ажилладаг хийгээд цаашид хууль тогтоомжийг тодорхой хэмжээнд өөрчлөх, боловсронгуй болгоход чиглэсэн санал дүгнэлттэй.</p> <p>Эрүүгийн хуульд ХХГХ–ийг зөв томьёолон хуульчлах, Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах, тэдний хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, сэргээх талаар бодитой санал дэвшүүлсэн судалгааны тайлан гэж үзэж байна. Түүнчлэн гэр бүлийн хууль дахь холбогдох заалт, Хүүхдийг бэлгийн мөлжлөгт ашиглахыг хориглосон хууль тогтоомж, конвенц, түүний нэмэлт протокол, Насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэх гэмт хэрэг, Садар самуунтай тэмцэх тухай хууль тогтоомж дахь хүн худалдаалах гэмт хэргээс сэргийлэх механизм, Монгол Улсын иргэд гадаадад зорчих, цагаачлах хуульд заасан механизм, Хараа хяналтгүй хүүхдийн талаарх хууль тогтоомж, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Донорын тухай хууль дахь ХХГХ–ээс урьдчилан сэргийлэх механизмын талаар авч үзсэн байна.</p>
20.	Азийн сан, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Зохиогч, хууль зүйн ухааны доктор /Ph.D/ П.Оюунчимэг	Хүн худалдаалах гэмт хэрэг. Шүүгч, прокурорт зориулсан гарын авлага.	<p>Уг гарын авлага нь шүүгч, прокурорт зориулж гаргасан нь онцлог бөгөөд ХХГХ–ийн тухай олон улсын гэрээ, конвенц, түүнтэй тэмцэх НҮБ–ын механизм хийгээд үндэсний хууль тогтоомж дахь зохицуулалт, ХХГХ–ийн олон улсын болон дотоодын нөхцөл байдлыг дэлгэрэнгүй авч үзсэн нь ажиглагдана. Гэхдээ энэ нь бусад бүтээлд байгаа агуулгыг илүү дэлгэрүүлсэн гэсэн үг бус ижил хэмжээнд тусгасан байгааг тэмдэглэх нь зүйтэй. ХХГХ–тэй тэмцэх стратегийг боловсруулах явдал нь бүтээлийн нэгэн онцлог болсон.</p> <p>Бидний судалгааны ажлын явцад шүүн таслах ажиллагааны талаар уг бүтээлд дурдсан агуулгаар бичсэн гарын авлага, судалгааны тайлан үндсэндээ ховор байна. Ялангуяа ХХГХ–ийг прокурор хянах, шүүн таслах ажиллагааны явцад анхаарах зүйлс, хохирогчийг харилцах, хамгаалах, хохирол, иргэний нэхэмжлэлийг арилгах талаар тодорхой хэмжээнд зөвлөмж өгсөн нь онцлогтой байна.</p> <p>Хэдийгээр шүүгч, прокурорт зориулсан гарын авлага боловч эрдэм шинжилгээний ажлын ерөнхий шаардлагад нийцүүлэн бичсэн нь /эшлэл зүүлт хийх, гадаад, дотоодын эрдэмтдийн бүтээлийг ашиглах, нэр томьёоны хувьд хууль зүйн техникийн үүднээс хандсан зэрэг/ сайшаалтай байна.</p>

21.	Хүйсийн тэгш эрхийн төв	Тодорхой төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны өртөг: Хүн худалдаалах гэмт хэргийн жишээн дээр.	<p>Энэхүү судалгааны тайлан нь ХХГХ-ийн жишээн дээр мөрдөн шалгах ажиллагаа, өмгөөлөх ажиллагаа, прокурорын хяналт, шүүн таслах ажиллагаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал түүнчлэн хохирогчид эмнэлгийн болон сэтгэл зүйн тусламж үзүүлэх, түүнийг хамгаалах, эх оронд нь авч ирэх гэх зэргээр бүхий л зардлыг гаргах гэж зорьсон нь шинэлэг ажил болжээ. Мөн хохирлыг тогтоох, улмаар хохирогчид учирсан эдийн болон эдийн бус хохирол, нөхөн төлж болох хохирлоос, нөхөн төлөхөд буюу хохирол тогтоох боломжгүй хохирлыг тодорхойлохыг авч үзжээ.</p> <p>Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад гарах зардал, түүнд нийцүүлэн гаргасан зардалтай холбогдох журам, тогтоолуудыг иж бүрэн авч үзсэн нь сайшаалтай. Судалгааны ажлыг улам бүр чамбайруулах үүднээс 2016 онд батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зардалтай хамаарах зүйлийг харьцуулан авч үзэж, дутагдалтай болон шинэлэг талыг авч үзсэн байна.</p> <p>Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал хууль сахиулах болон хуулийн байгууллагаас хэрхэн гарч буйг тогтоох зорилгоор цагдаа, шүүхийн шийдвэр, өмгөөлөл, прокурор, шүүхээс судалгаа авсан байна. Мөн хохирогчийн ар гэрээс болон ХХГХ-ийн хохирогчтой харилцаж, тусалцаа үзүүлдэг төрийн бус байгууллагаас гарч буй зардал ямар хэмжээтэйг гаргасан байна.</p> <p>Судалгааг илүү эмпирк болгох үүднээс шүүхээр шийдвэрлэгдсэн 6 эрүүгийн хэргийг сонгон авч байцаан шийтгэх ажиллагааны зардлын тооцоог гаргах оролдлого хийсэн нь дараа дараагийн олон бүтээл, судалгаанд ашиглагдахуйц болсныг тэмдэглэх нь зүйтэй.</p>
Хоёр: Тусгай бүтээлүүдийн тухай /маш нууцын зэрэглэлд хамаарах докторын диссертаци/			
22.	С.Гантулга	Хүн худалдаалах гэмт хэргийг эрүүгийн тагнуулаар урьдчилан сэргийлэх, илрүүлэх ажиллагаа	Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга замыг боловсруулсан. Мөн ХХГХ-ийн криминалистик шинжийг тодорхойлж, эрүүгийн тагнуулаар илрүүлэх ажиллагаа, арга зүйн зөвлөмж боловсруулснаараа онцлог ажил болсон.
23.	Р.Баярмагнай	Хүний цус, эд эрхтэн хууль бусаар авах гэмт хэргийг эрүүгийн тагнуулын ажлаар урьдчилан сэргийлэх, илрүүлэх ажиллагаа	Хүний цус, эд эрхтэн хууль бусаар авах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга замыг боловсруулсан. Уг гэмт хэргийг криминалистик шинжийг тодорхойлж, эрүүгийн тагнуулаар илрүүлэх ажиллагаа, арга зүйн зөвлөмж боловсруулснаараа онцлог ажил болсон. <p>Судалгааны багийн гишүүд уг бүтээлтэй танилцах боломжгүй тул зохиогчийн хэлсэн агуулгаар товч танилцуулга оруулсан болно.</p>

Бид хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой бичигдсэн сургалтын гарын авлага, шаардлагатай судалгааны ажлын тайлан зэргийг АНУ–ын Азийн сан, Хүйсийн тэгш эрхийн төв төрийн бус байгууллага, Хууль сахиулахын их сургуулиас цуглуулж, дээрх 17 бүтээлд харьцуулалт хийхээр ажиллалаа. Дээр дурдсан 17 бүтээлээс дараах гарын авлагуудыг сонгон авч, харьцуулан судлав. Үүнд:

1. Хууль зүйн яам, АНУ–ын Азийн сан, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхэд мөрдөн байцаагчдын ур чадварыг дээшлүүлэх модуль сургалтын гарын авлага,
2. АНУ–ын Азийн сан, Хүйсийн тэгш эрхийн төвийн хамтын бүтээл, Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь, сургагч багшийн гарын авлага,
3. Австралийн хөгжлийн агентлаг, Хүйсийн тэгш эрхийн төвийн хамтын бүтээл, Бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэргийн хохирогчид туслалцаа үзүүлэх гарын авлага,
4. Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам, НҮБ–ын Хүүхдийн сан, Хүйсийн тэгш эрхийн төв, Цагдаагийн академи, Хилийн цэргийн дээд сургуулийн хамтын бүтээл, Хүн худалдаалах гэмт хэрэг /суралцагсдын гарын авлага/,
5. Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам, НҮБ–ын Хүүхдийн сан, Хүйсийн тэгш эрхийн төв, Цагдаагийн академи, Хилийн цэргийн дээд сургуулийн хамтын бүтээл, Хүн худалдаалах гэмт хэрэг /сургагч багшийн гарын авлага/,
6. Хүйсийн тэгш эрхийн төв, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх гарын авлага /Цагдаа, хилийн шалган нэвтрүүлэх албаны ажилтнуудад зориулав/,
7. Хүйсийн тэгш эрхийн төв, Хүний аюулгүй байдлын судалгааны төвийн хамтын бүтээл, Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн зураглал,
8. Хүүхдийн төлөө газар, Хүйсийн тэгш эрхийн төвийн хамтын бүтээл, Хүүхэд худалдаалах гэмт хэрэг /нийгмийн ажилтнуудад зориулсан гарын авлага/,
9. Ж.Нямдулам, С.Гантулга, О.Амарсайхан, Л.Бат–Очир, Э.Золбоо, Б.Мөнхзул нарын хамтын бүтээл, Хүний эрх, эрх чөлөө, албар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэг,
10. С.Гантулга, Хүн худалдаалах гэмт хэрэг,
11. С.Ю.Журавлев нарын хамтын бүтээл, Хүн худалдаалах гэмт хэрэг мөрдөх ажиллагааны арга зүй, тактик / орчуулгын бүтээл/
12. Олон улсын шилжин суурьшлын байгууллага, Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх шууд тусламжийн гарын авлага

Гурав. Харьцуулалтын асуултууд:

1. Хүн худалдаалах гэмт хэргийн ойлголт
2. ХХГХ–тэй тэмцэх ирсэн түүх
 - a. Монгол улсад
 - b. Олон улсад
3. ХХГХ–тэй тэмцэх олон улсын гэрээ, конвенц
4. ХХГХ–тэй тэмцэх үндэсний эрх зүйн зохицуулалт
 - a. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль
 - b. Эрүүгийн хууль
 - c. Хүүхдийн эрхийн тухай хууль
 - d. Хүүхэд хамгааллын тухай хууль
 - e. Харьяатын тухай хууль
 - f. Хувь хүний нууцын тухай хууль
 - g. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль
 - h. Гэр бүлийн тухай хууль
 - i. Иргэний хууль
 - j. Үндэсний хөтөлбөрүүд
5. ХХГХ–тэй тэмцэж байгаа сайн туршлага
6. ХХГХ–ийн ойлголт, эрүүгийн эрх зүйн шинж
 - a. ХХГХ–ийн шинж
 - b. ХХГХ–ийн зорилго
 - c. ХХГХ–ийн үйлдлийн арга

- d. ХХГХ үйлдэгдэх үе шат
- 7. ХХГХ–ийн криминологийн шинж
- 8. ХХГХ–ийн зүйлчлэл, төсөөтэй гэмт хэргээс ялган зүйлчлэх нь
 - a. ХХГХ–ийг зүйлчлэхэд анхаарах асуудал
 - b. Хүчиндэх, бэлгийн мөлжлөг, хүн хулгайлах, хүн барьцаалах, албадан хөдөлмөрлүүлэх, хүний цус, эд эрхтнийг хууль бусаар авах, хүүхдийг хаях, төөрүүлэх, тэнүүчлэлд хүргэх, хүүхдээр гуйлга гуйлгах, хүүхэд худалдах, хүүхдийг садар самууныг сурталчлах, уруу татах, хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах, хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэргүүдээс ялган зүйлчлэх нь
- 9. ХХГХ–ийн хэлбэрүүд
 - a. Бэлгийн мөлжлөг
 - b. Хөдөлмөрийн мөлжлөг
 - c. Боолчлол
 - d. Захиалгат зуучлалын гэрлэлт
 - e. Эд, эрхтний наймаа
 - f. Хууль бус хүүхэд үрчлэлт
 - g. Захиалгат гэрлэлт
- 10. ХХГХ үйлдэгдэж буй шалтгаан, нөхцөл
- 11. ХХГХ–ээс урьдчилан сэргийлэх нь
- 12. ХХГХ–ийн хохирогч судлал, хохирогч, гэрчийг хамгаалах эрх зүйн орчин
- 13. Хохирогч төвтэй мөрдөн байцаалтын талаарх агуулга тусгагдсан эсэх
- 14. ХХГХ–ийн хохирогчид үзүүлэх тусламж, үйлчилгээ
 - a. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ
 - b. Сэтгэл зүйн тусламж үйлчилгээ
 - c. Хууль зүйн тусламж үйлчилгээ
- 15. ХХГХ–ийг нотлох ажиллагаа
 - a. ХХГХ–ийн нотлох баримт, түүний төрөл
 - b. ХХГХ–ийн нотолгооны зүйл, хэмжээ хязгаар
 - c. ХХГХ–ийг нотлох ажиллагаа, түүний үе шат
 - d. ХХГХ–т хийгдэх шинжилгээ, анхаарах асуудал
- 16. ХХГХ–ийн криминалистикийн шинж, мөрдөх арга зүй
- 17. ХХГХ–тэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын алба хаагчдад зориулагдсан байдал
 - a. Цагдаа
 - b. Прокурор
 - c. Шүүх
 - d. Шалган нэвтрүүлэх алба
 - e. Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн байгууллага
- 18. ХХГХ–тэй тэмцэхэд хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа

3.1. Ном, гарын авлагын агуулгын матриц /+ тэмдэгтэй бол бүтээлд тухайн агуулга нь байгааг илэрхийлнэ, нийт 12 номыг харьцуулав/

Матриц №1

Бүтээл		Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхэд мөрдөн байцаагчдын ур чадварыг дээшлүүлэх модуль сургалтын гарын авлага	Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь, сургагч багшийн гарын авлага	Бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэргийн хохирогчид туслалцаа үзүүлэх гарын авлага	Хүн худалдаалах гэмт хэрэг /суралцагсдын гарын авлага/	Хүн худалдаалах гэмт хэрэг /багшийн гарын авлага/	Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх гарын авлага /Цагдаа, хилийн шалган нэвтрүүлэх албаны ажилтнуудад зориулав/
Асуулт							
Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх	Хүн худалдаалах гэмт хэргийн ойлголт		+		+	+	+
ХХГХ-тэй тэмцэх ирсэн түүх	Монгол улсад				+	+	+
	Олон улсад		+		+	+	+
ХХГХ-тэй тэмцэх олон улсын гэрээ, конвенц			+		+	+	+
ХХГХ-тэй тэмцэх үндэсний эрх зүйн зохицуулалт	Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль		+				+
	Эрүүгийн хууль	+					+
	Хүүхдийн эрхийн тухай хууль						
	Хүүхэд хамгааллын тухай хууль						
	Харьяатын тухай хууль						
ХХГХ-тэй тэмцэх үндэсний эрх зүйн зохицуулалт	Хувь хүний нууцын тухай хууль						
	Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль						
	Гэр бүлийн тухай хууль			+			
	Иргэний хууль						+
	Үндэсний хөтөлбөрүүд						
ХХГХ-тэй тэмцэх байгаа сайн туршлага	Бусад журам /гушаал, тогтоол г.м/		+		+		+

Матриц №2

Бүтээл	Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн зураглал	Хүүхэд худалдаалах гэмт хэрэг /нийгмийн ажилтнуудад зориулсан гарын авлага/	Хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэг	Хүн худалдаалах гэмт хэрэг	Хүн худалдаалах гэмт хэрэг мөрдөх ажиллагааны арга зүй, тактик / орчуулгын бүтээл/	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх шууд тусламжийн гарын авлага
Асуулт	Хүн худалдаалах гэмт хэргийн ойлголт			+	+	+
	Монгол улсад					
XXГХ-тэй тэмцэх ирсэн түүх	Олон улсад			+	+	
	XXГХ-тэй тэмцэх олон улсын гэрээ, конвенц					
XXГХ-тэй тэмцэх олон улсын гэрээ, конвенц	Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль	+				
	Эрүүгийн хууль	+	+			
	Хүүхдийн эрхийн тухай хууль		+			
	Хүүхэд хамгааллын тухай хууль		+			
	Харьяатын тухай хууль					
XXГХ-тэй тэмцэх үндэсний эрх зүйн зохицуулалт	Хувь хүний нууцын тухай хууль					
	Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль					
	Гэр бүлийн тухай хууль					
	Иргэний хууль					
	Үндэсний хөтөлбөрүүд					
XXГХ-тэй тэмцэж байгаа сайн туршлага	XXГХ-ийн шинж		+	+	+	
	XXГХ-ийн зорилго		+		+	
	XXГХ-ийн үйлдлийн арга		+	+	+	
	XXГХ үйлдэгдэх үе шат		+	+	+	
XXГХ-ийн криминологийн шинж		+		+		

